



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-117
1.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	7-67
2.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	68-117

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
04 дүгээр сарын 24-ний өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 75 гишүүн хүрэлцэн ирж, 59.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Б.Батцэцэг, Х.Ганхуяг, Г.Дамдинням, Т.Доржханд, Б.Жавхлан, Б.Заяабал, С.Одонтуяа, Ч.Ундрэм, Б.Чойжилсүрэн, Д.Энхтуяа;

Чөлөөтэй: Х.Баттулга, Д.Ганбат, Б.Мөнхсоёл, З.Мэндсайхан, М.Нарантуяа-Нара, Л.Оюун-Эрдэнэ, О.Цогтгэрэл;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Амарсайхан;

Хоцорсон: Н.Алтанхуяг-01 минут, Б.Батбаатар-05 минут, Х.Болормаа-07 минут, Ш.Бямбасүрэн-04 минут, С.Бямбацогт-05 минут, С.Ганбаатар-07 минут, Л.Гантөмөр-35 минут, Ц.Даваасүрэн-04 минут, Б.Жаргалан-10 минут, Д.Жаргалсайхан-21 минут, Ж.Золжаргал-01 минут, Ч.Лодойсамбуу-01 минут, Г.Лувсанжамц-21 минут, Ц.Мөнхтуяа-06 минут, Э.Одбаяр-01 минут, Ц.Туваан-03 минут, А.Ундраа-16 минут, Н.Учрал-01 минут, Г.Уянгахишиг-04 минут, Д.Цогтбаатар-12 минут, Д.Энхтүвшин-03 минут, Р.Эрдэнэбүрэн-02 минут.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.3-т заасны дагуу Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан иргэн Билэгтийн Батбилэгээс нийгмийн даатгалын шимтгэлийг бууруулах тухай хуулийн төсөл санаачлах асуудлаар ирүүлсэн нийтийн өргөдлийг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулав./10:02/

Нэг.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Х.Баасанжаргал, Ц.Идэрбат, М.Бадамсүрэн, П.Сайнзориг, Ж.Алдаржавхлан, Г.Тэмүүлэн, Б.Баярбаатар, Ж.Батжаргал, Ц.Сандаг-Очир, Г.Хосбаяр нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.7-д “Нэгдсэн хуралдаанд асуулт асуух, хариулт авах үйл ажиллагааг Зөвлөлөөс тогтоосон хугацаанд багтаан зохион байгуулах ба шаардлагатай тохиолдолд хуралдаан даргалагч 1 хүртэл цагаар сунгаж болно.” гэж заасны дагуу асуулт, хариулт авах хугацааг 1 цагаар сунгав./12:38/

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут, Г.Очирбат, Б.Найдалаа, Б.Батбаатар нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, М.Бадамсүрэн, П.Сайнзориг, Ж.Ганбаатар, Ж.Бат-Эрдэнэ, П.Ганзориг, Б.Баярбаатар, М.Мандхай, Б.Батбаатар нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./13:30/

Уг асуудлыг 13 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 30 минут үргэлжилж, 13 цаг 30 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 15 цаг 00 минутад эхлэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль тогтоомжийн төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3-т заасны дагуу хууль санаачлагч төслөө татан авсанд тооцлоо./15:01/

Хоёр.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, мөн газрын мэргэжилтэн Б.Энхцэцэг, “Хэвлэл мэдээллийн зөвлөл” ТББ-ын захирал Г.Гүнжидмаа, “Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбоо” ТББ-ын тэргүүн С.Шаравдорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Б.Мажигсүрэн, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Ц.Идэрбат, А.Ариунзаяа, Л.Мөнхбаясгалан, П.Сайнзориг, С.Эрдэнэболд, Г.Ганбаатар, Ө.Шижир, Д.Пүрэвдаваа, Ж.Баярмаа, Ж.Золжаргал нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, “Хэвлэл мэдээллийн зөвлөл” ТББ-ын захирал Г.Гүнжидмаа, “Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбоо” ТББ-ын тэргүүн С.Шаравдорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, А.Ариунзаяа, П.Сайнзориг, Ж.Золжаргал, Ч.Лодойсамбуу, Д.Энхтүвшин, Б.Жаргалан, А.Ганбаатар, С.Эрдэнэболд нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./17:36/

Уг асуудлыг 17 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 6 цаг 06 минут үргэлжилж, 126 гишүүнээс 107 гишүүн хүрэлцэн ирж, 84.9 хувийн ирцтэйгээр 17 цаг 36 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 00 минут*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдэд энэ өглөөний амар амгаланг айлтган мэндчилье. 75 гишүүн бүртгэгдэж, ирц 59.5 хувьтай байна.

2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар өнөөдөр 2 асуудал хэлэлцэнэ.

Үдээс өмнөх хуралдаанаар Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.3-д нийтийн өргөдлийг дэмжсэн иргэдийн санал энэ хуулийн 95.2-т заасан тоонд хүрмэгц Улсын Их Хурлын дарга саналыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр холбогдох Байнгын хороонд ажлын 5 өдрийн дотор хуваарилж, нэгдсэн хуралдаанд танилцуулна гэж заасан.

Нийтийн өргөдлийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

Монгол Улсын иргэн Билэгтийн Батбилэг Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн НДШ-ийг бууруулах тухай асуудлаар хуулийн төсөл санаачлах нийтийн өргөдөл ирүүлснийг Улсын Их Хурлын нийтийн өргөдөл, гомдлын системд 2025 оны 3 дугаар сарын 12-ны өдөр нийтэлсэн.

Энэ өргөдөл 2025 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр Монгол Улсын 18 насанд хүрсэн 101138 иргэний санал авсан тул нийтийн өргөдөлд дурдсан асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний дагуу Нийгмийн бодлогын байнгын хороонд хуваарилж байна.

Нийгмийн бодлогын байнгын хороо иргэдийн гаргасан өргөдөлд дурдсан асуудлыг хуульд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэх, шаардлагатай бол холбогдох Байнгын хороотой хамтран хэлэлцэх нь зүйтэй.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Жадамбын Энхбаяр танилцуулна. Индэрт урьж байна. Хууль санаачлагчийн илтгэл.

Ж.Энхбаяр: Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, нөөцийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байж өвөлжилт, хаваржилтын хүндрэлийг даван туулах зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн чуулганаар Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хэлэлцэн баталсан болно.

Гаалийн албан татвараас чөлөөлөх, мал амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт улаан буудайн гурилын жагсаалтыг Засгийн газрын 180 дугаар тогтоолоор мөн баталсан.

Энэ хүрээнд улаан буудайн дээд болон 1 дүгээр зэргийн гурил, 9 нэр төрлийн мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийг гаалийн албан татвараас чөлөөлсөн.

Хуулийн хэрэгжилтийн хүрээнд гурилын импортын гаалийн албан татварыг чөлөөлсөнтэй холбоотой хилийн боомтуудаар орж ирж байгаа гурилын хэмжээ эрс нэмэгдэж жилийн эцсийн байдлаар нийт 64.2 мянган тонн улаан буудайн гурил буюу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар боомтоор 35.9 мянган тонн, Баян-Өлгий аймгийн Цагааннуур боомтоор 14.1 мянган тонн, Увс аймгийн Боршоо боомтоор 10.3 мянган тонн, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг боомт, Завхан аймгийн Арцсуурь боомтоор 3.9 мянган тонн улаан буудайн гурилыг Оросын Холбооны Улсаас тус тус импортолсон байна.

Мөн 2025 онд гарснаар эхний 4 сарын байдлаар нийт 17.1 мянган тонн улаан буудайн дээд болон 1 дүгээр гурилыг Оросын Холбооны Улсаас импортлоод байна.

Мал аж ахуйн салбарын өвөлжилт хаваржилтыг эрсдэл багатай даван туулахад шаардлагатай мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийг 24 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 65.2 мянган тонн буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 дахин их тэжээл импортолсон байна.

Энэхүү нөхцөл байдал нь стратегийн хүнс болох улаан буудайн болон гурилын үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч талуудын үйл ажиллагааг тогтворгүй болгож, тэдгээрт хийгдсэн хөрөнгө оруулалтын үр өгөөж үнэгүйдэх зэрэг эдийн засаг, нийгмийн олон сөрөг нөлөөг дагуулж болзошгүй болоод байна.

Иймд хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, нөөцийг

нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байх зорилгоор мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон улаан буудайн гурилыг гаалийн албан татвараас чөлөөлөхөөр баталсан хууль зорилгодоо хүрсэн гэж үзэж буй учир Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулаад байна.

Иймд хуулийн төслийг хэлэлцүүлж шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жадамбаагийн Баясгалан танилцуулна. Индэрт урьж байна.

Ж.Баясгалан: Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Төсвийн байнгын хороо 2025 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаараа үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явууллаа.

Хууль санаачлагчаас хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байх хүрээнд мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон баяжуулсан гурилыг гаалийн албан татвараас чөлөөлөхөөр баталсан хуулийн зорилгодоо хүрсэн гэж үзэж хуулийн үйлчлэх хугацааг үзэж, хуулийн хугацааг тодорхой болгох, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал мал, амьтны тэжээл, улаан буудайн гурилын гаалийн албан татвараас чөлөөлөх хуулийн хэрэгжилтийн явцад дотоодын гурилын борлуулалтын үнэ болон баруун бүсийн гурил тэжээлийн үнэд үзүүлсэн нөлөөллийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар Гаалийн албан татвараас чөлөөлөх хуулийг хүчингүй болгосноор малчдад очих гурилын үнэ буурах эсэх, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар мал, амьтны тэжээл, улаан буудайн гурилын импортын татвартай болгосноор дотоодын гурилын үнэ нэмэгдэхгүй байх боломжтой эсэх, хэрэглэгчдэд сонголт хийх боломжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд улаан буудайн гурилын албан татварыг чөлөөлснөөр үйл ажиллагаа нь доголдсон газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, гурилын үйлдвэрүүдийн тоог тодруулж, 2025 онд тариалах улаан буудайн хэмжээ гурилын үйлдвэрүүдийн хэрэгцээг бүрэн хангаж чадах эсэх талаар болон хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн чадавхыг сайжруулахаар салбарын яамнаас хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээний талаар асууж, хариулт авсан.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут улаан буудайн гурилыг гаалийн албан татвараас чөлөөлснөөр 1кг гурилын үнийн бууралтын талаар мэргэжлийн

байгууллагуудын тооцоо судалгаа хийсэн эсэх болон цаашид улаан буудайн гурил импортлоход гаалийн татвар төлөхөөр гурилын үнэ нэмэгдэх эсэхийг тодруулж тухайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд төрөөс дэмжлэг үзүүлснээр гурилын үнэ чанарт хэрхэн нөлөөлөх талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг улаан буудайн гурилд импортын татвар тогтоосноор дотоодын гурилын үйлдвэрүүд гурилын үнийг нэмэхгүй байх талаар холбогдох хуулиудаар хэрхэн зохицуулж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр үндэсний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор дотооддоо үйлдвэрлэдэг бүтээгдэхүүнийг импортлоход гаалийн албан татвартай болгохоос гадна татвар, нийгмийн даатгал, эрчим хүч нь үнийн өсөлтөөс хамгаалсан цэгц бодлогууд хэрэгжүүлж байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар улаан буудайн гурилын гаалийн албан татварыг чөлөөлснөөр газар тариалангийн салбарт үүссэн сөрөг нөлөөллийн талаар болон дотоодын гурилын үйлдвэрүүдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр салбарын яамнаас хэрэгжүүлж байгаа бодлогын талаар асууж, хариулт авлаа.

Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал хөдөө аж ахуйн салбараас төрөөс тогтвортой бодлогоор дэмжих нь зүйтэй бөгөөд баруун бүсийн гурилын борлуулалтын үнийг тогтвортой байдлыг хангах талаар тусгайлсан арга хэмжээг хэрэгжүүлэх, мөн газар тариалангийн салбарыг боловсруулах үйлдвэртэй цогцоор нь хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангаж, иргэдийн эрүүл, хямд үнэтэй хүнсээр хангахад төрөөс анхаарах нь зүйтэй бөгөөд дээрх төрлийн бүтээгдэхүүнийг импортын гаалийн албан татвараас чөлөөлснөөр валютын үнэд нөлөөлж байгааг анхаарах, мөн үндэсний үйлдвэрлэгчид үндэслэлгүйгээр үнэ нэмэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төрөөс зохицуулах оновчтой бодлогыг хэрэгжүүлэх нь зүйтэй талаар үг хэлсэн.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаар Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Жадамбын Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Цэндгомбын Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Даваасүрэнгийн Довчинсүрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга,

Даваасүрэнгийн Есөн-Эрдэнэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга.

Одоо Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуухаар нэр урьдчилан ирүүлсэн байгаа. Нэрсийн дарааллын дагуу асуулт асууна. Нийт 22 гишүүн нэр ирүүлсэн байна. Ирсэн ирцийн дарааллын дагуу Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн.

Б.Пүрэвдорж: Би түрүүлж ирсэн юм. Би нэгд ирсэн юм.

Д.Амарбаясгалан: Энэ яагаад өөрчлөлт орчхов дараалалд? Энэ ирцээрээ юу?

Б.Пүрэвдорж: Шинээр явуулчих даргаа?

Д.Амарбаясгалан: Пүрэвдорж гишүүний минутыг шинээр эхлүүлье.

Б.Пүрэвдорж: 2023 оны намрын чуулган, 24 оны хаврын чуулганаар 2 чуулган дамжуулаад энэ баруун аймагт гурилын үнэ хэтэрхий өндөр үнэтэй очиж байна. Ер нь тэр квотыг нь өөрөөр хэлбэл гадаадаас оруулж ирж байгаа тэр хязгаарыг нь байхгүй болгох талаар ажиллаач гэж. Ингэх юм бол баруун аймагт 2 дахин гурилын үнэ буучихаар байна гэж өчнөөн олон удаа хэлсэн. Тэгээд сонгууль дөхөж байсан учраас МАН-ынхан даваадуулаад өөрөөр хэлбэл, тэр хязгаарлалтыг хүчингүй болгохын зэрэгцээгээр татварыг нь байхгүй болгосон. Татварыг нь байхгүй болгосны үр дүнд ямар ч байсан хямд гурил идээд, хямд гурилаа идэнгээ, идүүлэнгээ ард иргэдээсээ сонгуулийн оноо авч тэр нэгээрээ ялалт байгуулсан. Сонгуульд ялалт байгуулчихсан юм чинь буцаагаад буулгаж байх шиг байна. Тэгээд удахгүй дахиад нөгөө Евразийн эдийн засгийн хэлэлцээрт орчихлоороо дахиад гурилын татвар нь бас тэглэгдэнэ. Ингэхээр яах юм бол? Тэгэхээр мэдээж энэ хугацаанд гурилын татварыг буулгаснаар дотоодынхоо үйлдвэрлэлүүдийг, гурилын үйлдвэр болон тариалан эрхэлдэг тэр компаниудаа бүгдийг нь асуудалд оруулчихаад одоо ингээд тийм Лениний 1910-аад оны үед бичсэн ном байдаг юм л даа. Тэр номоор яадаг вэ гэхээр коммунистууд 1 алхам урагшаа, 2 алхам хойшоо гэдэг ийм л зарчим дээр ажилладаг. Сайн юм хийчхээд буцаагаад түүнийгээ засах маягаар ингээд л улам доройтуулдаг ийм л ажлыг хийж байна л гэж би харж байна.

Тэгээд энэ хүнс, хөдөө аж ахуйн салбарт асар их хөрөнгийг зарцуулдаг. Жишээ нь КОВИД-ын үеэр 10 их наядын хөтөлбөр гаргахад 3 их наяд төгрөгийн хөтөлбөр нь аж ахуйн нэгжүүдэд 6 хувийн хүүтэй зээл өгнө, 3 хувийн хүүтэй зээл өгнө гэж орж ирсэн. Гэвч Ховд аймагт 1 ширхэг ч зээл очоогүй. Яагаад гэвэл энэ хавиараа бүгдийг нь эрх мэдэлтнүүд хуваагаад хэрэглэхсэн байдаг. 10 их наядаа үр дүнтэй хэрэгжсэн гэж МАН үзэж байгаа.

Гэтэл өнөөдөр энэ энэ Атрын 4 дүгээр аяны хүрээнд газар тариалан, хүнсний үйлдвэрлэл, мал аж ахуйн чиглэлээр 800 тэрбум төгрөгийн зээл гаргачихсан гэж байгаа юм. Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд ноолуур, ноос, арьс ширэнд зориулж 788 буюу нийтдээ 1.6 их наяд төгрөгийн зээл гаргасан гэж ярьж байгаа. Гэвч энэ зээлээс Ховдод очсон 1 ширхэг ч алга. Гав ганцхан үйлдвэр байгаа тэр нь Үлэмж саран ч гэлүү эмэгтэй дарга нарт ойрхон, гишүүдэд ойрхон

тэр нөхөр нь 300 сая төгрөг шийдвэрлүүлж авч байх шиг байна. Бусад жирийн гишүүд нь, жирийн бизнесменүүдийг дэмждэггүй, энэ дээр нь зээлүүдийг нь унагаадаг.

Тэгэхээр энэ их олон 1.6 их наяд гэх дээр тал нь Улаанбаатар хотод үлдлээ гэхэд манай 21 аймагт хуваахаар манай Ховд аймагт ядаж 40 тэрбум төгрөг ирэх юм. Тэр 40 тэрбум төгрөг хаана байгаа юм? 1 ч зээл олгогдоогүй байна шүү дээ. Нөгөө ЖДҮ-гийнхээ араас дахиад орчхож байгаа юм биш биз дээ айн? Тэгээд энэ ерөөсөө бүх мөнгөнүүд КОВИД-ын үед ч тэр 3 их наяд төгрөг ингээд энэ Цагаан алт янз янзын Атрын 4 дүгээр аяны хүрээнд ч маш их зээл гаргаж байна. Түүнийг нь эрх мэдлүүд аваад бүгдийг нь ББСБ-аар дамжуулаад зээлдүүлээд байх юм бол энэ Монгол Улс чинь яаж хөгжих юм? Жишээ нь тэр аймагт тэдэн төгрөг өгсөн гээд хэлээдэх дээ чаддаг юм бол. Байхгүй. Сэлэнгэ аймгаар жоохон авсан байж магадгүй. Гэтэл хамгийн их газар тариалантай.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Жадамбаагийн Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Евразийн эдийн засгийн холбоотой хийх түр гэрээнд гурилын асуудал ороогүй. Гурил хамгаалагдсан хэлэлцээрээс гадуур байгаа гэж ойлгож болно. Нэг.

Атрын 4, Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд нийтдээ 1.6 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй зээл аж ахуйн нэгжүүд дээр очиж байгаа нь үнэн. Цагаан алт хөтөлбөрийн гол зорилго арьс шир, ноос, ноолуурын үйлдвэрлэлтийн боловсруулалтын түвшнийг сайжруулах зорилготой. Жишээлбэл, Монгол Улсад арьс ширний 27 үйлдвэр ажиллаж байна. 2 үйлдвэр Дархан-Уул аймагт, 1 үйлдвэр Өвөрхангай аймагт, үлдсэн 24 үйлдвэр Улаанбаатар хотод ажиллаж байгаа.

Харин та мэдэж байгаа. Ховдод бид нар энэ арьс шир, ноос, ноолуураа боловсруулах Ховдын үйлдвэр технологийн паркийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж байгуулж байгаа. Энэ ажлаа шуурхайлж хаа хаанаа анхаараад энэ паркаа ашиглалтад оруулсны дараа энэ хөтөлбөр зээлд хамрагдах бололцоо байгаа.

Атрын 4 дүгээр аяны гол зорилго бол эрчимжсэн мал аж ахуй газар тариалангийн төгс хослолыг бий болгох, хөнгөн хүнсний үйлдвэрүүдээ баталгаат түүхий эдээр хангах ийм зорилготой хэрэгжиж байгаа. Арилжааны 10 банктай хариуцлагын гэрээ байгуулаад энэ зээл олгогдож байгаа. Өмнөх шигээ сайд мэдэж 1 төгрөгийн зээл гаргалт хийхгүй. Зөвхөн арилжааны банкууд бизнесийн зарчим, төсөл, хөтөлбөрөө шалгаруулаад, арилжааны банкууд эрсдэлээ хүлээгээд энэ зээлүүд гарч байгаа. Зээл олголт ид явагдаж байна Монгол улсын 21 аймгийн түвшинд адил, тэнцүү явагдана. Хаана үйлдвэрлэл байна, хаана газар тариалан байна тэнд энэ зээл түлхүү очиж байгаа гэдгийг хэлэхийг хүсэж байна. 10 хэд их наяд хөтөлбөрийн тухайд ямар үр дүн гарсан, хэрхэн зохион байгуулсан талаар мэдээлэл өгөх бололцоо алга.

Д.Амарбаясгалан: Пүрэвдорж гишүүн тодруулж асууя.

Б.Пүрэвдорж: Атрын 4 дүгээр аян чинь газар тариалан, хүнсний үйлдвэр, мал аж ахуйн чиглэлээр гээд 800 тэрбум төгрөг гарсан. Манай Ховд аймаг бүгдийг

нь хийж чаддаг ийм газар. Гэвч харамсалтай нь тэнд 1 ширхэг ч зээл гараагүй байна. Тэгэхээр ер нь ЖДҮ-г дэмжих зээл гээд энэ жилийн төсөв дээр 30-аад, 20 хэдээс 30 тэрбум төгрөг байгаа. Тэрний 10 тэрбум танай тойрог дээр оччихсон бусдыг нь тэгээд хохироогоод л байж байгаа шүү ер тийм бүх юмыг будилуулдаг байж байж тэгээд л тийм том том юм ярихгүй шүү гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Энэ зээл, над дээр бас Энхбаяр сайд саяхан Увсын тариаланчид ирж уулзлаа түрүүчийн 7 хоногт. Тэгээд бас зээлд хамрагдах гэсэн юм гээд ирсэн чинь Амарбаясгалантайгаа очиж уулз гээд явуулчихсан байна лээ Хөдөө аж ахуйн яамнаас. Тэр бас энэ Пүрэвдорж гишүүний ярьж байгаа зүйл бас үндэслэлгүй биш үндэслэлтэй зүйл шүү. Бас зүүн бүсийн гишүүд бас энэ дээр асуудал яриад яваад байсан. Та энэ дээр тайлбар хийгээч.

Ж.Энхбаяр: Эрхэм гишүүд ээ би ямар нэгэн аж ахуйн нэгжид зээл олго гэж хэлж чадахгүй. Хуулиар хязгаарлагдсан, бусдад давуу байдал олгосон асуудалд унана. Өмнө нь тэгээд явж байсан байж магадгүй. Одоо зөвхөн цэвэр арилжааны банкаар дамжуулаад тэр зээлийн эх үүсвэрийг ашиглалтыг арилжааны банкнууд хариуцлагаа хүлээгээд олгож байгаа. Цэвэр бизнесийн зарчмаар явж байгаа. Хэрвээ та бүхэн бодлогын зээл олго гэж надаа үүрэг өгвөл, Их Хурал шийдвэр гаргаж өгвөл тэрийг нь тэрийг зохион байгуулахад бэлэн байна. Одоо мөрдөж байгаа хууль, эрх зүйн хүрээнд үүнд зээл өг, энэ газар илүү өг, энд анхаар гэх бололцоо үнэхээр алга. Байгаа эх үүсвэр маш хязгаарлагдмал байна, эх үүсвэрээ бүгдийг нь энэ аль болох хувийн хэвшилдээ хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үүднээс зээлийн хүүгийн татаас болгож өгсөн. Үүгээр хөшүүрэгдэж байж энэ мөнгийг босгож ирж байгаа. Ингээд энэ зээл өгч байгаа арилжааны банк.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Пүрэвдорж гишүүн дахин тодруулж асууя.

Б.Пүрэвдорж: Атрын 4 дүгээр аян, Цагаан халалтын хүрээнд 1.6 их наяд төгрөг тараачихсан байна гэж байна шүү дээ. Гэтэл Ховд аймагт 1 ширхэг зээл олгогдоогүй байж байхад чинь Говь-Алтай тэр Завхан, Увс чинь бүгдээрээ л олгогдоогүй гэсэн үг байхгүй юу даа. Тэгээд 1.6 их наяд нь гарчихсан байж байж таны юм орсон л байж таарч байна шүү дээ. Айн орсон л байж таарч байна шүү дээ. Та нөлөөлөлтэй байж таараа айн? Үгүй орсон байж байгаад л энэ их 1.6 их наяд чинь гарчхаад таны хавьцаа тэр Сэлэнгэ аймгаар чинь, Дарханаар чинь оччихоод, Төв аймгаар чинь оччихоод бусад аймгууд дээр очихгүй байна шүү дээ. Ингэж төрийн мөнгөөр улс төр гэхгүй шүү та. Хариулт авахгүй.

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр: Пүрэвдорж гишүүнээ энэ үр тариа, газар тариалангийн үйлдвэрлэл явж байгаа гол бүс нутаг. 90 хувь нь энэ Дархан, Сэлэнгэ, төвийн бүс нутагт газар тариалангийн үйлдвэрлэл явж байгаа болохоор энэ зээл эндээ л очно шүү дээ. Нэг.

Ахиад хэлье бодлогоо гаргаад өг өө, батлаад өг. Тэрнээс ямар нэгэн улс төрийн албан тушаалтан энэ компанид зээл өг, энд давуу эрх олго гэх хуулиар хориотой шүү. Тийм бололцоо надаа байхгүй, тийм эрх байхгүй. Цэвэр арилжааны банкнууд эрсдэлээ хүлээгээд энэ зээлийн олголтыг хийж байгаа юм. Яамны тухайд

эх үүсвэрийг нь гаргаж өгсөн, хэрэгжүүлэх салбар бодлогыг нь тодорхойлж өгснөөс цааш оролцох хуулиар хориотой шүү. Бас нийгэмд их зөв мэдээлэл өгөх хэрэгтэй.

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя.

Х.Баасанжаргал: Сайдаас 3 асуудал дээр тодруулга асуулт, тодруулга яг тодорхой санал байр суурийг нь сонсмоор байна.

Нэгдүгээрт хэрвээ татвартай болох юм энэ улаан буудай болон гурилын чанарын үзүүлэлт хэрхэн сайжрах вэ, хяналтаа хэрхэн тавих вэ? Яагаад энэ асуултыг асууж байгаа вэ гэвэл шинжилгээнд ирсэн дотоодын улаан буудайны 70 хувь, гадаадын улаан буудайны 9.5 хувь нь шаардлага хангахгүй байна гээд. Дотоодын үйлдвэрлэлээ дэмжээд байдаг нөгөөдүүл чинь ерөөсөө чанартай гурил, улаан буудай үйлдвэрлэхгүй байгаа энэ тохиолдолд яах юм бэ? Эсрэгээрээ гадаадын энэ улаан буудай, гадаадаас орж ирж байгаа гурил чинь өөрөө чанарын шаардлага илүү хангаж байна гээд ийм судалгааны дүгнэлтүүд гараад байна.

Гурилын хувьд бол бас шаардлага хангаагүй дээжийнх нь 20 хувь нь гадаад, 80 хувь нь дотоодын гурил шаардлага хангахгүй гэдэг шинжилгээний дүгнэлт гарсан. Тэгэхээр энэ хэн нэгэн, аль нэгэн тойргийн асуудал биш. Энэ бүх Монголчуудын эрүүл мэндийн асуудал. Тийм учраас энэнд хариулт өгөөч. Бид нар татварын асуудал, татвараар зарим зүйлүүдийг дэмжлэг үзүүлж болно. Үүний та цаана байгаа чанарын асуудал ерөөсөө яригдахгүй байна. Тэгэхээр энэ дээр та тодорхой хариулт өгөөч.

Хоёрдугаарт энэ дотоодын үйлдвэрлэлийг дэмжих маш олон арга хэмжээ авлаа, зээлүүд гарлаа. Гэтэл дотоодын гурилын үйлдвэрүүдийн тоо улам цөөрөөд байдаг, улам монопол, олигопол шинж рүүгээ ороод байдаг. Энэ дээр төрийн хяналт яаж явах юм бэ? Энэнтэй холбоотой зохицуулалт ерөөсөө дагалдаж орж ирэхгүй байна.

Гуравдугаарт Баяжуулах хүнсний тухай хууль баталсан. Гурил дээр огт хэрэгжээгүй гэдэг дүгнэлт гарсан. Дахиад л нөгөө бид нар хүүхдүүдийн эрүүл мэндийн асуудал гээд л яриад л хууль батлаад байдаг хэрэгжилт ерөөсөө огт байхгүй байна.

Тэгэхээр энэ яагаад ерөөсөө хэрэгжихгүй, дотоодын үйлдвэрлэлүүд яагаад энэ баяжуулсан гурилыг ерөөсөө хийхгүй байгаа юм бэ, шалтгаан нь юу юм, зан үйлтэй холбоотой юм уу, хэрэглэгчийн зан үйлтэй холбоотой юм уу, зах зээл ашгаа хараад байдаг юм уу гэдэг дээр нарийвчилсан ийм судалгаа байна уу? Тэгэхээр би дандаа хуулийн хэрэгжилттэй холбоотой, үр дагавартай холбоотой асуулт асууж байгаа учраас маш тодорхой хариулт өгөхийг хүсье.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Жадамбаагийн Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Баяжуулсан хүнсний тухай хууль байгаа. Энэ хүнсээр дамжуулж ард иргэдэд дутаж байгаа эрдэс, витаминьг нөхөх ийм зорилготой хууль байгаа. Энийг гурилаар дамжуулж хийхээр ийм зорилготой, бас сүү болон бусад хүнсээр дамжуулах бүрэн бололцоотой. Энэ гарсан хууль маань татвараас энэ чөлөөлсөн хууль маань баяжуулсан болон баяжуулаагүй бүх гурилыг хилээр

татваргүй оруулахыг нээгээд өгчихсөн. Ингээд үндэсний үйлдвэрүүд энэ талд хийх ёстой бүх алхмуудыг зогсоочихсон байгаа юм. Шаардлагагүй болчхож байгаа байхгүй юу. Гаалиар хязгаарлалтгүй оруулаад ирэхээр чинь нөгөө дотоодын үйлдвэрүүд тэр үүргээ хүлээхээ больчихож байгаа юм.

Гурилын үйлдвэрүүд яагаад цөөрөөд байна. Өрсөлдөөн их байна л гэсэн үг. Өрсөлдөөн ширүүн байгаа болохоор, ашиггүй байгаа болохоор үйлдвэрүүдийн тоо цөөрөөд л байна. Одоо 9 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна. 2 үйлдвэр үйлдвэрээ зогсоосон байна. 5 үйлдвэр үйл ажиллагааныхаа 15-аас 20 хувь дээр үйлдвэрлэл, хүчин чадал дээр ажиллаж байна, хүндэрч байна гэдгээ мэдэгдсэн. 2-3 үйлдвэр тогтвортой байдлаа хангаад л байж байна. Нийт үйлдвэрлэлээ бид үйлдвэрлэлийнхээ хүчин чадлын 40 хувийг алдаад байна. Хүнсний хувьсгалын хөдөлгөөний үр дүнд бид нар 19, 20, 21, 22, 23 онууд дотооддоо 100 хувь тариад, дотооддоо 100 хувь үйлдвэрлэдэг байсан үйлдвэрлэл өнөөдөр 60 хувь руу уначхаад 40 хувиа гаднын зах зээлд алдаад байна. Энэ байдал цаашдаа үргэлжилбэл үндсэндээ дотоодын гурил үйлдвэрлэл тэсэж үлдэх бололцоогүй байгаа юм.

Чанарын асуудал. Энэ бол хэн гэдэг хүн ямар санаатай авсныг нь би мэдэхгүй байна. Монголын гурилын үйлдвэрийн чанар тасралтгүй сайжирч байгаа. Швейцар, Туркийн дэлхийн номерын технологиудыг манай үндэсний үйлдвэрлэлүүд суурилуулж дууссан. Гурилын чанар эрс сайжирч, гурилын төрөл баяжиж олон хэлбэрээр бүтээгдэхүүнийг гаргаж байгаа. Тариалангийн талбай, тариаланчид улаан буудайн тариалалт технологийн хамгийн сүүлийн дэвшлийг ашиглаж байгаа. Тариа цэвэр болсон, ургац тогтмол нэмэгдэж байгаа. Би энэнтэй санал нийлэхгүй. Улаан буудайн чанар ч сайжирч байна, үйлдвэрлэлийн чанар ч сайжирч байна. Энийг юу илэрхийлж байна гэвэл гурил, гурилан бүтээгдэхүүний тоо, чанар олноор бий болж байгаа. Ялангуяа маш нарийн гурил хэрэгтэй тэр бэйкери буюу нарийн боовны зах зээл хэрхэн өсөж байгааг та бүхэн харж байгаа. Гурилан бүтээгдэхүүн нэр төрөл хэрхэн олширч байгааг та бүхэн харж байгаа.

Чанарын асуудал улаан буудайн ургацтай холбоотой өөр өөр байдаг. Чанаргүй гэдэг нь юу юм, хатуулаг гэнэ үү, цавуулаг гэнэ үү, шилэнцэр гэнэ үү олон үзүүлэлт байгаа. Аль үзүүлэлт нь тухайн жилийн ургацаас хамаараад бороо хур, чийг, гангийн байдлаас хамаараад өөр өөр гардаг.

Д.Амарбаясгалан: Даваасүрэн Төсвийн байнгын хороон дарга нэмэлт хариулт өгчхөөд тэгээд дараад нь гишүүн тодруулж асууя.

Ц.Даваасүрэн: Байнгын хорооны хуралдаан дээр бас энэ газар тариалан эрхлэгч нар, мөн гурил үйлдвэрлэгч нарын чанарын асуудал бас яригдсан юм. Тэгээд энэ дээр ямар хариултууд өгч байна гэхээр бас харьцангуй техник, технологио сайжруулсан юм байна. Тэгэхээр гурилын чанарын хувьд бол их асуудал байдаггүй.

Харин тухайн жилийн ургацын байдал байгаль, цаг уураасаа шалтгаалаад бол бас улаан буудайн хувьд бол дутуу боловсрох тийм шалтгаан цавуулаг энэ тэр гардаг гэж ингэж хариулсан. Тийм учраас импортын 4 хувь нь бол гадных байсан юм билээ. Гаднын гурил будаа орж ирдэг байсан. Сая ямар хохирол учирч вэ гэхээр нөгөө импортын 4 хувь нь гадных байсан бол сая 40 хувь болчихсон

байгаа байхгүй юу. Тэгэхээр үйлдвэрлэл буурсан тэр хэмжээгээр таны хэлээд байгаа шиг үйлдвэрүүд хаалгаа барьсан байж бас болзошгүй ийм хохирол учирсан байх.

Гэхдээ ер нь үндэсний үйлдвэрлэл байдгийн ач тус бол КОВИД-ын үед нэлээн гарсан. Манайх Африк.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Даваасүрэн гишүүн гүйцээж хариулъя.

Ц.Даваасүрэн: Африкийн орнууд шиг хомсдолд ороогүй нь бол манай газар тариалагч, тариаланчдын маань бол ач тус байсан юм. Сая бид нар ингээд татвар тавьчихаар ямар хохирол учирсан байна гэхээр үйлдвэрлэл тэр импортын хувьд бол гаднын 40 хувь эзэлсэн байна.

Нөгөө талаараа 60 сая долларын бараа, бүтээгдэхүүн бид нар гурил худалдаж авсан байгаа байхгүй юу. Тэгээд энэ чинь валютын нөөцийг л бас гадагшаа сороход нөлөөлж байна гэсэн үг. Тийм учраас бид нар айлаас гуйхаар авдраа уудал атга гурил гарна гэдэг шиг бас энэ үндэсний үйлдвэрлэлээ бол хамгаалах ёстой юм байна гэдэг дээр бол бас гишүүд санал нэг байсан гэдгийг бас хэлье. Бас харьцангуй чанараа сайжруулаад ингээд явж байгаа гэдэг хариултыг өгсөн.

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултад тодруулж асууж.

Х.Баасанжаргал: Энэ Их Хурлын гишүүд сайд нарын хувьд ялангуяа энэ үнэн зөв мэдээлэл өгдөг байдал дээрээ ер нь Их Хурлын даргаа цаашид анхаарахгүй бол шал худлаа мэдээлэл өгдөг, шал худлаа ярьдаг энэ байдлыг ерөөсөө бүүр арай л хэтэрхий байдаг юм байна би. Би урьд өмнө арай ч ийм гэж бодож байгаагүй. Одоо 2018 онд, 2008 онд 19 байсан аж ахуйн нэгжүүдийн тоо 2014 онд 37 хүрээд, 15 онд өнжөөд, 16 онд буураад, 14 оноос хойш тогтмол буурсаар одоо 11 аж ахуйн нэгж үлдээд байна гээд. Энэ чинь ерөөсөө ямар ч энэ нөгөө татвартай ямар ч хамааралгүй байгаа биз дээ. Татварыг тэглэхээс өмнө аж ахуйн нэгжүүдийн чинь тоо аль хэдийн буураад, цөөрөөд монопол, олигопол шинж рүүгээ ороод байна гэдэг судалгааны дүгнэлт гараад байна. Эсвэл та нарт тэр мэргэжилтнүүд чинь худлаа мэдээлэл өгөөд байдаг юм уу? Ийм анхан шатны наад захын тоон дээр худлаа яриад байх юм.

Хоёрдугаарт тэр гурилын чанар дээр Хабул гээд лаборатори хүнсний лаборатори 200 дээж дээр шалгалт хийсэн. 148 гадаадынх.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр: Гишүүнээ гурилын үйлдвэрүүд ингээд 19 болоод 37 болоод 11 болоод байна. Энэ зах зээлийн зарчмаараа л өрсөлдөөн яваад байна шүү дээ. Одоо цөөрөөд байгааг монопол болсон гэж, олигополит зах зээл үүссэн гэж яаж хэлэх юм бэ? Яах ёстой юм? Эсвэл улс гурилын үйлдвэрүүд бариад олон үйлдвэр барих ёстой юм уу? Энэ жижигхэн зах зээл маань өөрөө бараг энэ 9 үйлдвэр чинь бодитойгоор бас л ихдэж байгаа юм. Өрсөлдөөн ширүүсэж байгаа эд нар. Эд нар ямар ч хуйвалдах, үнэ өгсөх бололцоо байхгүй. Өрсөлдөөн ширүүн байна шүү дээ.

Тэгээд 1 жоохон юм хийж байгаа үйлдвэрүүдээ ингээд урмыг нь хугалаад, нурууг нь дараад болимоор байна. Энэ жам ёсоороо л өрсөлдөөн яваад л байж байна. Монголын зах зээлд 9 үйлдвэр гэдэг хангалттай. Нэг.

Чанарын асуудал хар аа гурил ингэж байгаа юм. Жил жилийн нөгөө цаг уурын нөхцөл, газар зүйн онцлог.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Байз Энхбаяр сайд аа, энэ гишүүдийн хэлж байгаа бас яг статистик бодит мэдээлэл дээр тулгуурлаж хэлээд байгаа байхгүй юу. Үйлдвэр 37 үйлдвэртэй байсан 2019 онд 11 үйлдвэр болтлоо буурсан байгаа юм. Үр дүнгээр нь юу болчихоод байна вэ гэхээр байна шүү дээ Энхбаяр сайд үнэ тогтоодог монопол, олигопол зах зээл өөрөө бодитой бий болчихжээ. Сонголт байхгүй болчихсон. 2 том үйлдвэр нийлээд 50-аас дээш хувь, 3 том үйлдвэрийн үйлдвэрлэл нь нийлээд нийт зах зээлийнхээ 78 хувийг үйлдвэрлэдэг болчихсон. Улмаар үгсэн хуйвалдаж үнээ нэмдэг болсон гэдэг мэргэжлийн байгууллагын дүгнэлт нь удаа дараа гарсан.

Жишээлбэл, ШӨХТГ 2023 онд гурилын үнэ 2021 оноос 78 хувиар өссөн учраас үгсэн хуйвалдаж, үнээ нэмсэн байна гэдэг дүгнэлтийг гаргасан. Тухайн үед нь гурилын үйлдвэрүүд ШӨХТГ-ын шийдвэрийг шүүхэд өгөөд зогсоолгосон. Төрийн гарсан мэргэжлийн агентлагийн гаргасан шийдвэрийг шүүхэд өгөөд 2 жил зогсоолгоод 2 жилийн дараа шүүхийн шийдвэр гарч байгаа юм.

Тэгэхээр тухайн цаг үед нь үнэ нэмэгдэж байсантай төр тэмцэх гээд тэгэхээр шүүхэд өгсөн хэлбэрээр энэ шийдвэрийг зогсоочихдог, эргээд зах зээл нь өөрөө олигопол хэлбэрээр яваад байгаа юм. Түүнээс дотоодын үйлдвэрлэлийг энд муу байна, дотоодын үйлдвэр байх хэрэггүй гэж үзэж байгаа 1 ч гишүүн гарахгүй. Гол нь энэ зах зээлээ яаж зохицуулах юм бэ? Мэдээж салбараа хамгаалах ёстой, тариаланчдаа хамгаалах, ёстой үйлдвэрүүдээ хамгаалах ёстой. Гэхдээ энэ бүгдийн цаана нь бид төр хэрэглэгчийнхээ эрх ашгийг хамгаалах ёстой. Үйлдвэр байж байвал хэрэглэгчид үнэтэй бүтээгдэхүүн хэрэглэдэг байж болно гэдэг ойлголтоор бид асуудалд хандаж ерөөсөө болохгүй. Тэгвэл хэрэглэгчдийн гар дээр очих гэж байгаа бүтээгдэхүүн яавал чанартай, яавал хямд, яавал зах зээл дээр нь өрсөлдөөн байх юм бэ гэдэг асуудлыг бид ярих ёстой байхгүй юу.

Өнөөдөр та хөдөө сум дээр яваад очиж үзсэн байх. Хөдөө сумын төвд амьдарч байгаа иргэнд ямар ч сонголт байхгүй. 3500 төгрөгийн үнэтэй 1кг 1 дүгээр гурилыг авахаас өөр сонголт тэр хүнд байхгүй. Эмийн санд яваад орно өөр ямар ч сонголтгүй тэр эмийн санд байгаа эмийг л худалдаж авах боломжтой. Тэр эм нь хэдэн төгрөг байх нь тухайн байгууллагын л асуудал. Түүнээс хэрэглэгчид сонголт гэдэг зүйл байхгүй байна шүү дээ. Тэгэхээр энэ иргэдэд өнөөдөр тулгамдаж байгаа асуудал бол үнийн өсөлтийн асуудал. Сүүлийн хэдэн жил иргэдийн дунд тулгамдсан асуудлыг дандаа үнийн өсөлт л гэж нэрлэж байгаа юм. Тэгэхээр энэ үнийн өсөлтийг бид яаж зохицуулах юм бэ л гэж байгаа юм. Тэгэхээр салбарынхаа мэдээж эрх ашгийг хангах ёстой, салбараа хамгаалах ёстой энэний цаана хэрэглэгчийн эрхийг яаж хамгаалж үлдэх юм бэ?

Жишээлбэл, хар аа 2023 онд энд Монгол Улсад гурил үйлдвэрлэдэг гурилын үйлдвэрүүдийн ажилласан байдал нь нийт хүчин чадлынхаа 33 хувь, 33 хувиар л ажилласан. Татвартай байх үед шүү дээ. 2024 онд гурилын үйлдвэрүүд

25 хувийн хүчин чадлаараа ажилласан. Энэ чинь юу гэсэн үг юм бэ гэхээр өнгөрсөн цаг хугацаанд магадгүй салбарын бодлого гурилын үйлдвэрүүдэд олон төрлийн хөнгөлөлттэй зээл, дэмжлэгүүдийг өгсөн. Энэний үр дүнгээр магадгүй олон үйлдвэрүүд гарч ирсэн. Суурилагдсан хүчин чадал нь найм, есөн зуун мянган тонн гурил үйлдвэрлэх хэмжээнд хүрчихсэн байгаа.

Гэхдээ өнөөдөр яг бодит байдал дээр 25-30 хувь нь л ажиллаж, үйлдвэрлэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг шууд татвар тэглэсэнтэй холбож тайлбарлаад өнөөдөр гурилын үйлдвэрүүд шууд дампуураад унаж байгаа юм шиг байдлаар ярих нь бол зохисгүй юм. Гурилын үйлдвэрүүдээ хамгаалах ёстой. Гэхдээ хэрэглэгчийн эрхээ яаж хамгаалах юм? Та энэ дээр бүүр бодитой сайхан тайлбар хийгээдхээч.

Ж.Энхбаяр: Би гишүүддээ үнэ танилцуулъя. Үйлдвэрийн үнэ шүү. Миний хариуцах хүрээнд улаан буудайн тариалалтыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилготой. Алтан тариа компанийн 1 дүгээр гурил яг одоо үйлдвэрийн үнээр 1500 төгрөгт гарч байна. Од групп 1530, Милл хаус 1520, Хангай Миллс 1800, Өгөөж гурил 1760, Улаанбаатар гурил 2050, Өег гурил 1930, Дорнод гурил 1790, Хөвсгөл Алтандуулга 1830. Гурил хямдхан байгаа. Үнэ нэмэгдэлт өөр газар явагдаж байгаа. Тээвэр дээр нэмэгдэж байна. Мянга мянган км тээж байна. Ийм хямдхан барааг үнэтэй тээврээр тээгээд мянган км очоод тэр сумын төвд очихоор тээврийн өртөг, дэлгүүрийнх нь өртөг, зардал, хөрөнгө оруулалт нэмэгдээд л явж байгаа байх гэж бодож байна. Энэ миний асуудал биш. Би улаан буудайгаа тариулаад үйлдвэрүүд маань ард түмнээ тасралтгүй, чанартай хүнсээр хангах зорилгоор л хэрэгжүүлж байна. Дундаж энэ 1500 гэсэн үнэ бол маш боломжийн үнэ. 1 тонн улаан буудай тариаланчдаас 800-аас 1'000'000 төгрөг авч байгаа улаан буудайг тээрэмдээд 1500 төгрөгийн гурил гаргана гэдэг боломжийн. Энд ямар ч олигопол, үнэ хуйвалдсан, үгссэн зүйл байхгүй гэдгээ хариуцлагатай хэлье. Мянга мянган оролцогчтой, олон бэлтгэн нийлүүлэгчээс хамааралтай энэ зах зээл маш сайн шударга өрсөлдөөнийг хангаж байгаа гэж хэлэх хэлэхийг хүсэж байна.

Үнэ өөр. 30-40 хувийн нэмэгдэл тээвэр худалдаан дээр нэмэгдэж байгаа шүү. Энд анхаарал тавиач. Тэрнээс тариа тарьж байгаа тариаланч энийг боловсруулж байгаа үйлдвэрлэгчид асуудал байхгүй. Энэ Монгол Улсын хувьд бидний онцлог шүү дээ. Үнэхээр өргөн дэлгэр байна, зам харилцаа сул байна, хол явж байна тэр талаас нь хараад үзээч. Суурь салбар болсон энэ тариаланч үйлдвэрлэл рүүгээ эргэж ноцоод байж ердөө болмооргүй байна.

Д.Амарбаясгалан: Одоо гурилын үнэ яах вэ үйлдвэрийн үнэ гээд бас үнэ байгаа. Улаанбаатар хотод тэгээд яагаад 1 дүгээр гурил 2800 төгрөг хүрчихсэн байгаа юм? Одоо ер нь бол энэ нийт ард иргэдийн яг үндсэн хэрэглээ бол гурил шүү дээ. Магадгүй илүү чинээлэг хэсгийн хэрэглээ бол гурил эрс багассан байх. Гэхдээ яг гурилтай холбоотой хэрэглээтэй энэ үнийн асуудал байгаа байхгүй юу. Орон нутгийг бас ойлгож болно. Гэхдээ өнөөдөр жишээлбэл зарим нэг хилийн бүсээс хол аймгуудад гурилын үнэ дэндүү өндөр байгаа. Жишээлбэл, Төв аймгийн Улаанбаатар хотыг тойрсон сумуудад улсын хэмжээнд хамгийн өндөр үнэтэй гурил хэрэглэж байна. Аймгуудаас ярих юм бол дунджаар Хэнтий аймаг хамгийн өндөр үнэтэй гурилыг хэрэглэж байна.

Тэгэхээр энэ үнэтэй гэж байгаа үг чинь таны саяын хэлсэн үйлдвэрээс мянга тав, зургаан зуун төгрөгөөр гарч байгаа юм бол яагаад зах зээл дээр очихоороо 3500 хүртлээ үнэ нь нэмэгдээд байгаа юм бэ л гэдэг асуудал шүү дээ. Яг өнгөрсөн жил энэ татвар тэглэхтэй холбоотой асуудал ярьж байхад манай Идэрбат гишүүн хэлж байсан санагдаж байна 2023 оны хавар 50кг-ын шуудайтай гурил 65 мянган төгрөг байж байсан чинь 2024 оны хавар 4 дүгээр сард ирэхэд 50кг-ын шуудай гурил 120 мянган төгрөг, цаашлаад бүүр 140 мянган төгрөг хүртлээ үнэ өслөө гэдэг асуудал чуулган дээр яригдаж байсан юм. Яг бодитой амьдрал дээр. Тэгэхээр энэ чинь өөрөө нэгхэн жилийн дотор тэр өсчихсөн зохицуулалт дээр ямар тайлбар байх юм бэ? Энийг яагаад аажмаар зохицуулалт хийгдэж чадаагүй юм бэ гэдэг асуудал байхгүй юу.

Хоёрдугаарт нь энэ Болорчулуун дарга энэ дээр нэмэлт тайлбар хийчхээч. Би бас гишүүдийг мэдээлэлтэй болог гэж бодож байгаа юм. 2021 оноос 2020 оноос эхлээд гурилын үйлдвэрүүд хөнгөлөлттэй зээл хэлбэрээр нийт дүнгээрээ 220 тэрбум төгрөгийн зээл авсан. Хөрөнгө оруулалт хийх зорилгоор. Зээл авахдаа байгуулсан гэрээг нь тухайн үед харж байхад гурилын нийлүүлэлтийг бууруулахгүй, үнэ нэмэгдүүлэхгүй гэсэн гэрээний заалттайгаар хөнгөлөлттэй зээлийг төрөөс авсан байдаг. Зарим үйлдвэрүүд нь авсан зээлээ гурилын үйлдвэрлэлийн сайжруулахад зориулаагүй өөр зүйлд зарцуулсан байсан нь ч бас тухайн үеийн шалгалтаар илэрч байсан. Тэгэхээр энэ дээр энэ зах зээл яагаад энэ 1 жилийн дотор үнэ 78 хувиар нэмэгдсэн юм бэ гэдэг тайлбарыг бас ярих нь зүйтэй. Бид өнөөдөр энд татварыг тавина, тавихгүй гэж ярьж байгаадаа гол нь биш учир шалтгаан нь яг юу байсан юм, өнөөдөр бид энэ шийдвэрийг гаргавал тэр учир шалтгаан арилсан юм уу, үгүй юү гэдэг дээр л бид тогтож ярих ёстой байхгүй юу. Тэгэхээр энэ дээр Болорчулуун дарга тайлбар хийгээдэх. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Ц.Болорчулуун: Улсын Их Хурлын даргын асуултад хариулт өгье. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун.

Тэгэхээр гурилын үйлдвэрүүд хөрөнгө оруулалт хийсэн, технологи сайжирсан, тоног төхөөрөмжөө сольсон, дэлхийн шилдэг тоног төхөөрөмжүүдээр бүгдээрээ шинэчлэл хийж чадсан. Гурилын үйлдвэрүүдэд олгож байгаа энэ эргэлтийн хөрөнгийн зээл жилдээ 100 орчим тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээлийг олгож байгаа. 100 тэрбум төгрөг гэдэг 80-100 мянган тонн буудайг худалдаж авах л ийм мөнгө байгаад байгаа. Бид жилдээ 400 мянган тонн буудай авлаа, ургац хурааж авлаа гэж тооцох юм бол энэний 1/4-тэй тэнцэх хэмжээний ийм эргэлтийн хөрөнгийн зээлийг сүүлийн жилүүдэд гурилын үйлдвэрүүдэд олгож байгаа. Энэ нь 1 жилийн хугацаатай ийм зээлийг олгоод, намрын ургацаас тариаланчдын буудайг худалдаж аваад тэгээд жилдээ багтаагаад буцаагаад банкныхаа зээлийг төлдөг. Сүүлийн жилүүдэд ерөөсөө л бид нар энэ Засгийн газар дээр тавигдаж байгаа хүүгийн татаасаар арилжааны банкны эх үүсвэрт тулгуурласан ийм зээлийг гурилын үйлдвэрүүдэд олгож байгаа. Энэний үр дүнд тариаланчдын борлуулалт нэмэгдэж байгаа. Улаан буудайн борлуулалтыг дэмжиж байгаа л ийм хэлбэр. Хөрөнгө оруулалт тал дээр өөрсдөө бас гурилын үйлдвэрүүд хөрөнгө оруулалтаа хийсэн, технологио сайжруулсан чанарын хувьд ямар ч асуудалгүй болсон нь зэрэг нь бол өөрсдийн тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтын үр дүн гэж ингэж харж байгаа.

Өнгөрсөн жилийн орж ирээд байгаа Оросын Холбооноос орж ирж байгаа гурил бас яг үнийн хувьд өөрөө 2 янзын үнэтэй байгаа. Нэгдүгээрт нь яг улсын стандарт хангасан гурил нь манай дотоодын үйлдвэрүүдийн үнэтэй ойролцоо буюу 1700, 800 төгрөгөөр орж ирж байсан. Энэ нь энэ ГОСТ стандартыг хангасан гурил орж ирээд байгаа. 1300-1400 төгрөгт зарагдаад байгаа гурил нь бас тэр гурилын үзүүлэлтүүдийн 1-2 үзүүлэлтийг хангахгүй байгаа, техникийн нөхцөл хангасан ийм гурилууд орж ирээд байгаа. Энэ дээр бас чанарын 2 өөр зөрүүтэй байдал байгаа учраас би мэдээж тодорхой хэмжээний хэрэглэгчид үнэ хямдыг нь сонгож байгаа хэдий боловч яг үйлдвэрлэл дээр, цайны газар дээр, нарийн боовны цех дээр энэ ТУ нөхцөлийг хангасан энэ гурилууд төдийлөн борлуулалтгүй 1 удаа аваад эргэж авахгүй байна гэдэг тал дээр бид нар бас зах дээгүүр явж судалгаа хийхэд ийм асуудалтай бас тулгарч байсан гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Даваасүрэн гишүүн Төсвийн байнгын хороон дарга хариулт өгье.

Ц.Даваасүрэн: Тийм Байнгын хороон дээр яг ийм хэлэлцүүлэг болсон юм. Тэгээд ер нь энэ энэ дээр 2 зүйлийг бол бас анхаарах ёстой юм байна лээ. Энэ үнэтэй холбогдолтойгоор.

Нэгдүгээрт бол энэ гурилын татвар чинь 5-хан хувь, 5-хан хувийн л асуудал байгаа байхгүй юу. Тэрнээс тэр 30, 40 хувийн асуудал биш. Тэгэхээр хаанаасаа 30, 40 хувийн хямдрал гараад ирэв гэдэг асуудал. Тэгээд энэ ерөөсөө тээврийн зардал. Баруун аймаг Оросоос авчхаж байгаа учраас тээврийн зардлын л зөрүү гарч ирж байгаа. Тэрнээс биш импортын татвар айтхар нөлөөлөөд 30, 40 болгочихсон гэж бас үзэх буруу юм байна лээ.

Хоёрдугаарт ерөөсөө КОВИД-ын дараа бүх юмны үнэ 2 дахин өссөн юм байна лээ. Ганц гурил ч биш юм байна лээ. Тэгэхээр энийг бас бид нар анхаарах ёстой. Ерөөсөө КОВИД-ын дараагаас эхлээд энэ юуны үнийн сагсны үзүүлэлтэд ерөөсөө бүх барааны үнэ үндсэндээ 2 дахин өсөөд ингээд явчихсан юм байна лээ.

Д.Амарбаясгалан: Болорчулуун дарга хариулах уу, Энхбаяр сайд хариулах уу? Жишээ нь өнгөрсөн жил Улсын Их Хурал бараг Батжаргал гишүүн санаачилсан байх. Мэдээж татвартай холбоотой асуудал ингээд явж байгаа юм бол экспортод гаргах бодлогыг дэмжээч ээ, гурилаа экспортод гарга, үр тариагаа экспортод гарга гэдэг зүйлийг Улсын Их Хурлаас тогтоол батлаад өгчихсөн. Би түрүүн хэллээ шүү дээ. Монголд өнөөдөр суурилагдчихсан байгаа хүчин чадлынхаа 25-30-хан хувьд нь үйлдвэрүүд ажиллаж байна. Тэгэхээр тэр үйлдвэрүүдэд асар том боломжууд байгаа байхгүй юу. 100 хувь үйлдвэрлэнэ гэх юм бол бараг манай дотоодын үйлдвэрүүд 800 мянган тонн гурилыг үйлдвэрлэх хүчин чадал нь байгаад байгаа юм. Хүчин чадал нь байна. Тэгэхээр энэ илүү үйлдвэрлэж байгаа гурилыг яагаад экспортод гарах бодлогыг та нар дэмжиж өгөхгүй байгаа юм бэ? Зөвхөн дотоодын зах зээл дээр хэрэглэгчдийн нуруун дээр л бүх ачааг үүрүүлэх гэж байгаа юм шиг бодлого явж байгаа чинь өөрөө хэрэглэгчийн эрхийг зөрчиж байгаа асуудал юм л гэдэг өнцөг гарч байгаа юм.

Хоёрдугаарт нь 2021-24 онд гурилын үйлдвэрүүдэд нийт дүнгээрээ 212.4 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл өгчихсөн. Тэр хөнгөлөлттэй зээлийн бодлого

чинь өөрөө энэ гурилын үйлдвэрлэлүүдийнхээ хүчин чадал, зах зээлийнхээ багтаамж энэ бүх зүйлийг тооцож өгсөн зээл байдаг юм уу? Ерөөсөө үйлдвэр болгон ингээд зээл аваад амь зогоож гэдэг байдлаар өгөөд байгаа юм уу? Ахиад жил болгон 100 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээл өгдөг гэж байна. Гэтэл гурилын үйлдвэрүүдийн худалдаж авдаг үр тарианы зах зээл чинь өөрөө 225 тэрбум төгрөгийн зах зээл. Нэг ёсондоо гурилын үйлдвэрүүд тэгвэл 50 хувь нь төрөөс авсан хөнгөлөлттэй зээлээр бизнес хийж байна шүү дээ жил болгон. Тэгээд энэ чинь өөрөө зөв юм уу? Тэгээд энэнийхээ үр дүнгээр хэрэглэгчдийн гар дээр яагаад хямд өртөгтэй бүтээгдэхүүн очихгүй байгаа юм бэ л гэдэг асуудал энд яригдаж байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр тодруулаад хариулаад өгчхөөч. Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Монгол Улс болон Бүгд Найрамдах Хятад Улсын эрх бүхий байгууллага хооронд байгуулсан гурил экспортлох үеийн хяналт шалгалт, хорио цээрийн шаардлагын тухай ийм протоколтой байдаг. Үүгээр бид өнөөдрийн байдлаар 12 аж ахуйн нэгж БНХАУ-д гурил экспортлох эрхтэй бөгөөд экспортын гол 23 онд зургаан зуун нойл аравны зургаан мянган тонн буюу 600 кг гэсэн үг, 24 онд 1400 тонн, 25 оны байдлаар 240 тонн гурил экспортолж чадсан. Үнэхээр БНХАУ маань жилдээ 600 сая тонн үр тариа авдаг газар тариалангийн гайхалтай орон. Хойд хөрш маань өөрөө дэлхийн улаан буудайн гол үнэ тогтоогч. Дэлхийн улаан буудайн 20 хувийг дангаараа нийлүүлдэг ийм 2 улсын дунд бидний жилдээ 3, 400000-хан тонн улаан буудай тариад ургуулаад дотооддоо үйлдвэрлээд байгаа л ийм бодит амьдрал шүү дээ.

КОВИД-ын сургамж. КОВИД ахиад хил гааль 1 сарын хугацаагаар сунгахад Монгол Улс картын бараанд орж байсан. Өөр аргагүй байсан. Яагаад гэвэл хүнсний хангамж тийм сул байсан. Ийм учраас үйлдвэрлэлүүдээ яаралтай босгоё, энэ Хүнсний хувьсгал гээд төрийн тэргүүний санаачилсан хөтөлбөр чинь 19 нэр төрлийн хүнсийг дотооддоо бид нар хийе ээ, тарья, ургуулъя, бүтээе гэж л зорилго шүү дээ. 19-хөн нэр төрөл. Тэрний онцгой нэг нь гурил, гурилан бүтээгдэхүүн, улаан буудай байхгүй юу нэг хэсэг. 90 оны сургамж яг ийм шийдвэр гарсан, салбар унасан, аж ахуйнууд татан буугдсан, талбай зэрлэгшсэн, эрчимжсэн аж ахуй нөгөө нэгдлүүд тойроод байсан нэгдлүүд нь бүгд тарсан.

Ингээд 100 хувь гаднаас гурил гуйдаг болсон. Бүх төрийн тэргүүнүүд гадаад явахдаа гурил өгөөч, улаан буудай өгөөч гэдэг болсон. Гуравдагч орноор тусламжаар улаан буудай авдаг болсон. Энийг өөрчилье гээд л энэ 2008 оноос Атрын 3 дугаар аяныг өрнүүлээд ямар ч байсан дотооддоо энэ гурилаа хангах нь онцгой чухал юм байна. Гурил бол стратегийн бүтээгдэхүүн юм гэдгийг дахин сайн ойлгоод ингээд л явж байгаа ажил шүү дээ. Дөнгөж хөлөөр, хүүхдээр хөл тэнцээд ингээд жигдэрч байна. Тариалан босоод ирэхээр чинь энэ эрчимжсэн аж ахуй, гахай, тахиа, шувуу, өндөг, сүүний аж ахуй чинь бас дагаж овоо босоод байна шүү дээ. Яг энэ үед нь хамгийн суурь болсон газар тариаланг унагаана гэдэг бол энэ дагаад бүх хөнгөн үйлдвэрийн салбарыг, хүнсний үйлдвэрийн салбарыг унагаана л гэсэн үг.

Тэгэхээр 90 оны тэр сургамжийг ахиж санаач. КОВИД-ын нөхцөл байдлыг эргэж санаач. Энэ аюулгүй байдлын асуудал. Баталгаатай эх орны бүтээгдэхүүнээр ард иргэдээ хангах бодлого шүү дээ. Ахиад цөөхөн бараа шүү 19-хөн төрлийн бараа.

Д.Амарбаясгалан: Мэдээж 90 оны нөхцөл байдал өнөөдрийн нөхцөл байдал 2 их өөр түвшинд оччихсон л доо. Өчигдөр олон улсын мэдээллээр гарч байсан гишүүд бас харсан байх. Япон Улсад сүүлийн 2 жилийн дотор гол үндсэн хэрэглээ болсон цагаан буудаа үнэ нь 2 дахин нэмэгдсэн учраас импортынхоо нөхцөлийг хөнгөлөөд татваргүйгээр БНСУ-аас их хэмжээний цагаан буудай импортлох шийдвэрийг өчигдөр гаргасан байна шүү дээ жишээлбэл. Өнөөдөр Монгол Улсад 1 тонн улаан буудайн дундаж үнэ 200-250 долларын өртөгтэй байна, үнэтэй байна.

Гэтэл дэлхийн зах зээл дээр 119, 120 долларын үнэтэй байж байгаа байхгүй юу. Тэгэхээр яагаад бид энэ зах зээлийг өөрөө ингэж дэлхийн зах зээлтэйгээ ойролцоо түвшинд явуулах нөхцөл, боломжийг бүрдүүлж чаддаггүй вэ л гэдэг асуудлыг энд яриад байгаа юм. Түүнээс ерөөсөө нэг зүйлийг маш сайн ойлгох ёстой. Үндэснийхээ үйлдвэрлэлд дургүй 1 ч Улсын Их Хурлын гишүүн байхгүй, хэрэглэгчдийнхээ нуруун дээр хүнд ачаа үүрүүлэхгүй гэсэн иргэдээсээ сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд энд асуудалд хандаж үг хэлээд л сууж байгаа юм. Тэгэхээр энэ байдлаа бол бид гол нь зөв гарцаа яаж олох юм бэ л гэдэг асуудал байхгүй юу. Өнгөрсөн жилийн өдийд нөхцөл байдал ямар байсан, өнөөдөр ямар болсон, цаашдаа бид яг яаж явах юм бэ л гэдэг асуудлыг шийдэх гэж байгаа л гэж харж байгаа.

Тийм учраас өнөөдөр Засгийн газраас өргөн барьсан энэ асуудлыг Улсын Их Хурлаар хэлэлцээд явъя гээд өнөөдөр Улсын Их Хурал дээр хэлэлцэх эсэхийг шийдвэрлэхээр хэлэлцүүлэг болж байгаа юм.

Ингээд Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуултаа асууя.

Ц.Идэрбат: Өглөөний мэнд хүргэе. Одоогоос яг 1 жил хүрэхгүй хугацааны өмнө бид нар эргэж очих ёстой болчхож байгаа юм. Энэ удаагийн парламент 126 гишүүнтэй 81 шинэ гишүүн байгаа. Тэгэхдээ өнгөрсөн парламент одоогоос яг жил хүрэхгүй хугацааны өмнө энэ гурилын энэ татварын асуудал яригдахдаа дөнгөж сая Энхбаяр сайдын ярьдаг шиг өвлийг, хаваржилтыг өнтэй давах гэж зорилгоор хийсэн энэ тэр гэж тийм зүйл огт биш шүү дээ. Та яагаад ингээд худлаа яриад байгаа юм. Наадах чинь Их Хурлаар орохдоо нэгдүгээрт гурилын үнэ өсөөд байна КОВИД-ын үед ингэсэн ингэсэн байна.

Гэхдээ гурилын үнэ өсөж байгаагаас шалтгаалаад, шалтгаалаад барааны үнэ өсөөд байна. Тэр дундаа тэр нь инфляцад нөлөөлөөд байна, инфляцад нөлөөлөөд байгаа учраас бодлогын хүү өндөр байгаад байна гэж. Монголбанкны мөнгөний бодлогын танилцуулахад наадах чинь орж ирсэн асуудал байхгүй юу. Тэгэхээр энэ гурилын үнийн асуудал зөвхөн кг гурилын асуудал биш.

Цаашаа Монгол Улсын инфляцын асуудал болоод явчихдаг ийм өргөн цар хүрээг хамардаг юм билээ. Өнөөдөр гурилын үнэ тогтворжсон гэж ярьж байгаа нь магадгүй энэ хуулийн гавьяа байх гэж би боддог. Тухайн үед юу болсон бэ гэхээр юмны үнэ өсөөд байна, энэ хэдэн гурилын үйлдвэрүүд хуйвалдаад байна гээд л ШӨХТГ-ынхан дүгнэлт гаргасан. Бид нар хуйвалдаагүй гээд л шүүхэд өгсөн. Тэгээд өнөөдөр яг тэрнийхээ ард гарсан юм ердөө юу ч байхгүй зүгээр бараг өвөл, хавар өнгөрчихсөн юм чинь гэдэг утгаар ингэж танилцуулж бас болохгүй л дээ.

Тэгэхээр би эндээс нэг зүйл асуух гээд байгаа юм. Ер нь ингээд гурилын үйлдвэрийнхэнд ч тэр улаан буудайнханд ч тэр энэ монгол төрийн бодлого жоохон ойлгомжтой баймаар байгаа юм. Жилийн өмнө болохоороо татварыг нь ингээд л нэмээд л, гурилын үйлдвэрийнхнийг хэцүү байдалд оруулаад л улаан буудай тариалагчдыг эвгүй байдалд оруулаад л тэгснээ одоо ингээд энийг нь болино гээд л. Магадгүй жилийн дараа дахиад наад юмны гурилынхаа үнийг дийлэхээ болиод дахиад төр нь олигопол, монополоо ч дийлэхээ болиод ингээд буулгахаар болох юм уу? Тэгэхээр би гурилынхан ч тэр, улаан буудайнхан ч тэр бүх юм тодорхой баймаар байгаа юм гэж ингэж хэлэх гээд байгаа юм. Энэ гурилын үйлдвэрүүд цөөрлөө л гэнэ, хүчин чадлаа буурууллаа л гэнэ. Өнгөрсөн хавар энэ 2 сард шүү дээ. Дорнодод явж байхад Дорнод гурилынхан хүчин чадлаа 25 хувиар манайх нэмэгдүүлж байна гэж ярьж байна лээ шүү дээ. Дорнод гурил шүү. Тэгэхээр ингээд яамны ярьж байгаа юм амьдрал дээр 2 ингээд жоохон зөрөөд байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт улаан буудай тариалагч нар тухайн үед бас маш их гомдолтой байсан шүү дээ. Үйлээ үзээд хаврын хавсарганаас намрын хяруу хүртэл тарьдаг нөгөө үйлдвэрүүд нь авдаггүй. Одоо энийгээ яах вэ гэдэг. Тэгэхээр энэ дээр ер нь яам яг ямар бодлого гаргаад байгаа юм? Дахиад ингээд тариад маш их хэмжээний буудай авлаа тэрийгээ тэгээд яах юм? Яг энэ үеэр дараагийн нэг асуудал тэр Ургамал хамгааллын ерөнхий газар гэж гаргаад манайх улаан буудайгаа экспортлох боломжтой гээд бүүр агентлаг нэмээд 20, 30 хүний бүрэлдэхүүнтэй юм байгууллага бас л бөөн хэл ам болж байгаад нээсэн. Энэ одоо яах юм? Тэгэхээр бид ингээд юмыг зүгээр ингээд энэ чинь бас төрийн бодлого байна даа энэ чинь. Тэгээд л 1 жил болоод л нэг юм гаргадаг. Жилийн хүрэхгүйн дараа дахиад л өөр юм ярьдаг. Одоо наад гурил үйлдвэрлэгч тэр, тариаланч тэр жилийн дараа яаж ч магадгүй гэсэн хярсан байдалтай л байгаа шүү дээ. Тэгэхээр би энэ юу хэлэх гээд байна гэвэл юмыг ийм уг шугаар нь яриач. Зүгээр ингээд ийм өнгөцхөн өнгөцхөн юм яриад л. Жилийн дараа гурилынхаа үнийг дийлэхгүй бол энэ танхим тэгээд л дахиад л татвараа ярина шүү дээ. Тэгэхээр би энэ яамныхнаас нэгдүгээрт жилийн өмнө үүссэн нөхцөл байдлыг арилгах талаар юу хийсэн юм бэ? Хоёрдугаарт энэ тариаланчдыг гадаад зах зээл рүү гаргахад зориулж юу хийж байгаа юм бэ? Нөгөө хэл амтай байгуулагдсан тэр агентлаг яг энэ тал дээр юу хийж байгаа юм бэ? Ингэж байж бид нар энэ салбарын хөгжил ярихаас биш төсвийн мөнгөөр хэдэн зуун тэрбумаар нь өгөөд үнэтэй гурил идээд ингээд явна гэдэг чинь.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр: Та гавьяаны асуудлыг яриад байна. Үнэхээр үнэ бол тодорхой хэмжээнд унасан, тогтворжсон, 24 оны ургац боломжийн гарсан. Одоо нөөц шинэ ургац хүртэл асуудалгүй, үнэд ямар нэгэн өөрчлөлт гарахгүй тогтвортой байдлаа хангаж чадсан. Тэгэхээр энэ хууль гаргаад хуулиар ингээд түгжчихээр Засгийн газрын шуурхай байдал алдагдаад байгаа юм. Өмнө нь яадаг байсан гэвэл гурилын үнэ өсгөнгүүт зохицуулалтын арга хэмжээ Засгийн газар шуурхай аваад үнээ тогтворжуулдаг, нийлүүлэлт дутахаар шуурхай арга хэмжээгээр нийлүүлэлтээр идэвхжүүлдэг гэх мэтийн ийм хурдтай зохицуулалт хийх орон зайг хаагаад хуульчлаад өгчихөөр ингээд бүтэн жилдээ өөрчлөлт орж чадахгүй. Одоо шатах, тослох материал дээр чинь Засгийн газар маш хурдтай ажиллах ийм

бололцоотой байдаг байхгүй юу. Тэгвэл яг энэ шиг ингэж битгий зохицуулаач. Засгийн газарт зохицуулалт хангах эрхийг нь л өгчхөөч гэж байгаа юм.

Тэгвэл бид нар хаана үнэтэй байна, хаана инфляцад нөлөөлж байна, хаана нийлүүлэлтийг нэмэх вэ, импортоо нэмэх үү, экспортоо нэмэх үү, импортоо татах уу, экспортоо татах уу гээд зохицуулалт хийгээд эвтэйхэн аваад гарчихна шүү дээ. Одоо та бүхэн анзаарч байгаа нийслэл хотын махны нийлүүлэлт маш тогтвортой үнэ унаад эвтэйхэн болоод ямар нэгэн хэл ам гарахгүй гарчээ гэдэгтэй адилхан ийм зохицуулах эрхээ л бид нар хурдан өгөөч. Хууль гараад түгжчихээр ингээд бүтэн жил болж байж энэ хугацаанд чинь ингээд гадаад орчин чинь байнгын ингээд огцом огцом савлагаа үүсээд байна шүү дээ. Энэ болгонд чинь бид нар дагаж ингэж хөтлөөд энэ нь өөрөө улс төр болоод байгаа юм. Энийг тэгэхгүй Засгийн газар асуудлаа шийд, бүсийн бодлого, төвийн бодлого тариалалтын бодлогоо шийдээд яв л гэвэл их амар баймаар байна л даа. Тэгэхээр тэрийг их сайн ойлгомоор байна.

Тэгэхээр ер нь аль болох л тариалалтыг урамшуулах, улаан буудайн тариалалтыг нэмэгдүүлэх нь л онцгой чухал байна. Яаж ч магадгүй нөхцөл байдал байгаа юм. Улаан буудай 5 жил болоод улаан буудайг тээрэмдэхэд гурил гардаг. Ер нь дэлхийд байгаа ганцхан бүтээгдэхүүн. Тийм болохоор стратеги мууддаггүй хүнс байхгүй юу. Тэгэхээр бүх улс орон улаан буудайн тариалалд анхаарч нөөцөлдөг. Тэгэхээр Монгол Улсын бид нарын энэ багахан хэмжээний 3,400-хан мянган тонн улаан буудайнхаа юмыг дотроо хэл амгүй тариад, нөөцлөөд ингээд явж баймаар байна.

Ер нь мах, гурилын тогтвортой байдал гэдэг ер нь өөрөө нийгмийн амьдралын гол суурь шүү дээ. Тэгэхээр энийг битгий улс төржүүлээд ингэмээр байна л гэж би хүсээд байгаа юм. Одоо тариалалт эхлэх гэж байна 5 сарын 1-нээс эхний компаниуд тариалалт эхэлчхээд сая Хэнтийнх нь тариалалт, үрлэгээ эхэллээ гээд мэдэгдэж байна. Улаан буудай тарих уу, тарихгүй дээр тариаланчид эргэлзээд байна шүү дээ. Ингээд улаан буудай тариалалтаас татгалзаад бусад таримал руугаа ингээд хамаагүй шилжчихвэл өөрөө эргэж буцахад их туйлын амаргүй. Технологийн, техникийн их том ажил явчихдаг болохоор их хохирол их өндөр гарах гээд байгаа юм. Улаан буудай, гурилын хэрэглээ багасна л гэсэн үг шүү дээ намар гэхэд.

Д.Амарбаясгалан: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн тодруулж асууя.

Ц.Идэрбат: Үгүй. Энхбаяр сайд аа би их тэгж улс төржөөд, эсвэл тэгж попроод л байдаг хүн биш. Тал тал талаас нь судалдаг. Жилийн өмнө энэ сэдвээр яг наадхыг чинь дуугарч байсан хүний хувьд жил хүрэхгүйн дараа би дуугүй байж болохгүй байхгүй юу. Тэгээд жилийн өмнө ярьж байсан юмаа энэ төр ер нь яг яаж шийдсэн юм бэ? Тэгээд л ингээд л тэр үед тэгээд л ингээд л шуугиад л өнгөрөх юм уу? Энэ дээр л би танаас хариу нэхээд байгаа байхгүй юу. Гурилын үнэ өсөөд байгаагийн үндсэн шалтгааныг олохгүй бол дагаад олон сөрөг зүйлүүд гардаг юм байна. Сум, аймагт очих болгонд шуудай гурил нь 2 дахин нугарчихсан гээд иргэд яриад байна шүү дээ. Тэгэхээр чинь ярихгүй яах юм.

Гэтэл өнөөдөр орж ирж байгаа юм нь өнгөрсөн жилийн юмаа шийдсэн юм огт байхгүйгээр зүгээр ингээд л ороод ирж байгаа байхгүй юу. Улаан буудай

тариалагчид чинь бас шал өөр юм ярьдаг юм байна лээ шүү. Маш их зовлон ярьдаг юм байна лээ шүү. Авдаггүй барьдаггүй гээд. Энэ дээр ер нь ямар бодлого байгаа юм бэ гэж би асуугаад байгаа байхгүй юу.

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ тариаланчид, гурил үйлдвэрлэгчид хоёрын хоорондын хэрүүл рүү ормооргүй байгаа юм. Энэ чинь тариалалтын тухайн жилийн ургацын байдал, хур чийгийн байдал, буудай тарьсан технологийн байдал, түүнд хэрэглэсэн бордоо, ургамал хамгааллын бодисын байдал, нөгөө талаас тэр тариаланчийн ур чадвартай холбоотойгоор чанарын байдал өөр өөр гардаг. Монгол даяар ноолуур өөр өөр чанартай, өөр өөр микронтой байдагтай адилхан улаан буудай ч бас тэгдэг. Уулын ар, өвөр 2 өөр ургадаг. Гурилын үйлдвэрлэгч нар чанартай бүтээгдэхүүн хийхийн тулд тэр стандартынхаа дагуу л авна. Мэдээж ийм маргаан үүснэ. Чанарын үзүүлэлтүүд унасан тэр жилийн ургацтай тариаланчид өгөхөө бодно. Үйлдвэрүүд аль болох чанартай гурил авахаа, улаан буудай авахаа бодно. Ийм мэтийн маргаан тасардаггүй юм байнга байдаг юм. Жил жилийн онцлогоос шалтгаална. Зарим жил зарим газар их сайхан гараад л, зарим жил жоохон унаад л. Тэр болгон чинь л тохиргоонууд буюу зохицуулалтууд л хурдтай, шуурхай хийх л шаардлага байдаг.

Д.Амарбаясгалан: Тийм яах вэ Энхбаяр сайд өнгөрсөн жил яг энэ асуудлыг хэлэлцэж байхад бас Хүнс, хөдөө аж ахуйн сайд байгаагүй юм. Тэгээд тухайн үед Энхбаяр сайд бас тариаланчид ирж Улсын Их Хурлын гишүүдтэй бас нэлээн уулзалтуудыг хийж байсан. Тариаланчид дунд каст үүсчхээд байгаа шүү дээ. Гурилын үйлдвэрүүдийн захиалгаар гурилын үйлдвэрүүдээс зээл аваад юм уу, эс үгүй бол гурилын үйлдвэрүүдээс мөнгө аваад тариалалт хийгээд нийлүүлчихдэг нэг хэсэгтээ. Өөрсдийнхөө бор зүрхээр яваад тариа тариалаад, нөгөөдхийгөө хурааж авчхаад гурилын үйлдвэрүүдийг гуйгаад гурилын үйлдвэрүүдийн элеваторт нь хадгалуулах гээд хадгалуулах гэж мөнгө төлдөг, гурилын үйлдвэрт өгөх гэж авлига өгдөг ийм тогтолцоо үүсчхээд байна. Тэгэхээр бид яавч босож чадахгүй хэлбэр рүү орчихсон учраас бидэнд өсөж дэвжих боломжийг гаргаж өгөөч. Ялангуяа экспортын гарцыг нээж өгөөч гэдэг асуудлыг ярьсан.

Тэгээд тухайн үеэс эхлээд БНХАУ жил болгон 10 сая тонн улаан буудай импортолдог учраас тэр квотод нь багтах хүсэлтийг саналыг Гадаад харилцааны яам, Хөдөө аж ахуйн яам Хятадын Элчин сайдтай уулзаж, Хятадын Засгийн газар Хөгжил, шинэтгэлийн хороотой уулзаж, удаа дараа яриа хэлэлцээрүүдийг хийсэн. Гэтэл харамсалтай нь ямар хариу ирээд байна вэ гэхээр танай улаан буудай чинь манай хэрэглэдэг чанарын 3 дугаар зэрэглэлд ороод байна. Зөвхөн тэжээлд ашиглагдах улаан буудай ирэх гээд байгаа учраас бид наад авах эсэх асуудлаа ярья. Гэхдээ танайх нэгдүгээрт 1 га-аас авдаг улаан буудайнхаа хэмжээг нэмэгдүүл, хөрсөө борд сайжруул, чанарыг нь сайжруулах тал дээр анхаарах хэрэгтэй байна гэдэг асуудлыг яриад байгаа юм. Тэгэхээр энэ Идэрбат гишүүн нарын асуугаад байгаа асуултын гол агуулга энэ дээр оршиж байгаа шүү гэдгийг бас хэлье.

Идэрбат гишүүн дахин тодруулж асууя.

Ц.Идэрбат: Та бол энэ жил үнэ нэмэгдэхгүй л гэж байна. Он гараад би энэ энэ жил нэмэгдэхгүй гээ биз дээ гэж хэлэх л байх л даа магадгүй. Гэхдээ ургацаа шалтгаална. Ер нь яах вэ стратегийн бүтээгдэхүүн учраас энэ чинь яг бас л тэр 90 оных шиг ясны гурил идмээргүй л байгаа. Гэхдээ бас замбараагүй үнэтэй юм бас байгаад байж болохгүй. Энийг хянадаг, манадаг, зохицуулдаг, төр бол урамшуулаад байна шүү дээ. Татвар төлөгчдийн хэдэн зуун тэрбумаар урамшуулаад л байгаа жил болгон. Эргүүлээд бас монопол үүсгэж байна уу, үгүй юу гэдгийг хянахаар тийм юм байхгүй гээд ингээд байдаг.

Тэгэхээр энэ асуудал ер нь яг ямар шатдаа яваа юм бэ? Гурилын үйлдвэрүүдийн зөв юм уу, шударга өрсөлдөөний хэрэглэгчийн төлөө газрынх нь буруу юм уу? Эхлээд энийгээ эцэслэхдээ цаашаа явмаар юм шиг надад логикийн хувьд санагдаад байдаг юм. Тэгэхгүй тэгээд энэ чинь тэгээд л бужигнаад л хавар бужигнасан энэ хаврын бужигнаан нь өөр сэдэв болж таараад байгаа юм шиг.

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр: Үнэ тогтвортой байх уу гэдэг асуудал тухай тухайн жилийн ургацаас шалтгаална. Би танд юу хэлж чадах вэ гэвэл 24 оны ургац боломжийн, нөөц боломжийн импортын бэлэн бүтээгдэхүүн их хэмжээнд ороод ирсэн шинэ ургац хүртэл үнэ дээр ямар нэгэн хөдөлгөөн гарахгүй гэдэг нь тодорхой байгаа. Улаан буудай яагаад гэвэл жил жилдээ ургацаас шалтгаалаад дэлхийн хэмжээнд л үнэ нь өөрөө хөдөлж байдаг л бүтээгдэхүүн. Нөгөө нүүрстэй, алттай адилхан. Улс орнууд энийг тэнцвэржүүлэх үүднээс нөөц авдаг. Тэр нөөц буюу бид нар жилд 100 мянган тонныг улсын төсвөөр нөөц, аюулгүй нөөц буюу үнэ тогтворжуулалтын нөөцийг аваад байвал таны эмзэглээд санаа зовоод байгаа зүйл байхгүй. Тэгэхээр харамсалтай нь энэ бодлогыг оруулж ирсэн төсөв хассан. 26 онд ахиад оруулаад ирье 26 онд 100 мянган тонныг дотоодоос бид нар улаан буудай авч хадгална, улсын нөөцөд авна гэдэг бодлого л энэ хэлэлцүүлгийн үр дүн гарч ирсэн шүү дээ. Ингэх юм бол үнийн тогтвортой байдлыг 26 онд мөн баталгаатай хадгалж чадна.

Д.Амарбаясгалан: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууя.

О.Номинчимэг: Гурил бол өргөн хэрэглээний бүтээгдэхүүн манай Монгол Улсын хувьд. Энэ утгаараа бол яг эдийн засгийн энэ гаалийн татвар яаж нөлөөлөх вэ, татвар яаж нөлөөлөх вэ гэдэг дээр үнэд мэдрэг бус гэсэн үг. Үнэ нь өсөж байсан ч хэрэглээ байдаг учраас энэ дээр олигопол, монопол үнээ өгсөх энэ үйл ажиллагаа нь бол явагдахад их амархан салбар. Тэгээд гол энэ гишүүдийн хэлээд байгаа юм ч гэсэн үнэн л дээ. Бид нар яг нөгөө суурь асуудлыг нь углуургаар нь бас харах ёстой шүү дээ. Энийгээ харж чадсан юм уу гэдэг дээр бол санал нэг байгаа юм. Уг нь энийг бол би Энхбаяр сайд гэхээсээ илүү энэ монополын асуудал эрхэлж байгаа агентлагаа удирдаж байгаа Доржханд сайд байсан бол асуумаар байгаа юм. Доржханд сайд алга байна 2, 3 чуулган дээр ч харагдсангүй.

Мэдээж дотоодын үйлдвэрлэлээ бид нар дэмжих ёстой, гурилын үйлдвэрлэлээ хамгаалах ёстой, үр тариагаа өөрсдөө хүнсээ хийдэг байх ёстой. Гэхдээ гол асуудал энэ дээр үнэхээр тэр гишүүдийн яриад байгаа Шударга өрсөлдөөний газраас гаргаад байгаа монопол байдалтай картелиар үнээ ингээд нэмчихдэг энэ байдал үүсчихсэн юм уу гэдэг дээр өшөө нарийн дүн шинжилгээ хиймээр байгаа байхгүй юу. Тэгээд бид нар зах зээлийн хувьд хэн ингээд илүү

нөлөөтэй байна гэдгийг мэдээж зах зээл буюу салбар салбар дээрээ, үр тариа импортлогч дээрээ, буудай нийлүүлэгч дээрээ, гурилын үйлдвэрлэл дээрээ, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл дээрээ харж болно. Үүнээс гадна босоо буюу саплай чэйн/supply chain/ гэж ярьдаг нийлүүлэлтийн энэ сүлжээн дээрээ хэн нь дуу хоолой нь хүчтэй байна энэ дээрээ зах зээлээ илүү контролдож байгаа этгээдүүд байна уу гэдгийг нарийн харах ёстой. Манай одоогийн Өрсөлдөөний тухай хууль дээр зах зээлийн 30 хувиас дээш байх юм бол давамгай этгээд гэж үзнэ л гээд орчихсон байгаа. Энийг ингэж тоогоор зөвхөн 30 хувиар тооцох нь буруу. Энийг бид нар үнэхээр энэ зах зээл дээр хэн илүү хүчтэй дуу хоолойгоор нөлөөлж, үнэ тогтооход нөлөөлж байна гэдгийг зах зээл хэвтээ зах зээлээр болон босоо зах зээл дээр нь давхар харах ёстой байдаг.

Түрүүн тэгээд энэ ярианд дурдагдаж байна. Зөвхөн гурилын үйлдвэрээр нь авч үзэх юм бол мэдээж ингээд ашгийн маржин/margin/ эд нар бага. Гэхдээ гурилын үйлдвэрлэл өөрөө буудай нийлүүлэгч дээр ч юм уу, үр тариа тариалагч дээрээ илүү нөлөөлөл үзүүлж чадаж байна уу, тэн дээр үнэ тогтооход нөлөөлж байна уу гэдгийг бид нар бас давхар харах ёстой. Тэгээд энэ чиглэлээр нь ер нь ч харж дүгнэлтээ хийсэн юм уу гэдгийг уг нь би монополын газраас бас Доржханд сайдаас асуумаар байсан. Даанч ажлын хэсэгт бас энэ хүмүүс байхгүй байна.

Тэгээд гол нь энэ чинь бид нарын бас санаа зовоод байгаа юм одоо мэдээж дотоодын үйлдвэрлэлээ хамгаалъя гээд гаалийн татвараа нэмчхэж болно. Гэхдээ эргээд гурилын үнэ өсөх вий дээ гурилаас үүддэг энэ талх боовны үнэ өсөх вий дээ гэдэг л асуудал байгаа шүү дээ. Одоо ингээд харахаар эцсийн эцэст манай Монгол Улс чинь талхнаас хямдхан тамхитай л улс болох гээд байгаа юм шиг л бодлого харагдаад байна. Бид нар үр хүүхдүүддээ гурил, талх чинь үнэтэй байна өлсөөд байвал тамхи татчих гэдэг бодлого явуулж болохгүй.

Тэгэхээр үнэхээр энэ гурилын үнэ юун дээр болоод өсөөд байгаа юм, энэнийхээ арга хэмжээг бид нар сайн зохицуулж чадсан уу гэдэг дээр бас анхаарах ёстой шүү гэдгийг бас хэлмээр байна. Энийг бас ашиглаад Сангийн сайдад бас хэлмээр байна аа. Сангийн сайд, Сангийн яам энэ тамхины онцгой татвар дээр 2, 3 сар ажилласан, бүх юм нь, тооцоо бэлэн болчихсон. Эцэслээд нөгөө гэхээр ингээд усанд хаясан чулуу шиг алга болмооргүй байна. Сангийн яам тамхи, тамхин бүтээгдэхүүний онцгой татварынхаа энэ санал эцэслэсэн юмаа хурдан өгөөч гэдгийг бас хэлмээр байна.

Д.Амарбаясгалан: Номинчимэг гишүүн санал хэлчихлээ. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуулт асууя.

М.Бадамсүрэн: Нэгдүгээрт энэ тариаланчдыг дэмжих цогц бодлого чухал. Зөвхөн ингээд гаалийн, импортын татвар, тарифтай холбоотой асуудлаас илүүтэй. Тэгэхээр энд экспорт, импортын энэ уян хатан тохируулгыг хийж өгөх талаар ямар бодлогын арга хэмжээ авах вэ? Мөн энэ таримлын сонголт дээр ямар бодлого барьж байгаа вэ? Яг үнэндээ зах зээлийн эдийн засаг гэдэг сонголттой байх ёстой шүү дээ. Юу тарихаа сонгодог, экспортод гаргах боломж байна уу энийг сонгодог, гурилын үйлдвэрүүдээ нийлүүлэх зах зээлээ сонгодог энэ тогтолцоог төрөөс бүрдүүлж өгөхгүй бол үндсэндээ энэ Улсын Их Хурлын гишүүдийн яриад байгаа зүйлүүд яг бодитой байгаа шүү дээ. Ялангуяа сая Идэрбат гишүүний хэлдэг саналтай би санал нэг байгаа. Тариаланчдыг хөдөө аж ахуйн салбарын нэг багана,

дэмжинэ, дэмжих нь зөв. Гэтэл нөгөө талдаа малчдын чинь махны үнэ нэмэгдэхгүй байгаа болохоор малчид маань үнэтэй гурил хэрэглэвэл их хүндрэлтэй байдалтай байгаа шүү дээ. Тэгээд тойрогт ажиллахад иргэдийн сонгогчдын зүгээс энэ зүйлийг хамгийн их тавьдаг.

Зах зээлийн сонголттой холбоотой зүйл дээр ямар бодлогын арга хэмжээ авах вэ гэдгийг би бас энэ хуулийн төсөл оруулж ирж байгаа субъектээс асууж байна. Бодит байдал дээр ямар байдаг вэ гэхээр ингээд үйлдвэрүүд үнээ үндсэндээ бараг монопол байдлаар гэх юм уу тогтоодог. Тэгээд хол газраас тээвэрлээд ирнэ тэгээд нөгөөдөх нь экспортолж чадахгүй болохоор ингээд хэлсэн үнээр нь үндсэндээ авдаг. Тэгээд үндсэн үнээр нь тогтоосон үнээр нь авахаас өөр ийм сонголтгүй болж байгаа учраас энэ үнэхээр тариалан эрхлэгчдэд хамгийн хүндрэлтэй тусаж байгаа шүү дээ. Сайн бодоод үз ингээд төрөөс дэмжээд байдаг тодорхой зээлийн бодлого, тодорхой хөнгөлөлттэй нөхцөлөөр дэмжээд байдаг яагаад энэ хөл дээрээ тогтож чадахгүй байна вэ гэдэг дээр маш том дүгнэлт хийх хэрэгтэй гэж бодож байгаа.

Ийм учраас өндөр ургац авсан жил нь энэ борлуулалтыг нь яаж дэмжих юм бэ? Төр бол гадаад зах зээлтэйгээ аль болох холбож өгөх асуудлыг л ер нь том бодлогоор хийх ёстой шүү дээ. Тэгвэл тэгээд яг үнэндээ тариаланчид ашгаа олоод өндөр ургац авсан жилээ тоног төхөөрөмждөө хөрөнгө оруулалт хийгээд, мөн өөрийнхөө санхүүжилтэд хөрөнгө оруулалт хийгээд ингээд явах боломжтой гэж үзэж байгаа. Тийм учраас энэ нэгдүгээрт энэ тариаланчдыг дэмжих цогц бодлогыг юу гэж харж ямар энэ дээр бодлого баримтлахаар төлөвлөж байгаа вэ гэдэг? Нэг.

Хоёрт нь импортын татварыг ингээд 15 хувийг сэргээж хэрвээ Их Хурлын гишүүдийн олонх нь дэмжиж шийдвэл үнэ өснө. Тэгээд инфляцад нөлөөлнө. Тэгэхээр бид ямар хариу өгөх вэ? Тог, цахилгааны үнэ нэмэгдсэн, инфляцад нөлөөлсөн гэж үзэж байгаа. Дээр нь өргөн хэрэглээний хамгийн жирийн иргэдийн авч хэрэглэдэг энэ гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ нэмэгдвэл Улсын Их Хурал ямар хариуцлага хүлээх вэ? Тийм учраас би энэ дээр хоёрт нь бодвол үнэ өсөх үү яг инфляцад нөлөөлөхгүй гэсэн баталгаа байна уу?

Гуравдугаарт нь энэ хэрвээ Их Хурал шийдвэр гаргавал үнэ нэмэгдвэл автоматаар эргээд импортын татварыг тэглэдэг ийм болзолтойгоор шийдвэр гаргах ёстой л гэж үзэж байгаа юм. Ийм болзолтойгоор. Энэ гурилын үйлдвэрүүд ч тэр, тариалан эрхлэгчдэд ч тэр томоохон хэмжээний бас энэ үйл ажиллагаандаа зохицуулалт хийх үнэхээр тэр зарим Их Хурлын гишүүдийн иргэдийн хэлээд байгаа монопол байдал байна гэдэг зүйл дээр хязгаарлах ийм арга хэмжээ болно л гэж үзэж байгаа. Дараагийнх нь бол энэ малын тэжээл импорт 5 хувийн татвартай гэж ойлгож байгаа. Тэгээд энийг ер нь татваргүй байсан нь зөв дөө. Яагаад гэвэл хавартаа ингээд тэжээлийн үнэ нь, хивгийн үнэ маш их хэмжээгээр өсчихдөг шүү дээ. Тэгээд малчдад төл малын үед хамгийн хүндрэл гардаг. Тэгээд энийг бол энэ бодлоготой хам.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр: Гишүүнээ тантай энэ салбар уян хатан байх ёстой гэдэг санал нийлж байгаа юм. Хурдтай, шуурхай цаг үед нь тааруулаад хурдтай шийдвэр гаргаад зохицуулж байх ёстой. Яг л шатахуунтай адилхан гурилын үнэ дутагдал,

экспорт, температурын балансаа харж байгаад л зохицуулалт хийгээд л үнийн бодлогоо эвтэйхэн аваад явах бололцоотой. Ахиад хэлье ингээд хууль гаргаад түгжчихээр тэр зохицуулах орон зай чинь хөдөлгөөн хязгаарлагдаад заавал Их Хурал дээр орж асуудал шийдэх болчихоод хавар, намрын чуулган хүлээдэг ажил руугаа ороод байна шүү дээ.

Бид таримал дээр нэлээн бодлого өөрчилж байгаа. Атрын 4 дүгээр аяны гол зорилго бол тэжээл. Тэжээлийн ургамал, тэжээлийн таримлын нэр төрлийг эрс нэмж байгаа. Энэ жил 140-өөд мянган га-д тэжээлийн ургамал таригдана. Нэгдүгээрт эрчимжсэн аж ахуйнуудаа тэжээлээр хангах. Нөгөө талаар уламжлалт мал аж ахуйгаа байгалийн эрсдэлээс хамгаалах зорилгоор тэжээлийн таримлыг эрс нэмэгдүүлэх ийм бодлого хийж байгаа.

Нөгөө талаас тэжээлийн таримлын экспортыг нэлээн урамшуулна буюу таны хэлдгээр олон сонголттой, олон зах зээлтэй болгох чиглэлээр бид нар ажил хийж байна. БНХАУ-ын эрх бүхий байгууллагууд дээр асуудлаа тавиад 7 нэр төрлийн таримлыг шинээр экспортод гаргах асуудлыг хөөцөлдөөд явж байна. Энэ амжилттай ингээд шийдэгдвэл бидэнд бас газар тариаланд нэлээн бодлогын бөгөөд үйл ажиллагаанд нэлээн томоохон өөрчлөлт орох ийм бололцоо байгаа юм.

Үнийн асуудал үнэхээр улаан буудай, гурил бол стратегийн бүтээгдэхүүн, тогтвортой байдал ард түмний хамгийн өргөн хэрэглэдэг бараа. Тэгэхээр та бүгдээс хүсэхэд жилдээ 100 мянган тонн үр тариаг л улсаас төсөв гаргаад худалдан авдаг л болчихооч гэдгийг л хэлэх гээд байгаа юм. Тэгвэл тогтвортой байдлаа хангачихна. 100 мянган тонн аваад л жил болгон 100, 100 мянган тонныг аваад л нөөцөлж байдаг. Тэрийгээ эргэлтэд оруулаад ингээд тогтвортой байдлаа хангах тэр зохицуулалт хийх гол хүч хэрэгсэл чинь тэр 100 мянган тонн улаан буудайн нөөц бүрдүүлэх асуудал байгаа юм. Энэ л асуудлыг нь гол шийд. Тэгээд мэдээж өөр бусад экспортыг идэвхжүүлэх, шаардлагатай импортыг хязгаарлах, боомт дээр квот тогтоох гээд олон арга хэрэгсэл байна буюу энэ улаан буудай гурилын асуудлыг нь ингээд асуудал болгоод байхааргүй зохицуулах боломж энэ Засгийн газарт нь байгаа юм. Тэгэхээр тэр эрхийг нь Засгийн газарт нь энэ хуулиараа гаргаад өгчхөөч. Тэгвэл бид нар зохицуулаад л эвтэйхэн аваад явчихмаар байна даа.

Д.Амарбаясгалан: Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн тодруулж асууя.

М.Бадамсүрэн: Нэгдүгээрт тариаланчдаа үндэсний үйлдвэрлэлээ дэмжих бодлого, хоёрдугаарт нь иргэдийг хямд үнэтэй гурилаар хэрэгцээг нь хангах гэдэг энэ 2 л бодлого л явж байгаа шүү дээ. Тийм учраас энэ дээр би энэ хуулийн төслийг өргөн мэдүүлэхтэй хамт ийм Улсын Их Хурлын тогтоол өргөн мэдүүлэх ёстой байсан юм болов уу гэж бодож байна. Тэгээд энэ дээр ийм боломж байна уу гэдгийг асууя. Томьёолж хэлэх юм бол хэрвээ гурилын үнэ Үндэсний статистикийн хорооны 3 сар дараалсан мэдээллээр нэмэгдэх юм бол энэ татварыг эргэж шууд тэглэх хуулийн төслийг тухайн цаг үед нь шууд оруулж ирэхийг Засгийн газарт даалгасан ийм болзолтойгоор энэ асуудлыг хэлэлцэх нь зүйтэй гэж үзэж байгаа. Яагаад гэвэл энэ тариаланчдад, үндэсний үйлдвэрүүдэд бодох санах, үнэхээр ийм монопол байдалтай байгаа бол энийгээ арилгах ийм тодорхой нэг.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийг хэлэлцээд явахыг зарчмын хувьд дэмжиж байна. Тэгэхдээ өнөөдрийн энэ өглөөний чуулган дээр явж байгаа асуудлууд, мэтгэлцээнүүд ерөөсөө л нэг зорилгыг л яриад байна л даа. Хүнсний аюулгүй байдлаа яаж баталгаатай хангах вэ, энэ үйл ажиллагаандаа дотоодын тариаланчид, энэ дотоодын аж ахуйн нэгж байгууллагуудаа яаж бодлогын хүрээнд дэмжиж явах вэ, энэ нь ямар ач холбогдолтой юм бэ гэдэг зүйл байгаад байгаа юм.

Нөгөө талдаа хэрэглэгч буюу Монголчууд бид бас хямд тэгэхдээ чанартай ийм найдвартай түүхий эдтэй хийгдсэн ийм хүнсний бүтээгдэхүүн хэрэглэх энэ асуудал бас цаана нь яригдаж байна гэж ойлгож байгаа. Тэгэхээр гол асуудал ерөөсөө энэ гаалийн тарифыг чөлөөлж бас 1 жил үзлээ. Энэ дээр бас нийт гурилын үйлдвэрийн 40 орчим хувь буюу тодорхой аж ахуйн нэгж байгууллага үндсэндээ хаалгаа барьсан юм байна. Тэгэхээр бид хэд ийм бодлогын гэдэг юм уу гэнэтийн ийм шийдвэрүүд гаргаж ерөөсөө ийм богино хугацааны цохилтуудыг аж ахуйн нэгж байгууллагууддаа өгөөд байж ерөөсөө болохгүй байгаа юм.

Тэгэхээр яригдаж байгаа энэ зүйлүүдийг ингээд харахаар ерөөсөө цэвэр өрсөлдөөний асуудал байгаад байгаа юм. Зах зээлийг яаж зохицуулах вэ, өрсөлдөөн тэр үнэхээр үнэ тогтоохдоо хуйвалдаж, картель үүсгэж, монопол байдлаа ашиглаж ингээд яваад байгаа бол энэ гааль, тарифын гэдэг юм уу, энэ дотоодын зах зээлийг нээж нэг үзэж, хааж нэг үзэх гэхээсээ илүүтэй бид хэд өөрсдийн эдийн засгийн зохицуулах энэ өрсөлдөөний хууль тогтоомжоо сайжруулах асуудал байна гэдэг зүйлийг л би хэлэх үүднээс өнөөдрийн энэ асуудал дээр үг авч байгаа юм. Түүнээс биш ингээд 1 жилээр янз бүрийн арга хэмжээнүүдээ аваад яваад ингээд гэнэтийн бэлэг ерөөсөө аж ахуйн нэгж байгууллагууд барьж боломгүй байна. Ямар ч байсан эхлээд бид хэд дотоодын нөхцөл байдлаа үнэлж хийж энэ өрсөлдөөний асуудлыг яг зохицуулдаг аргаар нь зохицуулж үзмээр байна. Түүнээс биш ийм байдлаар биш. Та нар үнээ нэмээд байвал гаалийн татварыг чинь бид чөлөөлчихнө гэдэг байдлаар ингээд аж ахуйн нэгж байгуулаад бас ингээд байж болохгүй.

Тэгэхдээ нөгөөдүүл нь бас энэ хэрэглэгчийнхээ эрх ашгийг бодохгүйгээр үнээ нэмээд бас ингээд хуйвалдаад байж болохгүй. Тэгэхээр энэний балансыг л олох, энэ хууль, эрх зүйн орчныг яаралтай бүрдүүлэх шаардлага зайлшгүй энэ сагсны бүтээгдэхүүн гэдэг юм уу, мах гурил дээр байна. Тэгэхдээ энэ асуудлуудыг зохицуулахдаа ерөөсөө зах зээлийн зарчмыг ерөөсөө алдагдуулж болохгүй. Энэ хүнсний бүтээгдэхүүн хөнгөн үйлдвэрийн салбар чинь маш олон ажлын байрыг хадгалж байгаа, дундаж давхарга яг энэ салбараас босож ирэх боломжтой салбар байхгүй юу. Өнөөдөр дундаж давхаргыг нэмэгдүүлье гээд байдаг бид нар дундаж давхаргыг босож ир гэсэн салбар руугаа элэгдэж унагаагаад байж ерөөсөө болохгүй. Гэнэтийн гэнэтийн хагас жилийн шийдвэрээр, эсвэл аман шийдвэрүүдээр, эсвэл ийм эргэж буцсан жилийн хүрэхгүй шийдвэрүүдээр ерөөсөө ийм нөхцөл байдлуудыг үүсгээд байж болохгүй л гэсэн юм байгаа юм.

Тэгэхээр Өрсөлдөөний хууль тогтоомжоос гадна бас салбарын сайдаас би бас хариулт үзье гэж бодож байгаа. Ер нь зүгээр энэ улаан буудайн тариалалтыг дэмжих, бусад энэ чиглэл дээр сая гаалийн татвар чөлөөлөгдсөнөөс хойш рапс руу нэлээн шилжсэн гэдэг мэдээлэл яваад байгаа. Тэгэхээр энэ рапс руу шилжих гэдэг юм уу, бусад ургамлыг тарих энэ нөхцөл байдал ер нь хэдэн хувь руу ахичихсан байгаа. Тэгэхээр энэ зохицуулалтын балансыг бусад энэ газрын төлбөр байдаг юм уу, усны төлбөрөөр нь зохицуулах бодлогын тийм зохицуулалтууд хийж болохгүй юу? Илүү их улаан буудай тариалах юуг нь дэмжих, магадгүй рапс болон бусад юун дээр илүү их газрын төлбөр нь арай улаан буудай тарьснаас өндөр байх жишээний.

Тэгэхдээ энэ чиглэлдээ мэдээж малын, эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх үүднээс энэ малын тэжээл энэ тэрийг тарих асуудал бодлогоор явах ёстой. Тэгэхээр би өнөөдрийн асуулт гэхээсээ илүүтэй тэгэхдээ бас Энхбаяр сайдыг бас хариулаасай гэж хүсэж байна. Энэ өөрчлөлтийн ер нь сөрөг үр дагавар нь юу гарсан юм бэ? Энийг засах бололцоо нь юу байгаа юм бэ? Ер нь энэ хууль зорилгоо биелүүлсэн гээд та хэлж байна лээ танилцуулга дээрээ. Энэ ямар.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр: Хуулийн зорилго бол ган, зудын хохирлыг барагдуулахад хямд гурил, хямд тэжээлээр хангах шаардлага байна гэж үзсэн. Ингээд импортоор квотгүй, хязгаарлалтгүй авсан. Ингээд тогтвортой байдал хангагдсан. Үр дүнд үнэ унасан байна. Би үйлдвэрүүдийн үнийг танилцууллаа. Дунджаар 1кг 1 дүгээр гурил 1500-аас 2000 төгрөг дээр үйлдвэрээс худалдаанд шилжиж байна. Ингэхээрээ энэ зорилго биелжээ гэж би хэлээд байгаа юм.

Хоёрдугаарт энэ уул уурхайгаас ангид эдийн засгийг бий болгох гол тулгуур нь энэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар. Энэ салбарын маань ерөөсөө л хамгийн том суурь нь л газар тариалан байгаа юм. Тэнд тарьж байж ургаж байж, тэр нь малын тэжээл гахай, тахианы тэжээл энэ нь өөрөө хөнгөн үйлдвэрийн, хүнсний үйлдвэрийн гол түүхий эд болж байгаа зүйл маань газар тариалангаас л бий болж байгаа. Газар тариалан нь өөрөө үр тариан дээр тогтож байгаа. Улаан буудайн тариалалтыг л бид аль болох нөгөө стратеги гэдэг талаасаа бодож тогтвортой тариалалтыг хангаж явах нь онцгой чухал байдаг. Мэдээж бас технологи сайжирч байна. Тариаланчид маань бусад олон төрлийн таримал руу бас шилжиж байна. Зөвхөн ганц улаан буудай тариад байж болдоггүй заавал сэлгээ хэрэгтэй болдог. Сэлгээг бид нар нэмэгдүүлж байна. Түрүүн хэлдэг тосны ургамал, тэжээлийн ургамал, мөн үр тариа гэсэн чиглэлээр ингээд сэлгээг улам л нэмэгдүүлэх буюу олон төрөлт бүтээгдэхүүнтэй болох зорилгыг энэ Атрын 4 дүгээр аянаа дэвшүүлээд, шаардлагатай үр, бордоо, техникийг нь хангаад ингээд ажил явж байна. Ирэх жилийн намар гэхэд манай газар тариалан бүтээгдэхүүн нэлээн олон төрөлтэй болоод нэлээн экспортын шинж чанартай болчихсон. Газар тариалангаас бид нар хамгийн багадаа 100 сая долларын экспорт хийчихсэн ийм л зорилготой л ажиллаж байгаа юм.

Тэгээд газар тариалан өөрөө босоод ирэхээр энэ бусад аж ахуйнууд чинь дагаад бий болж байна. Энэ гахай, тахиа, шувуу, өндөг, сүүний энэ эрчимжсэн аж ахуйнууд. Ер нь суурь нь л газар тариалан. Тэр тэжээлийн бааз. Тэгээд өнгөрсөн

бид нар жилүүд чинь тэгээд л 9 сая мал ерөөсөө л хөлдөөгөөд л осгоод алчхаж байгаа шүү дээ бид нар яг үнэндээ. Жоохон тэжээлтэй байсан бол, жоохон нөөцтэй байсан бол ийм эрсдэл гарахгүй. Тэрбум долларыг бид нар ингээд үр ашиггүй байгальд тавьж туучхаад зуд гэдэг эзэн биегүй хүнд буруу гээд байгаа юм. Энэ бол тун хариуцлагагүй. Сайн тэжээлээ тарья. Нөөцөө бүрдүүлээд ингээд байхад тэр гэнэтийн байгаль цаг уур давтахаа болиод малчдын орлого нь ч тогтвортой, салбар нь ч тогтвортой, хөдөө аж ахуй өөрөө их цогц салбар болохоор тогтвортой байдлыг их шаарддаг. Нэг нэгээсээ маш хамааралтай байдаг. Зөвхөн шувууны аж ахуй гэхэд л энэ жил 50 мянган тонн үр тариа хэрэглэдэг болж эхэлж байна. Манай газар тариалангийн 10 хувийг шувууных нь, өндөгнийх нь хэрэглээд эхэлж байна. Гахайных нь хэрэглэдэг болж байна, сүүнийх нь хэрэглэдэг болж байна. Ингээд бусад аж ахуйнуудын хэлбэрт энэ газар тариалангийн өнгө төрхийг эрс өөрчилж байгаа. Энд олон мянган ажлын байр бий болж байгаа.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн тодруулж асууя.

П.Сайнзориг: Тэгэхээр сайдын хэлж байгаа би энэ яг ерөнхий ийм бодлого, суурь концепцыг дэмжээд байгаа. Тэгэхээр ер нь бас энэ асуудлыг хуулийг хүчингүй болгоод зогсох биш ер нь энэ газар тариалан, мал аж ахуй, эрчимжсэн мал аж ахуй дэмжих, энэ өрсөлдөөнийг ил тод болгох энэ бодлогын бусад хууль тогтоомжуудаа бас Засгийн газар анхаараач л гэдэг зүйлийг би эцэст нь хэлэх гэсэн юм. Яг энэ газар тариалангийн салбарт өрсөлдөөний зохицуулалтыг яаж хийх юм? Монопол үүсээд байвал ямар зохицуулалтуудыг авч хэрэгжүүлэх юм? Шууд хил гаалиа нээх гэхээсээ илүү наад талын дотоодын арга хэмжээнүүдээ бид нар эхлээд авах ёстой байхгүй юу. Дээрээс нь ер нь КОВИД-ын гэдэг юм уу, иймэрхүү дэлхий нийтийг хамарсан үзэгдлүүд болохыг бас үгүйсгэхгүй байгаа. Тийм учраас би энэ хөдөө аж ахуйн салбар дээр хамаагүй донсолгож янз бүрийн юу гэдэг юм ийм богино хугацааны, шийдвэрүүдээр, бас энэ салбартаа тодорхой бус байдлуудыг үүсгээд байж болохгүй гэдэг зүйл дээр зарчмын хувьд байгаа. Энэ дээрээ хөдөө аж ахуй хаанаа анхаарч энэ зөв хууль тогтоомжуудын орчныг бүгдээрээ бүрд.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Харин тийм гишүүдийн Энхбаяр сайд бас энийг нь зөв ойлгох хэрэгтэй. Тийм. Гишүүд бол мэдээж татвартай байх татваргүй байх байх гэдэг асуудлаас гадна ер нь цаашдаа яг ямар зохицуулалтууд хийж үнэ өсөхгүй байх нөхцөл хангагдах юм бэ гэдэг дээр л төвлөрөөд байгаа гэдгийг салбар талаасаа их зөв хараарай. Түүнээс татвар, тавиулна тавиулахгүй гэж хэрүүл хийж байгаадаа гол нь биш эцсийн бүлэг дээр хэрэглэгчийн эрх ашиг, хэрэглэгчийн гар дээр очиж байгаа гол нэрийн бүтээгдэхүүн нь өндөр үнэтэй биш өргөн сонголттой байх тэр боломжийн талаар илүү ярьж байгаа л гэдэг талаас нь хараарай.

Д.Амарбаясгалан: Жамбалын Ганбаатар гишүүн асуулт асууя.

Ж.Ганбаатар: Баярлалаа. Өчигдөр бас Байнгын хороон дээр ч сайд бас тэгж хариулаад байсан, өнөөдөр ч бас 2, 3 удаа энэ КОВИД-ын үед аягүй хэцүү болчихсон байсан бараг сарын дараа асуудал үүсэх байсан. Үгүй шүү. Ерөнхий сайд тэр үед одоогийн улсын тэргүүн Ерөнхий сайд байж байсан. Та бас тэр үед Их Хуралд байгаагүй л дээ. Бид нар ажлаа хийж байсан шүү сайд аа. Тийм, бид нар тэрийг чинь хийж байсан. Тэгээд тэр наад гурилыг чинь бид нар ямар ч байсан хэд хэдэн сар болох тэр урьдчилсан бэлтгэл ажлаа хангачихсан байсан гэдгийг

хэлье. КОВИД-ын үед айхтар ангал руу унаж байсан юм шиг дахин дахин битгий дурдаад байгаарай гэдгийг бас танд хэлье.

Хоёрдугаарт, Энхбаяр сайд би бас өчигдөр очоод зүгээр чихэнд нь бас хэлсэн юм энэ гишүүд чинь зарим нь авах зүйлүүд яриад байхад үгийн сандаа санал нэг байна гэдэг үгтэй л доо. Санал нэг байна, таны зөв шүү дээ, тэр энийг тусгаад авъя энэ тэр гээд. Ийм та надаас илүү туршлагатай парламентч хүн энэ дээр гэдэг энийг энэ хүмүүсийн энэ хэлэлцүүлэг чинь энийг чинь сайжруулах гэж л явж байгаа биз дээ. Тэгэхлээр энийг бас зөв талуудыг нь тусгаад авах хэрэгтэй. Би өчигдөр бас хэлсэн танд тийм баярлалаа. Одоо сурч байгаад танд их маш их баярлалаа. Сайн суралцаж байна шүү. Та ч туршлагатай хүн л дээ. Тоглоом шахуу хийж байгаа бол эвгүй шүү. Зөв хүлээж авна шүү дарга. Дээрээс нь би танд анхааруулж хэлж байгаа юм. Энэ Европын Холбоо таны жишээ аваад байгаа Япон ч гэдэг юм уу энэ ингээд тэр дэмжих салбараа ингээд маш олон жил дэмжээд явах эдийн засгийн хувьд үнэхээр боломжтой, чадалтай улсууд чинь нэг салбараа олон жил дэмждэг байхгүй юу. Байхгүй юу гэдэг хэрэглэчихлээ уучлаарай. Тэгж дэмждэг.

Гэтэл манайх өөрөө ямар эдийн засагтай, ямар төсөвтэй, хэчнээн жил алдагдалтай төсөвтэй явж байгаа улс билээ, хэдэн жил дэмжих ёстой юм бэ гэдгийг анхаараарай даа. Дэмжинэ гэдэг дээр нь би эсрэг зүйл алга дэмжих ёстой. Өчигдөр ч гэсэн Байнгын хороон дээр энийг би 2, 3 удаа танд хэлсэн. Хамгийн гол нь хилийн наана үнэтэй. Бид Монгол Улс үнэтэй улс бас болж болохгүй шүү. Хилийн цаана хямдхан, бүх юм хилийн дотор үнэтэй. Хүнс бүгдээрээ Монгол дотор үнэтэй, хилийн цаана хямдхан. Одоо бензин тос, энэ цемент, арматур бүгдээрээ Монголд үнэтэй, хилийн цаана хямдхан ийм байвал бид, тийм тог, цахилгаан ч үнэтэй. Тэгэх юм бид бол юугаар ч өрсөлдөж чадахгүй шүү. Ийм байж болохгүй. Зүгээр зөв голдирлоор явж байгааг төрийн дэмжлэгээр дэмжиж байна гээд энэ зөв явж байгаа салбарыг унагадаг шүү. Тэгээд цаана нь дараа нь дандаа төрийн дэмжлэг хүлээдэг, хэрвээ төрийн дэмжлэг байхгүй бол наад хүмүүс чинь ерөөсөө ямар ч ажил, ямар ч юм нь явахгүй болчих вий л гэж санаа зовж байгаа юм. Зөв голдирол руу нь оруулна гээд явж байгаа нь зөв байх л даа.

Тэгэхдээ таны жишээ авч байгаа та өчигдөр Японыг авч байна лээ, Европын холбоог авч байна лээ. Энэ улсууд чинь эдийн засгийн хувьд ямар чадвартай, хаанаас мөнгө олж байгаа билээ энэ бүх зүйлийг анхаарах хэрэгтэй гэдгийг би бас өчигдөр хэлсэн. Тэгээд өчигдөр би тодорхой хариултуудаа авчихсан л даа. Тэгэхдээ би энэ гурилын үнэ ингэснээрээ хэд өсчих вий гэж энэ гишүүдийн болгоомжилж байгаа зөв шүү. Ингээд намар их, энэ бид нарын валют гэж валютын нөөц үнэхээр хэцүү байгаа үед энэ бас том асуудал үүсчих вий дээ гэдгийг хүмүүс санаа зовж хэл.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Жамбалын Ганбаатар гишүүн санал хэллээ. Жуковын Алдаржавхлан гишүүн асуулт асууя.

Ж.Алдаржавхлан: Би бүүр ингээд гайхаад л сууж байна. Их Хурлын дарга, Хөдөө аж ахуйн сайд. Энэ өнгөрсөн жил энэ гаднаас орж ирж байгаа импортоор орж ирж байгаа гурилын гаалийн татварыг тэглэсэн явдал маань ер нь үр дүнтэй байсан уу, үгүй юү гэдгийг би жишээгээр Хөдөө аж ахуйн сайдаас асуух гээд байгаа юм. Засгийн газраас бидэнд энэ тарааж өгсөн материал дотор ингэж

байгаа юм л даа энэ өнгөрсөн жил экспортоор, импортоор орж ирж байгаа гурилыг татваргүй болгосноор 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр 2969 төгрөгийн үнэтэй байсан дээд гурил 2024 оны 12 дугаар сарын байдлаар 3207 төгрөг болжээ гэж байгаа юм.

Тэгэхлээр энэ чинь ер нь байгаа оносон юм уу тэр тэглэдэг чинь? Тэгээд үнэ өссөн юм бол бид нар ер нь яах гэж импортын татвар энэ тэрийг нь авч ингэсэн юм бэ? Яг албан ёсны байр сууриа нэгдүгээрт Хүнс, хөдөө аж ахуйн сайд хэлж өгөөч. Энэ яг аль тоо нь үнэн яваад байна аа? Би бас Их Хурлын ажлын хэсгээс тоо авахлаар үнэ буурсан гэж байна. Засгийн газраас тарааж өгсөн материалд үнэ өссөн гэж байгаа юм. Тэгэхлээр энийг нэгдүгээрт хариулж өгөөрэй гэж хүсэж байгаа юм.

Хоёрдугаарт нь энэ үндэсний гурил үйлдвэрлэгч нар бид нар дэмжье гээд ингээд энд бүгдээрээ зовоод сууж байгаа. Гаднаас гурил идчихгүй юм сан. Монголын айл өрхийн бараг хүнсний 30 орчим хувь нь гурилын хэрэглээ юм байна лээ шүү дээ. Бид нар багаасаа л боов, боорцог идэж ингээд өсдөг. Тэгэхлээр үндэсний гурил үйлдвэрлэгч томоохон аж ахуйн нэгжүүд өнгөрсөн 3 жилийн хугацаанд 101 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан байна. Авсан нөхцөл нь үнэ гурилынхаа үнийг тогтвортой барина гэжээ. Гэтэл өнгөрсөн жил яагаад нөхдүүд 3000-д гурилынхаа үнийг хүргэв? Яагаад хөнгөлөлттэй зээл авчхаад хариуд нь хариу үйлдэл үзүүлсэнгүй вэ? Энэ дээр ер нь Хүнс,хөдөө аж ахуйн яам нөгөө нөхдүүдтэйгээ уулзаж байгаа юм уу, эд нар ер нь ямар байр суурьтай, тэрийгээ юу гэж юу гэж тайлбар өгч байх юм. Энийг бас хоёрт нь хариулж өгөөч гэж байгаа юм.

Тэгээд бид нар ингээд салаа замын уулзвар дээр байгаад байгаа юм. Эсвэл импортын татвар тавьчихаад, тариаланчдаа дэмжих юм уу, эсвэл импортын татварыг нь авч хаяад тариаланчид маань гурилаа тарихгүй байх юм уу гэсэн ийм зүйл яригдаад байгаа. Бид нар тариаланчдаа бодоод байдаг үндэсний гурил үйлдвэрлэгчдээ бодоод байдаг. Гэтэл нөхдүүд маань улсаас авсан хөнгөлөлттэй зээлийнхээ хариуд ямар ч үйлдэл үзүүлэхгүй үнэ өсгөх юм бол бид нар маш хүнд байдалд орох юм биш үү гэсэн ийм асуултууд байна. Энэний дараа бас тодруулж асууя. Эхний 2 асуултад хариулж өгөөч гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр: Та их нарийн анзаарсан байна. Үнэхээр дээд гурил дээр үнэ өсчхөж байгаа юм. Улаан буудай тээрэмдээд 80 хувь нь 1 дүгээр гурил буюу гол өргөн хэрэглээний өрхийн хэрэглээ. Дээд гурил 10 гаруй хувь. Энэ нь өөрөө яг үйлдвэрийн нөгөө кэйк торт, нөгөө пиццаны гурил, нөгөө сэндвичийн талхны гурил буюу яг үйлдвэрлэлийн цехийн тийм нарийн ширхэгт гурил байдаг. Энийг яагаад өсөв гэхээр дотоодын үйлдвэр нь унахаар дотоодын дээд гурилын гарц унаад эхэлж байгаа, багасчхаж байгаа юм. Импортоор орж ирж байгаа гурил маань өөрөө манай дээд гурилын чанарыг гүйцэхгүй байна л гэсэн үг. Тэгэхээр дээд гурил дээр эрэлт нэмчхэж байгаа юм. 1 дүгээр гурил дээр үнэ сайн буусан. Би түрүүн хэллээ 1 дүгээр гурил 1500-2000 төгрөгөөр үйлдвэрлээд борлуулж байгаа үнэ ингэж гарч ирж байна. Борлуулалтын бусад сүлжээн дээр, тээвэрлэлт дээр үнийн өсөлт газар зүйн байрлал шалтгаалаад янз янз өсөж байгаа юм байна. Тэгэхээр тэнд бид нар анхаарлыг анхаарах хэрэгтэй. Үйлдвэр өнөөдөр кг 1 дүгээр

буюу ард түмэн яг өргөн хэрэглээний гол гурилаа 1500-2000-аар үйлдвэрлээд тариаланчдаас будаагаа аваад үйлдвэрлэлээ нийлүүлж байгаа. Энэ маш боломжийн үнэ байгаа шүү. Нэг.

Тэгэхээр энэ нийтэд нь тавьсан энэ татварын зохицуулалт бас ийм ийм өөр өөр эффектийг харуулаад байна гэдгийг сайн ойлгоод ахиад би ганц хүсэж байгаа юм бол энэ засгийн зохицуулалт хийх орон зайг л бид нар хангаад өгвөл ийм юм гаргахгүйгээр тааруулаад, зохицуулаад явах бололцоотой. Тэр хөнгөлөлттэй зээл авсан гээд гурил үйлдвэрийнхэн дээр яриад байгаа энэ хийгдэж байгаа бүх ажил Хөдөө аж ахуйн сайд өөрөө сайн дураараа ингээд зохиогоод хийж байгаа зүйл ердөө байхгүй шүү дээ. Энэ 2028 он хүртэл хэрэгжүүлэх улс орны хэмжээнд хэрэгжүүлэх хэдэн ийм бодлогын хөтөлбөр манай салбарт хэрэгжиж байгаа. Тэр Их Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэлтийг л бид нар хангаж байгаа шүү дээ. Тэр хэрэгжилтийг хангахын тулд Улсын Их Хурлын баталсан төсвийн хүрээнд л зохицуулалтууд хийгдэж байгаа юм.

Нөгөө талаас бид 2-3 дахин өндөр ургац авдаг, шатахуун, үр, бордоо, ургамал хамгааллын бодис, техник төхөөрөмж, хэрэгслээ өөрсдөө дотроос 100 хувь хангадаг, чийгшлийн хувьд давуу, хөрсний хувьд давуу ОХУ-тай үнэхээр өрсөлдөхөд амаргүй, дотооддоо хангалттай өрсөлдөөд явж байна. Одоо нэмэх нь ийм давуу талтай Оросын Холбооны Улсын тариаланчид, гурил үйлдвэрлэгчтэй өрсөлдөхөд амаргүй.

Тийм болохоор тодорхой нөөц буюу бодлогоор дэмжиж энэ хүнсний аюулгүй байдлаа хангах улаан буудай дээр ийм бодлого явагддаг.

Д.Амарбаясгалан: Жуковын Алдаржавхлан гишүүн тодруулж асууя.

Ж.Алдаржавхлан: Нэг зүйлийг л анхаараасай гэж хүсэж байгаа юм. Бид нар үндэсний үйлдвэрлэлээ дэмжинэ гээд импортын татвар ингээд тавилаа гэж бодоход нөгөө бид нараас хөнгөлөлттэй зээл аваад бүхий л хайр энэрлийг хүртэж байгаа үндэсний үйлдвэрлэгч нар маань хөнгөлөлттэй зээл авчхаад үнээ нэмээд байх юм бол энэ дэндүү шударга биш явдал болно шүү дээ. Дэндүү шударга биш явдал болно. Тийм учраас Хүнс, хөдөө аж ахуйн сайд хэрвээ энэ хууль батлагдаад, хэрвээ энэ асуудал яваад үндэсний үйлдвэрлэгчдийн талд жишээ нь шийдвэр гарлаа гэж бодъё, бид нар үндэсний үйлдвэрлэлийг дэмжих гээд байгаа шүү дээ. Гэтэл нөгөө нөхдүүд маань импортын гурил хаагдсаныг далимдуулаад үгсэн хуйвалдаад үнээ нэмэх юм бол энийг буцаах асуудал л яригдах байх. Тийм учраас энэ дээр манай Хүнс, хөдөө аж ахуйн яам бүүр хариуцлагатайгаар анхаарч өгөөч гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр: Гурилын үнэ ургацаас шалтгаалж байгаа. 24 он авсан ургацын үр дүнд байгаа одоо нөөцийн хүрээнд 25 оны намар болтол ямар нэгэн үнэд өөрчлөлт орохгүй. Харин улс орны хэмжээнд явагдаж байгаа инфляц, цахилгааны үнийн нэмэгдэл, шатах тослох материалын үнэ, цалингийн өсөлт зэрэг ийм салбарын суурь хамаарал бус ийм нэмэлтүүд үүссэн нөхцөлд энэ үнийн асуудал амаргүй. Тэгээд тэрийг бас ялгаж салгаж хараарай. Өнөөдөр 1500-2000 дээр гол гурилыг хангалтыг барина гэдэг маш бага ашигт ажиллагаа дээр энэ үнэ өртөг гарч

байгаа шүү. Энэ дээр ахиад хэлье. Хариуцлагатай ямар нэгэн үгссэн, хуйвалдсан үнэ асар ихээр нэмж ашиг олж байгаа зүйл ердөө байхгүй. Үйлдвэрүүд маань 6-9 хувийн ашигт ажиллагаа дээр л ажиллаж байсан 24 оны байдлаар.

Д.Амарбаясгалан: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуулт асууя.

Г.Тэмүүлэн: Би энэ гурилын үнэтэй холбоотойгоор, гаалийн албан татвартай холбоотойгоор суурь зарчмын асуудлыг л асуух гэсэн юм. Яг одоогоос жилийн өмнө, жил хүрэхгүй хугацааны өмнө Хөдөө аж ахуйн яамнаас энэ асуудлыг оруулж ирж бас шийдүүлж байсан. Энэтэй нь холбогдуулаад бид нар энэ Хууль баталсантай холбогдуулах арга хэмжээний тогтоол баталж байсан юм. Тэгээд Засгийн газарт бол 8 зүйл, заалтаар эргээд саяын тэр Өрсөлдөөнийхөө тухай хуулийг, Дэмпингийнхаа тухай хуулийг, Худалдааныхаа тухай хуулиудыг оруулж ир, дээрээс нь энэ гурил болоод энэ улаан буудайнхаа чанарыг баталгаажуулах лаборатори болоод энэ стандартыг шинэчлэх энэ асуудлуудаа оруулж ир гэдэг асуудлуудыг тавьж байсан юм.

Гэтэл одоо бол яг энэ энэ тогтоолын хэрэгжилт өөрөө нэг талдаа би бас Улсын Их Хуралд оруулж ирж танилцуулаагүй, холбогдох Байнгын хороодод танилцуулаагүй байгаад байгаа. Хуулийн хэрэгжилт өөрөө 0 байгаад байна. Тогтоол нь байдаггүй. Жилийн дотор сайд нь солигдсон боловч газрын дарга нар нь хэвээрээ байгаад байгаа. Тэгээд би газрын дарга нар яг жилийн дотор орж ирж байсан, жилийн өмнө ярьж байсан хэлж байсан зүйлүүд нь шал өөр 100 хувь эргэчихсэн. Жилийн өмнө бид нар танилцуулаад асуудлуудыг шийдүүлж байсан нөхцөл байдал нь өөр өөрөө орвонгоороо эргэчихсэн энэ асуудал байгаад байгаа байхгүй юу. Ингэж болдог юм уу? Төрийн бодлого энэ жил хүрэхгүй хугацаанд ингэж өөрчлөгдөж болдог юм уу, Монголын төр ийм загасны ой санамжтай байж болдог юм уу л гэдэг асуудлыг ярих гээд байгаа юм. Нэгдүгээрх. Өөрөө энэ гурилын асуудал чинь өөрөө нэг талдаа бас эмзэг л асуудал л даа. Тэгээд хэрэглээний сагсанд өөрөө 8-10 хувиар нөлөөлдөг, өрхийн хүнсний зарлагын 20-25 хувийг нөлөөлдөг гурил, гурилан бүтээгдэхүүн. Тэгэхээр би зүгээр инфляцад ч гэдэг юм уу, макро эдийн засаг дээр бас сөрөг нөлөөлөх асуудал үүсэх вий дээ. Цаг хугацаа нь, бас моментод зөв таарч байгаа юм уу, үгүй юм уу гэдэг асуудал байгаад байгаа юм.

Суурь зарчмын асуудал би энэ Хөдөө аж ахуйн яамтай холбоотой асуудал биш. Ер нь зүгээр зарчмын хувьд Их Хурлын дарга анхаарал хандуулахгүй бол болохоо байсан зүйл нэг байна. Ер нь энэ хууль засаглахтай холбоотойгоор, энэ ардчилсан эрх зүйт төрийн чинь үндэс нь өөрөө хууль засаглах асуудал байгаад байгаа юм. Монгол Улс парламентын засаглалтай улс орон. Гэтэл үндсэндээ энэ Засгийн газрын зарим сайдаар би бүүр онцолж хэлэх гээд байгаа зүйл энэ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Энх-Амгалан гэдэг хүн хуулийг хэрэгжүүлдэггүй, гацаадаг, Улсын Их Хурлаас баталсан хууль дээр заасан журмуудыг нь хэрэгжүүлэхгүйгээр жил гаран болгодог ингээд ард нь хоцорч байгаа тэр нийгмийн эрх ашиг буюу малчдын эрх ашиг ч гэдэг юм уу эргээд түүн цаана байгаа асуудлуудыг нь бол ингээд өөрийнхөө үзэмжээр нэг сайд хуулийг хэрэгжүүлдэггүй гацаадаг асуудал байж болдог юм уу? Хууль өөрөө гууль болж байгаа жишээг асуудлыг иргэд маш их ярьж байна. Бид нар иргэдтэй уулзалтууд хийсэн. Цаашдаа энэ эрх зүйт төр чинь засаглах юм уу, хууль цааз засаглах юм уу, эсвэл хувь хүн засагладаг байх юм уу гэдэг асуудлыг хүртэл яриад байгаа юм.

Тэгэхээр бид нар энэ дээр ер нь хуулийнхаа хэрэгжилт дээр зарим энэ сайд нар дээр энэ асуудлыг ер нь ярих хэрэгтэй байх. Нэг хүний үзэмжээр хууль мөрдөгддөг байж болохгүй асуудлууд байгаад байгаа юм. Энэ өөрөө суурь зарчмын асуудал. Тэгэхээр бид нар ер нь мянга хууль санаачлаад ер нь яах юм бэ хууль санаачлах гэж. Их Хурал өөрөө бараг сүүлдээ хууль батлаад яах юм цаашдаа Их Хурал байх шаардлага байгаа юм уу? Эсвэл нэг хүн, нэг сайд бодлого тогтоогоод түүнийгээ хэрэгжүүлж болдог юм уу гэдэг асуудал үүсээд байгаа байхгүй юу. Уг нь бид нар нэг талдаа би бас энэ Нийгэм хамгааллын яамтай холбоотой л асуудал энэ нэг талдаа бас бухимдаж байна л даа бас энэ нийгмийн баталгаатай холбоотой асуудлууд. Бид нар газар дээрх хамгийн том баялаг өөрөө хүн гэж авч үзээд Улсын Их Хурал нь бодлогоо гаргаад энэ дээр энийг хэрэгжүүл гээд, хүнээ хамгаал гээд тэр хүнийг томилсон. Хуулийг хэрэгжүүл гэж явж байтал эсрэгээрээ бол хувь хүний үзэмжээр энэ хууль хэрэгждэг боллоо шүү дээ. Маш олон малчид энэ асуудлуудыг ярьж байна. Нийгмийн баталгааг хангах асуудлуудыг ярьж байна. Хуулийг хэрэгжүүлэх асуудлуудыг ярьдаг. Тэгэхээр бол энэ өөрөө зөвхөн нэг салбар дээр байгаа асуудал биш нэг сайд дээр байгаа асуудал биш Улсын Их Хурал хууль батлахаас гадна хуулийнхаа хэрэгжилтийг шахдаг, шаарддаг энэ асуудал бол зарчмын асуудал болоод байна. Энэ дээр бид нар Улсын Их Хурлаас дорвитой асуудлыг хөндөж гаргаж ирж тавихгүй бол үндсэндээ бол иргэдийн бухимдлыг маш ихээр үүсгэж байна. Нийгмийн асуудлууд маш ихээр тулгамдаж байна.

Д.Амарбаясгалан: Тэмүүлэн гишүүн үг хэллээ. Энхбаяр сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр: Салбарын эрх зүйг боловсронгуй болгох чиглэлээр Их Хурлын даргын захирамж гараад Мандхай, Батжаргал нарын гишүүнээр ахлуулсан хэд хэдэн ажлын хэсэг манайтай хамтран ажиллаж байгаа. Бид ч бид бэлтгээд боловсруулсан 4, 5 хуулийн төсөлтэй байна. Энийгээ богино хугацаанд өргөн барих, хэлэлцүүлэх асуудлыг зохион байгуулна гэж.

Хөрөнгө оруулалт буюу нөгөө лабораториудын асуудлыг тоймловол үнэхээр лабораториудыг чанаржуулах, тоног төхөөрөмжөөр хангах, хүний нөөцийн бэлтгэх олон мөн ийм ажлууд хүлээгдэж байгаа. Үүн дотор онцлоод Био комбинатыг яаралтай шинэчлэх, малын эм бэлдмэл, вакцин үйлдвэрлэлийг эрс нэмэгдүүлэх ийм зайлшгүй шаардлага байна.

Харамсалтай нь өнгөрсөн Их Хурал төсөв дээр энэ асуудал дэмжигдээгүй. Бид 26 оныхоо төсөв дээр энэ асуудлыг дахин тусгаад оруулж ирье.

Д.Амарбаясгалан: Баярмагнайн Баярбаатар гишүүн асуулт асууя.

Б.Баярбаатар: Улсын Их Хурлын гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Энэ манай парламент 126 гишүүн өнөөдөр 1 ч гишүүн энэ үндэсний үйлдвэрлэлийг дэмжихгүй, дотоодын үйлдвэрлэлээ дэмжихгүй гэсэн ийм бодолтой хүн 1 ч байхгүй. Гол асуудал нь энэ салбарын бодлого чинь өөрөө буруу байна гэдэг дээр л асуудал яриад байгаа юм. Үнээ дийлэхээ болиод аргаа бараад импортын татварыг чөлөөлж, өрсөлдөөнийг нэмэгдүүлсэн шийдвэр гаргаад жил ч болоогүй байна. Тодорхой түвшинд гурилын үнэ одоо л бууж эхэлж байгаа шүү дээ ер нь.

Нэгдүгээрт энэ гурилын зах зээл дээр энэ 2020 оноос хойш үнэ яагаад огцом өссөн талаар та ер нь салбарын сайд яг юу гэж бодож байгаа юм? Атарын аяны дараа 37 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байсан гээд сая хэллээ. Одоо 9 болчихсон байгаа юм байна. Яагаад энэ аж ахуйн нэгжүүд шахагдав, энэ дээр салбар ямар бодлого гаргаж ажиллав, энийгээ дагаад энэ үнэ өсөөд байгаа энэ картель нөхцөл байдал үүсчихсэн юм биш үү гэж харагдаад байгаа юм.

Хоёрт энэ КОВИД-ын үед юмны үнэ өссөн гэж яриад байна. 2022 оны 1 сард өмнөх оны сартай харьцуулбал хүнсний инфляц 22 хувьтай, дундаж инфляц 14 хувьтай. Энийг яг юунаас болсон гэж үзэж байгаа юм? Та хэллээ дээ ямар ч үнээр, өчигдөр Төсвийн байнгын хороон дээр ч илэрхийлсэн ямар ч үнээр дотоодын үйлдвэрлэлээ хамгаалах нь зүйтэй гэсэн байр суурийг илэрхийлж байгаа юм байна. Үйлдвэрлэл чухал, газар тариалан чухал, хэрэглэгч бол хамаатай зүйл биш л гэж л хандаж байгаа юм байна. Тэр Япон улсын жишээг өчигдөр та бас ярьж байсан. Япон улс 770 мянган тонн будааг татваргүй импортоор оруулж ирдэг жилд. Тэрнээсээ дээшилбэл татвар тавигддаг ийм квоттой. Тэгээд энэ квотын талаар ер нь та ийм асуудал оруулж ирье гэсэн санал байсангүй юу? Квот дээр. 2020 оноос хойш гурилын нийлүүлэлт яг ямар байсан бэ? Энэ тоо баримт байна уу? Харахад ингээд нийлүүлэлт буураад үнэ өсөөд байсан байгаа байхгүй юу 22 оноос хойш үнэ өсөөд байсан байгаа юм.

Импортын бодлого нээгдээд жил орчим үргэлжлэх гэж байна. Тэгтэл 40 хувь үйлдвэрлэл буурлаа гэж та мэдээллээ. Энэ яг зөв үү ямар үндэслэлээр энэ тоог та танилцуулж байна? Үнийг зах зээл шийднэ гээд бусдыг нь бид мэднэ гэсэн байр сууриас хандаж байгаа юм байна. Шууд гурилын салбарт шууд төрөөс өгч байгаа дэмжлэг, дээр нь зах зээлийн систем, дээр нь хамгаалалт гэсэн ийм 3 зүйл нэмэхээр тэгээд иргэдийн нуруун дээр л ачаа ирнэ л дээ. Ерөөсөө тодорхой нь тэр л байгаа юм. Хохирч үлдэх ..нд нь иргэд байгаа юм. Тэгээд хууль, эрх зүйн орчны шинэчлэл өөрөө их чухал байгаа юм. Энийг л би яагаад хийхгүй байгаа юм бэ гэдэг асуудал өөрөө их чухал. Өчигдөр би бас их ийм мэдээлэл өгсөн нэлээн гуйвуулаад цахим орчинд түгээж байх шиг байна лээ. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан олон хөтөлбөрүүд өнөөдөр амжилттай сайн хэрэгжиж байгаа. Хүнсний хувьсгал, Атрын аян, Тэрбум мод эх орныхоо хөрсөнд ургуулсан органик хүнсээр иргэдээ 100 хувь хангадаг болох энэ том зорилт өнөөдөр хэрэгжээд явж байгаа.

Гэтэл энэ дунд шатан дээр очоод салбар дээрээ очоод тэр Тариалан эрхлэгчдийг дэмжих сан гэж байсан ер нь энэ сангуудаар дамжуулаад энэ будилаанууд чинь үүсээд байна гэдэг агуулгыг би хэлсэн. Өчигдөр үр дүн сулраад байна гэдэг агуулгыг хэлсэн. Тэрийг бас нэлээн гуйвуулсан байдалтай асуудалд хандаж байх шиг байна лээ. Энд их харамсаж байна. Тэгээд Хүнсний тухай хууль, Баяжуулсан хүнсний тухай хууль, Тариалангийн тухай хууль, энэ лабораторийн асуудал, Өрсөлдөөний тухай хууль эд нарыг сайжруулахгүйгээр өнөөдөр энэ зах зээлийн систем, энэ гурилын салбар чинь өнөөдөр одоо бид нар ингээд татвар тэглэснийг хүчингүй болгоно тэгээд гурилын үнэ өснө л дөө. Өсөхгүй байна гэж байхгүй. Тэгээд өссөн үед нь бид нар дахиад яах вэ ингээд л татвараа буцааж тавиад л нэг тэглээд ингээд явах нь зөв юм уу, эс үгүй бол яг хууль, эрх зүйн орчинд тогтвортой байдлаар нь ингээд ажиллуулаад явах нь зөв юм уу гэж л.

Эцэст нь би хэлье энэ салбарын сайд та энэ монопол болчихсон гурилын үйлдвэрүүдийн хэвлэлийн төлөөлөгч шиг битгий ажилла. Энэ Хөдөө аж ахуйн яам төвийн бүсийн бодлогын яам шиг битгий ажилла. Монгол Улсын хэмжээнд бодлого гаргаж ажиллах төрийн сайд хүн шүү та. Хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Яагаад гурилын үйлдвэрлэл уначхав гэж байна. энэ хуультай холбоотойгоор 64.2 мянган тонн баяжуулаагүй, баяжуулсан гурил импортолсон, 52 мянган тонн тэжээл импортолсон тэгээд энэ нь өөрөө үйлдвэрлэлд шууд нөлөөлөөд нөхцөл байдал ийм болсон. Өнөөдөр миний ажил авснаас хойш үнэ тасралтгүй буудаж байгаа, ургац эвтэйхэн байсан, холбогдох зохицуулалтуудыг хурдан шуурхай хийж авч хэрэгжүүлсэн. Тариалалт болон ургац хураалт, гурил үйлдвэрлэл, үнэ дээр ямар нэгэн сөрөг юм үүсээгүй, үнэ тогтвортой байгаа. 25 оны ургац хүртэл тогтвортой байж чадна, хангалттай нөөц байна, боломж байна. Үнэ дэлхийн зах зээл тухайн жил дэлхийн глобал цаг уурын өөрчлөлттэй холбоотойгоор тухайн жилийн үр тариа ургацын байдлаас л дэлхийн үнэ тогтдог. Энэ асуудлаас бид хаашаа ч зайлахгүй. Энгийг тогтвортой үнэ барья гэвэл миний түрүүний хэлдэг жил бүр 100-аас доошгүй мянган тонн тогтворжуулалтын сан буудайг бид нар улсын нөөц нь барьж, үнийн нийлүүлэлтийг барих ёстой. Энэ асуудлыг Улсын Их Хурал дэмжиж өгөөрэй гэж би хүсэж байгаа юм.

Үйлдвэрүүд яагаад цөөрөв? Өрсөлдөөн байна л гэсэн үг. Үнэхээр өндөр ашигтай байсан бол тэнд олон үйлдвэрүүд л байгаад байна. Тийм орон зай байхгүй байна л гэдэг нь үүгээр харагдаад байна шүү дээ. 30 хэдэн үйлдвэр байсаар байгаад одоо 9 болсон байна. Одоо 9-сөө нэлээн хэд нь бас жоохон хүндэрчхээд байна? Квот өмнө бид нар энэ квотоор бүх зохицуулалтыг хийдэг байсан юм. Баруун бүс, зүүн бүс боомтыг нь заагаад квотын зохицуулалт хийгдээд буюу тэр хүн амын тоотод нь харьцуулаад хэрэглээг нь тооцоод ингээд зохицуулаад яваад байсан. Тэгэхээр квотын зохицуулалт ялангуяа улаан буудай гурил дээр ...-ын Засгийн газрын их хурдан маневртай байх гол бололцоог хангадаг юм шүү.

Хууль эрх зүйн орчин түрүүн хэллээ. Улсын Их Хурлын гишүүдээр ахлуулсан ажлын хэсгүүд гарчихсан ажиллаж байгаа. Яам тэд нартайгаа мэдээллээр хангаад хуулийн төслүүдээ өгөөд ажиллагаа явагдаж байна гэж.

Та дунд шатын асуудал буюу авилгийн асуудал хөндлөө. Өмнө нь ийм зүйл байсан болохоор байгаа бүх эх үүсвэрээ би арилжааны банкнуудад зээлийн эх үүсвэрийн хүүгийн татаас болгож өгсөн. Бүгдийг арилжааны банк ил тод бизнесийн зарчмаар зээл олголт явагдаж байгаа. Яам зөвхөн аль салбарт ямар бодлого хийх вэ гэдгээ л бид нар тодорхойлж байгаа. Тэр бодлого нь дандаа Улсын Их Хурлаар батлагдсан бодлогын хүрээнд.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Засгийн газар чинь гүйцэтгэх байгууллага шүү дээ. Улсын Их Хурлаар батлагдсан энэ хөтөлбөрүүдийн хүрээнд ямар зорилт тавьсан билээ тэр зорилтыг хангах хүрээнд бид нар арилжааны банкнуудад бодлогыг нь гаргаж өгч байгаа. Жишээлбэл, Цагаан алт хөтөлбөр дээр зөвхөн ээрэх, сүлжих чадавх дээр

анхаарна шүү гэдэг. Тэрнээс угаах, самнах хангалттай хүчин чадал суурилагдсан. Энд зээл олгохгүй. Энэ зээл зөвхөн ноос, ноолуурын сүлжих, ээрэх, эцсийн бүтээгдэхүүн хийх энэ салбарт олгогдоно гэх мэтийн ийм бодлогын бид нар зохицуулалтыг чиглэлийг гаргана. Арилжааны банк яг бизнесийн зарчмаар зээл олголтоо хийж байгаа. Энэ зээл олголтод манай яамны ямар ч мэргэжилтэн сайд нөлөөлөх буюу энд өг, тэнд өг гэж хэлэх эрх байхгүй хуулиар хязгаарлагдсан байдаг.

Д.Амарбаясгалан: Баярмагнайн Баярбаатар гишүүн тодруулж асууя.

Б.Баярбаатар: Үнэ тогтвортой байгаа байдал чинь ерөөсөө сайд энэ импортыг нээж өгсөн, нийлүүлэлт нэмэгдэж өрсөлдөөн нэмэгдсэнээр л үнэ тогтвортой байгаа юм байгаа. Үгүй үгүй энэ ургац гэж энэ чинь ерөөсөө 1 жилийн, 1 жил ч хүрээгүй шийдвэр шүү. Тийм 1 жил ч хүрээгүй шийдвэр. Нэгд.

Хоёрт энэ өрсөлдөөн байна гэж үзээд байгаа юм дотор. Энэ өрсөлдөөн би төрөөс үзүүлж байгаа дэмжлэг нь өөрөө энэ өрсөлдөөнийг хумьчихсан юм байна л гэж харсан шүү дээ. Жишээлбэл энэ Улаанбаатар гурил 43 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл, Милл хаус 47 тэрбум, Өгөөж гурил 37 тэрбум, Дорнод гурил 10.5 тэрбум гээд л ингээд л хөнгөлөлттэй зээлүүдийг авчихсан тоонууд нь энд байж байна шүү дээ. Яагаад энэ шинээр үүсгэн байгуулагдаж байгаа гурилын үйлдвэрт энэ зээл олгогдохгүй байгаа асуудал байгаа юм? Одоо Хөгжлийн банкин дээр гурилын үйлдвэр 25 тэрбумын өртэй гурилын үйлдвэр хураагдчихсан байгаа шүү дээ. Хаалгаа хаачихсан.

Д.Амарбаясгалан: Жадамбын Энхбаяр сайд нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: Тэр 37 байсан үйлдвэрүүд бүгд хаалгаа барьчихсан байж л байгаа. Ажиллах бололцоогүй байгаад байгаа. Үр ашиггүй болоод л хаагдчихсан. Улаанбаатарт хэд хэдээрээ байна, Эрдэнэтэд байна, Булганд байна. Тэгэхээрээ үйлдвэрүүдээ бид нар нөгөө чанарын асуудлыг нэлээн шахсан. Энэ бодлого маань өөрөө хүнсний аюулгүй байдал, энэ Хүнсний хувьсгалт хөтөлбөр маань чанар сайжруулалт дээрээ үүрэгжүүлсэн. Ингээд үйлдвэрүүд зээлээ аваад технологио шинэчлээд дууссан. Одоо баталгаатай хэлэх юм бол энэ ажиллаж байгаа 9 үйлдвэр Швейцарын, Туркийн хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр иж бүрэн шинэчлэгдээд дууссан буюу энэ технологийн шинэчлэлийг хийх төсөл амжилттай хэрэгжсэн. Энийг та яваад үзсэн, танилцсан. Манай гурилын үйлдвэрийн технологи сайн болсон. Энэний үр дүнд маш олон нэр төр

Д.Амарбаясгалан: Баярмагнайн Баярбаатар гишүүн дахин тодруулж асууя.

Б.Баярбаатар: Гурилын үйлдвэрүүдийн технологи сайжирсан. Энийг бол хүлээн зөвшөөрнө. Олон төрлийн гурилууд гардаг болсон. Одоо бид нар цаашдаа зөвхөн тарифтай зууралдаад байхаасаа илүүтэйгээр эрх зүйн орчин дээрээ нэлээн зууралдмаар байна. Тэгээд би энэ иргэдэд ч сануулах үүднээс 4 жилийн өмнө гурилын үнэ мянган 1065 төгрөг байсан юм. Өнөөдөр тогтвортой байлгах гэж нийлүүлэлт татвар тэглээд бариад бариад 3000 дотор л барьж байгаа юм. Гэтэл бид нар энэ хугацаанд 212 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг аж ахуйн нэгжүүддээ олгочихсон байдаг. Энэний хэрэгжилт нь өөрөө таны хэлдгээр нөгөө гурилын үйлдвэрүүд хөрөнгө оруулалт хийгээд технологио сайжруулсан энэ л үр

дүн байна л даа. Тэрнээс яг гурилын үнэ дээр үр дүн гарсангүй л гэдгийг л хэлэх гээд байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд. Энэ 2023, 2024 онд Монголын зах зээл дээр улаан буудайн дундаж үнэ гурилын үйлдвэрүүд хэдэн төгрөгөөр худалдаж авсан байдаг юм? Тэнчээнээс хариулт өгье. Ажлын хэсгийн 10 дугаар микрофон.

Д.Есөн-Эрдэнэ: Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Есөн-Эрдэнэ. Их Хурлын даргын асуусан асуултад хариулъя. Улаан буудайн үнийн асуудлууд дарааллаа 22 онд улаан буудайн үнэ, дизель түлшний үнэ нэлээд нэмэгдсэн. 7 сард 2865 байж байгаад 4030 болтол ингээд дизель түлшний үнэ нэмэгдсэн. Мөн яг энэ үед рублийн ханш 38 байж байгаад 54-өөр нэмэгдсэн. Үүнтэй холбоотой бордооны үнэ нэмэгдсэн. Шатах, тослох материалын үнэ нэмэгдсэн, тээврийн зардал нэмэгдсэн. Энэтэй холбоотойгоор 21 онд 750 төгрөгийн үнэтэй улаан буудай, дундаж үнэ нь 750 байсан бол 22 онд мянга, 1 сая болж ингэж нэмэгдсэн. Тэгээд 22 оны 10 сараас эхлээд бол бас энэ гурилын үнэ бас ингээд нэмэгдээд явсан. 23 оны, 22 оны 10 сард 1700 байсан гурил 23 оны сард 2069 болоод ингээд нэмэгдсэн. Энэ нь бол ерөөсөө л тээврийн зардал, шатахууны үнэ, энэ юуны зардалтай холбоотойгоор ингээд нэмэгдсэн ийм.

Д.Амарбаясгалан:Хоёулаа ерөөсөө яг тодорхой хариулчих. 2021, 22, 23, 24 онд зах зээл дээрээс худалдаж авсан улаан буудайн дундаж үнэ яг хэд байсан гэдгийг зүгээр тодорхой тэд тэд тэд байсан.

Д.Есөн-Эрдэнэ: 21 онд 750 мянган төгрөг байсан. 20 онд 610 мянган төгрөг байсан, 22 онд 1 сая төгрөг болсон. 23 оны байдлаар бол бас 800-аас 1'000'000 төгрөг болсон. Өнгөрсөн 24 онд бас 900- 1'000'150 төгрөгийн үнэтэй ийм болсон.

Д.Амарбаясгалан: Тэгээд яах вэ дундаж үнэ гэж байгаа. Энэ өөрөө яг үйлдвэрүүдийн худалдаж авсан дундаж үнэ юм уу, хөдөө аж ахуйн корпорацийн нөөцөд авсан дундаж үнэ юм уу?

Д.Есөн-Эрдэнэ: Энэ хөдөө аж ахуйн корпорацийн авсан дундаж үнэ байгаа. Бас ү яг энэ үнэ дундаж үнэтэй харьцуулж гурилын үйлдвэрүүд үнээ тогтоож авдаг.

Д.Амарбаясгалан: Тэгэхээр энэ би Баярбаатар гишүүний асуулт дээрээс л тодруулж хэлэх гээд байгаа юм л даа 2021 онд 1 тонн улаан буудайг дунджаар 750'000 төгрөгөөр худалдаж авсан гурилын үйлдвэрүүд гурилаа 1065-1300 орчим төгрөгийн дундажтайгаар зарж байсан. 2023 онд дунджаар өөрийн чинь хариулсан хариулт шүү 800'000 төгрөгөөр худалдаж авсан улаан буудайгаар үйлдвэрлэсэн гурилын үнэ 1600-2000 төгрөгөөр үйлдвэрээс гарсан хэрэглэгчдийн гар дээр 2500-2800 төгрөг болж нэмэгдсэн. Тэгтэл улаан буудайн үнэ яаж нэмэгдсэн байгааг хар даа. Тонн тутамдаа 50'000 орчим төгрөгөөр нэмэгдсэн. Гурилын үнэ нь тонн тутамдаа 2 дахин нэмэгдчихсэн. Энэ асуудал дээр л өнгөрсөн жилийн татвартай холбоотой асуудал хөндөгдсөн шүү дээ. Тэгэхээр энэ дээрээ зөв, буруу гэж ярих гээд байгаадаа гол нь биш. Энэ зах зээлээ яаж зөв болгож зохицуулах гээд байгаа юм бэ гэдэг л асуудлыг ярьж байна гэдэг энэ асуудал явж байгаа шүү.

Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн асуултад хариулъя. Асуулт асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Миний бие ноднин жил энэ 2024 оны 4 сарын 19-ний өдөр гарсан энэ Их Хурлын тогтоолыг гаргахад ажлын хэсгийг нь ахлаад ажилласан хүн байгаа юм. Тухайн үед 2024 оны 5 дугаар сард 1 дүгээр гурилын үнэ 2454 байсан. Монгол Улсад. Та эхлээд юм яриулчихгүй юу. Тэгээд өнөөдөр энэ 9.5 хувиар буучихсан байгаа үнэ. Нэг.

Хоёрдугаарт таны амнаас сая гарч ирсэн гурилын үнэ тогтворжсон гэсэн. Хэрвээ гурилын үнэ тогтворжсон юм бол, энэ тогтоол гарсан юм бол хэрэв ард түмнийхээ төлөө энэ Засгийн газар, танай яам ажиллаж байгаа юм бол, та ажиллаж байгаа юм бол олон л асуулт л асуугаад л байна л даа. Олон удаа хариулт хариулаад л байна. Энэ тогтворжиж байгаа дээр нь өшөө арга хэмжээ авч болохгүй байсан юм уу? Тэгээд яг хажуугаас ингээд хариулаад элдэв янзын юм яриад байгаатай адилхан юм яриад байх юм. Одоо энэ Засгийн газрын тогтоол гэж гараад энэ тогтоолын дагуу 7, 8 арга хэмжээ байна шүү дээ. Та энэ тогтоолоо харсан юм уу, хэрэгжүүлж болохгүй байна уу? Би тухайн үед аж ахуйн нэгжүүдтэй бүгдтэй нь уулзсан. Гурилынхантай уулзсан, тариаланчидтай уулзсан. Энэ дотор бүх үнийн асуудал чинь бол хүссэн хүсээгүй тэн дотор чинь монопол яваад байгаа шүү дээ. Монопол яваад байгаа. 37 аж ахуйн нэгж байсан хүн өнөөдөр яагаад 5, 6-хан аж ахуйн нэгж яг нидер дээрээ ажиллаж байгаа юм бэ? Та болохоор өрсөлдөөн гээд байх юм.

Харин энэ өрсөлдөөн чинь бий болж байж өнөөдөр энэ нь тогтворжоод, үнэ чинь тогтворжчихлоо шүү дээ. Тэр аж ахуйн нэгж чинь ямар юмных нь өрсөлдөөн байдаг юм бэ? Өчнөөн олон 30, 40 тэрбум төгрөгөөр нь 50 тэрбум төгрөгөөр нь дэмжлэгүүд аваад л ингэж явсаар байгаад л тэгээд л жижгүүдээ няц няц дарсаар байгаад л өнөөдөр 5, 6-ханаа л үйл ажиллагаа явуулж байгаа шүү дээ. Тэр аж ахуйн нэгжүүд дээр очоод ярьж байсан тэр аж ахуйн нэгжүүдийн өөрсдийн тэр том үйлдвэрлэлээ хамгаалсан яриа өнөөдөр таны амнаас өнөөдөр Хөдөө аж ахуйн яамны амнаас л гарч ирээд байна шүү дээ. Бодлогоос гарч ирээд байна шүү дээ. Би аж ахуйн нэгжүүдээ дэмждэг хүн, аж ахуйн нэгжүүдээ дэмждэг хүн. Аль болох том аж ахуйн нэгж биш аль болох бага, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж, жижиг, дунд үйлдвэрлэл байж байж 1 том аж ахуйн нэгж байх уу, эсвэл 10 жижиг аж ахуйн нэгж ажиллах уу, 10 дахин хүмүүс ард иргэд өөрсдөө амьжиргаатай болох уу тэр болгонд 1 ар гэр, 1 аж ахуйн нэгж, 1 хамт олон амьжиргаагаа дэмжиж явах уу гэдэг энэ бодлогыг л авч явдаг. Өнөөдөр Монгол Улсад ядуурлын хэмжээ хэд байгаа билээ, 30 хувьтай байгаа шүү дээ. Буугаагүй байгаа. 30 хувьтай байгаа. Энэ өндөр тоо шүү дээ. Бид нар энийг өнөөдөр ерөөсөө ярихгүй. Бид энэ заал дотор байж байгаа арга хэмжээ юуны эцсийн эцэст юуны төлөө явж байгаа юм бэ? Ард иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, тэднийг орлоготой болгох, тэдний хэрэглээний түвшнийг нь өндөрсгөх, хэрэглэж байгаа бүтээгдэхүүнийг нь аль болох хямдхан боломжийн үнээр л гаргах ёстой гэсэн ийм бодлогыг л бид нар барих ёстой шүү дээ. Худлаа биш шүү дээ. Хилийн цаана бүх зүйл хүнд хямдхан байгаа. Бүх зүйл хямдхан байгаа. Тэр Америкт нь ч тэр, Европт нь ч тэр, энэ гадаа, урд хойд хөршид ч тэр бүгдэд нь л хямдхан байгаа шүү дээ. Бид нар яагаад энэ бодлогыг энэ юундаа оруулж болохгүй байгаа юм, хөдөө аж ахуйн бодлого руу яагаад оруулж болохгүй байгаа юм? Хамгийн гол асуудал Өрсөлдөөний тухай хууль, худалдааны болон Дэмпингийн эсрэг хуулийг боловсруулж Улсын Их Хурлаар оруулж ир гэсэн. Энэ хууль хаана байгаа юм? Энэ хууль орж ирээгүй.

Дээрээс нь энэ Хөдөө аж ахуйг дэмжих сан, бирж. Энэ яагаад менежментийг нь бид нар сайжруулж явж болохгүй байгаа юм бэ, энийг яагаад арга хэмжээний дор нь оруулж ирээд Улсын Их Хурлаар оруулж ирж батлуулж болохгүй байгаа юм бэ ийм ийм арга хэмжээнүүд аваад яваач л гэсэн ийм зүйлийг л хэлье. Хариулт хэрэггүй. Зөндөө олон хариулт л сонслоо.

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн алга байна. Далайн Батбаяр гишүүн алга байна. Жигжидийн Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Баярлалаа. Засгийн газраас Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг оруулж ирсэн. Үзэл баримтлалынх нь хувьд дэмжиж байгаа. Энэ хууль яагаад гарсан бэ гэдгийг бүгдээрээ мэднэ. Тэр цаг үед Монголд цаг үеийн байдал, цас зудын байдал, давагдашгүй хүчин зүйлийн түвшинд оччихоод тэжээлийн маш их нэмэлт хэрэгцээ үүссэн юм. Тэрийг хангах нэг том бодлого байсан.

Хоёрдугаарт нийгмээрээ гурилын үнэ зохиомлоор дэндүү их өсчихсөн байна. Энийг арилгах ёстой. Ийм учраас импортын гаалийн татварыг нь чөлөөлж байж өрсөлдөөнийг бий болгоно гэж ингэж зорьсон юм. Ингэж энэ шийдвэр гарсан. Бас тодорхой бодит байдлуудыг ойлгуулж чадсан гэж би ингэж ойлгодог. Бүгдээрээ сэргэцгээсэн байх гэж би ойлгоод байгаа. Тариаланчид, гурил үйлдвэрлэгч нар хоорондоо олон жил толхилцсон юм. Үгүй бид хэдийн толхилцоод байсан ч ер нь худлаа толхилцоод байсан юм биш үү гэдгээ ойлгоцгоосон болов уу гэж ойлгоод байгаа юм. Нэг.

Хоёрдугаарт дан ганц тарифын хязгаарлалт үнэд нөлөөлөөгүй юм байна гэдгийг харуулж чадсан. Импортын гаалийн албан татвар 5 хувь л байсан. Энэ үнэд тийм хүчтэй нөлөө үзүүлэхээр бас тариф биш. Баруун бүс нутагт гурилын үнэ бараг 50 орчим хувиар өсчхөөд байсан. Гэтэл 5 хувийн тариф буулгахад тэр буугаад ирж байгаа байхгүй юу. Тэгэхээр энд тарифын бус ерөөсөө нийлүүлэлт, борлуулалтынхаа сүлжээ талд бидэнд юм байгаа юм байна гэдгийг тодорхой харуулсан. Үүнийг зохицуулах ёстой.

Хоёрдугаарт ер нь үнэ ямар байсан юм, ямар байж болох юм бэ гэдгийг энэ шийдвэр харуулж чадсан. Энэ хууль батлагдсанаар 8.7 хувийг л улсын дундаж 8.7 л хувиар л үнийн өсөлтөд нөлөө үзүүлсэн юм билээ. Тэгэхдээ үйлдвэр үйлдвэрээрээ янз, зарим нь 3 хувьтай буурсан, зарим нь 11 хувьтай буурсан ийм л дүн харагддаг. Бүс нутгаараа үзэхээр бас өөр гардаг. Тэгэхээр энэ дээрээс хараад би юу гэж бодоод байна вэ гэхээр зэрэг газар тариалан сул хөгжчихсөн бүс нутгуудынхаа гурил, гурилан бүтээгдэхүүний хэрэгцээг төр ямар байдлаар хангах юм бэ? Үүн дээр Хөдөө аж ахуйн яам ер нь ямар бодлого барьж байна вэ гэдэг асуудал байна.

Хоёр дахь асуудал нь энэ гаалийн тариф чөлөөлсөн хуулийг дагуулж газар тариалангийн үйлдвэрлэлээ хамгаалах зорилготой гаргасан тогтоол бий. Тэр тогтоолын хэрэгжилт ер нь юу болсон бэ гэдэг асуудал бид надад их ч чухал байгаад байгаа юм. Бид ер нь энэ татварын тухай ярих, тэрний цаад үйлдвэрлэл, хангалтын тухай ярихад анхдагч үйлдвэрлэл газар тариалангийн үйлдвэрлэлийг ярихгүйгээр энийг ярих боломжгүй. Тийм учраас бид бүтээгдэхүүн хийдэг будаандаа урамшуулал өгөөд явсан хэр нь будааг өөрийг нь бий болгодог үрэн

дээрээ ямар ч асуудал бариагүй. Энэ нь Монголын газар тариалангийн үйлдвэрлэлд нэлээн том доголдлыг бий болгосон.

Тийм учраас тэр технологийн нөөц бүрдүүлэлт, түүнд өгөх дэмжлэгийн асуудлыг Хөдөө аж ахуйн яам юу гэж ойлгоод байгаа юм бэ? Газар тариалангийн үйлдвэрлэлд хөгжчихсөн бүс нутгууд чинь энэ технологийн нөөцийг таваарын будааныхаа үнээр тариалах аж ахуйнууддаа өгчихдөг. Төрөөс нь таваарын улаан буудайны 50 хувьтай тэнцэх хэмжээний.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Батжаргал гишүүнд 1 минут нэмж өгье.

Ж.Батжаргал: Юун дээр ямар бодлого ямар зохицуулалт хийхээр тооцож байна вэ гэдэг нэг ийм асуудал байна. Дараагийн нэг асуудал суурилагдсан хүчин чадлын 30 хэдхэн хувийг ашиглагчаад хэдүүлээ үнэ яриад болж өгөхгүй байгаа улс. Үүнийг яаж дөхүүлэх юм бэ 800 гаруй мянган тонн будаа тээрэмдээд бараг 6 зуугаад мянган тонн гурил үйлдвэрлэх хүчин чадал байгаад байдаг. Тэгвэл Монголоос гурил авах сонирхолтой импортлогч нар хэр байгаа юм? Эд нарын хэрэгцээг хангахын тулд бид яаж тусгай зохицуулалттайгаар бараг будаа импортолж оруулж ирээд гаргах ёстой юм, эс үгүй бол хурааж авах ургацынхаа хэмжээг яаж нэмэгдүүлээд хүчин чадлаа гүйцэд ашиглах юм гэдэг л асуудал байгаад байгаа байхгүй юу. Манай гишүүд яриад байгаа гурилын үйлдвэрүүдийн тоо цөөрсөн байна, хэдэн монополууд байна гэж яахаараа цөөрдөг юм гэхээр уг нь энэ нийгмийн өөрийнх нь хууль бол үнэ, чанар хоёроо.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Хариулт өгье Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Үнэхээр гурилын үйлдвэрүүд цөөрсөн асуудал үнэ, чанарын өрсөлдөөн л ширүүн байна гэсэн үг шүү дээ. Тэгэхээр өрсөлдөөн энэ салбарт хангалттай байгаа гэдгийг салбар хариуцаж байгаа хүний хувьд хэлэхийг хүсэж байна.

Нөгөө талаар нөөц хязгаарлагдмал. Монгол Улс 1 сая 564 мянган км квадрат нутаг дэвсгэртэй. Үүний 900 орчим мянган га буюу 0.5 орчим хувь, 0.6 орчим хувьд нь л газар тариалан эрхлэх бололцоотой. Ийм байгаль, цаг уур, хөрсний өгөгдөлтэй. Тэр газар нь үндсэндээ төвийн бүсэд байдаг. Тэгэхээр яам өөрөө энэ төвийн бүс дээр Их Хурлын шийдвэрийг хэрэгжүүлж тэнд шилжиж очоод үйл ажиллагаа явуулж байгаа. Энэ нүдний цөцгий мэт хайрлах ёстой тэр 0.6-хан хувийн тэр газраас авах өгөөжийг, таримлын төрлийг нэмэгдүүлэх, мал аж ахуй эрсдэлээс хамгаалах, тэжээлийн баазыг нэмэгдүүлэх, тэнд үр сортын аж ахуйнуудыг бий болгох, эрчимжсэн аж ахуйнуудыг бий болгох энэ хэт төвлөрөл үүсээд байгаа төвлөрсөн хүн амын хүнсний хэрэглээг тогтвортой нийлүүлэлтийг хангах гэдэг л ийм ажил шүү дээ. Тэрнээс Улаанбаатарт суугаад хуралдаад байвал ажил явахгүй. Энэ манайх аж ахуйн яам аж ахуй дээр очиж ажиллах ёстой.

Тэгэхээр үнийн асуудал дээрх үнэхээр өргөн хэрэглээний гол суурь бараа мөн. Тэгэхээр энэ дээр ямар бодлого авч хэрэгжүүлэхээ бид нар оруулж ирнэ. Өнөөдрийн гол зорилт тариалалт эхлээд байдаг, тариаланчдыгаа улаан буудайгаа тарьцгаа гэдэг мессежийг л өгөх ийм хуулийн зохицуулалтыг л ярьж байгаа. Дараах зохицуулалтуудыг бид нар хаврын чуулгандаа багтаагаад оруулж ирье. Үнийг явал тогтвортой байх вэ, явал баруун бүсэд төвийн бүстэй адилхан нэг

үнэтэй байлгах вэ энэ бүгд л өөрөө санхүү, хөрөнгө оруулалт, бусад төрийн зохицуулалттай л холбоотой шүү дээ. Тэгээд би оруулж ирнэ. Тэр үед энийгээ бүгдээрээ дахиад тойроод нарийн хэлэлцье.

Энэ татвартай холбоотой 8 заалт өгсөн ийм арга хэмжээ гарсан тогтоол. Энийг хэрэгжилт дээр яриад байна. Хэрэгжилтийг яам өөрийнхөө хийх хариуцах ажлуудаа бүрэн хийсэн. Хөдөө аж ахуйн биржээр үрийн болон хүнсний улаан буудайг арилжих талаар судалж шийдвэрлэсэн, шийдвэрлэсэн. Бүх үр тариа, үр улаан буудай биржээр арилжиж байгаа. Хөдөө аж ахуйн корпорац элеваторыг тариаланчид ашиглах бололцоог бүрдүүлэх, чөлөөтэй ашиглаж гэрээлж хадгалж өгч байгаа. Дотооддоо хангаад илүү гарсан хүнсний будааг экспортлох бололцоог бүрдүүлнэ. Бүрдүүлсэн. БНХАУ-ын хорио цээрийн байгууллагад ажиллаад улаан буудайн экспортыг нээсэн. Харамсалтай нь тийшээ илүүчлээд гаргаад байх улаан буудай алга. Сүүлийн мэдээгээр 240 тонн улаан буудай, гурил экспортод гарсан л ийм дүн шинжилгээтэй байна.

Лаборатори, сорилтын үр дүнд үндэслэн баталгаажуулах чанарыг анхаар гэсэн. Энэ намар ямар ч чанарын маргаан гараагүй. Бүх будаа.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Үйлдвэр нийлүүлсэн бүх улаан буудайн чанар дээр маргаан гараагүй бөгөөд энд хамгийн сүүлийн үеийн лабораторийн тоног төхөөрөмж бүрэн суурилуулж дууссан. Гурилын үйлдвэр хөдөө аж ахуйн корпорацын элеваторуудад хүлээж авч байгаа будаа нэг стандартаар дүнг 5 минут дотор шинэчлээд тариаланчид нүдэн дээр нь гаргаад, 2 талаасаа акт зураад будааны чанарыг тогтоогоод явж байгаа.

Энэ Өрсөлдөөний хуулийн асуудал, худалдаа, Дэмпингийн хуулийн асуудал өөр харьяа байгууллагын асуудал. Стратегийн нөөц бүрдүүлэх зорилгоор жил бүр 100 мянган тонн улаан буудайг улсын нөөцөд худалдан ав гэсэн. Худалдан авах санал төслийг оруулсан. Улсын Их Хурал хассан. 26 онд төсөв дээр дахин оруулж ирнэ ээ, дэмжиж өгөөрэй.

Стандартчилал, техникийн зохицуулалтын стандартыг шинэчлэх асуудал энэ Стандартчилал хэмжил зүйн газрын эрхлэх асуудлууд нь өөрөө үндсэндээ яам энэ хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээгээ 100 хувь хариуцлагатай биелүүлсэн.

Д.Амарбаясгалан: Жигжидийн Батжаргал гишүүн тодруулж асууя.

Ж.Батжаргал: Тийм. Одоо ингээд базаад үзэхээр дан ганц гаалийн тарифаар ноцолдох биш юм байна лээ. Квот, бусад тариф тэгээд монополын зохицуулалтаар л ноцолдох юм байна лээ. Тэгж байж бид хэд амьд үлдэх юм байна лээ. Хятад Монгол хоёртой, Монгол Орос хоёртой Монгол өрсөлдөж чадахгүй байгаа нь масс үйлдвэрлэл тэдний давуу, боломж яг энэнтэй чинь адилхан Алтан тариа, Улаанбаатар хоёртой жижгүүд нь өрсөлдөж чадахгүй байгаа байхгүй юу. Хэрвээ эд нар үгсэн хуйвалдаад үнэ нэмсэн бол жижгүүд нь дагаад л босоод явчих ёстой шүү дээ. Тэгээгүй байна гэдэг нь тодорхой харагдаад байгаа

тэр 2 нь масс үйлдвэрлэл хийж байгаа учраас наад хэдэн жижиг нь тэр хоёртоо чирэгдээд ойчиж байгаа байхгүй юу.

Тийм учраас энд бид зохиомол үнэ байсан юм байна гэж ярих ямар ч боломжгүй боломжгүй байгаа юм. Эдийн засгийн агуулга, энэ зах зээлийг чинь мораль талаасаа харвал. Тэгэхээр хэдүүлээ ноцолдох юмаа зөв олж ноцолдъё, тариаланчдаа итгэл төгс тариа.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Нанзадын Наранбаатар гишүүн алга байна. Цэндийн Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Өнгөрсөн жил жил хүрэхгүй хугацааны өмнө 5, 6 сард байх Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг гараад ажилласан юм. Энэ гурилын, гаалийн албан татварыг тэглэх асуудлаар. 4, 5 хүнсний захуудаар явсан. 5, 6 гурилын үйлдвэрүүдээр газар дээр нь очиж үзэж танилцсан. Тэгээд тэр үед Хөдөө аж ахуйн яамныхан гаалийн үнэ, тарифыг тэглэх ёстой л гээд ингээд л ярьж байсан даа. Гурилын үнэ хаданд гарчихлаа. 2700, 800 хүрчихлээ кг гурил. 27, 8 мянгаар авдаг байсан 25 кг-ийн гурил 53, 4 мянга хүрч байсан.

Гэтэл өнөөдөр дараагийн сайд нь солигдонгуут л ингээд л эсрэгээрээ бодлого яриад л оруулж ирэх юм. Үгүй тэгээд энэ чинь ямар учиртай юм бэ? Төрийн бодлого ингээд сайд нар цаг хугацаатай томилгоотой шүү дээ. Тэгээд сайд нарыг дагаж энэ яамдын энэ тогтвортой ажиллаж байгаа төрийн албан хаагч нарын бодлого ингэж явмааргүй байна шүү дээ. Тэгээд жил хүрэхгүй хугацааны дотор гаалийн албан татвараас тэглэхгүй болохоо байлаа гэж ярьж байсан улсууд жил хүрэхгүй хугацааны дараа энэ хуулиа хүчингүй болгоё, энэ хуулийн үр өгөөж өгсөн ийм л юм яриад л сууж байх юм. Тэгээд өнөөдөр энэ хуулийн хэрэгжилтийг тэгвэл гүйцэтгэлийн хяналт шинжилгээ хийж үзсэн юм уу, үр дүнгээ өгсөн юм уу, гурилын үнэ буурсан юм уу? Эцсийн эцэст Монголын ард түмнийг л хямд үнэтэй, өртөг багатай гурилаар л хангах бодлого шүү дээ.

Тэгээд үндсэндээ яг үнэнийг хэлэхэд тухайн үед өнгөрсөн жил ШӨХТГ чинь Монополын эсрэг газар байгаа байх хяналт шалгалт хийгээд энэ хэдэн гурилын үйлдвэрүүд чинь хоорондоо үгсэн хуйвалдчихсан байна гэдгийг нь нотлоод тогтоогоод, акт торгуулийг нь тавьчихсан л байсан юм байна лээ шүү дээ. Зөвхөн гурил гэлтгүй Монголд чинь эмийн үйлдвэрүүд ч хүртэл хоорондоо үгсэн хуйвалдаад тэгээд энэ ШӨХТГ хуулиараа ерөөсөө ийм шүдгүй арслан юм шиг 20 сая төгрөгийн торгууль тавих эрхтэй, өөр ямар ч арга хэмжээ авч чаддаггүй, үйл ажиллагааг нь таслан зогсоож чаддаггүй ийм л хуультай яваа. Тэгээд нөгөө компаниуд нь бүүр сурчихсан. 20 сая төгрөгөө өгнө гээд тухайн компанийнхаа жилийн төсөв дээр нь төсөвлөчихсөн явж байгаа шүү дээ. Торгуулийнх нь 20 саяыг төлчихнө. Тэгээд л эцсийн эцэст цаана нь арга хэмжээ авагддаггүй, үйл ажиллагаа таслан зогсоогддоггүй өнөөдрийг хүрчихсэн. Энэний дунд Монголын ард түмэн үнэтэй гурил идээд байгаа. Тэгээд л намар болохоор хангалттай гурил будаа, тариа хурааж авлаа гээд яриад л байдаг, яриад л байдаг, тэгээд л өвөлжин, хаваржин үнэтэй гурил идээд л байгаа шүү дээ яг үнэнийг хэлэхэд.

Би бол энэ жилийн өмнө баталсан хуулийг өнөөдөр хүчингүй болгох гээд орж ирж байгаа энэ хуулийн төслийг дэмжих боломжгүй л гэж үзэж байгаа.

Боломжгүй гэж байна. Энэ ШӨХТГ-ын энэ акт торгууль өнөөдөр энэ ажлын хэсэг дээр яагаад энэ компани, газраас хүмүүс оруулж ирэхгүй байгаа юм? Энэ дүгнэлтийг яриулмаар байна шүү дээ. Ямар арга хэмжээ авагдсан юм? Энэний чинь цаана монополын л асуудал яригддаг юм байна лээ шүү дээ. Явж явж үнэ тарифын чинь цаана. Хэдэн газрууд хоорондоо үгсэн хувилж байгаад л төрөөс өчнөөн зуун олон тэрбум төгрөгийн хөнгөлөлт, зээл өгчөөд эргээд ард түмэн төр үнэтэй гурил иднэ гэж юу байх юм бэ. Ард иргэдээ үнэтэй гурил идүүлэх гэж тэр компаниудад зээл өгнө гэж бодлого баймааргүй юм. Тэр компаниуд чинь өдий зэрэг хөл дээрээ тогтоход төрийн дэмжлэг дээр, дэмжлэгээр зээлээр л үйлдвэрүүдээ тоног төхөөрөмжөө шинэчилсэн юм байна лээ шүү дээ. Шинэчилж авчхаад эргүүлээд хоорондоо үгсэн хувилж байгаад үнээ нэмж байгаад ард түмнийг үнэтэй гурил л идүүлж байгаа шүү дээ яг эцсийн дүндээ. Тэгээд энэ дээр сайд нь.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Ажлын хэсэг 9 дүгээр микрофон Болорчулуун дарга хариулт өгье.

Ц.Болорчулуун: Сандаг-Очир гишүүний асуултад хариулт өгье. Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун.

Өнгөрсөн жил бид бас гурилын импорттой, үнийн өсөлттэй холбоотойгоор энэ хуулийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Засгийн газраар дамжуулж Улсын Их Хуралд өргөн барьсан. Өргөн барихдаа энийг хугацаатай, тооны хязгаартай буюу 25 мянган тонн гурилыг 7 сарын 1-ний дотор оруулж ирэх ийм хуулийн төслийг өргөн барьсан байгаа. Ингээд хэлэлцүүлгийн шатад энэ хууль маань батлагдах мөчид тоо хэмжээний хязгааргүйгээр, хугацаагүйгээр батлагдсан юм. Тийм учраас бид энэ дээр дүн шинжилгээ хийгээд цаашдаа ийм байдлаар явах нь үр дүнгүй байна. Энэ тухайн үед батлагдсан хууль нь 1 жилийн хугацаанд хэрэгжихдээ үр дүнгээ өгсөн байна гэж тооцож энийг дахиж оруулж ирж байгаа асуудал байгаа гэж хэлье.

Д.Амарбаясгалан: Тийм, Болорчулуун дарга энэ үйлдвэрүүд хөнгөлөлттэй эргэлтийн хөрөнгийн зээлийг жил болгон 100 орчим тэрбум төгрөг авч гурил үйлдвэрлэж байна гээд та түрүүн хариулчихсан тийм ээ? Тэгээд энэ хөнгөлөлттэй зээл авч үйлдвэрээ эрхэлчхээд яагаад энэ өртөг өсөөд байгаа юм бэ гэдэг асуудлыг л бас жоохон тодорхой хариулаад л өгчихмөөр байгаа юм. Ялт ч үгүй санаа зовох энэ гишүүд орон нутаг, сонгогдсон тойрогт гурилын үнэ өсвөл бүх л бараа, бүтээгдэхүүний үнэ дагаад өсөх нөхцөл рүү орно. Харин зүгээр энэ арга хэмжээг авсны үр дүнгээр өнгөрсөн жилээс хойш үнэ нэмэгдээгүй 1 дүгээр гурил 8.9 орчим хувиар буурсан. 2 дугаар гурил 15.4 хувиар үнэ буурсан гэдэг статистикийн байгууллагын мэдээлэл байж байдаг. Мэдээж бусад бараа, бүтээгдэхүүн бол 10-15, 20 хувиар үнэ жилийн дотор өсчихсөн байгаа шүү дээ. Гурилын үнэ бол өсөөгүй хадгалагдсан. 1, 2 дугаар гурил үнэ нь буурсан гэдэг ийм үзүүлэлттэй байж байгаа.

Тэгэхээр одоо энэ асуудал шийдэгдсэний дараа яах вэ? Жишээлбэл өнөөдөр Улаанбаатар хотод ойрхон байгаа аймгууд хүртэл бараг баруун бүсээсээ илүү нугалсан үнээр өндөр үнэтэй гурил хэрэглэж байгаа шүү дээ. Төв аймгийн Баян сум дээр яваад очиход бол хамгийн өндөр үнэтэй гурил хэрэглэж байна. Төв аймгийн Эрдэнэсантад яваад очиход хамгийн өндөр үнэтэй гурил гэж. Гаалиасаа

хол, тээвэр ложистик нь ойрхон. Тэгсэн мөртөө хамгийн өндөр үнэтэй гурил. Монгол Улсын хэмжээнд Хэнтий аймаг 1 дүгээр гурилыг 3500 төгрөгөөр Хэнтий аймгийн сумууд худалдаж авч хэрэглэж байна шүү дээ. Тэгэхээр энэ асуудлаа яаж зохицуулах юм бэ, бодлогын зохицуулалт нь юу байх юм бэ л гэж асуугаад байгаа юм. Түүнээс биш салбарыг татаж унагаах, нураах гэдэг бодлого огт байхгүйг зөв ойлгох хэрэгтэй. Ямар зохицуулалт хийх гээд байгаа юм бэ гэдгийг чинь л гишүүд асуугаад байгаа юм. Тэгээд Болорчулуун дарга энэ дээр хариулт өгөөдхөөч. Ажлын хэсгийн 9.

Ц.Болорчулуун: Их Хурлын даргын асуултад хариулъя. Тэгэхээр өнгөрсөн жилийн гурилын огцом үнийн өсөлтийн асуудал 2022 оны намрын ургац хураалтын үед 2850 байсан шатахууны үнэ 4050 болж 40 хувиар нэмэгдсэн. Дээрээс нь Оросын Холбооны Улсын рублийн ханш 35 төгрөг байснаа 62 болж хүртэл нэмэгдсэн. Үүнтэй холбоотойгоор энэ тариалалтын бүх орцуудад ордог үндсэн 5 төрлийн орцын өртөг нэмэгдээд ингээд улаан буудайны өөрийн өртөг нэмэгдсэнтэй холбоотойгоор гурилын үнэ өсөлт харагдаж байгаа юм.

Мэдээж баруун аймгуудад ялангуяа эндээс Улаанбаатар хотоос 1600, 700 км-ийн алсад байх баруун аймгуудад тээврийн зардал шингэсэн үнээр гурил үнэтэй байсан. Энэ хуулийг баталж хэрэгжүүлснээр гурилын үнэ буусан, тогтворжсон. Тэгэхдээ хэрэглэгчид яг Монгол Улсын үйл ажиллагаа явуулж байгаа энэ 10-аад үйлдвэрийн түвшинд үйлдвэрээс гарч байгаа гурилын чанарын асуудал бол импортоор орж ирж байгаа тухайлах юм баруун аймгаар орж ирж байгаа зарим гурилын чанар энэ манай үйлдвэрүүдийн хаана ч хүрэхгүй гэдэг нь бол хэрэглэгчдийн түвшинд батлагдаж байгаа ийм асуудал байгаа. Тэгэхээр бас бид нар яг нэгэнт урагшаа алхсан чанар хэрэглэгчийнхээ түвшнийг бас 1 алхам бууруулмааргүй байна гэдгийг бас хэлэх нь зүйтэй байх гэж бодож байгаа.

Д.Амарбаясгалан: Улаанбаатар хотоос 200км-ийн-ийн зайд байгаа суман дээр яагаад дүгээр гурил 2800-3500 төгрөгийн хооронд зарагдаж байгаа юм бэ? Тээвэр ложистик хүнд биш, энэ чинь хол биш ойрхон. Тэгээд дотоодын гурил тэнд очиж яагаад ийм өндөр үнээр сонголтгүйгээр зарагдаж байгаа юм бэ л гэдэг асуултыг асуулаа шүү дээ. Баруун бүсэд магадгүй 1000, 1500 км-ийн цаана ийм өндөр үнэтэй зарагдаж байна гэвэл хүн бас ойлгож болно. Гэтэл Улаанбаатар хотод ойрхон байгаа цэгүүд дээр энэ гурил чинь яагаад үнэтэй байгаа юм бэ л гэдгийг асууж байгаа шүү дээ.

Ц.Болорчулуун: Бид түрүүн сайд бас энэ асуултад хариулсан байгаа. Ер нь салбарын үндсэн үүрэг чиг, зорилго бол тариалалтын хэвийн явуулж стратегийн бүтээгдэхүүн болох улаан буудайгаар гурилын үйлдвэрүүдийг түүхий эдээр бүрэн хангах нөхцөлийг л авч хэрэгжүүлэхэд том зорилгоо дэвшүүлж байгаа. Ингээд хаврын, бидэнд шаардлагатай 300 гаруй мянган тонн хүнсний улаан буудайг бид гурил үйлдвэрлэлтээ нийлүүлэхийн тулд төлөө ажиллаж байгаа. Тэгэхээр гурилын үйлдвэрүүдийн үнэ маань үйлдвэрийн үнээр нэгэн жигд үнээр гарч байгаа.

Дээрээс нь худалдааны шатад энэ хэд хэдэн дамжлагыг дамжиж гурилын үнэ нэмэгдээд байгаа ийм асуудлууд байгаа. Яг үйлдвэрийн үнэ бол нэг үнээр гарч байгаа, хямд гарч байгаа буюу өнөөдрийн байдлаар 1500-2050 төгрөгийн үнэтэй ийм гурил үйлдвэрийн үнээр гарч байгаа. Бид энд ярихдаа дандаа л үйлдвэрийн

үнэ л ярьж байгаа. Худалдааны шатад тодорхой хэмжээний нэмэгдлүүдийг.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: 23 оны ургацын байдлыг эргээд санаадхаарай. Тэгэхэд айхтар яг ургац хураалтын үеэр олон хоног дараалсан хур бороо ороод тариа өөрөө түрүүн дээрээ дахин соёолоод будааны чанарт их томоохон өөрчлөлт гарсан. Энэ бол дотоодын гурилын үйлдвэрийн нийлүүлэлтэд бас их нөлөөлсөн. Нөгөө талаас тэр шатахуун, бордоо, техник, сэлбэг хэрэгсэл, ургамал хамгааллын бодис гээд гол үнэ бүрдүүлж байгаа зүйлээ бид 100 хувь үндсэндээ Оросын Холбооны Улсаас импортоор авдаг шүү дээ. Тэгээд рублийн ханшийн өөрчлөлт энэтэй холбоотой үнэд өөрчлөлт маш хүчтэй нөлөөлсөн. Энийг их хаа хаанаа ойлгомоор байна.

Худалдааны энэ зохицуулалт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс цаашаа гараад хаана, ямар үнээр яаж зарах асуудал манай энэ эрхлэх асуудал бүүр ерөөсөө гарч явчхаад байгаа юм. Тэгэхээр энэ яг үнэндээ Монгол Улсад өнөөдөр худалдааны хууль байхгүй, гадаад худалдааг асуудал зөвхөн Гадаад яамаар дамжиж байгаа ,дотоод худалдааны зохицуулалт байхгүй бодит байдал ийм л байгаа. Тэгэхээр энэ.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулж асууя.

Ц.Сандаг-Очир: Өнгөрсөн намар гурилын үйлдвэрүүд газар тариалан эрхлэгчдээс тонн буудайг хэдээр авсан бэ? Ноднин бид нар газар тариаланчидтай ч уулзаж байсан, гурилын үйлдвэрийнхэнтэй ч уулзаж байсан. Гурилын үйлдвэрийнхэн болохоор тонн буудайг сая нэг зуугаар авсан гэж ингэж ярьдаг юм байна лээ. Газар тариалан эрхлэгчид нь болохоор гурилын үйлдвэрүүд бид нарын буудайг доош нь мяалсаар байгаад 600, 700-гаар чүү чай гуйж байж өгдөг өө л гэж байна лээ. Тэгээд энэ хоёрын хооронд бараг 300, 400 мянган төгрөгийн асуудал 1тонн буудайн дээр яригдаж байгаа байхгүй юу. Ингээд л наад гурилын үйлдвэрийнхэн чинь үгсэн хувилж байгаад л авах буудайгаа хямдаар авчихдаг, зарах гурилаа болохоор үнээ нэмээд зарчихдаг тэгээд ийм байгаа нөхцөл дээр та бүхэн маань ямар мэдээлэл, тооцоо, судалгаа хийж байна? Өнгөрсөн жил ямар үнээр авсан бэ гурилын үйлдвэрийнхэн, газар тариаланчдын буудайг?

Д.Амарбаясгалан: Харин тийм сая Энхбаяр сайдын хэлж байгаа шалтгаан бас байх шиг байгаа юм. Зарим жилүүдэд хур бороо багатайгаас болж ургац хураалт муудлаа гэж байгаа юм. Тэгвэл тэр үед нь үнэ нэмэгдчихсэн бол ургац хураалт сайтай байсан үед нь үнэ буурах үзэгдэл гэж юм байна уу? Иргэдийн хамгийн их бухимддаг зүйл тэр шүү дээ. Учир шалтгаануудыг дандаа тоочоод үнэ нэмж байдаг. Буурах нөхцөл үүсэхэд 1 ч төгрөгөөр бууруулдаггүй л гэж байгаа юм. Энэ хамгийн том асуудал байхгүй юу. Тэгэхээр өнөөдөр бид ингээд ярьж байгаа сэдэв маань ганцхан гурил, улаан буудайн импортын татварыг нэмнэ, нэмэхгүй, тавина, тавихгүй гэдэгтэй холбоотой гэхээс илүүтэйгээр энэ бодлого зохицуулалтын асуудал чинь юу байна вэ гэдэг дээр их төвлөрч яриад байна гэдгийг л их сайн ойлгомоор байна.

Болорчулуун дарга энэ дээр нэмж хариулъя. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Ц.Болорчулуун: Сандаг-Очир гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Тэгээд өнгөрсөн жилийн түвшинд бид нар 950-1'000'150-ын хооронд гурилын үнэ, буудайны үнэ тогтож авсан байгаа. Тэгэхээр хүнсний улаан буудай стандартын шаардлага өөрөө 4 ангилалтай. 1, 2, 3, 4 дүгээр зэргийн ангилалтай байгаа. Тэгэхээр энэ 950 гэдэг бол хамгийн доод талын буюу 4 дүгээр ангиллын будаа. Тэгэхээр 6, 700 мянган төгрөгийн үнэтэй улаан буудай гэдэг өөрөө гурилын гурил үйлдвэрлэлд шаардлагыг нь хангаж тэр үйлдвэрт орох боломжгүй ийм будаанууд байгаад байгаа юм. Тэгэхээр энэ өөрөө стандартын шаардлага хангаагүй буудай учраас гурилын үйлдвэрүүд бол энийг зөвхөн тэжээлийн зориулалтаар авч байгаа ийм л будаа. Манай цаг агаарын нөхцөл байдалтай тэгээд бас аж ахуйн нэгжүүдийн зарим аж ахуйн нэгжүүдийн өөрсөдтэй нь холбоотойгоор энэ.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Болорчулуун дарга нэмж гүйцээж хариулъя. Тэгэхдээ байна шүү дээ зөвхөн тэжээлийн зориулалтаар авч байгаа гэж та хэлээд байгаа юм. Гэхдээ 1 тонн тэжээл ямар үнэтэй байгаа билээ зах зээл дээр? Та тэрийгээ бас давхар хариул тэр чинь хаягдал биш байхгүй юу. Тэжээлээ бас зарж байгаа шүү дээ. Тэжээлийн зориулалтаар авна гэхээсээ илүү өөрөө энэ чанарын шаардлага хангахгүй учраас гурилын стандартын чанарын шаардлага хангах учраас шаардлага хангах нь тэжээлийн стандартын шаардлага л хангах будаанууд байгаад байгаа юм. Тэглээ гээд 6, 700 мянган төгрөгөөр тэр тэжээлийн стандартын шаардлага хангасан буудайг гурилын үйлдвэрүүд бүрэн авах бас боломжгүй.

Яагаад гэвэл өөрөө энэ үнэтэй ийм өндөр технологийн тоног төхөөрөмжүүд тавьчихсан энэ үйлдвэрлэлд энэ буудай өөрөө тэнцэж орох ийм боломжгүй байгаад байгаа учраас зүгээр ер нь тэжээл үйлдвэрлэлд ийм үнээр байж болох юм гэдэг цааш нь ингээд, шувууны аж ахуй ч гэсэн яг гурилын бараг стандартын шаардлага хангасан буудайг л авч байгаа. Тэгэхээр энэ тэжээлийн үйлдвэрүүдэд л энэ будаа орох юм гэдэг байдлаар үнэ тогтож байгаа болохоос биш яг тэрийг тэнцэхгүй, шаардлага хангахгүй гэдэг 700 мянгаар үнэлээд тэжээл аваад байгаа асуудал байхгүй байгаа гэдгийг хэлье.

Энхбаяр сайд нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ бол тариаланчдын хариуцлагын асуудал. Тариаланчид өндөр чанарын, хольцгүй цэвэр үйлдвэрлэлд тэнцсэн будаа тарьж тушаах ёстой. Яагаад гэвэл энэ өөрөө ард түмний өргөн хэрэглээний бараа. Тэгээд чанар муутай, ажлаа муу хийгээд, техник боловсруулалт технологио мөрдөөгүйгээс болоод чанар муутай ургасан улаан буудайг хүнсний үйлдвэрүүд аваад ард түмэнд хүргэж болохгүй. Энэ зүй ёсны асуудал. Бид энэ дээр тэжээлийн үйлдвэрүүдийг нэлээн дэмжиж энэ Атрын 4 дүгээр аян бодлогын хүрээнд тэжээлийн хэд хэдэн том үйлдвэрүүд ашиглалтад орж байна. энэ нь өөрөө нөгөө гахай, тахиа, шувуу, сүүний аж ахуйн тэжээлүүдийг үйлдвэрлэх, өсвөр малыг бордох, тэжээх, нөгөө экспортын чиг баримжаатай дээрээс нь төв суурин газрыг байнгын шинэ махаар хангах ийм аж аж ахуйнуудыг олон арваар бий болгох зорилготой явж байгаа.

Ер нь бид тэгээд энэ Атрын 4 дүгээр аянаар газар тариалангийн талбайгаа нэмье. Хүн ам өсөн нэмэгдээд байна, хэрэглээ эрс нэмэгдээд байна.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Хүн амын өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангахын тулд хүн ам 1 сая орчим байхад манайх 1 сая орчим га талбайг эргэлтэд оруулсан юм. Атрын 1, 2 дугаар аяны хүрээнд хүн ам 3.5 сая дээр ойрын үед 4 сая хүрнэ. Дээрээс нь 1 сая орчим жуулчин дотоод энэ хүнсний хэрэглээнд оролцож бас Монгол Улсад зорчиж байна. Тэгэхээрээ бид нар тариалалтын талбайгаа Атрын 4 дүгээр аяны хүрээнд 200 мянган гагаар нэмэгдүүлье. Үр тариа, төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамлынхаа тариалалтыг нэмэгдүүлэхгүй бол одоо манай зах зээл бас дутагдалд ороод дутаад байгаа буюу үндсэндээ экспортлох ийм чадавх байхгүй, дотоодын хэрэглээн дээрээ л бид нар асуудал яриад байна шүү дээ.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Ганзориг гишүүн асуулт асууя.

П.Ганзориг: Бид нар энэ үндэсний үйлдвэрлэлүүдээ дэмжих, дотоодын зах зээлээ хамгаалах, тэр тусмаа стратегийн хүнсний бүтээгдэхүүн болох энэ гурилыг дотоодоосоо бүрэн хангах дээр бол анхаарч дэмжиж ажиллах ёстой. Тиймээс энэ би гурилын энэ импортын татварыг сэргээх энэ хуулийн төслийг дэмжиж байгаа.

Ер нь бид нар 2 юмыг салгаж харж ярихгүй бол болохгүй байна. Нэгд ард иргэдэд энэ гурил болох яг энэ ард иргэдийн амьжиргаанд нөлөөлж байгаа гол хэрэглээний сагсанд ордог бүтээгдэхүүнийг зохимжтой үнээр, тохиромжтой үнээр хүргэх энийг зохицуулах бол импортын гаалийн татвараар зохицуулдаг зүйл биш. Энийг бид нар дотооддоо Өрсөлдөөний хууль болон холбогдох бусад зохицуулалтуудаараа зохицуулаад явах ёстой.

Гэтэл бид нар иргэдэд хямд үнээр гурил хүргэх гэсэн зорилго нь зөв хэдий ч гаалийн татвараа тэглэж, гаднаас бүтээгдэхүүнээ хараат болгож ингэж Монгол Улсынхаа бүхэл бүтэн салбар зах зээлийг бас золиосолж болохгүй. Одоо хойд хөршөөсөө бид нар эрчим хүч, нефть гээд хамааралтай байж байна. Дахиад гурилаас хамааралтай болох гэж байна шүү дээ. 40 хувийн хамааралтай стратегийн бүтээгдэхүүн 37 гурилын үйлдвэр байсан. Төрөөс явуулж байгаа татаас бодлого байгаа оноогүйгээс болоод 9 үйлдвэр байж байгаа. Тэндээс энэ гаалийн татвар тэглэснээс хойш 3 үйлдвэр нь хаалгаа барьсан гэж байна. Энэ үйлдвэрүүд босож ирэх гэж дор хаяж 5 жил болно буцаж. Тариаланчид тариалангийнх нь хэмжээ буурч байна. Түүнийг дагасан тоног төхөөрөмжүүдийн бас бизнесүүд бас дампуурч байна.

Хоёрт валютын нөөцөө яаж нэмэгдүүлэх вэ, ханшаа яаж тогтвортой байлгах вэ гээд л ингээд л зориод л ажиллаад байдаг. Нөгөө талд нь яг энэ гурилын импортын татварыг тэглэсэнтэй, гаалийн татварыг тэглэсэнтэй холбоотой 60 сая доллар бас гараад явчхаж байгаа юм. Цемент дээр бас тэгсэн үндэсний үйлдвэрлэлүүд босож ирж байсан 20 орчим хувийн гаалийн татвартай байсныг 5 болгож бууруулсан. Бас хэдэн 100 сая доллар гарч явсан. Ингээд валютын нөөц буурдаг ,ханш өсдөг. Ингээд төр засгийн бодлого бас уялдаатай байх, ёстой

тогтвортой байх, ёстой тодорхой байх ёстой гэдэг бас зарчмыг бид нар бодолцох ёстой гэдгийг бас хэлмээр байна.

Ер нь бол энэ үнийг тогтвортой байх, зохиомол үнийн өсөлтөөс хамгаалах асуудлыг бол бүгд санал нэгтэй дэмжиж энэ дээр бодлого зохицуулалтаа хийж ажиллах ёстой гэж харж байгаа. Тэгээд энийгээ бол бид нар дотооддоо Өрсөлдөөний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоороо хийх ёстой. Тэрнээс гадаадын, хөрш улс орнуудынхаа бид нар бизнесийг, эсвэл бүтээгдэхүүнийг оруулж ирж энэ зах зээл дээр дотоодын үйлдвэрүүддээ ингэж хүнд цохилтууд өгч зохицуулалт хийнэ гэдэг бол энэ Монгол Улсын төр засгийн бодлого биш байх гэж бодож байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Ганбатын Хосбаяр гишүүн асуулт асууя.

Г.Хосбаяр: Бид бүхэн жоохон бодит байдлыг бас яг газар дээрээ, амьдрал ахуй дээр, хөдөө орон нутагт ямар байгааг бас ярих шаардлагатай байх гэж бодож байна. Өнөөдөр хөдөө орон нутагт энэ гурилын асуудал, ноолуурын асуудал 2 маш чухал асуудал яригдаж байна. Би Өвөрхангай аймгийн Богд суманд төрж өссөн Сумын төвийн хүүхэд. Өнөөдөр Өвөрхангай аймгийн Богд суманд Улаанбаатар хотоос 630км зайд 50кг-ын ууттай шуудай гурил 115 мянган төгрөгийн үнэтэй байна. Ноднин өдийд 105 мянган төгрөгийн үнэтэй байсан юм байна. Ноднин ноолуур эсрэгээрээ 145 мянган төгрөгийн үнэтэй байсан 1кг ноолуур. Ноднин 700гр ноолуураар 50кг-ын ууттай гурил авч болдог байсан бол энэ жил ноолуурын үнэ буурчихсан 90-100 мянга болчихсон. кг 100, 200гр ноолуураар 1 уут гурил авч байна. Тэгэхээр бид нар гурилын үйлдвэрийг энэ салбарыг ингээд бодлогоор дэмжээд, хөнгөлөлттэй зээл өгөөд, ингээд төр бодлогоор хүртэл дэмжээд л татварыг нь хүртэл импортын татварыг хүртэл ингээд нэмж өгч байна. Гэтэл гурилын үнэ нэмэгдэхгүй гэсэн баталгаа байна уу? Энэ дээр салбарын сайд гурилын үнэ нэмэгдэхгүй, тогтвортой байна гэдэг баталгааг хэлж өгөөч.

Нөгөө талдаа бас ноолуурын салбарыг зөндөө дэмжиж байгаа тухай бид ярьж байна. Өчигдөр хамгийн сүүлд 500 тэрбум төгрөгийн вексель гаргаж байгаа, бичиж өгч байгаа, бас урьд нь ингээд хөнгөлөлттэй эх үүсвэр шийдэж өгсөн. Одоо ингээд үндэсний үйлдвэрүүд ноолуур аваад ноолуурын үнэ тогтвортой байна ингээд байдаг. Гэтэл энэ жилийн тухайд ноолуурын үнэ буурчихсан байна. Тэгэхээр хөдөөгийн иргэдийн тэр дундаа малчдын амьдралд хэрэглэдэг бараа, бүтээгдэхүүн хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн гурилын үнэ нь нэмэгдээд байхад эсрэгээрээ ноолуурын үнэ буюу гол орлого олдог энэ зүйл нь үнэ нь буураад байна.

Тэгэхээр энэ хоёр ноолуур гурил хоёр дээр хоёулан дээр нь ингээд Монгол төр энэ Хүнс, хөдөө аж ахуйн салбарын яам ингээд дэмжээд хөнгөлөлттэй зээл өгөөд бүх талаар дэмжээд байхад гурилын үнэ болохоор нэмээд байдаг, ноолуурын үнэ нь болохоор ингээд буураад байдаг. Тэгээд энэ дээр тайлбар хэлээч. Өчигдөр салбарын сайдтай ярьж байхад ноолуураа угааж самнаад гаргахаар бас ноолуур тогтворжино л гээд байна.

Тэгээд яг бид нар угааж самнасан ноолуураа дэлхийн зах зээлд хааш нь гаргах юм бэ? Өмнө нь өмнөх жилүүдэд Хятад руу зөвхөн угаагаад гаргахад аваад

цааш нь дахин боловсруулаад зардаг байсан бол одоо дараагийн шатны буюу угаагаад самнаад гаргахаар яг Хятадууд авах юм уу? Эсвэл бид нар дараагийн зах зээл Европ руу ч юм уу, Америк руу ч юм уу, өөр зах зээлийг зориод байгаа юм уу? Хятад маань тарифт орчихсон учраас Хятад руу түүхий самнасан, угаасан ноолуур гаргахаар авахгүй байгаа шахуу юм яриад байдаг. Гэтэл яг дахиад бид нар дараагийн шатын боловсруулалт хийгээд угаагаад, самнаад гаргахаар авах юм уу энэ Хятад маань?

Ер нь тэгээд энэ малчдын яг бодит амьдрал дээр байгаа энэ орлогыг нэмэгдүүлэх, буцаагаад хэрэглэж байгаа энэ бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах энэ зүйл дээр онцгой анхаарахгүй бол хөдөөд иргэдийн амьдрал олж байгаа орлого нь буураад хэрэглэж байгаа бараа бүтээгдэхүүн, шатахуун тос, инфляц өсөөд байна. Энэ тал дээр бас анхаарна уу.

Хоёрдугаарт нь малын тэжээлийг бас ингээд л гаалийн татвартай болгож байгаа юм байна л даа. Тэгээд бид нар чинь нөгөө талдаа Евразийн хэлэлцээрт хүртэл ороод л мах, махан бүтээгдэхүүн гаргана гээд байдаг. Мал, мах экспортлох асуудал дээр чинь энэ тэжээлийн асуудал бас чухал асуудал шүү дээ. Тэгэхээр ер нь яг Монгол маань энэ ирээдүйд хийх мал махны экспортынхоо тэжээл, энэ баяжуулсан бүтээгдэхүүнийг бүрэн хангах тийм хүчин чадал байгаа юу? Яг тэр технологи юм нь болж байгаа юу? Ирээдүйд бид нар чинь махны том зах зээлийг зорьж байгаа. Энд.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд хариулт өгье. Уг асуудал хэлэлцэх хугацаа дууссан байна. Үүнтэй холбогдуулаад 6, 5 гишүүн асуулт асуухаар байгаа учраас гишүүдийг асуулт асууж дуустал 1 цаг хүртэл хугацаагаар сунгаж болдог учраас сунгая. Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Үнэхээр энэ гадаад орчны эрс өөрчлөлттэй холбоотойгоор дэлхийн улс орон болгон ийм тарифын бодлогоор дотоод зах зээлээ хамгаалсан, сөргөлдсөн ийм нөхцөл байдал үүсээд байна. Энэтэй холбоотойгоор манай гол экспортын түүхий эд болсон нүүрс үндсэндээ 230 доллар байсан нүүрс өнөөдөр 70 доллар болж унаж байна шүү дээ. Харин үйлдвэрлэлтэй тулдаа, бид боловсруулах чадавхтай тулдаа ноолуурууд үндэсний үйлдвэрүүд нь аваад энд онцлон тэмдэглэмээр байна Их Хурлын даргын дэмжлэгтэйгээр сая Монголбанкнаас өрийн бичиг гаргаж үйлдвэрүүдээ ноолуур худалдан авалтыг дэмжих ийм том шийдвэр гарч байгаа. Энэтэй холбоотойгоор үндэсний үйлдвэрүүд маань энэ дотоодоосоо ноолуураа авах, үнийг тогтвортой хангах бодлогоо аваад явчихна. Гол зах зээл болсон урд хөрш маань өөрөө 130, бараг 200 хувийн гаалийн худалдааны татварт орчихсон гол зах зээл дээрээ. Тэгээд урд хөрш маань идэвхжил сул, дотоодоос худалдан авалт үндсэндээ байхгүй байгаа. Өдийд бужигнаж байдаг шүү дээ. Байхгүй байгаа. Ноолуурын, гол угаасан ноолуурын, самнасан ноолуурын гол зах зээл Европын зах зээл.

Тэгэхээр Монгол Улс шууд түүхий ноолуураа Хятадад өгөөд Хятадууд боловсруулалт хийгээд Европ руу гаргадаг байсан бол одоо бид дотооддоо 100 хувь боловсруулалтаа хийгээд 100 хувь угааж самнаад экспортод гаргах ийм үйлдвэрлэлийнхээ чадавхыг бүрдүүлсэн буюу үйлдвэрүүд технологио техникийнхээ хүчин чадлыг нэмж чадсан. Ийм болохоор үүнийг тогтвортой барьж чадаж байгаа. Үүнтэй адилхан гурилын үйлдвэрүүдээ барьж чадаж, газар

тариалангаа, энэ хүнсний хувьсгал бодлогоо өөрөө сэргээсэн тулдаа бид гурил үнийнхээ тогтвортой байдлыг хангаж чадаж байгаа. Тэгээд энд юу хэлээд байна гэвэл үндэсний үйлдвэртэй байна гэдэг маань өөрөө тогтвортой байдал, эрсдэлийг даван туулах, нөгөө үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх гэдэг маань өөрөө л яг энэ. Үйлдвэрлэдэг, ургуулдаг, тарьдаг, бүтээдэг улс орон бол аль болох л энэ хямралыг багаар даван туулна.

Тэжээл мөн адилхан. Тарилт дээр бид нар тэжээлийн таримлыг эрс нэмэгдүүлнэ. Газар тариалангаа 200 мянган га-гаар нэмнэ. Энэ нь өөрөө бидний нөгөө махны экспорт нүүдлийн мал аж ахуйгаа ган зудын бэрхшээлээс даван гарахад тэр чадавхыг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд л тэжээлийн таримлуудаа болон тариалалтын талбайг нэмж байгаа. Мөн экспортын зах зээлийг нь бас нээж өгөх ажлыг хийж байгаа.

Тэгэхээр янз янз. Алт гэхэд өнөөдөр 3500 болоод дээд рекордоо хийж байна. Хүнс дээр дэлхийн улс орон болон хүнсний өсөлт явж байна. Бусад аж үйлдвэрлэл, олон төрлийн бараа бүгд унаж байгаа ийм л ийм янз янзын байдал гарч байна. Улс орон болгон хүнс дээрээ л онцгой анхаарч байна. Ерөөсөө хүнсний нөөцөө бүрдүүлэх дээр анхаараад л, хүнсээ тарифаар хамгаалаад л энэ рүүгээ бүүр нийтээрээ.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Ганбатын Хосбаяр гишүүн тодруулж асууя.

Г.Хосбаяр: Одоо Монгол чинь 8000 тонн ноолуур бэлтгэдэг гээд байгаа. Үүнийхээ надад ирсэн мэдээллээр 30 орчим хувиар нь үндэсний үйлдвэрүүд эцсийн бүтээгдэхүүн хийгээд экспортолж байгаа. Үлдсэнийг нь угааж самнаад 5600 орчим тонн ч юм уу ноолуур гаргана гээд байгаа. Тэгээд яг энэ 5600, 5000 гаран тонн угааж, самнасан ноолуурын маань Хятадын зах зээлд нийлүүлж Хятадын зах зээл авах юм уу, эсвэл Европ руу гаргах юм уу? Магадгүй Европ руу гаргана гэвэл тэр тээвэр ложистик, тэр гэрээ, хэлэлцээр юм нь хийгдсэн юм уу? Нөгөө төр баахан баталгаа гаргаад баахан ноолуур авчихдаг нөгөө мөнгө цаас нь түгжигдээд, нөгөө экспорт нь хийгдэхгүй ийм асуудал үүсчихгүй биз дээ? Монгол чинь хаварт хэдэн 100 сая долларын эх үүсвэр ноолууран дээр орж ирдэг энэ маань энэ жилийн тухайд ингээд зогсчихоод байна. Тэгэхээр энэ дээр тэр яг угааж самнаснаа өөрөө хааш нь экспортлох юм бэ?

Д.Амарбаясгалан: Жадамбаагийн Энхбаяр гишүүн, сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр: 30 хувиа дотооддоо эцсийн бүтээгдэхүүн хийж байна. Үлдсэн 70 хувийг нь угаагаад, самнаад экспортод гаргана. Экспортын гол зах зээл Европ холбоо. Үүн дотроо Итали улс гол текстилийн гол салбар, гол брэндүүд тэнд төвлөрч байгаа. Тэнд монгол ноолуурыг бусад олон төрлийн хольц болон дангаар нь янз бүрийн даавуу, нэхмэл, ээрмэл сүлжмэлээ хийж байгаа.

Мөн Англи улсад нэлээн хэмжээнд авч байна, Франц улсад авч байна. Сүүлийн Японы зах зээл, Солонгосын зах зээлд их идэвхжилттэй байна. Америк ноолуурын салбарын маш том хэрэглэгч. Үндсэндээ Хятадын зах зээлийн хамгийн том хэрэглээ бол Америкийн зах зээлд байдаг. Энэ зах зээл өөрөө тарифын хязгаарлалт, зохицуулалтад орсон тул хэрвээ бид энэ үйлдвэрээ өргөтгөх энэ бодлогыг хийж амжаагүй байсан бол манай ноолуур маш хүчтэй уналтыг амсах

ийм байгаа. Нэгэнт дотоодын үйлдвэрлэлгүй юм чинь тэгээд гол нийлүүлдэг үйлдвэрлэл нь хязгаарлалтад орохоор үнэ 50, 60 мянгаас хэтрэхгүй байх хэмжээ нь унахаар байсан.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Дамбын Батлут гишүүн асуулт асууя.

Д.Батлут: Өдрийн мэнд хүргэе. Би бас Байнгын хороон дээр хариулт авч чадаагүй асуултуудаа ахиж асуух гэж байгаа юм. Гурилын импортын татварыг тэглэж үр дүн гарсан. Яг үнэндээ өнөөдөр зах зээл дээр гурилын үнэ тогтвортой байх боломжийг бас бүрдүүлэхэд нөлөөлөл үзүүлсэн гэж харж байгаа юм. Гэтэл одоо 1 жилийн дараа ахиад импортын татвараа сэргээе гэдэг асуудлыг оруулж ирж байна. Хөдөө аж ахуйн яамны энэ бодлого 1 жилийн настай ийм бодлого болж хувирч байгаа юм. 21-23 онд ямархуу байсан бэ гэдэг талаар. 21-23 онд буудайны үнэ 1 тонн тутамд 26.4 хувиар өссөн байна. Гэтэл гурилын үнэ 1 тонн тутамд 52.3 төгрөгөөр өссөн байгаа. Энийг Шударга өрсөлдөөний газар тухайн үеийн Шударга өрсөлдөөний газрынхан судлан үзээд үндэслэлгүй үнэ нэмжээ гэдэг асуудлыг гаргаж ирж тавьсан.

Тэгвэл 21-23 онд энэ компаниуд ямар дэмжлэг авсан юм бэ? 9 компани 38.8 тэрбум төгрөг, 10.65 хувийн хүүтэй авснаас 7.65 хувийн хүүг нь Засгийн газар дааж аж ахуйн нэгжүүд 3-хан хувийн хүү л төлсөн. Энэ татварын хүүд татвар төлөгчдийн мөнгөнөөс 2.93 тэрбум төгрөг зарцуулсан. 22 онд 8 аж ахуйн нэгжид 81.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Үндсэндээ 20-24 он хүртэл 209 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон байгаа юм. Хөнгөлөлт үзүүлсэн. Бүүр зээлийн хүүг нь төлөлтийг нь хүртэл хариуцсан байгаа шүү дээ төр. Үгүй ийм байж байхад гурилын үнэ нь өссөөр байдаг энэ бодлогыг чинь ямар бодлого гэх юм бэ? Тэгэхээр Хөдөө аж ахуйн яамны гаргаж байгаа бодлого монопол хэдэн компанийн кармад орчихсон байна гэж харагдахаар байгаа юм шүү.

Тэгээд энийгээ та бүхэн хариулаарай. Би доромжлоод байх юм биш. Энхбаяр гишүүнээ би асуудал бүрэн эрхийнхээ хүрээнд асуулт авч, танаас хариулт авах гэж байгаа. Та дундуур нь хэрэлдээд байх юм байх ч үгүй. Энэ асуудлууд дээр хариулт өгөөч. Дэмжээд л байгаа. Татвар төлөгчдийн мөнгөнөөс хөнгөлөлттэй зээл олгож байна, зээлийнх нь хүүг нь төлж байна бүүр. Ингээд байхад гурилын үнэ өсөөд байгаа асуудал. Ийм учраас л бид нар гурилын импортын татварыг тэглэх асуудал яасан. Одоо жилийн дараа ахиад энэ асуудлаа сэргээе гэж байгаа асуудал дээрээ яагаад ингэж байгаа талаар хариултыг авъя. Бид нар учир шалтгаанаа тодорхойлж чадсан юм уу, чадаагүй л байгаа яг үнэндээ. Мэдээж үндэсний үйлдвэрлэлүүдээ дэмжихгүй сөхрүүлчихье гэж байгаа 1 ч бодолтой гишүүн энэ танхимд байхгүй гэж харж байгаа шүү.

Хоёрдугаарт нь хүнсний аюулгүй байдлыг сайжруулах ёстой, үр дүн гаргах ёстой гээд хараад байгаа юм. Өнгөрсөн хугацаанд Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан 59 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг судалгаа хийсэн байна л даа 241 дээжээс шинжилгээ хийгээд үзсэн чинь 80 дээж буюу 30 орчим хувь нь чанарын шаардлага хангахгүй ийм улаан буудай байна гээд. Тэгээд энэ дээрээ ямар арга хэмжээ авсан юм? Бид нар тэгээд яагаад арга хэмжээ аваагүй мөртөө хүнсний аюулгүй байдлын тухай асуудлыг яриад болж байгаа юм уу? Энийг нь асуунгуут би харж үзээ ч үгүй, юун судалгаа вэ яасан ийсэн гээд асуудал ярьж байгаа.

Гуравдугаарт нь энэ салбар бас төвийн бүсийн салбар болж хувирч байна л даа. Манай Пүрэвдорж гишүүн жоохон дутуу мэдээлэлтэй байх шиг байна. ЖДҮ-лэгчдийг дэмжих чиглэлээр 40 тэрбум төгрөг батлагдсан. 26 тэрбум нь төвийн бүс дээр хуваарилагдаж байна. Үгүй бусад 5 бүс чинь тэнд ЖДҮ эрхэлдэг хүмүүс байхгүй юм уу? Тэнд нь Монгол Улсын Засгийн газрын бодлого хэрэгжихгүй юм уу?

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Жадамбаагийн Энхбаяр сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр: Нэгдүгээрт ЖДҮ-ийн газрыг дэмжих бүх аймагт хүсэлт явуулсан. 25 оны төсөв батлахдаа ЖДҮ-ийг дэмжээч, баталсан эх үүсвэр дээр бид нар нэмэгдүүлж олгоно гэж 21 аймагт явуулсан 10-аад аймаг тодорхой хэмжээний эх үүсвэр тавьсан. Зарим нь 150 сая төгрөг тавьсан, зарим нь 400 сая төгрөг тавьсан, зарим нь 5 тэрбум төгрөг тавьсан. 5 тэрбумд тавьсан газар бид нар 5 тэрбум нэмж өгсөн, 150 сая төгрөг тавьсан газар 150 саяыг нэмж өгсөн. Нөгөө доор Улсын Их Хурлаас сүүлийн 5 жил ЖДҮ-ийг дэмжих чиглэлээр оруулсан 1 ч хөрөнгө оруулалт байхгүй. Бид байгаа нөөц хэмжээндээ энэ мөнгийг яавал үржүүлж гэдэг зорилгоор орон нутагт хандаад та нар анхаарвал бид анхааръя. Нэг.

Нөгөө талаас ЖДҮ-лэл маань гол байгаа бүс нутаг, тэнд л энэ зорилго тэндээ л илүү очиж байна. Тэр чинь харьцаа, тооны хэмжээнд байгаа шүү дээ. Зарим орон нутаг мөнгө тавиагүй ерөөсөө. ЖДҮ-ээ бид дэмжихгүй л гэсэн ийм хариу өгсөн. Чанарын асуудал ярилаа. 241-ийн дээжийн 30 гэж яриад байгаа юм. Ямар чанараа яримаар байна? Цавуулаг нь муу байсан юм уу, шилэнцэр нь муу байсан юм уу, яг юу нь юм, ислэг нь муу байсан юм уу энэ чинь. Тухайн тухайн ургац аль аж ахуйн нэгжээс шалтгаалаад энэ чинь өөр өөр гарна шүү дээ. Эндээ тааруулаад энэ чинь 4 ангиллаар үйлдвэрлэлийн болон тэжээлийн гээд бүх спиртийн гээд энэ чинь хуваагдаад таарсан таарсан зориулалтаараа л явдаг шүү дээ. Улаан буудай хаягддаггүй шүү дээ. Хамгийн доод чанарын үзүүлэлттэй нь тэжээл болоод л явна. Ямар ч чанар үзүүлэлт тэнцэхгүй байсан юм тэр нь л шалтгаалаад л дараагийн бүтээгдэхүүн болно. Тэгэхээр энийг нийтэд энэ Монгол Улсын тарьсан улаан буудай, үйлдвэрлэсэн гурил чанаргүй гэсэн маягаар ойлгуулах гээд байна. Тийм зүйл байхгүй.

Дэмжлэг авсан үйлдвэрүүд ажлаа хийсэн. Швейцар, Туркийн технологиор иж бүрэн шинэчлэгдсэн. Үүгээр хаана ч бардам хэлнэ. Манай гурилын үйлдвэрийн бүтээгдэхүүн Оросын Холбооны Улсын гурилаас чанарын хувьд хол илүү.

Тийм болохоор төрөл бүрийн нарийн гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдээд байгаа нь энэ. Энэ хоригтой холбоотойгоор зөвхөн дээд гурилын үнэ өсөөд бусад нь унаж байгаа нь бас энэтэй холбоотой. Импортыг бүгдийг нь тэглэхихье гэдэг бодлого манай яамны бодлого биш байсан. Сая тайлбарлалаа шүү дээ. Хохирлыг багасгахын тулд 25 мянган тонныг л татваргүй оруулж ирээд энэ нөхцөл байдлыг цэгцэлье гэсэн. Их Хурал дээр 100 хувь боомтын хязгаарлалтгүй авна гэдэг шийдвэр гарсан.

Д.Амарбаясгалан: Дамбын Батлут гишүүн тодруулж асууя.

Д.Батлут: Ингээд үндэслэлгүй нэмсэн гэдэг нь шударга ёсны, тухай үеийн Шударга ёсны газрынхнаар шалгалтаар тогтоогдсон асуудал. Дээрээс нь татвар төлөгчдийн мөнгөнөөс хэдэн зуун тэрбумаар тэр байтугай хүүд нь хүртэл, хүүг нь хүртэл татвар төлөгчдийн мөнгөнөөс төлчихөөд гурилын үнэ нь өсөөд байгаа бодлогыг хөдөө аж ахуйн салбарын бодлого гэж бүгдээрээ яриад суух нь зөв юм уу? Та энэ дээрээ хариулаад өгөөч.

Хоёрдугаарт нь 40 тэрбумын, 26 тэрбум төвийн бүсийн 3 аймагт тавигджээ. Наад 3 аймаг чинь тэгээд 26 тэрбумыг бүгдээрээ гаргаж байгаа юм уу давхар, ингээд 52 тэрбум хөрөнгүүд хийж байгаа юм уу? Битгий үлгэр яриад байгаарай сайдаа. Та бол төвийн бүсийн хөдөө аж ахуйн сайд биш шүү. Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын бүхий л аймаг таны энэ салбарын салбар байгаа тэр бүхэндээ хүртээмжтэй үйл ажиллагаа явуулах нь таны үүрэг шүү. Тэгээд ер нь тэгээд Хүнс, хөдөө аж ахуйн яамны энэ.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд нэмэлт хариулт өгье.

Ж.Энхбаяр: Монгол Улсын хүн амын маань 70 хувь энэ төвийн бүсэд нь байна. Нийт үйлдвэрлэл явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн бараг 95 хувь нь энэ бүсэд байна. Тэгэхээр энэ зориулалт нь тэр зориулагдсан газраа л очно. Энэ төвийн бүс чинь газар тариалангийн үйлдвэрлэлийн 90 хувь энд л явагдаж байна. Бодит байдал шүү дээ. Би тэгшитгэн хуваах бололцоогүй шүү дээ энэ чинь. Энэ өөрөө яг үйлдвэрлэл дээр очих ёстой л зээл. Би эх үүсвэрээ л бэлдээд гаргаад өглөө байгаа эх үүсвэрээ дандаа хөнгөлөлттэй зээлийн хүүгийн татаас болгоод өглөө. Арилжааны банкнууд энэ зээлийн олголтыг хийгээд ингээд шалгаруулалт явагдаж байна. Газар дээр нь очоод танилцаж болно. Энд хэлэхэд төвийн бүс гэж яриад байна. Бид төвийн бүс дээрээ тулгуурлаж хөдөө аж ахуйгаа л босгож ирнэ, хөнгөн хүнсний үйлдвэрээ босгож ирнэ. Өөр бидэнд ийм байгалийн нөөц байхгүй юм. Юм ургадаг, тарьдаг.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Тэгэхдээ би бас Ерөнхий сайд, Засгийн газарт хэлээд байгаа энэ бүсүүдийн хөгжлийн бодлогыг бас эн тэнцүү авч явахгүй бол энэ иргэдийн эрхийн томоохон зөрчлийн асуудал яригдана шүү. Газар тариалан хөгжөөгүй бүсэд амьдарч байгаагаараа иргэд хохирч болохгүй учраас Энхбаяр сайд та бас энэ дээр бас гишүүдийн саналыг бас бодолцоорой тийм ээ. Тэгэхгүй бол бүсүүд тэр чигтээ хаягдаад байж болохгүй шүү дээ. Газар тариалангүй юм чинь гээд л тэр чигтээ хаягдаад л, магадгүй аягүй бол мал аж ахуй үгүй юм чинь гээд хаягддаг хэлбэр рүү ерөөсөө явуулж болохгүй шүү. Энэ бол бас асуудал үүсэх байх.

Ганбатын Очирбат гишүүн асуулт асууя.

Г:Очирбат Өдрийн мэнд. Энэ манай монгол төрийн бодлого галзуу хүний өдрийн тэмдэглэл шиг л явах юм даа. Тэгээд 1 жилийн өмнө оруулж ирсэн хуулиа өнөөдөр ингээд өөрчлөх гээд сууж байдаг. Тухайн үед батлагдаж байсан үзэл баримтлалын хүрээнд хуулийн үр дүн ер нь ямархуу байсан юм Энхбаяр сайд аа? Энийгээ та бас их сайхан тодорхой тайлбарлах хэрэгтэй байгаад байна.

Хоёрт гэх юм бол энэ 4 жилийн хугацаанд 209 тэрбум төгрөгийг энэ том аж ахуйн нэгжүүдэд өгсөн. Тэр аж ахуйн нэгжүүдтэй яг уулзаж байгаа юм уу? Ямар шалтгааны улмаас энэ үнийг өсгөөд, хөөрөгдүүлээд байгаа юм? Ер нь бодлогын шийдвэр гаргасан юм бол энийгээ хэвээр нь үлдээгээд өшөө өрсөлдөх бодлогын ямар боломжууд байна гэдэг дээр Хүнс, хөдөө аж ахуйн яам, дээрээс нь сайд энэ дээр бас бодлогын түвшинд судалгааны бичиг баримтууд хийсэн юм уу хийгээгүй юм уу? Одоогийн мөрдөж байгаа хууль дээр шүү. Оросын зах зээл дээр дахиад өрсөлдөх өшөө ямар бодлогоор дэмжвэл үр дүн гарахаар байна гэдэг дээр судалгаа хийсэн юм уу, үгүй юм уу. Ер нь манай энэ Хүнс, хөдөө аж ахуйн яамныхан бас ийм төрийн бодлогоо барьж явахгүй бол нэг сайд очихоор дарга нар нь бүгд өөр болчихдог, байгаад байдаг зан характер, тухайн үеийн батлуулж байсан хуулийн үзэл баримтлал дээр ингээд өөр байр суурь илэрхийлээд байдаг ийм хандлага яваад байдаг.

Ер нь энэ хүнс, хөдөө аж ахуйн салбар түрүүн зарим гишүүдийн хэлээд байгаа бас бодитой шүү дээ. ЖДҮ-лэлийн салбар гээд түрүүн гишүүн асуухаар газар тариалангийн салбар гээд татаж оруулж ирээд тэгээд хэдэн ах сайд нар маань өөрийнхөө сонгогдсон бүс дээр тэр мөнгө аваачиж хуваарилдаг энэ байдлаа хэзээ зогсох юм? Зарим юмыг үнэнээр хэлмээр байна шүү дээ. Энэ Шинэ хоршоо ингээд л асуудалд орно шүү Энхбаяр сайд аа. Яг энэ гурил шиг. Тухайн үед сонгуульд зориулаад л ийм юм хийчихсэн. Өнөөдөр үр дүнгээ бид нар ингээд бүгдээрээ хэлэлцээд л сууж байна. Сонгуулиас сонгуулийн хооронд төрийн бодлогыг өөрчилдөг ийм юм байж болохгүй байна.

Ялангуяа энэ хүнсний салбар дээр, газар тариалан, мал аж ахуйн салбар дээр, аж үйлдвэрийн салбар тогтвортой явж байж хөгжих ёстой. Тэгээд энийгээ бас болимоор байдаг. Энхбаяр сайд сүүлийн үед ингээд Их Хурал баталж өгсөн л гэдэг яриатай болсон. Мөнгө төгрөг байхгүй байна Их Хурал баталж өгсөн тэрний хүрээнд л ажиллаад байна гээд байдаг. Үгүй та сайд бодлого боловсруулах ёстой, хөрөнгө оруулалт татах ёстой, гадна дотнын байгууллагуудтай боломж бололцоог нь нээх ёстой, хуулийн төсөл дээрээ ажиллах ёстой. Миний мэдэхийн л өнгөрсөн 12 сард тантай уулзаж байгаад хуулийн төслөө удахгүй өргөн барина гэсэн одоо хүртэл ингээд өргөн бариагүй л байдалтай байж байгаа.

Хамгийн сүүлд хэнд хариуцлага тооцох юм бэ? Зүгээр ингээд яриад өнгөрөөд байдаг бид нар цаашдаа ингээд яваад энэ улс эх орон хөгжихгүй гэдэг нь харагдаж байна. Ямар нэгэн хүн энэ хуулийн төслийг өргөн барьсан, ямар нэгэн бодлогоор дэмжээд явсан ийм алдаа оноотой байсан юм бол хэн хариуцлага тооцох юм, хэнд тооцох юм? Хариуцлага тооцож байж дараа дараагийн сайд нар дараа дараагийн дарга нар үр ашигтай ажлуудыг хийж үр дүнд хүрэхгүй бол тэгээд л ийм цаг хугацаа өнгөрөөсөн, асуулт асуухаар амыг нь тагладаг хэдэн хариулттай. Үр дүнгээ л ярья. Энэ хуулийг баталснаараа ямар үр дүн гарсан бэ? Яагаад өөрчлөх гээд байгаа юм бэ? Одоо энэ батлагд байгаа хууль дээрээ илүү дахиад дэмжээд энэ гаднын зах зээлтэй өрсөлдөх боломжуудаа нээж өгөхгүй юм уу? Дотоодын хөрөнгө оруулагч нар, гадаадын хөрөнгө оруулагч нараа энэ мал аж ахуй, газар тариалангийн салбар дээрээ нээж оруулж ирэхгүй юм уу? Зах зээлээ тэлэхгүй юм уу? Ийм тодорхой асуултууд дээр Энхбаяр сайд багцлаад Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас хариулчхаарай. Тэгээд тодруулъя.

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр: Засгийн газар Улсын Их Хурлын баталсан бодлого, Улсын Их Хурлын баталсан төсвийн хүрээндээ л үйл ажиллагаа явуулдаг. Жил жилийнхээ төсөв мөнгөний бодлогоор бодлогууд орж ирдэг. Их Хурал дэмжвэл тэр бодлого тусгал болоод л, төсөв болоод л явдаг. Тэр хүрээнд ажил явж байгаа. Тэрнээс сайдын сайн дурын уран сайхан гэж байх боломжгүй шүү дээ. Нэг.

Хоршоодын асуудал хөндлөө. Хоршоодын асуудал үндсэндээ нийт хоршоод зориулсан эх үүсвэрийн 90 хувь нь орон нутаг, төвийн бүсээс бусад газар л байгаа. Яагаад гэвэл хаана мал аж ахуй байна, хаана хоршоо зохион байгуулдаг юм тэнд л эх үүсвэр нь очиж байгаа. Нөгөө талаас хоршооны асуудлыг Шадар сайд Амарсайхан хариуцдаг, хоршоо хариуцсан үндэсний хороо байдаг. Тэр хүрээнд энэ зохион байгуулалт хэрэгжилтийг хангаад явж байгаа. Энэ амжилттай явж байгаа. Малчид нэгддэг хөдөлмөрөөрөө хоршдог болж байгаа. Шаардлагатай санхүү эх үүсвэрээр нь маш хүчтэй дэмжиж байгаа. Энэний үр дүнд түүхий эд бэлтгэл, энэ ноос ноолуур, арьс ширний. Цагаан алт болон бусад бодлого энэ дээр холбогдож орж ирж байгаа. Ингээд цогц явуулах гэж л оролдож байгаа зүйл шүү дээ. Хуулиудыг бэлдээд үндсэндээ түрүүчээс нь ажлын хэсгүүд Их Хурлаас гарчихсан ажиллаж байгаа. Тэр ажлын хэсэгтэйгээ бид хамтраад хуулийн төслүүд дээр ажиллаж байна. Гол гол хуулийн удахгүй хөдөө аж ахуйн ерөнхий хуулиас авхуулаад ер нь хөдөө аж ахуй гэдгээ бид нар сайн ойлгоод авъя.

Ер нь хөдөө аж ахуй манай тулгуур салбар мөн үү, уул уурхайгаас ангид эдийн засгийг босгоод хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарыг хэрхэн хөгжүүлж бодох юм бэ гэдэг асуудлыг нэг мөр оруулж ирж Улсын Их Хурлаар бас бодлогын асуудлыг шийдүүлнэ. Тогтвортой байдлаа хангахын тулд улаан буудай гурил дээр нөөцийн асуудал байгаа. Нөөц жил болгон 100 мянгаас доошгүй улаан буудайн худалдан авч байж стратегийн нөөц бүрдүүлээд үнэ өссөн үед нөөцөөсөө гаргаж үнэ тогтворжуулдаг, үнэ хямдхан үед нөөцөө зузаатгаж байдаг ийм л бодлогыг хэрэгжүүлчихэд энэ газар тариалангийн салбар ингээд л жигдрээд л хэл амгүй явчихна. Тэр зохицуулалт хийх үүрэг, эрхийг нь энэ Засгийн газарт хариуцсан яаманд нь өгчихвөл тэгээд зохицуулаад л явчихна шүү дээ. 300-гаад мянган тонн үр тариа нийтдээ багадаа 300 гаруй тэрбум төгрөгийн л бүтээгдэхүүн байхгүй юу.

Гэхдээ энийг хийхийн тулд мянга мянган тариаланч, олон мянган хүний хүч хөдөлмөр, олон бэлтгэн нийлүүлэгч оролцож байж хийдэг ийм бүтээгдэхүүн салбар шүү дээ. Тэгээд 26 оны төсвийн бодлоготой нийцүүлээд бид нар оруулах бүх бодлогоо оруулж ирнэ. Энэ жижиг, дундыг үнэхээр дэмжих хэрэгтэй байна. 4 их наядын хүсэлт байна. Бидэнд эх үүсвэр байхгүй. Байгаагаа бид нар эргэн төлөлтөөр маневрлаад ингээд ийм хэмжээнд эх үүсвэрийг хөшүүрэгдсэн маягаар нэмж чадаж байгаа нь л энэ. Жижиг, дундаа дэмжиж байгаа аймгуудад л мөнгө нэмээд л, дэмжээд л, хамтраад л хүчийг нь нэмж байгаа. Манай энэ хэрэгжүүлж байгаа бодлого мөн адилхан шүү дээ. Дандаа банкнуудад зээлийн хүүгийн татаас өгөөд мөнгөө өсгөж байгаа. 10 тэрбумыг 100 болгож эдийн засагт оруулж байгаа л бодлого шүү дээ.

Д.Амарбаясгалан: Хариулт авлаа. Харин тийм. Энэ Энхбаяр сайдын энэ хөдөө аж ахуйг дэмжих бодлогыг бол Их Хурал сайн дэмжиж өгмөөр байгаа юм. Ялангуяа саяын хэлсэн тэр стратегийн нөөцөө бүрдүүлэх төсвийг Энхбаяр сайд

ирэх 7 хоногоос энэ төсвийн хүрээ хэлэлцээд эхлэх юм байна лээ. Асуудлаа дэвшүүлээд Улсын Их Хурлын гишүүддээ сайхан ойлголт өгөөд дэмжүүлэх хэрэгтэй. Ер нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжинэ гэдэг бол тодорхой хэмжээний хөнгөлөлттэй зээлтэй байж байж л хөдөө аж ахуйн үйлдвэрлэл аль ч улсын жишгээр босож ирэх боломжтой учраас Улсын Их Хурал ч гэсэн энэ дээр бас онцгой анхаарч энэ хөдөө аж ахуйн салбарын бодлогыг бас сайн дэмжиж өгөх нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай бас байгаа.

Бадрахын Найдалаа гишүүн асуулт асууя.

Б.Найдалаа: Энэ гурилын татварыг тэглэснийг буцаан татвартай болгож байгаад дэмжиж байгаа. Гэхдээ энэ дээр ноцтой нэг зүйл байна. Аливаа татвар гаалийн татвар ч байна уу, орлогын татвар ч байна уу урт хугацааны ийм бодлогын шийдэл байдаг. Гэтэл бид нар богино хугацааны түр зуурхан асуудлыг тэр урт хугацааныхаа бодлогыг хууль өөрчилж байгаад, татвараа өөрчилж байгаад шийдэх гэж оролдсон байна. Энэ бол яг Монгол Улсын Их Хурлын хувьд бол, бодлогын хувьд үнэхээр том алдаа гэж бодож байна. Жижигхэн асуудал гарангуут том асуудлаа хууль гаргаж байгаад өөрчилчих эргээд өөрчилж чаддаггүй ч юм уу ийм байж болохгүй. Тэгэхээр энэ бол урт хугацааны, богино хугацааны асуудлыг урт хугацааны бодлогын хэрэгслээр шийдэх гэж оруулж байгаа нь том алдаа байна.

Хоёрт нь бас зүгээр сая ингээд сонсоод байхад энэ хууль өөрөө ямар зорилготой байсан нь тодорхойгүй болчихоод байна. Энэ хууль батлалцаж байсан, оруулж байсан яам гишүүд ч энд байна. Нэг болохоор гурилын үнийг тогтворжуулах гэсэн ч юм шиг, инфляц үнийн өсөлтийг бүр улсын хэмжээнд буулгах гэсэн ч юм шиг эсвэл хуйвалдсан компаниудыг хашраах гэсэн ч юм шиг, нэг бол гурилын импортыг дэмжих гээд байгаа ч юм шиг ийм эргэлзээтэй, яг тодорхойгүй хоорондоо маргасан байдал үүсээд байгаа байхгүй юу. Энэ бас харамсалтай байна. Тэгэхээр асуулт ийм л асуулт байна л даа. Ямар ч байсан тодорхой энэ хэлэлцүүлгээс ч харсан тариаланчид гурилын үйлдвэрүүдийн хэлж байгааг бодсон ч, харсан ч, үнэлсэн ч яг шалтгаан нь яг гаалийн татвар биш байна. Сая хэлж байна бас тээвэр ложистик байна, өртгийн асуудал байна, бизнесийн орчны асуудал байна, зээлийн хүүгийн асуудал байна, цаг хугацааны асуудал байна гээд.

Тэгэхээр хамгийн гол нь асуух гэж байгаа нь би бас Болорчулуун даргаас асууя. Энхбаяр сайд бас хариулна биз ер нь зүгээр цаашдаа яах юм? Ингээд л үнэ өсөөд ирлээ гэхэд гаалийн татвараа дахиад л эргүүлээд л татвараа тэглээ, нэмье, буулгая гээд оруулаад ирэх юм уу? Одоо тэр тээврийн зардлыг яах юм, эсвэл бүсүүд дээр ту ялгаатай бодлого хийх юм уу? Үндэсний үйлдвэрлэлээ дэмжсэн хэр нь, гурилтайгаа хэр нь, чанартай гурилтай хэр нь үнийг нь яаж тогтвортой байлгах юм энэ дээр энэ гаалийн татварыг л ганцхан тэглэж буулгаад, нэмж хасаад ингээд маргалдаад байдаг биш өөр ямар бодлогын хэрэгслүүд, ямар дэмжлэгүүд авч хэрэгжүүлэх юм бэ? Баруун бүсэд яаж гурилын үнийг тогтвортой байлгах юм? Энэ төвийн бүсээс өөр болж таараад байгаа байхгүй юу.

Тэгээд энэ дээр ялангуяа Болорчулуун дарга яамны яг институц нь өөрөө ямар бодлоготой байгаа юм? Яагаад гэвэл би ингэж асууж байна гэхээр яг жил хүрэхгүйн өмнө, жилийн өмнө яг энийг ингээд оруулж ирж байсан байгаад байгаа.

Одоо эргээд тэр бодлого нь хэвээрээ байна уу, эсвэл бодлого нь өөрчлөгдсөн байна уу, цаашдаа ер нь яах юм гэдгийг сайд болон Болорчулуун даргыг хариулж өгөөч гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье Болорчулуун дарга ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Ц.Болорчулуун: Найдалаа гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр өнгөрсөн жил хууль барихдаа яг энэ гурилын үнэ тогтворжуулах, үүссэн нөхцөл байдалтай холбоотойгоор авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ учраас тоон хязгаар хэмжээтэй, хугацаатай бас байсан юм. Яагаад гэхээр хаврын тариалалтын үед гурил будааны асуудал яригдахаар намрын буудайны үнэд нөлөөлчихдөг учраас. Бид нар 7 сарын 1-нээс өмнө оруулж ирээд энэ гурилынхаа асуудлыг 25 мянган тонныг оруулж ирээд тэгээд үнэ тогтворжуулаад, тариалалтаа хэвийн явуулаад намар ургацаа хурааж аваад ингээд бид нар ийм хэмжээний будаа, гурилтай байхад ингээд гарсан асуудлыг шийдэх нь гэдэг байдлаар явсан нь тэгээд батлагдахдаа ингээд өөр байдлаар батлагдсан учраас энэ хуулийн зорилго биелсэн гэж үзээд дахиж энэ хуулийг оруулж ирж байгаа юм. Тэрнээс яг бодлого ингээд жилийн дотор хувираад шал өөрөөр 360 градусаар эргээд байгаа асуудал биш байх гэж хэлмээр байгаа юм.

Ер нь бол цаашдаа мэдээж хүн амыг чанартай, эрүүл, дотоодын үйлдвэрлэлээр гурилаар хангах ийм төрийн бодлого хэвээрээ байна. Тэгээд бид нар баруун бүсэд тодорхой хэмжээний жишээлбэл арга хэмжээнүүдийг авч байгаа. Баруун бүсийн Увс аймгийн Баруунтуруун сумд гэхэд бид нар 10 мянган тонны элеваторыг бариад үүнийг түшиглэсэн гурилын үйлдвэр байгуулаад баруун бүсийнхээ гурилын хангамжийг нэмэгдүүлье гэсэн.

Дээрээс нь зүүн бүсдээ бас энэ 10 мянган тонны элеваторын асуудлыг бас улсын төсвөөр ингээд авч хэрэгжүүлээд явж байгаа. Тэр бол гурилын үйлдвэрүүд мэдээж энэ дээр гурилынхаа үнийг улаан буудайн өөрийн өртөгтэй уялдуулаад яг зохистой хэмжээнд нь барих нь гурилын үйлдвэрүүдийн үүрэг. Тэрнээс энийг зохиомлоор үнэ хөөрөгдүүлэх нь бол мэдээж байж болохгүй асуудал. Энэ дээр тэр хөндлөнгийн хяналт шалгалтын байгууллагууд нь байнга хяналтаа тавьж тодорхой асуудал гарвал хариуцлага тооцож явах үүрэг чиглэлтэй. Бид бол ер нь хүн амын хүнсний хангамж буюу түүхий эд, анхдагч түүхий эд буюу стратегийн бүтээгдэхүүн болох улаан буудайгаараа яг гурилын үйлдвэртэй хангамжийг тогтвортой хангах чиглэлд л энэ бодлогоо чиглүүлж явж байгаа гэж хэлье.

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ ганц гурилаар өдөөгдөж гарч байгаа асуудал ганц гурилын асуудал биш. Ер нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, дотоодын энэ хөнгөн хүнсний жоохон үйлдвэрлэл, газар тариалангийн асуудал. Ер нь энэ дээр цаашид ямар бодлого байх юм бэ гэдэг асуудлыг л энэ гурил дээр тойрч гарч ирээд байна гэж би ойлгоод байна.

Нэгдүгээрт, худалдааны хуулийн асуудлыг яаралтай бий болгож өгмөөр байна. Худалдаа зохицуулалтгүй, гадаад худалдаа зохицуулалтгүй, дотоод худалдаа зохицуулалтгүй. Ялангуяа стратеги гэж байгаа улаан буудай, гурилын

хангалт дээр төр оролцох уу оролцохгүй юу гэдэг асуудал шүү дээ. Бас айхтар асуудал. Оролцвол яаж оролцох юм, яаж тогтвортой үнийн нийлүүлэлтийг хангах юм. Хэрвээ төр оролцоод үнэ дээр зохицуулалт хийнэ гэвэл нөөц бүрдүүлэх асуудал албан ёсоор Их Хурлаар төсөвтөө жил болгон тогтмол авч хэрэгжүүлэх ёстой гэх мэтчилэн ийм бодлогууд байгаа юм. Бид нөөцөө бариагүй байж байж үнэ зохицуулах гэхээр савлагаа үүсэж байна. Энийгээ гааль, импортоос чөлөөлөхөөр дотоод үйлдвэрлэл хүндрэл үүсэж байна гээд энэ гурил их сайн жишээ болж байна гэж би үзэж байна. Гурил энэ.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Бадрахын Найдалаа гишүүн тодруулж асууя.

Б.Найдалаа: Тодруулаад асуулт биш саяын санаагаа тодруулчихъя. Түрүүн Болорчулуун даргын хэлж байгаа тэр үг бодлого хэвээрээ байж болно. Гэхдээ Улсын Их Хурал чинь жил болгон хуулийг ингээд л өөрчлөөд л 180 градус эргээд л нэг тавиад л, нэг буцаагаад л ингэдэг байгууллага биш. Тэр хууль бол нэлээн урт хугацаанд хэрэгжиж байж жинхэнэ яг бодлого болж шингэнэ. Тэгэхээр харин гол нь энэ дээрээ нөгөө хуулиас гадна бусад яамны хэмжээний эсвэл өөр хөшүүргээр бодлогуудыг хийгээд явж байхгүй бол яг зөвхөн хууль нь дулдуйдаад ингээд явах юм бол маш эрсдэлтэй буруу гэж бодож байна. Зарчмын хувьд бүр эрс буруу. Энэ хууль жишээлбэл ямар нэгэн байдлаар уначихвал яах юм, амжихгүй яах юм? Одоо тариалалт болох гэж байдаг. Тэгэхээр чинь ингээд аюултай байгаад байгаа биз дээ. Тэгэхээр ерөөсөө ингээд дараа нь ингэхдээ заавал хуулиар дамжиж ч юм уу тийм бүдүүлэг байдлаар, Их Хурлаар дамжиж ингэж шийдэж байгаа нь буруу л гэж хэлээд байгаа юм. Тийм болохоор яаман дээр арай өөр бодлогын хэрэгслүүд.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Энэ хуулийн хэрвээ энэ хуулийг өөрчлөөд дэмжээд өгвөл засаг эрхээ авчхаж байгаа юм. Засаг өөрөө зохицуулалтаа хийгээд л аль боомтоо нээх вэ, ямар бараан дээр квотоо нэмэгдүүлэх вэ, хаагуур экспорт, импортоо дэмжих вэ, татах вэ гэдэг бодлогоо л хийгээд явна. Өмнө нь дандаа ингээд шуурхай ажиллагаа хийгээд яваад байдаг бололцоотой байсан юм. Шатахуун дээр чинь бас тэгдэг шүү дээ. Шатахуун хомсодвол татвараа буулгана, шатахуун нийлүүлэлт байвал татвараа бас өсгөнө гэдэг юм уу ийм татварын зохицуулалтаа, боомтын зохицуулалтаа хийдэгтэй адилхан энэ улаан буудай, гурил дээр би ийм зохицуулалт хийгээд байх бололцоо байгаа. Тэгээд тэр эрхээ авахгүй заавал Их Хурлаар ордог болох болчихсон ингээд хууль болчихоор ингээд жил тойроод хуулийн процедур болоод ингээд байгаад байгаа юм. Тэгэхээр ер нь их шуурхай байдлыг л хангаж өгөөч гэж оруулж ирж байгаа зүйл шүү дээ. Бид шуурхай байдлаа хангаад ингээд зохицуулалтаа хийгээд явах бололцоотой ийм бараа, бүтээгдэхүүн, дотоодын чадавх бий болчихсон байна, тариаланчид нь бэхэжчихсэн байна, үйлдвэрүүд нь байна.

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн асуулт асууя.

Б.Батбаатар: Энэ хууль батлагдах үед 25 мянган тонн улаан буудай татваргүй импортлох зорилго тавьж энэ хуулиа оруулж ирж батлуулж байсан юм байна. Тэгээд яг бодит байдал дээр болохоор 64, 5 мянган тонн болчихсон. Тийм Их Хуралд өөрчлөхөд энэ хуулийг оруулж ирсэн зорилго эвдэгдчихээд байна шүү

дээ анхны санаачлагч. Тийм болохоор ингээд энэ хууль хэрэгжиж байх явцад гурилын үнэ 10 хувиар, гурилан бүтээгдэхүүний үнэ 50 орчим хувиар өссөн гэсэн ийм тооцоо гарсан юм байна. Тэгээд энэ тооцооноос үнэ болон энэ жишээ нь тэжээлийн импорт ч гэсэн 2 дахин өссөн гээд тооцооноосоо нөгөө хууль үйлчилснээр Их Хурал зарим талд нь нээж өгч чөлөөлснөөр ингээд нөгөө хүссэн зорилтот түвшиндээ очоогүй. Тэгэхээр тэр хүсэж байсан зүйлээс өөр үр дүн гарч байна гэдэг чинь эргээд дотоодын үйлдвэрлэлдээ шокийн байдалд цохилт өгөөд эхэлж байгаа шүү дээ. Тэгэхээр Энхбаяр сайдаас ингээд асуумаар байгаа юм. Бид нар Улсын Их Хурал дээр болон Засгийн газар тодорхой асуудлуудыг шийдээд энд ингээд асуулт, хариулт тавиад явж байгаа боловч энэ бодлогын шийдвэр ингэж гарч байна гэдэг сигналыг иргэд, үйлдвэрлэгч, хэрэглэгчдэдээ хүргээд байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ татвартай болгож байгаа бодлого, таныг сайдаар ажиллаж байх хугацаанд дахиж өөрчлөгдөхгүй. 24 оных шигээ ингээд ийм 1 жилийн дараа буцааж өөрчлөх хууль оруулж ирэхгүй. Нэг ёсондоо үйлдвэрлэгчид, тариаланчид, гурилын үйлдвэрүүд, энэ чиглэлийн хүнсний үйлдвэрүүд энэ хугацаанд санаа зоволгүй үйлдвэрлэлийнхээ процесс дээр цаг хугацаагаа тооцоод ажиллаж болно гэдэг энэ зүйлийг их тодорхой бодлогын хувьд гаргаж хэлмээр байгаа юм. Хууль батлагдах явцад.

Тэгвэл нөгөө бизнес хийж байгаа хүмүүс маань эрсдэлээ тооцоод, ашиг алдагдлаа тооцоод ажиллах боломжтой болно. Гадаадын хөрөнгө оруулалт дээр манайд ганцхан тулгаж тавиад байгаа асуу бодлууд 10 жил, 20 жил, 25 жилээр тогтвортой байх уу, үгүй юү гэдгийг асууж байна гээд гаднын хөрөнгө оруулагчид асууж байгаа ганцхан асуулт нь тэр байна гэдэг зүйлийг л хэлээд байгаа шүү дээ. Олон улсын гэрээ, хэлэлцээр илүү дутуу ингээд бүх зүйлийг оруулж ирж ярихад. Дотоодын үйлдвэр, аж ахуйн нэгжүүд иргэддээ энэ зүйлийг бас тодорхой хэлмээр байх. Би энэ жил тариа тариадах гэсэн чинь, гурил үйлдвэрлээдэх гэсэн чинь намар юм уу, ирэх хавар дахиад хууль өөрчлөгдчих юм байна, би улаан буудай тарих нь зөв юм уу, гурил үйлдвэрлэх нь зөв юм уу, буруу юм уу гэдэг сигнал дээрээ оччихоод. Тэгэхээр энэ зүйлээ их тодорхой хэлмээр байгаа юм.

Дээрээс нь газар тариалангийн 90 хувь төвийн бүсэд байна гэж байна. Бид нар эдийн засгаа солонгоруулъя гээд яриад байдаг. Бусад энэ бүсчилсэн хөгжил Засгийн газрын чинь зорилтот хөтөлбөр энэ хүрээнд баруун, зүүн бүс, говийн бүс, энэ бүсүүдэд мал аж ахуй газар, тариалангаас үл хамаараад мал аж ахуй болон бусад энэ бүсчилсэн хөгжлийн хүрээнд хөдөө аж ахуйн асуудлыг шийдэх ямар зүйлүүд орж ирж байна вэ? Ганцхан л энэ газар тариалан, тэр хямд эх үүсвэр, зээл, хөрөнгийг зөвхөн төвийн бүсийн газар тариаланд олгоно, өөр зүйлд олгохгүй гээд Монгол Улсын мал сүргийн 50 хувь нь баруун 8 аймагт байж байдаг. Тэнд өөрт өөрт чинь бодож байгаа зүйл байна уу, Засгийн газар дээр энэ тухай ярилцаж байгаа зүйл байна уу гээд?

Мөн малын тэжээлийн тухай ярьж байна. Малын тэжээлийг дахиж ингэж гаалийн татваргүйгээр оруулж огт болмооргүй байна. Тэр малын тэжээлийн үйлдвэрлэлээ.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Энхбаяр сайд хариулт өгөх үү? Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Манай салбарт 600 мянган хүн ажиллаж байгаа. Монгол Улсын ажиллах хүчний 1/2 нь. Ерөөсөө хөдөөгийн хөгжил гэдэг нь өөрөө энэ төвлөрлийг сааруулах гол бодлого. Тийм болохоор хөдөөд хүн ажиллах, амьдрах, бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэх ёстой. Энэ бодлого бол энэ хэрэгжүүлж байгаа бодлого маань яваад байгаа. Бусад газар газар тариаланг хөгжүүлмээр байна гэж. Үнэхээр тэгмээр байна. Яагаад гэвэл мал аж ахуйг эрсдэлээс хамгаалахын тулд малын тэжээлийн таримлыг онцгой нэмэгдүүлэх ёстой. Бүхий л аймгуудад бичиг, хүсэлт очсон байгаа гишүүд ээ. Атрын 4 дүгээр аяны хүрээнд 200 мянган га талбайгаар тэжээлийн таримлыг нэмэгдүүлэе гэдэг зорилт тавьчихаад байна. Аймгууд янз янз байна. Хамгийн идэвхтэй нь Дорнодынх нь байгаа. Дорнод гэхэд 30 мянган га талбайг бид нар тэжээл, үр тарианы тариалалтаа нэмэгдүүлнэ, хөдөө аж ахуйг хөгжүүлнэ, ажлын байр бий болгоно гэж байна. Ихэнх аймгууд нойл.

Тэгэхээр энд бас яригдсаных энэ бололцоог Засгийн газар Их Хурал бодлого гаргаад 200 мянган гагаар нэмэгдүүлэе, мал сүргийнхээ ашиг шимт байдлыг нэмэгдүүлэе, газар тариалан, мал аж ахуйгаа ингээд хослуулан хөгжүүлэе, экспортын чиг баримжаатай явъяаа, махаа экспортод гаргая, ноос ноолуураа сайн боловсруулаад экспортод гаргая, үр тариагаа ахиухан тэжээл тариад бас экспортод гаргая. Ер нь хөдөө аж ахуйн экспортод гарч байж малчдын орлого, тариаланчдын орлого, энэ салбар өөрөө тогтвортой хөгжих юм байна л гэдэг бодлого явж байгаа шүү дээ. Тэгэхээр оролцоо нь өөр өөр байна. Тэгээд яах аргагүй л нөгөө төвийн бүс нь гол тулгуур, өөрөө энэ газартай харьцаж сурсан соёл, ийм уламжлалт хуучны сангийн аж ахуйнуудын суурь, эрчимжсэн аж ахуйнуудын суурь байдаг болохоор энэ энэ төвийн бүс өөрөө илүү мэдрэг буюу хурдтай энд хандаж ажиллаж байна.

Үнэ тогтвортой байх асуудлыг би түрүүн хэлсэн 25 оны ургац хураалт дүн гартал тогтвортой байдлыг хангаж чадна. Тогтвортой байдлыг хангах бодлого бас Их Хуралтай хамтарч шийднэ буюу улсын төсөв дээр тэр жилдээ 100 тэрбум, 100 мянган тонн үр тариа худалдан авах улсын стратегийн нөөц бүрдүүлж байж энэ үнийн бодлогыг зохицуулах арга хэрэгсэлтэй болно. Энэ дээр дэмжлэг үзүүлээч.

Мөн дараа нь энэ гурилын хангамж, үнэхээр улаан буудай, гурил, стратеги бол үнийг дотортой хэрхэн барих вэ гэдэг бодлогыг би оруулж ирье. Энэ болгон бүгд л энэ төсвийн хүрээний мэдэгдэл, хүрээнд л бас яригдаад 26 онд төсөв суух байх гэж бодож байна. Одоо төсвийн өөрчлөлт ямар нэгэн тодотгол хийх асуудал яригдаагүй болохоор боломжгүй, хязгаарлагдаад байна л даа. Хуулиудаа бид нар багцлаад, боогоод нэлээн асуудал гарч байна. Ажил аваад жил ч болоогүй байна шүү дээ. Миний ажил авснаас хойш энэ үнэ тогтвортой буюу хямдарсан байгаа. Энэ салбарт ямар нэгэн айхтар өөрчлөлт гараагүй байна.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гарсан санал, дүгнэлтийг дэмжсэн эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дарааллын дагуу асуулт асууна. Нэр өгсөн дарааллын дагуу Бөхчулууны Пүрэвдорж гишүүн алга байна. Баярмагнайн Баярбаатар гишүүн үг хэлнэ. 2 дугаар индэр.

Б.Баярбаатар: Би та бүхэнд санал хэлэх үүднээс дүгнэлтээ бас танилцуулъя. Дотоодын буудайн гурилын зах зээлийн төвлөрлийг тооцоход цөөн тооны аж ахуй эрхлэгчдээс хамааралтай төвлөрөл бүхий өрсөлдөөний орчин хязгаарлагдмал төлөвтэй, цаашид салбарын зохицуулалт болон өрсөлдөөний бодлогын уялдааг хангах замаар тухайн салбарт өрсөлдөөний мэдрэмжтэй шийдвэр гаргах үйл явцыг дэмжих шаардлагатай гэж хөндлөнгийн шинжээчээс дүгнэж, их төвлөрсөн гэсэн дүгнэлтийг гаргасан. Импортын гаалийн татвар болон хязгаарлалтаас чөлөөлсөн нь огцом өсөж байсан үнийн өсөлтийг саармагжуулсан гэсэн ийм дүгнэлтийг гаргасан.

Дотоодын 1 дүгээр зэргийн гурилын үнэ 2024 оны 5 дугаар сард 2454 төгрөг байсан бол 2025 оны 3 дугаар сарын сард 2221 болж 9.5 хувиар буурсан. 1 болон 2 дугаар зэргийн гурилын дундаж үе өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2024 оны 6 сараас эхлэн буурч эхэлсэн байна.

1 дүгээр, 1кг дээд гурилын үйлдвэрлэх өртөг нь 1744 төгрөг, 73.9 хувь нь улаан буудай, 26.1 хувь нь бусад зардал, 1 дүгээр үйлдвэрлэх өртөг нь 1516 төгрөг, үүний 70 хувь нь улаан буудай, 30 хувь нь бусад зардал.

2 дугаар гурилын өртөг нь 1259 төгрөг үүний 63.8 хувь нь улаан буудай, 36.2 хувь нь бусад зардал гэсэн ийм судалгааны дүн байна.

2025 оны 3 дугаар сарын байдлаар Улаанбаатар хотод худалдаалагдаж буй дотоодын дээд гурил 3188 төгрөг, 1 дүгээр гурил 2228 төгрөг, 2 дугаар гурил 1358 төгрөгийн үнэтэй байна. 2024 оны 5 дугаар сартай харьцуулахад дээд гурилын үнэ 7 хувиар өссөн байхад 1 болон 2 дугаар гурилын үнэ 9.5-15.4 хувиар үнэ буурсан гэсэн ийм дүгнэлт байна.

Монгол Улсад им гурил импортлох худалдааны зохицуулалтын Хүнсний тухай хууль Баяжуулсан хүнсний тухай хууль, Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 336 дугаар тогтоол, Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөмж зэргийг тус тус үндэслэн гаалийн импортын тариф, квотыг тогтоож байсан. Баяжуулсан хүнсний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д албан журмаар баяжуулах хүнстэй ижил нэр төрлийн импортын бүтээгдэхүүн Монгол Улсын үндэсний стандарт шаардлагыг хангасан байна гэж заасан.

Монгол Улсын Засгийн газар 2018 оны 336 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан албан журмаар баяжуулсан хүнсний жагсаалтад хүнсний давс, буудай, гурил орсон гурилыг импортлоход заавал баяжуулах шаардлагатай бөгөөд баяжуулаагүй гурилыг улсын хилээр нэвтрүүлэх боломжгүй байхаар тарифын бус зохицуулалт хийсэн. Сүүлийн жилүүдэд тохиолдож буй гамшигт үзэгдэл, цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж дотоодын үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд хийсэн татварын тохируулгыг богино хугацааны давтамжтайгаар өөрчилж байна. Төрөөс импортыг оруулах бараа, бүтээгдэхүүний тоо хэмжээ, хязгаар тогтоохыг багасгаж, импортын бараа, бүтээгдэхүүний хэмжээг гааль, онцгой бусад татвараар дамжуулан хянаж байна.

Хөдөө аж ахуйн яамнаас тариалан эрхлэгчид, гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэгчид төрөөс 10 аж ахуйн нэгжид 212.86 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлж, зээлийн хүүгийн хувьд 3-6 хувийг нь төлж,

Засгийн газраас 7.65-13 хувийг нь хариуцан төлөх нөхцөлтэйгөөр арилжааны банкны эх үүсвэр 60 хүртэл сарын хугацаатайгаар олгож байна.

Эндээс үзэхэд төрөөс гурилын салбарт олгож байгаа зээл, хөнгөлөлт нь гурилын томоохон аж ахуйн нэгжүүдэд илүү давуу байдал олгогдож байна гэж үзэж байна.

Тариалан эрхлэгчдийн хийсэн уулзалтаас үзэхэд тухайн салбар дахь төрийн бодлого, өрсөлдөөний хязгаарлалт, нөхцөл байдал нь үүсгэсэн байж болзошгүй. Иймд газар тариалан, гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нар төрөөс олгосон хөнгөлөлттэй зээлийн үр дүн, урамшууллын асуудал, ялангуяа хөнгөлөлттэй зээлийг томоохон аж ахуйн нэгжүүд олгосон асуудлаар Улсын Их Хурлаас хяналтын сонсголыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах нь зүйтэй гэж үзсэн.

Их Хурлын 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн хууль батлагдсантай холбогдуулан зарим арга хэмжээ авах 31 дүгээр тогтоолоор Засгийн газар 8 арга хэмжээ авах.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Хугацаа дууссан байна. Мэндбаярын Мандхай гишүүн үг хэлнэ. 2 дугаар индэрт урьж байна.

М.Мандхай: Хөдөө аж ахуйн бас салбарт ажиллаж байсан хүний хувьд бас хэдэн зүйл хэлмээр байна. Гурил өөрөө яах вэ ер нь өргөн хэрэглээний бараа. Хэрэглэгчийн энэ худалдан авалт сул, энэ эмзэг байгаа үед энэ гурилын үнэ өсөхгүй бууруулах бол зайлшгүй шаардлагатай байгаа.

Гэхдээ бид салбарын чухал асуудлыг бас эрсдэлийн асуудлыг ярихгүй болохгүй байгаад байгаа юм. Хэрвээ бид нар энэ гурилын импортыг тэглэх юм бол яг үндсэндээ энэ салбарт байгаа дотоодын үйлдвэрүүд хаалгаа хааж, энэ тоног төхөөрөмж зэвэрч, энэ салбарт ажиллаж байгаа ажиллах хүч үндсэндээ өөр салбар луу шилжиж тарж бутраад алга болно. Үлдсэн энэ салбарт үлдэж байгаа хэд рапс тариалаад нөгөө хөрс нь муудсан, шим тэжээлгүй үр тариатай байдал үүсэх вий. Гадаадаас орох энэ импортын одоо гурил хямд ч гэсэн цаашид үнээ нэмэх бас эрсдэлтэй. Нэгэнт гаднаас хямдхан гурил ороод ирчихсэн зах зээлийг эзэлчихсэн тохиолдолд бид үнийг тэр үнэ нь өссөн байх юм бол хянаж чадахгүй. Ингээд 5 жилийн дараа гурилын хараат улс болох ийм эрсдэлтэй гэж харагдаж байгаа. Нэгэнт энэ унасан салбарыг бид 5 жилийн дараа босгоё гээд төрөөс их мөнгө гаргаад ч гэсэн босгож чадахгүй. Тэгэхээр ер нь энэ шууд тэглэнэ гэхээсээ илүүтэй тодорхой ийм квот, эсвэл бусад өөр төрлийн энэ тарифаар зохицуулалт хийгээд явах нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай байгаа. Төр илүү олон жилийн алсыг бас харж салбарын бас энэ хөгжлийг бас бид хөгжүүлэхийн төлөө дэмждэг ийм байвал зүгээр гэсэн ийм саналтай байна.

Хоёрт нь гурил өргөн хэрэглээний бараа. Угаасаа ч үнийн таазтай явж ирсэн. Гэхдээ бид байна шүү дээ энэ яамны энэ бодлого шийдвэр гаргаж байгаа сайд болон газрын дарга нарт бас шүүмжлэлтэй хандаад байгаа нэг юм нь бид ингээд 2, 3-хан сая хүний зах зээл дээр гурилаа борлуулж үнийг буулгах ингэж ажиллаад явах юм уу? Гэтэл энэ Орос, Турк, Казакстан, Герман, Энэтхэг гээд маш олон улсууд өөрсдийнхөө гурилыг экспортолж чаддаг. Монгол Улс чинь өөрөө ийм

органик шим тэжээлтэй газар нутагтай улс. Бид нар гурилынхаа ялгарлыг үүсгээд олон улсын зах зээл дээр бид нар борлуулах бүрэн боломж байгаа.

Яагаад ингээд 2, 3-хан сая хүнд л бид нар гурилаа борлуулаад ингээд өнөөдөр үнийн асуудлыг ингээд хэлэлцээд сууж байгаа юм бэ гэдэг дээр үнэхээр харамсалтай байна. Тэгэхлээр энэ ер нь гурилын бизнес өөрөө масс үйлдвэрлэл явуулж байж нэгж бүтээгдэхүүний өөрөө өртөг буурдаг бизнес. Гэтэл энэ яг үнэнээ хэлэхэд манай улирлын чанартай бизнес, дээрээс нь 2, 3-хан сая хүнд ингээд л жил ирэх тусмаа үнийн таазтай борлуулаад явах нь өөрөө энэ салбарын хувьд хөгжихгүй харагдаж байгаа.

Тийм учраас энэ салбарыг 3 сая биш яагаад 5 сая хүнд борлуулдаг энэ боломжийг нь яам өөрөө бодлогоороо дэмжиж, олон улсын худалдаа, хэлэлцээрээр зах зээлийг нь нээж болдоггүй юм бэ. Тэгэх юм бол үйлдвэрлэгч нар эсрэгээрээ дотоодынхоо зах зээл дээр үнээ бууруулаад үлдэж байгаа гадаадын зах зээл дээрээ чөлөөт тэр зах зээлийн үнийг ингээд бариад ажиллах бүрэн боломжтой гэж харж байгаа. Тийм болохоор яам энэ дээр анхаарч ажиллаач. Энэ зах зээлийг тэлэх дээр дотоодын зах зээл биш, бид нар экспортын зах зээл дээр 5 сая зах зээлд борлуулдаг энэ боломжийг нь нээх тал дээр бодлогын яам анхаарч ажиллаач гэсэн ийм үг хэлэх гэсэн юм.

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн үг хэлнэ. 2 дугаар индэрт урьж байна.

Б.Батбаатар: Гаалийн татварыг өөрчлөх тухай энэ хуулийн төслийг дэмжиж байгаа. Иргэний зориг ногоон нам Атрын 3 дугаар аяныг санаачилж, энэхүү аяны хүрээнд дотоодын үйлдвэрлэл сэргэж, хүнсний аюулгүй байдал хангагдахад чухал хувь нэмэр оруулсан. Хүнсний аюулгүй байдлаас гадна байгаль орчны доройтолтой тэмцэхийн тулд тэжээлийн үйлдвэрлэлийг Монголд эрчимжүүлэх, нэмэгдүүлэх шаардлага байгаа. 2024 онд Их Хурлын сонгуулийг угтаж баталсан энэ хуулиар тэжээлийн үйлдвэрлэлийг унагаахад хувь нэмэр оруулсан ийм зүйл баталсныгаа өнөөдөр засаж байна. Энэ засах ажлаа хийж байгаад нь бас Засгийн газарт талархъя.

Гэхдээ энэ тэжээлийн үйлдвэрлэл олноор нэмэгдэх нь өөрөө эргээгээд бэлчээрийн доройтол буюу мал сүрэг эрчимжсэн фермерийн чиглэл рүүгээ ороход чухал юм. Энэхүү бодлогуудаа Засгийн газар болон Улсын Их Хурал, салбарын сайд, олон нийтэд, үйлдвэрлэгчдэд, иргэдэд, бизнес эрхлэгчдэд тодорхой зарлаад энэ бодлого 3 жил, 5 жил өөрчлөгдөхгүй гэдгийг илэрхийлдэг баймаар байна. Салбараа бодлого хариуцсан сайд нар нь энэ бодлогуудаа зарлаад илэрхийлээд байх нь Монголын бизнес эрхлэгчид дотооддоо бизнесээ эрхлэхэд гаднын хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулахад таатай нөхцөлийг бий болгоно. Энэ бодлогыг өөрчлөхгүй гэдгийг амлаж байна гэдэг нь энэ бодлого өөрчлөгдсөн тохиолдолд тухайн салбарын сайдууд өөрчлөгддөг байх, бодлогоо явуулж чадахгүй байна гэдэг энэ хариуцлагын тогтолцоог ч гэсэн бий болгох ёстой гэж Иргэний зориг ногоон нам үзэж байна.

Гаалийн татвар гурил, тэжээл дээр гаалийн татвар бий болсонтойгоо холбоотойгоор дотоодын үйлдвэрлэл явахдаа шударга өрсөлдөөнийг хангаж

иргэдэд хямд, чанартай бүтээгдэхүүнийг хүргэх тал дээр хүртээмжтэй байх тал дээр анхаарах ёстой.

Гэхдээ энийгээ захиргааны аргаар, зээл, тусламж, хөнгөлөлттэй мөнгө, хөрөнгө санхүү олгож өгөх аргаар биш өрсөлдөөнд оролцох аж ахуйн нэгж, тоо хэмжээг нэмэгдүүлэх, өрсөлдөөнд оролцох тэр бизнес эрхлэгчийг олшруулах чиглэлээр явуулах нь зүйтэй. Цөөн тооны олигархажсан түлшний бизнес эрхлэгчдэд том хэмжээний нэг аравны хэдэн их наядаар нь яригдаж байгаа ийм хэмжээний зээлийн эх үүсвэр, хямд эх үүсвэр гаргаж өгөх нь Монголын эдийн засгийг цөөхөн хүнээс хараат байдал руу оруулж байгаа. Үүн дээрээ анхаарлаа, бодлогоо өөрчилж, олон иргэд, олон бизнесийн компаниуд энэ чиглэлийн бизнест ажиллах тэр орон зайг нь бүтээж өгөхийн төлөө ажиллах ёстой гэж ингэж үзэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалтыг хойшлуулна. 5 дахь өдрийн үдээс өмнөх чуулганы хуралдаан дээр санал хураалтыг явуулна. Гишүүдийн ирцийг хангалттай үед. Дараагийн асуудал үдээс хойших хуралдаан дээр байгаа. Ингээд 13 цаг 30 минут болсон байна. Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаан хүртэл завсарлуулъя.

Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаан 15 цагаас эхэлнэ. Гишүүдийг цагтаа ирэхийг хүсэж байна.

13.30 цаг

Пүрэв гараг 24 Дөрөвдүгээр сар 2025

Төрийн ордон “Их хуралдай” танхим 15 цаг 00 минут

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын 25 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 24-ний өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан эхэлснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д хууль санаачлагч хэлэлцүүлгийн аль ч шатад санаачилсан хуулийн төслөө татан авч болно гэж, 32.3-д хуулийн төслөө татан авах тохиолдолд тухайн төсөл нь хэлэлцүүлгийн аль шатад байгаагаас үл хамааран хууль санаачлагч хуулийн төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд энэ тухай танилцуулснаар хууль санаачлагч хуулийн төслөө татан авсанд тооцно гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр хуулийн төсөл татан авах тухай Засгийн газрын 1/50 дугаартай албан бичгийг ирүүлснийг уншиж танилцуулъя.

Хуулийн төсөл татан авах тухай Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлд хамт өргөн мэдүүлсэн бусад хууль тогтоомжийн

төслийг татан авахаар Засгийн газрын 2025 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар шийдвэрлэснийг танд үүгээр мэдэгдэж байна. Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийг хавсаргав гэсэн ийм албан бичиг иржээ.

Ингээд хуулийн төслийг эргүүлэн татсан танилцуулгыг хийлээ.

Засгийн газраас 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдөр өргөн мэдүүлсэн Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг татан авсанд тооцлоо.

Хэлэлцэх асуудалд оръё.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Оюунсайханы Алтангэрэлд танилцуулна. Индэрт урьж байна.

О.Алтангэрэл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүний эрхийг дээдэлсэн нийгэм бүтээх зорилгын хүрээнд 5.5.9-д хэвлэлийн эрх чөлөөг бүх талаар хангаж, ёс зүйтэй, мэргэшсэн сэтгүүл зүйг хөгжүүлнэ гэж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1-д хүний эрх, эрх чөлөө бүлгийн 4.1.2.1, хэвлэл, мэдээллийн хэрэгслийн чөлөөт, хараат бус, бие даасан байдлыг хангах, тэдгээрийн редакцыг эздийн нөлөөллөөс гаргах, сэтгүүлчийн хэвлэн нийтлэх эрх чөлөө болон мэргэжлийн ёс зүйг баримтлан хариуцлагатай ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлнэ гэж тус тус заасан.

Техник, технологийн дэвшил, цаг үеийн өөрчлөлт нь хүн бүрд үзэл бодлоо олон нийтэд хандан илэрхийлэх боломжийг улам бүүр нэмэгдүүлж байгаа нь сайн талтай боловч нөгөө талаар үзэл бодлын илэрхийлэмжүүдээс бусдын нэр төр, нийгмийн ёс суртахуун, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах буюу тэнцвэрийг олох зохицуулалт бий болгох нь төрийн үүрэг юм.

Монгол Улсын Үндсэн хуульд тунхагласан хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулах, сэтгүүл зүйг мэргэжлийн бөгөөд ёс зүйтэй нийтэлдэг байдлаар нь иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнөөс ялгах, хэвлэл мэдээллийн бие даасан хараат бус байдлыг хангах, олон ургалч, чөлөөт хэвлэл мэдээллийг хөгжүүлэх зорилгоор Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан танилцуулж байна.

Хуулийн төслийг боловсруулахдаа хэвлэн нийтлэх эрх чөлөөний үндсэн мөн чанар болох бусдын нэр төр, алдар хүнд, нийгмийн ёс зүй, үндэсний аюулгүй

байдалд хохирол учруулахгүйгээр хэвлэн нийтлэх боломжтой байх үзэл баримтлалын хүрээнд боловсрууллаа.

Хуулийн төсөлд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүл зүйн үйл ажиллагаа зэрэг нэр томъёог тодорхойлж өгснөөр иргэний үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнөөс сэтгүүл зүйн үйл ажиллагаа нь ялгаатай бөгөөд үүрэг хариуцлага өндөртэй болохыг тодорхойлох ач холбогдолтой.

Хуулийн төсөлд 1998 онд батлагдсан хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль дахь үзэл санаа зохицуулалтыг бүрэн тусгахын зэрэгцээ хэвлэл мэдээллийн салбарт үүсээд байгаа хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх зорилгоор эзэмшлийн ил тод байдлыг хангах, эх сурвалж хамгаалах эрхийг баталгаажуулах, хэвлэл мэдээллийн салбарын өөрийн зохицуулалтын байгууллагын эрх зүйн үндсийг бий болгохтой холбоотой зохицуулалтыг тусгалаа.

Хуулийн төслийг боловсруулахдаа өмнө нь боловсруулагдаж байсан төслүүдийн алдаа оноог харгалзан үзэж, хэвлэл мэдээллийн салбарынхан болон олон нийтэд хуулийн төслийн үзэл баримтлалыг ойлгуулах, санал зөвлөмжийг авах зорилгоор өргөн хүрээний хэлэлцүүлгийг зохион байгуулж ажиллалаа.

Хуулийн төслөөр хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь бүгд хуулийн этгээд хэлбэрээр үйл ажиллагаа явуулах, 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч, төрийн байгууллагаас авсан төлбөртэй нийтлэл, нэвтрүүлгийн талаар мэдээлэл ил тод байх, хэт төвлөрөлтөөс урьдчилан сэргийлэх, хэвлэл мэдээллийн байгууллага нь мэргэжлийн редакцтайгаар үйл ажиллагаа явуулах, төрийн байгууллагаас хэвлэл мэдээллийн байгууллагын нийтэлсэн мэдээ, мэдээллийн талаар хүн, хуулийн этгээд тухайн редакцад болон өөрийн зохицуулалтын байгууллагад гомдол гаргах боломжтой байх, эх сурвалжийг нууцлах, эрхийг баталгаажуулах зэрэг шинэлэг зохицуулалтыг тусган боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар хэвлэн нийтлэх эрх, түүнтэй холбоотой бусад ойлголтуудыг нэг мөр ойлгох боломж бүрдэх, хэвлэн нийтлэх эрхийг өргөн хүрээнд тайлбарласнаар зөвхөн редакцтай хэвлэл мэдээллийн байгууллага бус олон нийтийн эрх ашгийн төлөө хэвлэн нийтлэх эрхээ хэрэгжүүлдэг бусад этгээдүүдийн эрхээ хэрэгжүүлэх боломж бүрдэх, хэвлэл мэдээллийн байгууллага мэргэжлийн үйл ажиллагааны хувьд хараат бусаар ажиллах, мэдээллийн эх сурвалжаа хамгаалах эрхийг баталгаажуулснаар хууль бус байж болох үйлдлийг хэвлэл мэдээллээр дамжуулан илчлэх, хариуцлагатай, ёс зүйтэй сэтгүүл хөгжих боломж бүрдэнэ. Хэвлэл мэдээллийн хэт төвлөрөл бий болгохоос сэргийлснээс олон ургалч үзэл оршин тогтнох орон зай нэмэгдэж, эзэмшигч ил тод нээлттэй байснаар хэвлэл, мэдээллийн хэрэгслийг улс төр бизнесийн болон бусад хувийн зорилгоор ашиглахгүй болох юм. Иймд хуулийн төсөл, төслийн үзэл баримтлалын хэлэлцэх эсэхийг дэмжиж өгнө үү.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Төслүүдийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй дэгийн байнгын хорооны дарга Баярмагнай Баярбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Баярбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч уг хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулах, сэтгүүл зүйн хараат бус, бие даасан, ил тод байдлыг хангах, хэвлэл мэдээллийн салбарын өөрийн зохицуулалтын байгууллагын эрх зүйн үндсийг тогтоох замаар олон ургалч хариуцлагатай хэвлэл мэдээллийн салбарын хөгжлийг дэмжих зорилгоор боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар улсын төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд хуулийн төслийг d.parliament.mn цахим системд байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Улсын Их Хурлын Тамгын газраас Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5.5 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт заасны дагуу хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулахын өмнө хууль зүйн дүгнэлт гаргаж Байнгын хороонд танилцуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар сэтгүүлч мэдээллийн эх сурвалжаа нууцлах эрхтэй болсноор гарах үр дүн орон нутагт үйл ажиллагаа явуулдаг радио, телевизийн талаар зохицуулалт төсөлд туссан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын Тамгын газраас төсөлд гаргасан хууль зүйн дүгнэлтийг хууль санаачлагч хэлэлцүүлгийн аль шатад ямар арга хэмжээ авах талаар, Төрийн байгууллага төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд иргэдээ хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа явуулах бүтцийн нэгжгүй болох эсэх, үүнээс үүсэх үр дагаврын талаар илт худал мэдээлэл, ташаа мэдээлэл гэсэн ойлголтуудын ялгаа, заагийг тодруулах, илт худал мэдээлэл түгээхэд ноогдуулах хариуцлага, ташаа мэдээлэл гэдэг нь хууль зүйн ямар агуулгыг илэрхийлэх талаар хамт өргөн мэдүүлсэн Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох заалтаас бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль, ёсны ашиг сонирхлыг хохироохгүй хүндэтгэлтэй хандахтай холбоотой эсэхийг хасах болсон хууль зүйн үндэслэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд гэрчийн мэдүүлэг авахад Эрүүгийн хуулийн 19 дүгээр бүлэг болон 29 дүгээр бүлэгт зааснаас бусад гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал тогтоох зорилгоор сэтгүүлчээс мэдүүлэг авч болохгүй хязгаарлалтыг хэлэлцүүлгийн шатад нарийвчлан зохицуулах боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин хэвлэл мэдээллийн салбарын зах зээлийн хэмжээ, үүнээс төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хэвлэл мэдээллийн чиглэлээр зарцуулдаг зардлын талаар, агуулгын хяналтын хүрээнд нийгмийн сүлжээний ард ажилладаг алгоритмын талаар мэдээлэлтэй эсэх, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг хуулийн төслийг хэлэлцэхийг зарчмын хувьд дэмжиж байгаагаа илэрхийлээд төслийг Хэвлэл

мэдээллийн эрх чөлөөний тухай болон хэвлэл мэдээллийн байгууллагын тухай хууль гэж салгаж боловсруулан өргөн мэдүүлэх байсан эсэх, хэвлэл мэдээллийн ёс зүйн гомдол, маргааныг шийдвэрлэх хүрээнд хэвлэл мэдээллийн арбитрын зохицуулалтын талаар, эх сурвалжаа нууцлах хүрээнд ямар тохиолдолд нууцлах, нээлттэй болох талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг чөлөөт сэтгүүлчийг бусад нийтлэл, контент бүтээгч иргэдээс хэрхэн ялгах, хэвлэл мэдээллийн байгууллагын хамтын үйл ажиллагааны төрлийн талаар, хэвлэл мэдээллийн байгууллагын болон бусад контент бүтээгчийн олон нийтийн телевизээр гарах мэдээ, контентын тэнцвэрт байдлыг хангах чиглэлээр төсөлд тодорхой зохицуулалт туссан эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх болон Эрүүгийн процессын хуулийн уялдаа, холбоог хангах хүрээнд хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль зүйн байнгын хороогоор хэлэлцүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг үнэн зөв мэдээлэл авах иргэдийн эрх ашгийг хангах, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллага дэргэдээ арбитртай байх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир Төрийн байгууллага үйл ажиллагаагаа сурталчлах хүрээнд зарласан сонгон шалгаруулалтад жижиг хэвлэл мэдээллийн байгууллага редакцууд оролцож чадахгүй болох. Цөөн тооны монопол хэвлэл мэдээллийн байгууллага үүсэх эрсдэлээс сэргийлэх, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироохгүй байх зохицуулалтыг хасах асуудлыг хэлэлцүүлгийн шатад анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Лодойсамбуу хуулийн төслийг хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хэвлэл мэдээллийн байгууллага, тэдгээрийн хүрээ хязгаарыг нь тогтоох, оролцоог хязгаарлах бус хэвлэл нийтлэх эрх чөлөөг хангахад төслийн зорилгыг чиглүүлэх, төрийн оролцоог хэвлэл мэдээллийн зах зээлээс салгах, илт худал мэдээлэл тараах, гүтгэхтэй холбоотой зохицуулалтыг Эрүүгийн хуулиас хасах зэрэг саналуудыг тус тус хэлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэг Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар ил санал хураалт явуулна гэж заасны дагуу санал хураалт явуулахад Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт

оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаар Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Нэргүйн Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Нармандахын Жамъянхүү Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Болдбаатарын Энхцэцэг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн, Гонгорын Гүнжидмаа Хэвлэл мэдээллийн зөвлөлийн захирал, Сампилын Шаравдорж Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбооны тэргүүн, Лхагвасүрэнгийн Галбаатар Глоб Интернэшнл төвийн хуульч.

Одоо Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дарааллын дагуу асуулт асууна. Нийт 24 гишүүн байна. Ирцийн дарааллын дагуу Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууна.

Х.Баасанжаргал: Юуны өмнө Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл орж ирж байгаа нь өөрөө бас их сайшаалтай. Маш олон жил энэ хуулийг хэрхэн яаж боловсруулах, хэрхэн санал нэгдэх гээд маш олон зарчмын байр суурийн зөрүүтэй олон саналууд байдаг. Тэгэхдээ энэ хуулийн төсөл өргөн баригдах энэ нөгөө багц дээр нь би бүүр онцгойлон бас талархал илэрхийлмээр байна. Энэ бид нарт тараагдаж өгсөн энэ материал дээр бусад хууль тогтоомжуудыг ингэж өргөн барьдаг болмоор байгаа байхгүй юу. Саналын ТОВЬЁГ нь бүгд орчихсон байна, холбогдох бүх судалгаанууд нь хийгдчихсэн, тэр бүх судалгаануудыг нь бүгдийг нь эмхэтгээд гээд ингээд ийм юм уг нь их хурлын гишүүд Засгийн газраас нэхээд байдаг. Тэгэхээр энэ бүрдүүлбэрийн хувьд бол надад энэ бас бусад, цаашид бусад сайдууд бусад хууль өргөн мэдүүлэхдээ бид нар ийм байдлаар бол явах ёстой гэж харж байгаа юм.

Агуулгын хувьд харин 2, 3 асуулт байна. Өнгөрсөн хугацаанд өргөн барьснаас хойш салбарынхан их олон янзын байр суурь илэрхийлж байгаа. Тэгэхээр түүнтэй холбоотой асуулт асууя гэсэн үг. Нэгдүгээрт энэ хэвлэл мэдээллийн байгууллага маань өөрөө өөрийгөө удирдах, өөрийн мэргэжлийн удирдлагын байгууллагатай болох уу? Холбооны тухай маш ерөнхий зохицуулалт бичигдээд орхигдчихсон байгаа. Энэний үзэл санаа нь цаанаа юу байгаа юм бэ гэдгийг тодорхой хэлж өгөөч. Манай Хуульчдын холбоо энэ тэр шиг нэг мэргэжлийн холбооны дээвэр доор оруулах гээд байна уу, эсвэл хэд хэдэн холбоонууд одоогийн байгаа хөгжлөөрөө яваад яваандаа жам ёсоороо энэ нь өөрөө бас нэгтгэгдэнэ гэж харж байгаа юу гээд?

Хоёрдугаарт сэтгүүлчийн ёс зүйн асуудал. Тэгэхдээ зайлшгүй хариуцлага хүлээдэг байх энэ механизм ер нь их төвөгтэй байгаа. Эрүүгийн эрх зүй, Зөрчлийн хууль гэхээс илүүтэй бас ёс зүйн асуудал нэлээн өндөрт тавигдаад байгаа. Энэ нь огт шийдвэрлэгдэхгүй байгаа. Тэгэхээр ёс зүйн механизмаа хэрхэн харж энэ хуульд тусгасан бэ?

Гуравдугаарт энэ хуулийн төсөл дээр үзэл санаа, үзэл баримтлалын хувьд надад огт таалагдахгүй байгаа нэг зүйл бол энэ хуулийг хэтэрхий институцийн шинжтэй хууль болгоод оруулаад ирлээ. Уг нь бол үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай хууль, эрх чөлөөг баталгаажуулах хууль байх ёстой. Тэрнээс биш энэ эрхээ эдлэхийн тулд ийм төрийн байгууллагад бүртгүүлэх барих, янз бүрийн институц яах ийх гэдэг ийм юм харьцангуй бага байх ёстой гэж би хувьдаа харж байгаа. Тэгэхээр яагаад ингэж ийм институцийн шинж рүүгээ, илүү ийм тогтолцооны шинж рүү болгож ийм байгууллагын шинжтэй хууль байна гэдэг ийм дүгнэлт бас хийчхээд байгаа учраас бас яг энэ зохион байгуулалт байгууллагын шинж рүү оруулсан бас шалтгаан нөхцөл юу вэ?

Хамгийн сүүлд улс төрийн болоод төрийн алба хаагчид байгууллагын нэр хүнд энэ тэр гээд ийм олон асуудлууд яригдаад байгаа. Би хувьдаа иргэний нэр хүндэд халдсан асуудал, албан тушаалтны нэр хүндэд халдсан асуудал хоёрыг ялгаатай үзмээр байгаа юм. Гэтэл бид нар яг иргэнтэйгээ адилхан ингээд л бүгдээрээ барьцаад л ингээд л миний нэр хүндэд халдчихлаа гээд л манай улс төрчид ч гэсэн ингээд л гомдол гаргаад л шүүхээр шийдүүлээд л ингээд л асуудал яваад байгаа юм. Эсрэгээрээ бид нар харин иргэнийхээ нэр төрийг хамгаалах тэр үзэл санаа руугаа явах ёстой. Тэрийг ялгамжтай зохицуулж чадсан уу? Үндсэн хуулийн хүрээлэн болоод Нээлттэй нийгэм форумын бас санал дээр ч гэсэн бас энэ саналууд байсан. Тэгэхээр энийг ялгаж зохицуулах тал дээр ямар байр суурь байгаа вэ?

Харин манай шүүхүүдийн өгсөн санал бол миний бодсоноор шал өөр санал өгсөн байна. Илүү байгууллагын нэр хүндийг бас хамгаалах ёстой гэсэн саналууд манай шүүхүүд өгч байна. Тэгэхээр энэ нөгөө нэр төрийг хамгаалах зохицуулалтыг субъектийнх нь хувьд, хөндөгдөж байгаа эрх ашгийнх нь хувьд ялгаж зохицуулж чадсан уу?

Д.Амарбаясгалан: Оюунсайханы Алтангэрэл сайд хариулт өгье.

О.Алтангэрэл: Баасанжаргал гишүүний хөндөж байгаа энэ салбарынхны байр суурь гэдэг асуудал хэвлэл мэдээллийн салбарт маш чухал асуудал юм билээ. Ер нь бид нар энэ хуулийн төслийг хэлэлцүүлээд сэтгүүлчдийн дунд 4 удаагийн хэлэлцүүлэг хийсэн, олон улсын байгууллагатай 2 удаа хэлэлцүүлэг хийсэн. Яг хэвлэл мэдээллийн байгууллагад өдөр тутмын үйл ажиллагаа явуулж байгаа сэтгүүлчид, редакцын эзэд, орон нутгийн сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн энэ байгууллагуудын дунд нь бид нар хэлэлцүүлэг хийсэн юм. Тэгэхээр хамгийн том бэрхшээлтэй асуудал ер нь юу ажиглагдсан бэ гэхлээр аль байгууллага нь том болох гэж байгаа юм гэдэг ч юм уу, аль байгууллагыг зохицуулах гэж байгаа юм гэдэг ч юм энэ асуудал дээр байр сууриуд нь их өөр өөр байдаг. Тэгээд сэтгүүлчид маань өөрсдөө олон ургалч үзэлтэй хүмүүс учраас өөр өөрөөр илэрхийлдэг юм байна лээ.

Тэгэхээр бид харин таны хэлснээр бараг эсрэгээр энэ байгууллага институцийн шинжтэй зүйлүүд энэ хууль дээрээ бас бага хөндөх гэж хичээсэн юм. Тэгээд эрх зүйн зохицуулалтын үндсийг нь тавьчихъя. Ингээд байгууллагад өөрийн зохицуулалтын байгууллагатай байж болно гээд оруулчихъя гээд. Цаашаагаа өөрсдийн хөгжлөөрөө, салбарын хөгжлөөрөө энэ байгууллага нь ямар байх юм, яаж төлөвших юм, өнөөдөр ямар үүрэг гүйцэтгэж байгаа юм энэнийхээ

хүрээнд улам сайжраад төлөвшөөд явах болов уу гэсэн энэ үндсэн дээр бид нар тийм байгууллагад байж болно гэдэг тэр ерөнхий заалтаар нээгээд тэгээд чухам ямар байгууллага байх юм, ямар бүтэцтэй байх юм, яаж сонгогдох юм гэдэг юм уу энэ аль болохоор салбарын институцлаг зүйлээс нь аль болохоор бид нар тойрч ингэж хийсэн юм.

Сэтгүүлчийн ёс зүйн механизм бол бид нар энэ гомдол гаргаж байгаа этгээд редакцад нь өөрийн зохицуулалтын байгууллагад хандаж болох болно гэдэг зүйлийг нээж өгсөн юм. Ингээд цаашаагаа бас дахиад шүүхэд хандах эрх нь нээлттэй байгаа. Тэр байгууллагын нэр хүндтэй холбоотой асуудал бол чухал асуудал. Манай хуулийн төсөл 4 дэх хэлэлцүүлэгт ортлоо бид нар бүүр яг тусгайлан зохицуулаад өгчихсөн байсан. Төрийн байгууллагаас, төрийн байгууллагаас төрийн байгууллагын нэр хүндийг хамгаална гэдэг юм уу ийм зорилгоор ямарваа байдлаар гомдол гаргахгүй гэдэг бүүр ийм хатуу зохицуулалт бид нар уг нь хуулийнхаа төсөлд хийчихсэн байсан юм. Тэгээд олон байгууллагаас өгсөн саналууд дээр ер нь ийм зохицуулалт байж болохгүй гэдэг ийм саналууд хэлсэн. Хэлэлцүүлгийн явцад бас нэлээн чамгүй олон шүүмжлэлтэй тулгараад энийг тэгвэл хуучин байсан чигээр нь орхиё гээд ингээд орхичихсон юм. Ер нь таны хэлж байгаа санаа үнэн. Иргэн хүн бол өөрөө гомдлоо гаргаад өөрийнхөө нэр төр, ажил хэргийн нэр хүндтэй холбоотой санал гаргаад явж байж болно. Зарим аж ахуйн нэгж, хуулийн этгээдтэй холбоотой ч болно гэж бид нар үзэж байсан.

Жишээлбэл, бизнес явуулж байгаа аж ахуйн нэгж бол өөрсдийнхөө нэр хүндийг хамгаалах зорилгоор болно. Гагцхүү төрийн байгууллага энэ чиглэлийн гомдлыг гаргаж болохгүй гэдэг энэ зохицуулалтын хүрээнд бид нар оруулж явж байгаад тэгээд хэлэлцүүлгийн явцад хамгийн сүүлд хасагдаад өнөөгийнхөө яг энэ байдлаар болоод хасагдаад энэ төсөл ороод ирчихсэн гэдгийг хэлье.

Тэгээд энэ салбартай холбоотой зүйл дээр дарга ажлын хэсгээс салбарын байгууллагуудаас тайлбар өгүүлчихье.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгээс хэн хариулт өгөх вэ? 4 номер Гүнжидмаа Хэвлэл мэдээллийн зөвлөлийн захирал асуултад хариулъя. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Г.Гүнжидмаа: Та бүхний энэ өдрийн амар энэ амрыг эрье. Хэвлэл мэдээллийн салбар өөрөө маш онцлог, бусад хууль зүйн салбар өөр бусад салбаруудын зохицуулалтаас бас их ялгаатай байгаад байдаг. Энэ яагаад гэвэл өөрөө олон ургалч үзэл барь бодлыг хэрэгжүүлж байдаг салбар. Институт, холбоод эвслийн хувьд ер нь олон улсын чиг баримжаагаараа 3 тулгуур баганатай гэж үздэг.

Нэгдүгээрт сэтгүүлчдийн эвлэлдэн нэгдэх эрх чөлөөгөөр нэгдсэн сэтгүүлчдийн холбоо, сэтгүүлчдийн мэргэжлийн эрх ашгийг хамгаалж ажилладаг.

Хоёрдугаарт нь хэвлэл мэдээллийн эздийн холбоод байдаг. Өнөөдөр энэ холбоонууд өөрсдийн чиг үүргээ хэрэгжүүлээд явж байгаа. Эздийн буюу хөрөнгө оруулагч талын бизнесийн эрх ашгаа хамгаалаад ажилладаг. Энэ 2 холбоодын нэгдэлд суурилсан төлөөллийн хувьд 50, 50 хувийн оролцоотой.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Товч тодорхой хариулт өгөөрэй. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Г.Гүнжидмаа: Энэ 2 холбоодын төлөөлөлтэйгөөр хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт буюу ёс зүйн асуудал дээрээ зөвхөн нэгдэж байгуулдаг. Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг. Тэгэхээр өнөөдрийн хуульд салбар ёс зүйн буюу сэтгүүл зүйн бүтээлийн ёс зүйн асуудлаа өөрсдийн энэ холбоодын төлөөлөлтэйгөөр байгуулагдсан өөрийн зохицуулалтын системээр нь дэмжиж явах нь төрийн оролцоог хэвлэл мэдээллээс холуур байгаагийн бас нэгэн баталгаа гэж харж байгаа. Энэ үүднээс салбарын хувьд өөрсдийн чиг үүрэг бүхий холбоонууд түүнээс улбаалсан ёс зүйн хариуцлагаа хэрэгжүүлэх энэ зохицуулалтын байгууллага нь 10 жилийн түүхийг үзүүлээд явж байгаа. Бид нарын хувьд ялангуяа эрх зүйн системийн хувьд Европын чиг баримжаатай, нийгмийн үнэт зүйлд суурилсан, хамтын эв нэгдэлд суурилсан энэ зохицуулалтыг бол аваад явж байгаа. Энэ нь бол бусад улс орнууд, Азийн орнууд гэх мэтчилэнгээс харилцан ялгаатай буюу салбар бие дааж ёс зүйн зохицуулалтаа өөрсдөө хийдэг. Энэ.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн тодруулж асууя.

Х.Баасанжаргал: Тодруулаад бас салбарынхан болоод сайд хариулаарай. Энэ төлбөртэй мэдээллийн тухайд ямар зохицуулалт орж байгаа вэ? Уг нь бол төлбөртэй мэдээлэл гаргаж байгаа тохиолдолд заавал төлбөртэй гэдэг тайлал байх ёстой. Одоо ер нь манай телевиз, контент энд тэнд хийгдэж байгаа бүх юунуудыг ерөөсөө энэ төлбөртэй гэдэг мэдээлэл огт тавигдахгүй байгаа. Тэгэхээр энэ эдийн засгийн хөшүүрэг гэх юм уу, эдийн засгийн эрх чөлөөний хувьд энэ дээр үзэл санааны хувьд ямар өөрчлөлт гарч байгаа вэ? Үүнтэй холбоотой төрийн байгууллагуудын дэргэд байгаа энэ олон хэвлэл мэдээллийн алба, нэгж шиг ажилладаг уг нь хэвлэлийн төлөөлөгч гэдэг нэртэй байгаа боловч гээд ингээд бүүр асар том ингээд сүлжээ үүсчихсэн байгаа байхгүй юу. Манай гишүүдийг анх гишүүн болсны дараа манай сэтгүүлчид ч гэсэн уулзсан шүү дээ гэрээ байгуулаарай гээд. Бүгдээрээ л мэдэж байгаа шүү дээ. Гэрээ байгуулах нь байгуулсан байх. Би хувьдаа 1 ч сэтгүүлчтэй гэрээ байгуулаагүй. Яагаад гэвэл энэ хууль батлагдсаны дараа бид бид нар өөрсдийнхөө баримтлах зарчмыг бол би харах ёстой гэж харж байгаа. Тэгэхээр энэ төлбөртэй мэдээлэл, нэвтрүүлгийн хувьд.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Алтангэрэл сайд нэмж хариулт өгье.

О.Алтангэрэл: Энэ хуулийн төслөөр бас орж ирж байгаа шинэлэг харилцаатай нь энэ байгаа юм. Хуулийн төслийн 6.5 төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь өөрийн үйл ажиллагааг тусгайлан сурталчлуулах бол хэвлэл мэдээллийн байгууллагыг хуульд заасны дагуу сонгон шалгаруулж гэрээ байгуулна гэж оруулсан. Өөрөөр хэлэх юм бол тендер зарлана.

Ер нь нэн ялангуяа энэ төрийн болон төрийн өмчит хуулийн этгээдүүдэд их наяд, олон их наядаар тоологдох ийм хөрөнгө мөнгөний эргэлт байгаа. Энэ дундаас хэвлэл мэдээллийн байгууллагад өөрсдөө сонгодог, өөрсдөө дэргэдээ энэ студи, бараг редакц маягийн юм үүсгэн байгуулдаг, өөрсдийнхөө үйл ажиллагааг сурталчилна гэж татвар төлөгчдийн мөнгийг зарцуулдаг энэ байдлыг нь хяналттай

болгоё гээд бид нар энд энэ хуульд заасны дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулна гэж зааж өгөөд тэгээд энэ хуулийн 6.5 буюу төрийн байгууллага төрийн өмчит аж ахуйн нэгжүүд энэ сурталчилж байгаа.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгээс хэн хариулт өгөх вэ? Ажлын хэсгийн 7 дугаар микрофон Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбооны тэргүүн Шаравдорж 1 минутад.

С.Шаравдорж: Ер нь орон нутагт гэлтгүй нийслэлд яам, тамгын газар, хөдөөд аймаг, сум, бүх төрийн байгууллагууд, иргэдээ ер нь эхлээд хэвлэл мэдээлэл хариуцан ийм ажилтан байдаг байсан. Одоо бол энэ ажилтан нь алба болоод төсвийн мөнгөөр сэтгүүлчдийг цалинжуулдаг, тоног төхөөрөмж техник авч өгдөг, контент үйлдвэрлэдэг, ерөөсөө сэтгүүл зүйн үйл ажиллагааг төрийн байгууллагууд дэргэдээ хавтгайдаа эрхлээд явуулж байгаа. Одоо бол аймгаасаа сум руугаа нэвтрээд явж байна. Сургуулийн захирлууд дэргэдээ хэвлэлийн ийм ажилтнууд, алба байгуулаад ажиллаж байна. Тэгэхээр энийг энэ хуулиар зохицуулах хамгийн чухал асуудал байгаа юм. Энийг зохицуулахын тулд энэ төлбөртэй явуулж байх асуудлыг оруулж ирсэн зөрүүлээд.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Өдрийн мэнд хүргэе. Энэ хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг хэлэлцэхийг дэмжиж байгаа. Тэгээд олон ч удаа л бас буцдаг юм шиг байдаг. Нийгэмд маш их том сэдэв болоод л тэгээд хэвлэлийн эрх чөлөөг боомилох гэлээ, тэлэх гэлээ, 4 дэх засаглал гээд л ингэдэг. Тэгээд энэ удаа бас энэ Хэвлэлийн эрх чөлөөний хууль их хуралд орж ирсэн ч гэсэн хэвлэлийнхэн бас нэлээн тийм хүлээцтэй хандаж байгаа юм. Сая би сайдын хэлснээр 3, 4 удаагийн уулзалтын бас үр дүн байгаа юм байна. Энэнд нь бас нэлээн сайн сууж өгсөн юм байна гэж ингэж харж байгаа.

Миний хувьд яах вэ хэвлэл мэдээллийн салбар гэх үү тэгэхдээ л энэ сошиал орчны асуудал дээр бид ер нь бас нэлээн ер нь ямар бодлого барих ёстой байдаг юм бол? Сошиал, аливаа юм сайн муу талтай. Сайн тал нь мэдээж олон байгаа иргэдэд мэдээлэл маш хурдан түгдэг, нэгддэг, нягтардаг. Тэгээд л бараа юмаа сурталчилдгаас авхуулаад л зөндөө л юм байна. Ил тод байдал гэх мэтчилэнгээр нөгөө үг хэлэх эрх чөлөө энээ тэрээ бүх юм байна. Муу тал нь, сөрөг тал нь юу юм бэ гэдгийг бас бид бодож байх ёстой юм болов уу гэж боддог юм. Ялангуяа энэ танхим бүр.

Ер нь энэ 2015 оноос хойш энэ фэйсбүүк сошиал орчин энэ идэвхтэй болсноос хойш энэ 10 жилийн хугацаанд Монголын нийгэм ер нь бас яг юу олж, бас юу болж байгаа вэ гэдгийг бас дүгнэдэг, цэгнэдэг ийм юм бас байгаа болов уу, үгүй болов уу гэж ингэж боддог юм. Тэгээд л нүдэн дээр энэ чинь тэгээд л Шар хад руу ч явж л байна, орон шоронд ч явж л байна. Үгүй тэгээд л эрэгтэй байсан хүн нүдэн дээр галзуурсаар байгаад л эмэгтэй болоод л хувирчихлаа шүү дээ.

Тэгэхдээ ер нь тэгээд цаашдаа бид энэ сошиал орчныг ер нь энэ дараагийн 10 жилийг бид ер нь бас яаж харах юм? Монгол Улсад энэ сошиал орчин маань ер нь албан бусаар хэвлэлийн юу болсон шүү дээ. Тэгээд л зүв зүгээр байж байгаа хүн дээр л утсаа нүүрэнд нь тулгаад л лайв/live/ хийгээд л өөрийнхөө хүссэн

хариултыг авахыг хүсээд байгаа, өөрийгөө би хэвлэлийн ажилтан гэж ярих гээд байгаа тэр нөхдүүдийг ер нь яаж зохицуулах юм? Энэ тролл хаягуудыг бид ер нь яах ёстой юм? Энэ чинь тэгээд явж явж магадгүй бид нар ирэх 10 жилийн дараа газар нутаг нь бүрэн бүтэн байгаа ч гэсэн бие биедээ дургүй бие биеийгээ үзэн ядсан 3 сая 500 мянган хүн болж хувирах вий дээ.

Тийм учраас энэ дээр ер нь хуулийн байгууллага ч тэр, хэвлэл мэдээллийн байгууллага ч тэр яг ямар байдалтай байдаг юм, олон улсын жишиг нь бас яадаг юм? Зарим улсуудад тийм тролл хаяг нээх ямар ч бололцоо байдаггүй гэж байгаа. Зарим нь бүр ашиглуулдаггүй гэж байгаа, заримд нь заримд нь шүү ингээд дурын хүн дурын хаягаа нээж цэцэг, ус, тэгээд л янз янзын сайхан нэр ус өгөөд ингээд тэгээд тэр дээр дураараа юмаа бичиж байдаг, доромжилж байдаг, занаж байдаг, зүхэж байдаг ийм л бас нийгэм болж хувирчхаад байна шүү дээ.

Тэгэхээр аливаа юм бас эрх чөлөө байлгүй л яах вэ. Гэхдээ нөгөө талдаа бас энэ нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөг нь бид бас үнэлдэг, дүгнэдэг л байхгүй. Надад 10 жилийн дараа тэгээд яг ний нуугүй хэлэхэд аль нам засаг барих нь сонин биш шүү дээ. Энэ Монгол Улс 10 жилийн дараа ямар болчих юм байх вэ гэдэг нь л энэ танхимд бас би ярих ёстой юм болов уу даа л гэж нэг ёсондоо үг хэлье л гэж ингэж бодсон юм. Тэгэхээр энэ дээр ер нь энэ дээр хийсэн судалгаа юм байдаг юм болов уу, үгүй юм болов уу? Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Оюунсайханы Алтангэрэл сайд хариулт өгье.

О.Алтангэрэл: Энэ удаагийн Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиар бид нарын гол зохицуулах гээд байгаа харилцаа нь яг энэ редакцтай, бас хариуцлагатай сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг сэтгүүлчдийн эрх зүйн байдлыг бид нар тодорхойлж, хамгаалах энэ чиглэлээр л бид нар боловсруулсан.

Өөрөөр хэлбэл, одоо ингээд энэ хуулийн төслийг боловсруулж хэлэлцүүлэх явцад маш их хөндөгдсөн асуудал бол жишээлбэл яг таны саяын хэлсэн асуудлыг манай хэлэлцүүлгийн үеэр манай нэр сэтгүүлч Ганчимэг гуай тавьж байсан. Тэгэхээр 1 ялгаатай тал нь юу юм бэ гэхлээр хэдийгээр олон дагагчтай, хэдэн зуун мянган дагагчтай, олон дагагчтай ч гэсэн тэр фэйсбүүкээр, сошиал платформуудаар инфлюэнсер хийгээд бусдад нөлөөлж байгаа хүмүүс бол бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа нь зохицуулагдъя.

Харин яг сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаа явуулж байгаа энэ хүмүүсийнхээ эрх зүйн статусыг бид нар өөр үзье. Өөрөөр хэлбэл, яагаад өдийг хүртэл Монгол Улсын Эрүүгийн хуульд нэг зүйл байгаа юм. Сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаанд саад учруулах гэдэг. Энэ гэмт хэргээр ерөөсөө хүн ял шийтгэгддэггүй. Энэ гэмт хэргээр мөрдөн байцаалтын ажиллагаа явагддаггүй. Үгүй тэгээд өнгөрсөн энэ он жилүүдэд, өнгөрсөн 20, 30 жилийн хугацаанд сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаанд хэн ч саад учруулаагүй юм уу гэдэг асуудал гарч ирж байгаа. Харамсалтай нь маш олон ийм саад учруулж байсан үйлдлүүд байсан.

Гэтэл сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаа гэж юу юм бэ гэдэг нь тодорхойгүй байсан учраас, бас яг сэтгүүлч гэж хэнийг хэлэх юм бэ гэдэг нь

тодорхойгүй байсан учраас ийм үр дагавар үүсээд байна гээд бид энэ хуулийнхаа хүрээнд, энэ хуулийнхаа төслийн хүрээнд сэтгүүл зүйн үйл ажиллагаа гэдэг нь олон нийтэд мэдээлэл хүргэх зорилгоор мэдээ, мэдээлэл хайх, эрэн сурвалжлах, олж авах, цуглуулах, боловсруулах, нягтлах, агуулга бүтээх ажиллагаа явуулсны үндсэн дээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэх, нэвтрүүлэх, түгээх мэргэжлийн үйл ажиллагааг ойлгоно гэж.

Сэтгүүлч гэдэг нь яг саяын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн байгууллагын редакцад хамааран орон тооны болон орон тооны бус байдлаар, эс үгүй бол бие даасан чөлөөт байдлаар гүйцэтгэж байгаа хүнийг гэж. Өөрөөр хэлбэл, бид нар Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиар холбогдох статусыг нь зохицуулаад, зарим нэг зүйлийг нь хамгаалаад, хариуцлагажуул ингэснийхээ дараа заавал хамгаалах ёстой. Тэгэхээр энэ сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаа бол бүх хуулиараа, мөн нэн ялангуяа Эрүүгийн хууль ч байдаг юм уу, бусад хуулиудаар хамгаалагдах ёстой юм. Харин таны ярьж байгаа яг энэ сошиал орчинд үйл ажиллагаа явуулж байгаа инфлюэнсер гэгдэх инфлюэнсер биш байсан ч гэсэн өөртөө харьяалагдах сошиал орчноор үйл ажиллагаа явуулж байгаа хүмүүсийн асуудал яг энэ хуулийн хүрээнд зохицуулагдахгүй байдлаар томьёолж оруулж ирсэн.

Д.Амарбаясгалан: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн тодруулж асууя?

Ц.Идэрбат: Тийм хэвлэл мэдээллийн байгууллагын нэр хүндийн асуудал бас энэнтэй шууд холбогдох юм болов уу гэж ингэж боддог. Тийм учраас одоо яг энэ телевиз, энэ сэтгүүл, энэ сонин, энэ үүдэнд байгаа энэ редакцтай сайтууд эд нар ямар ч асуудалгүй шүү дээ. Бүгд хэлсэн ярьсандаа хариуцлагаа хүлээнэ гэдгээ ухамсарласан тийм мэргэжлийн хүмүүс байгаад байгаа байхгүй юу.

Нөгөө талдаа би сэтгүүлч юм гээд хаяг нээчихсэн нөхөр гүйгээд байгаа тэр асуудал чинь магадгүй сэтгүүл зүйн нэр хүндэд ч бас нөлөөлөөд байгаа юм шиг харагдаад, бөөн хар хэрүүл л байх юм байна шүү дээ. Тийм учраас энэ тал дээрээ ч гэсэн бас анхаараад явах нь зүйтэй байх. Энэ хуулийг үзэл баримтлалын хувьд хэлэлцэхийг нь дэмжиж байгаа. Тэгээд энэ 4 дэх засаглал улам л бэхжих ёстой, бас тодорхой хэмжээнд үүргээ биелүүлдэг гэж ингэж боддог. Харин энэ хуулийг хэлэлцэх явцад тэгээд өшөө юмнууд нэлээн тодорхой болох байлгүй. Миний саяын хэлсэн зүйлийн агуулгыг та бас Хууль зүй, дотоод хэргийн сайдын хувьд бас сайн бодоорой л гэж ингэж хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Алтангэрэл сайд энэ хэвлэл мэдээллийн байгууллага, зарим сэтгүүлчдийн зүгээс бас энэ хуулийн үзэл баримтлалтай санал нийлэхгүй байгаад байгаа тийм тал бас байна шүү дээ тийм ээ? Гишүүд ч бас тэр талаар бас олон хүнтэй уулзаж мэдээлэл сонссон байна. Та бас хэд хэдэн удаагийн хэлэлцүүлэг хийчихсэн гэж байгаа юм. Тэгэхээр ер нь энэ хэлэлцүүлэгт хэвлэл мэдээллийн байгууллагуудын төлөөлөл ямархуу хувь хэмжээтэй оролцсон бэ? Нөгөө мэргэжлийн байгууллага, холбоонууд нь энэ өргөн барьчихсан байгаа, хэлэлцэж байгаа төсөлтэй санал хэрхэн ний нийлж байгаа? Гол нийлэхгүй байгаад байгаа санал нь яг юу байна вэ? Энийг та тайлбарлаад хэлээдхээч.

О.Алтангэрэл: Хэд хэдэн үндэслэл ярьж байгаа юм. Бид бол хэлэлцүүлгээ аль болохоор өргөн хүрээнд явуулсан, бүгдэд нь урилга хүргүүлсэн. Сэтгүүлчдийн

дундах хэлэлцүүлгийг түрүүнд нь яригдаж байсан хуулийн төслүүдээс хамгийн олон удаа хамгийн өргөн хүрээнд хийсэн. Энэ дунд мэдээж сөрөг байр суурьтай, эсэргүүцэж байгаа байр суурь, дэмжихгүй хүмүүс ч байсан. Үйл ажиллагаа ингээд явах ёстой, одоо бид нар ингээд ийм задгай байж болохгүй байна гэдэг юм байж байсан. Бид нар хамгийн түрүүнд Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн байр суурь ямар байна гэж харж байсан. Одоо хүндэтгэн дурсахад манай Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн ерөнхийлөгчөөр ажиллаж байсан манай нэрт сэтгүүлч Отгонбаатар сэтгүүлч маш их дэмжиж байсан. Энэ байр сууриа илэрхийлж, яриа өгч ингэж ярьж байсан. Одоо хэвлэл мэдээллийн байгууллагуудыг төлөөлөөд манай ажлын хэсэгт бас ороод ирчихсэн байгаа олон ургалч үзлийг хүндэтгэж байгаа. Тэгэхдээ 2, 3 төрлийн ийм ойлголт байдаг юм байна лээ.

Нэгдүгээрт одоогийн манай ба хууль маш сайн хууль. Тэгээд энийг ер нь яах гэж өөрчлөх гээд байгаа юм гэдэг нэг үзэл санаа байдаг. Тэр хуулийн төсөл маань яг үг, үсгээрээ энэ хуулийн төсөлд орчихсон байгаа. Нөгөө 4 зүйлтэй хууль маань тэгээд энэ дотроо байж байгаа. Нөгөө талаар зохицуулахгүй байгаа харилцаануудыг нь, сэтгүүлчийг эх сурвалжаа нууцлах эрхийг нь хамгаалахгүй байгааг, илт худал мэдээлэх гэдэг зүйлийг тодорхойлохгүй байгааг, тэгээд сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаа гэдгийг тодорхойлохгүй байгааг, төрийн байгууллагаас хэвлэл мэдээллээр хэт үүрэгтэй байгааг хязгаарлахгүй байгаа энэ чиг үүргийг заавал хууль гаргаж л бид нар зохицуулахгүй бол болохгүй байгаа.

Нөгөө талаас төр хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангана гэж юу байдаг юм бэ гэсэн бас ийм аргумент гардаг. Тэгэхлээр төр өөрөө хууль баталдаг. Нийгмийн харилцааг хамгаалж Эрүүгийн хууль, Зөрчлийн хуулиудаа баталж, хүний эрх, эрх чөлөө, амь нас, эрүүл мэндийг хамгаалдаг. Тэгэхээр сэтгүүл зүйг ч гэсэн эрүүл байлгах ямар халдлагаас болон тэр эх сурвалжаа ядаж нуух эрхгүй байж, дуудагдаж мөрдөгдөх энэ зүйлээс нь төр хамгаалах үүрэгтэй гэдэг талаас нь энэ хуулийн төслийг боловсруулсан. Тэгээд энэ олон ургалч байдал, үзэл санааг хүндэтгэж байгаа. Тэгэхдээ бид маш олон удаагийн хэлэлцүүлэг хийсэн. Ажлын хэсэг.

Д.Амарбаясгалан: Хэвлэл мэдээллийн зөвлөлийн захирал Гүнжидмаа энэ дээр нэмээд хариулъя.

Ер нь бол 2 зүйл дээр л асуудал төвлөрнө шүү дээ. Хэвлэл мэдээллийн байгууллага эрх чөлөөтэй хэвлэн нийтлэх эрхээ эдлэх тэр нөхцөл, боломжийг бүрэн эдлэх, ямар нэгэн байдлаар төрөөс хянаж цагддаг байдалтай байж болохгүй гэдэг ийм байр суурийг бол тогтмол илэрхийлнэ.

Нөгөө талдаа мэдээж энэ хуулиар буюу гүтгэгдсэн нэр төртэй холбоотой асуудал, үүнээс үүсэх сөрөг үр дагавруудтай холбоотой асуудлыг хэрхэн зохицуулж, мэдээллийнхээ үнэн, зөв байдлыг хэвлэл мэдээллийн байгууллагууд хэрхэн нягталж, хэрхэн хариуцах вэ гэдэг асуудал. Яг ингээд энэ 2 асуудлыг л зөв зохицуулах ёстой л гэдэг зүйл энд яригдах ёстой байхгүй юу. Тэгэхээр энэ дээр Гүнжидмаа мэргэжлийн хүний хувьд тайлбар хийгээч. Хариулт ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Г.Гүнжидмаа: Улсын Их Хурлын даргын асуултад хариулъя. Энэ зарчмын хувьд хэвлэл мэдээллийн салбарын эвсэл, холбоонууд энэ удаагийн хуулийн

төсөл дээр маш нэгдмэл байдлаар хамтарч ажилласан. Ажлын хэсэгт голлох байгууллагууд орж ажиллаж энэ төсөлд хувь нэмрээ оруулсан гэдгийг онцлон хэлье.

Энэ хуулийн төслийг дэмжиж энд бас үгээ хэлж байгаагийн хувьд энэ удаагийн төсөл дээр төр ямар эрх, эрх зүйн орчныг зохицуулж өгөх юм, хэвлэл мэдээллийн салбар өөрсдөө юугаа зохицуулж, хариуцлагаа хэрхэн үүрэх юм бэ гэдгийг маш тодорхой зааглаж өгч байгаа нь ач холбогдолтой байгаа.

Тэгэхээр хэвлэл мэдээллийн байгууллага сэтгүүлчдийг эрх зүйн статусуудыг нь тодорхой болгох, мэдээллээ олж авах, хайх, хэвлэн нийтлэх, эх сурвалжаа нууцлах, редакц болоод редакцын дотоод зохицуулалтаа илүү дэмжих талд нь дэмжсэн. Үүний зэрэгцээ яг худал, ташаа мэдээлэл тараах, эсвэл алдаа мадаг гарахад мэргэжлийн ёс зүйн зохицуулалтаараа шийдэх энэ боломжийг Монгол Улсын төр үүнийг хүлээн зөвшөөрч ойлгож, салбар нь өөрөө маш хариуцлагатай ажиллах ёстой гэдэг энэ зарчимд туссан нь бол маш чухал байгаа.

Тэгэхээр хуулийн хүрээнд бид нар үйл ажиллагаагаа явуулахын хажуугаар мэргэжлийн салбарын байгууллагууд, хэвлэл мэдээллийн байгууллагууд өөрсдийн хариуцлага ёс зүйгээ маш өндөрт ухамсарлаж энэ талдаа илүү чамбайруулж ажиллах энэ боломжийг бас гарч байгаа. Энэ нь өөрөө төр хэвлэл мэдээлэлд оролцохгүй, агуулгын цензур тавихгүй, бие даасан байдалд нь халдахгүй гэсэн гол баталгаа гэж харж байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Энэ би түрүүн асуугаад байна л даа яг тодорхой хэвлэл мэдээллийн байгууллага сэтгүүлчид жишээлбэл яг ямар заалт дээр сэтгэл дундуур байна уу? Яг Улсын Их Хурлаар хэлэлцэгдэж байгаа энэ төсөл дээр тэр нь болохгүй байна гэж хамгийн ихээр хөндөж байгаа заалт юу байна вэ? Нэмээд хариулаадхаач ажлын хэсэг нь 4.

Г.Гүнжидмаа: Хамгийн эсэргүүцэж байгаа 1 заалт 5 дээр байгаа. Хэвлэл мэдээллийн ёс зүйн зохицуулалтыг хуульчилсан байна гэж байгаа. Сэтгүүл зүйн ёс зүйн зарчмууд гэж тавьсан. Энэтэй огтын санал нийлэхгүй байгаа. Тэгэхээр энийг, энэ заалтыг би татаж аваасай, энэ бол ёс зүйн хүрээндээ зохицуулах энэ зарчмуудын асуудал байгаа гэж харж байгаа.

Дээрээс нь нэмээд тодорхой бас хэтэрхий компанийн зарчим руу шахаж байгаа нь энэ зөв үү, буруу юу гэдэг дээр бас их ярьж байна. Олон төрлийг хүлээн зөвшөөрсөн. Түүнийхээ хажуугаар арилжааны хэвлэл мэдээллийн зарчмаар ажилла гэж дийлэнх хэвлэл мэдээллийг компанийн хэлбэр рүү шахаж байгаа нь олон талт байдал бас сөрөг нөлөөлөх вэ гэдэг энэ асуултыг бас тавьж байна. Гэхдээ энэ олон ургалч байдлыг агуулсан олон хэлбэрийг энэ хуулийн төсөлд оруулсан байгаа нь арилжааны, олон нийтийн.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууя.

А.Ариунзаяа: Энэ бэлдсэн материалтай холбоотой Баасанжаргал гишүүний хэлсэн сайн бүрдүүлбэр байна гэдэгтэй санал нийлж байна. Гагцхүү ийм олон хуудастай бичиг баримт дотроо 4-хөн хуудас буюу 8-хан нүүр хууль дээрээ жоохон дутуу дулимаг ажиллачихсан юм уу даа гэдэг ийм хувь хүний мэдрэмжтэй байна.

Миний бодлоор одоо байгаа хууль дээрээ энэ хуулийн орж ирж байгаа 8.5 буюу өөрийн зохицуулалтын байгууллагатай байна гэдэг тэр эрх мэдлийг нь өгөөд л бараг болохуйц хэмжээний харагдаж байна. Хэд хэдэн санаа зовж байгаа асуудал байна.

Нэгдүгээрт төрөөс хэвлэл, мэдээллийн хэрэгслийн нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд агуулгын хяналт тавих байгууллага, албан тушаал бий болгохгүй бөгөөд ийм үйл ажиллагааг санхүүжүүлэхийг хориглоно гэж байна. Яах вэ төрийн булхай, луйврыг илчлэх гээд байгаа юм уу гэдэг ийм хяналтыг хэн ч тавьж болохгүй гэдэг агуулгаар ч ойлгоод байна.

Гэтэл хууль бус мөрийтэй тоглоом, гэмт хэргийн шинж чанартай, хүүхдүүдийн эсрэг энэ болохгүй байгаа зүйл, заалтууд дээр хэн цензур тавих юм бэ? Дураар нь тавиад туучих юм уу? Цахим орчноо хянаж чадахгүй байгаа учраас 16 хүртэл насны хүүхдийн сошиал хэрэглээг нь хязгаарлая гээд Боловсролын сайд нь яриад явж байгаа шүү дээ. Хүүхдүүдээ хорьчихоод. Тэгээд өөрсдөө энэ цахим орчинд дураараа дургих уу ямар ч цензургүй. Манай төр ер нь ингээд 2 туйлын шийдвэр гаргаад байдгаа ер нь болихгүй юм уу. Энэ олон хуудас дотор байгаа бүхий л зовлон нь сошиал орчинтой холбоотой, хувь сэтгүүлчтэй холбоотой гомдлуудын талаар маш их судалгаанууд байна. Гэтэл яг энэ асуудлууд энэ хуулиар зохицуулагдаагүй. Сэтгүүлч гэдэг маань өөрөө хувь хүнийхээ, өөрийнхөө пэйж/page/-ээр, өөрийнхөө аккаунтаар бичиж байгаа сэтгэгдэл, бичиж байгаа мэдээ, мэдээлэл нь хэвлэл мэдээллийн байгууллагадаа орж явах юм уу, үгүй юм уу? Хариуцлага хүлээх юм уу, үгүй юм уу энэ чинь чухал шүү дээ. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэдэг дотор уг нь бол энэ сэтгүүлч гэдэг нь орж байгаа байхгүй юу.

Гэхдээ нөгөө талдаа үгүй энэ чинь миний хувь сэтгүүлчийнхээ хувьд хэлж байгаа юм, энэ бол манай байгууллагын асуудал биш гэж хэлэх энэ гарц нь байгаад байна шүү дээ. Төрийн байгууллагуудыг хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно гэсэн ийм заалт нь тухайн сонин сэтгүүл, радио, телевиз бусад юмыг нь ойлгож байна. Цахим хуудастай байхыг, мэдээ мэдээллийн цахим хуудастай байхыг бас энэ хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэж оруулж байгаа байхгүй юу.

Тэгэхээр тухайн яамнууд Алтангэрэл сайд ч гэсэн өнөөдөр Хууль зүйн яамны сошиал пэйж/page/-үүд нь байгаа шүү дээ. Энийгээ болих юм уу? Мэдээ, мэдээллээ хэрхэн яаж өгөх юм? Тэгээд мэдээ мэдээллээ нээлттэй өгөхдөө заавал тендер зарлаж, заавал мөнгө өгч байж мэдээ, мэдээллээ олон нийтэд хүргэх юм байна л даа. Төрийн байгууллага гамшиг, аюулт үзэгдлээс бусад үед хэвлэл мэдээллийн хэрэгслээр үнэ төлбөргүй мэдээ, мэдээлэл нэвтрүүлэхийг шаардахыг хориглоно гээд 6.4 дээр байна. Үгүй энэ чинь нөгөө мэдээллийнхээ агуулгаасаа байж болдоггүй юм уу? Хүүхэд хамгаалал, нийгэмд хэрэгтэй, хэрэгцээтэй мэдээллүүдийг үнэ төлбөргүй явуулж болохгүй юу. Яагаад заавал тендер зарлах ёстой юм? Дахиад л нөгөө мөнгөний харилцаа үүсэж байна шүү дээ. Тендерт шалгарч байгаа компани нь дараад нь өөрөө өөрийнхөө санхүүгийн бүхий л тайлангаа олон нийтэд нээлттэй тавих юм гэнэ. Тэгэхээр миний бодлоор бол үнэхээрийн Байнгын хороон дээр ч энэ хууль маань 3 ч удаа санал хураагаад 3 ч удаа унаад арай гэж босгож орж ирсэн, арай л жоохон дутуу юм уу даа гэдэг л ийм

сэтгэгдэлтэй байгаад байна. Хүний үзэл бодол чөлөөтэй илэрхийлж болно болно бололгүй яах вэ. Гэхдээ ёс зүй нь хаана байх вэ, гүтгэх нь хаана байх вэ? Өнөөдөр редакцтай хэвлэл мэдээллийн байгууллагуудад ямар ч.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Оюунсайханы Алтангэрэл сайд.

О.Алтангэрэл: Ариунзаяа гишүүний байр суурийг хүндэтгэж байна. Тэгэхдээ зарим зүйл дээр бас ташаа ойлголттой байна гэж хэлье. Ерөөсөө одоо байгаа хууль дээр байгаа заалт тэр чигтээ байгаа. Төрөөс хэвлэл мэдээллийн байгууллагад цензур тавихгүй. Тэрүүгээр юу нэвтрүүлж байна, эднийх архи, тамхи сурталчилж байна уу гэдэг ч юм уу ийм байдлаар байгууллага гаргаад тэрийг хянаж суухгүй гэдэг л агуулга. Ер нь хэвлэлийн эрх чөлөөний хамгийн гол тулгуур багана дээр тэрийг оруулж байгаа. Тэгэхээр энэ хуулийн төсөл дээрээ бид нар анхаарууштай, нэмэх шаардлагатай, хасах шаардлагатай зүйлүүд байж болохыг хүлээн зөвшөөрнө.

Тэгэхдээ тэр ганцхан хэрвээ манай Ариунзаяа гишүүний хэлж байгаа шиг ганцхан өөрийн зохицуулалтын байгууллагад зохицуулалтыг оруулаад ирсэн бол цаана нь энэ сэтгүүл зүйн үйл ажиллагаа гэж юуг хэлэх юм бэ, сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаа юу юм, сэтгүүлч гэж хэн юм бэ, эх сурвалжаа яаж нууцлах юм бэ, саяын тэр шүүмжлэлтэй хандаж байгаа тэр төртэй холбоотой асуудал зэрэг үй олон харилцаа огт зохицуулалтгүй үлдэх гээд байсан юм. Ер нь ямар нэг зохицуулалтгүй байгаа учраас өнөөдөр сэтгүүлч болоод сэтгүүл зүйд учирч байгаа хүндрэл, бэрхшээлүүдийг арилгах зорилгоор л орж ирж байгаа хууль.

Гэтэл төр хэвлэл мэдээллээ хүргэхдээ хэвлэлийн төлөөлөгч, хэвлэлийн ажилтан өөрсдийнхөө хуудас, цахим хуудсаар хүрэх бүрэн боломжтой. Энэ хуулиар ерөөсөө хориглоогүй. Гагцхүү бид энэ хуулиар юу хориглохыг эрмэлзээд байгаа вэ гэхлээр татвар төлөгчдийн мөнгөөр медиа ажил явуулдаг. Өөрөөр хэлбэл, ийм рийл хийдэг, багтай, нэвтрүүлэг хийдэг багтай, компьютер дээр компьютер график хийдэг, тастдаг гээд бүтэн редакц дайны ийм зүйл хажуудаа ажиллуулаад, тэрийгээ татвар төлөгчдийн мөнгөөр хийлгээд, дахиад цаашаагаа сурталчилгаагаа явуулахдаа татвар төлөгчдийн мөнгөөр явуулдаг энэ байдлыг таслан зогсоогоод, ингэж хийж байгаа бол нээлттэйгээр явуул л гэж байгаа.

Яг өнөөдрийн байдлаар ямар байдалтай явагдаж байгаа вэ гэвэл нэн ялангуяа төрийн өмчит томоохон аж ахуйн нэгж байгууллагууд дээр энэ хэвлэл мэдээлэл, Пи Ар-тай холбоотой зүйлүүд нийгмийн хариуцлагын хүрээнд гэдэг халхавч дор, эсвэл өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчлах гэдэг халхавч дор тэнд байгаа тодорхой нэг тодорхой этгээд, эсвэл заримдаа тодорхой улс төрчийн эрх ашгийг хамгаалахын тулд яваад байгаа учраас бид нар ийм биш биш байя гэж. Эргээд энэ байдал маань өөрөө хэвлэл мэдээллийн байгууллагад муугаар нөлөөлөөд байна. Бид нар яаж төртэй өрсөлдөх юм бэ, тэнд өндөр цалин, хөлс аваад хүмүүсийг аваад явчихдаг, өөрсдөө тэндээс мөнгө зарцуулдаг энэ нь манай хэвлэл мэдээллийн байгууллагад сөргөөр нөлөөлж байна гэдэг гомдол сэтгүүлчдийн зүгээс хэлэлцүүлгийн үеэр маш их гарсан.

Тэгээд Төрийн байгуулалтын байнгын хороон дээр 3 удаа санал хураалгасан гээд ингээд яриад байгаа. Яг үнэхээр өнөөдрийн бид нарын чуулганы хуралдаанд байгаа бэрхшээл л гарсан. Нөгөө төхөөрөмж нь ажиллахгүй, би өөрөө

Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүн шүү дээ. Би өөрөө хуулийн төсөл ингээд бариад явж байгаа хүн. Миний дарж байгаа төхөөрөмж дээр улаа асаад л би эсрэг санал өгөөд л дахиж санал хураалгая гэж гэж, гишүүдээр ч ийм санал гаргаж явж байгаад л хураасан. Тэрнээс унагаад их босгоод байсан зүйл та буруу ойлгосон байна шүү гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Аюушийн Ариунзаяа гишүүн тодруулж асууя.

А.Ариунзаяа: 1 удаагийн тохиолдол яах вэ. 3-ын 3 удаа болохлоор мөн оролцохгүйгээр танхимаас гарсан хүмүүс ч байхыг үгүйсгэхгүй.

Тус хуулийн 6.10 дээр тухайн хуулийн этгээдүүд дэргэдээ хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ажиллуулахыг хориглоно гээд заачихсан байгаа бол тус хуулийн 4.1.3 дээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэж юуг хэлэх вэ гэхлээр мэдээллийн цахим хуудсыг хэлнэ гэхихсэн байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ мэдээллийн цахим хуудсыг ажиллуулахад бүх төрийн байгууллага, бүх пэйж/page/, бүх энэ цахим хуудаснуудаа хаана гэсэн үг вэ гэсэн ийм асуулт байгаад байна. Энэ цагаан дээр хараар бичээстэй байгаа юмыг би уншаад байна шүү дээ.

Хоёр дахь нь болохлоор энэ зузаан номынхоо харилцаа, зовлон бэрхшээл тоочсон энэ сошиал болоод сэтгүүлчийн, хувь сэтгүүлчийн өөрийнх нь тэр ёс зүй, хариуцлага, гүтгэлэг энэ асуудлууд чинь огтоос зохицуулагдаагүй байна. Тэгэхээр энэ асуудал нь тэнд байгаад байхад энд шал өөр хууль оруулж ирж байгаа нь өөрөө учир дутал.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Оюунсайханы Алтангэрэл сайд нэмж хариулъя.

О.Алтангэрэл: Ерөөсөө саяын сэтгүүлчтэй холбоотой гомдлыг зохицуулах гэж энэ хуулийг бас боловсруулаагүй ний нуугүй хэлэхэд. Энэ бол өөр бусад хуулиудаар зохицуулагдаад явдаг харилцаа. Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж байгаа өөр бусад хуулиудаар зохицуулагдана. Сэтгүүлчийг яаж ёс зүйтэй байлгах вэ, яаж цензурдэх вэ гэдэг энэ зорилгоор энэ хууль маань ерөөсөө хийгдээгүй. Тэгээд сая манай Ариунзаяа гишүүний харж байгааг та өгүүлбэрийг гүйцээгээд уншвал 4.1.2 дээр чинь хэвлэл мэдээллийн байгууллага гэж редакциягаар сэтгүүл зүйн үйл ажиллагаа эрхэлдэг сонин, сэтгүүл, радио, телевиз, цахим хуудас зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгсэл эзэмшдэг хуулийн этгээдийг ойлгоно гээд хуулийн этгээд байх нь байна, редакциягаар байх нь байна. Тэгээд энд сэтгүүл зүйн үйл ажиллагаа эрхэлдэг байх нь байна. Тэгэхээр зүгээр өдөр тутмынхаа үйл ажиллагааг тавьдаг ийм төрийн байгууллагуудтай холбоотой цахим хуудаснууд бид хамаарахгүй гэж үзэж байгаа.

Д.Амарбаясгалан: Дахин тодруулж асууя Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: 2 дахиа дутуу хариулсан бол 2 дахиа тодруулж болдог шүү дээ тээ? Би 4.1.3-ыг бол хэлсэн. Мөн дээрээс нь энэ хуулийг дагаж орж ирж байгаа бүхий л тайлбарууд чинь хувь сэтгүүлчтэй холбоотой, цахим харилцаатай холбоотой ийм зовлон жаргалыг нь бичсэн байгаа байхгүй юу. Тэгээд ийм олон бүрдүүлбэрээ оруулчихаад яг гол асуудлаа шийдвэрлээгүй байна гэдгийг л би хэлээд байгаа юм ер нь бол. Тэрнээс биш би ингээд хэвлэл мэдээллийн байгууллагын эрх чөлөөг үгүйсгээд байгаа юм огтоос биш шүү дээ. Зүгээр асуудал

чинь хэвээрээ үлдчихлээ шүү гэдгийг л хэлээд байна. Асуудал нь хэвээрээ үлдчихлээ. Төрийн байгууллагууд иргэдэд мэдээллээ өгөх үүргийг бас нөгөө талдаа хүлээж байгаа шүү дээ. Манай зарим гишүүд өөрсдөө ч хэвлэлийн төлөөлөгчид байсан. Тэгээд бүхий л энэ ажлуудаа болих юм уу? Ер нь ингээд тийм ойлгомжгүй хууль бичилт болоод жоохон дутуу ажиллачихсан байна гэдгийг л би хэлээд байгаа юм.

Д.Амарбаясгалан: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Энэ салбарын зовлон, жаргалыг 28 жил үүрч түрж явсан хүн байна. Хүн гүтгэх гэдэг бол хувь сэтгүүлчийн өөрийнх нь ёс зүйгээр тодорхойлогддог. Ёс зүйг хэчнээн код гаргаад гаргаад бардаггүй. Энийг зүгээр л нээлттэй мэдээллээр зохицуулж өгдөг юм байна лээ. Швед улс дэлхий дээр хамгийн алдартай хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуультай, бүх мэдээлэл нь нээлттэй. Яг үндэсний аюулгүй байдал, төрийн онцгой нууц нь л нууц, бусад нь бүгд нээлттэй.

Мэдээлэл хэдий чинээ нээлттэй байна нөгөө сэтгүүлч гүтгэх эрх чөлөө нь хаагддаг байхгүй юу. Тэгэхээр бид нар ингээд өнөөдөр нөгөө еэвэнгийн 2 тал шиг юмаар маргаад байгаа юм. Өөрөө дампуурах эрх чөлөөг нь хэвлэл мэдээллийнхэнд өгөх ёстой. Дампуурах эрх чөлөө нь өөрсдөд нь байх ёстой. Би 3 байгууллага дампууруулж байсан. Тэгэхээр би өөрөө хэвлэлийн эрх чөлөөг хангалттай эдэлсэн хүн байхгүй юу. Буруу юм хийгээд хэрвээ олигтой юм хийхгүй бол дампуурдаг. Нэг бол эрх баригчидтай үзэж тарвал дампуурдаг, хаагддаг. Тэгэхээр өөрөө дампуурах эрх чөлөөг нь өгмөөр байна.

Олон жилийн мөрөөдөл, манай сэтгүүлчдийн мөрөөдөл болсон хэвлэлийн эрх юу эх сурвалжаа нууцлах заалт орж байгаа нь маш сайн байна. Энийг хэдэн талаас нь тайлбарлаж байна. Миний бодлоор энэ зөв заалтаар орсон. Буруу юмнууд байна. Хэвлэл мэдээллийн байгууллагын редакц гэж юу юм бэ гэдгийг тодорхойлж байгаа юм. Энэ дээр татвар төлдөг байх ёстой байхгүй юу. Тэрнээс биш хэдэн компьютер тавиад Алтангэрэл сайдын хэлдгээр тасалдаг, рийл хийдэг камертай нөхдүүд нийлж суучхаад тэрийг мэргэжлийн байгууллага гэж хэлэхгүй. Татвар төлж, хариуцлагаа хүлээдэг байх ёстой. Татвар төлдөггүй ийм тиймэрхүү газрууд зөндөө байна шүү дээ. Би ёстой маш их татвар төлсөн. Тэгэхээр татвар төлдөг байх ёстой.

Дээрээс нь энэ орон нутгийн нөхдүүд хамтын ажиллагааны байгууллага гээд байх юм. Хамтын хэвлэл мэдээллийн байгууллага гээд энэ буруу. Дээрээс нь тэр төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд өөрсдийнхөө үйл ажиллагааг сурталчлах гээд тендер зарлана гэж байгаа. Энэ зөв. Энэ нийтэд ил тод санхүүжилтийг олж авах боломж нээгдэж байгаа юм байгууллагуудад. Ариунзаяа гишүүний хэлсэн шүүмжээ яг эхний заалт дээр нь яг тийм гал ус, хүүхдийн эрхтэй холбоотой бол үнэгүй гаргана гэчихсэн байгаа юм. Харин Алтангэрэл сайд энэ тендер зарлалтыг чинь дараагийн заалт дээр Засгийн газраас энэ үнэ төлбөрийг нь, тэр агуулгыг нь тогтооно гэж байгаа чинь буцаагаад цензур оруулчихаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр миний бодлоор яг энэ байгууллагад 28 жил ажиллаж, 3 байгууллага дампууруулж, асар олон удаа цагдаа, шүүхээр яваад огт хүн гүтгэсэн

гэдэг зүйлээр ял сонсож үзээгүй сэтгүүлч хүний хувьд хэлэхэд энэ хуулийг дахиж сайн базмаар байна. Дахиж сайн янзалмаар байна. Манай Хэвлэл мэдээллийн зөвлөл гээд байгууллага байдаг. Дандаа худлаа шийдвэр гаргадаг. Аль нэг хүний нөлөөнд орчихдог. Гүтгэсэн гээд л тодорхойлолтоо гаргачихдаг. 5 жилийн дараа гүтгээгүй болох нь АНУ-ын Ерөнхий прокуророор тодорхойлуулж байсан хүн би өөрөө байна. Намайг хүн гүтгэсэн гэдэг шийдвэр гаргаж байсан.

Гэтэл АНУ-ын Ерөнхий прокурор дэлхий даяар мэдээлэл хийхэд би тэнд цагаадаж байгаа байхгүй юу. Тэгэхээр ийм зөвлөл огт хэрэггүй. Зүгээр би та бүгдээс юу хүсэж байна гэхээр мэдээлэл авах эрх чөлөөг нь л нээгээд өг, ажилд нь бүү саад бол. Татвараа төл, улсын нууцаа аваад үлд. Тэр цагт хүн гүтгэх эрх чөлөө нь хаагдана. Тийм хүн гүтгэдэг байгууллагад тэр угаасаа дампуурдаг. Тэгэхээр тэр дампуурах эрх чөлөөг нь өг. Одоо ингээд дампуур.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Тодруулж асуух 1 минут нэмж өгье Мөнхбаясгалан гишүүнд.

Л.Мөнхбаясгалан: Тэгэхээр өөрсдөө дампуурах эрх чөлөөг нь л өг гээд байгаа юм. Тэр нь мэдээлэл нь нээлттэй байвал худал мэдээлэл гаргах юм бол тэр байгууллага дампуурна. Нөгөө дампуурах эрх чөлөө гэж кавичкад хэлж байгаа нь эрх баригчидтай үзэлцвэл нэг дампуурдаг юм. Тэгэхээр эрх чөлөөг нь тавиад өг, нууцаа аваад үлдчих тэгээд л болоо. Асар олон мэдээллээ өгөхгүй л байвал тэндээс чинь хүн гүтгэх байдал нь бий болоод байдаг. Хүн гүтгэх эрх чөлөөг нь хаагаад өг. Миний санал ийм байна.

Д.Амарбаясгалан: Алтангэрэл сайд хариулт өгөх үү? Хамтын байгууллага. Орон нутгийн Хэвлэл мэдээллийн холбооны тэргүүн Шаравдорж гуай ажлын хэсгийн 7 дугаар микрофон.

С.Шаравдорж: Асуултад хариулъя. Энэ хамтын байгууллага гэдэг энэ нэр томъёо өмнөх манайд бас орчуулахдаа их янз бүрээр орчуулаад яваад байгаа. Хүйн хэвлэл мэдээлэл гэдэг нэр ч гэсэн нэг хэсэг явсан. Тэгэхээр энэ нийгмийн тодорхой бүлэг, тодорхой сонирхлын бүлгийн хэмжээнд жижиг ийм өөрийн хэвлэл мэдээлэл байж болох юм. Алслагдсан сум суурин ч юм уу, эсвэл ямар мэргэжлийн бүлгийнхэн, сургуулийн сурагчид ийм хэмжээний олон улсын ийм жишиг байдаг. Коммунити медиа гэдэг ийм нэрээрээ.

Тэгэхээр энийг бас энэ хуульдаа Монгол Улс байлгаж, нээлттэй байлгах нь зүйтэй юм гэдэг дээр бид нар санал нэгдсэн. Эхлээд ер нь энэ нэр томъёоноосоо авхуулаад ойлгогдохгүй энэ ямар хэрэгтэй юм гэдэг маргаан их явсан. Энийг эцсийн дүндээ байлгах нь зүйтэй юм гэдэг энэ нэр хамтын гэдэг нэрээр орсон байгаа.

Д.Амарбаясгалан: Хариулт хангалтгүй бол ахиж 1 тодруулах эрх байгаа. Мөнхбаясгалан гишүүн тодруулж асууя гэж байна.

Л.Мөнхбаясгалан: Одоо тэгэхээр манай Бямбацогт гишүүн Бямбын ярилцлага гээд нэвтрүүлэг юм хийгээд байгаа шүү дээ. Энийг хэвлэл мэдээллийн редакц гэж үзэх үү, хамтын хэвлэл мэдээллийн байгууллага гэж үзэх үү,

сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаа хийгээд байгаа Бямбацогт гишүүнийг сэтгүүлч гэж үзэх үү? Үүгээрээ хүн гүтгэвэл яах вэ?

Д.Амарбаясгалан: Оюунсайханы Алтангэрэл сайд хариулт өгье.

О.Алтангэрэл: Бямбацогт сайдын хийж байгаа нэвтрүүлгийг сэтгүүл зүйн бүтээл гэж үзэхгүй. Бид яг л ийм зүйлээс ялгах гээд байгаа юм. Хувь хүний хийж байгаа контент редакцтайгаар, хариуцлагатайгаар сэтгүүл зүйн бүтээл хийж байгаа бол энэ хуулийн хүрээнд болон бусад хуулийн хүрээнд сэтгүүлч, сэтгүүл зүйн байгууллага гэдгээрээ хамгаалагдаж байя. Хувь хүн өөрөө ямар нэг байдлаар контент бүтээгээд, өөрөө хийгээд сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаанд энэ нь өөрөө хамаарахгүй байгаа бол энэ хуулийн хүрээнд хамгаалагдахгүй л гэж энэ үндсэн дээр бичигдэж байгаа. Энэ хуулийн хүрээнд хамгаалалт гэж бид нар юуг хэлээд байна гэхлээр энэ хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа хүний үйл ажиллагаанд саад учруулах юм бол Эрүүгийн хуулиар хамгаалагдана. Сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаанд саад учруулсан гэж буруутгагдана. Энэ хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа хүн өөрөө андуурах, ташаарах гэдэг юм уу илт худал мэдээлэл гэдэг дээр хамгаалагдана гэсэн энэ зүйлийг хийж байгаа.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Баярлалаа. Уг нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хууль бас олон жил яригдаад олон ч удаа буцсан. Үүн дээрээсээ хэвлэл мэдээллийн эздийн ил тод байдлын асуудал нь Улсын бүртгэлийн тухай хууль батлагдахад шийдэгдсэн байдаг. Бусад асуудлууд нь шийдлээ хүлээгээд явж байгаа юм уг нь. Тэгээд энэ холбогдох судалгаа энэ тэр их олон жил хийгдсэн. Олон ч юмнууд ингээд уншигдаж, судлагдаж эргээд бас явсан. Тэгэхдээ би яах вэ энэ хуулийн төслийг уг нь зөвлөлдөөд бас уг нь хэлж л байсан 2 салгаад ороод ирээч. Бас холилдох ямар ч бололцоогүй сэдвийг бас ажлын хэсэг дээр бид хэд бас ташаараад бас хольж хутгаад явж байсан ийм алдаанууд байна. Энэ алдааг давтах хэрэггүй. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хуулиа тусад нь хийчих. Хэвлэл мэдээллийн байгууллагын хуулиа тусад нь хийчих гээд явж байсан. Холиод ороод ирсэн.

Хольж орж ирэхдээ нэлээн зэрэмдэглэчхэж. Ерөөсөө асуудал шийдэж байгаа юм алга. Дандаа тунхаг. Асуудал шийдэгдэж байгаа ганцхан өнцөг нь юу вэ гэхээр 14 дүгээр зүйл дээр байгаа хэвлэл мэдээллийн салбарт өөрийн зохицуулалт ... хийж буй байгууллага ажиллана гээд. Энэ байгууллага нь бүх редакцтай хэвлэл мэдээллүүд орох ёстой юм уу, орох ёсгүй юм уу бүү мэд. Тэгээд иргэд энд гомдол гаргаж болно л гээд байгаа юм. Гарсан гомдлыг нь нөгөө редакцууд нь би танай байгууллагын гишүүн биш учраас дагаж мөрдөхгүй л гэнэ. Ийм байдлаар иргэдэд ийм ойлгомжгүй, тэгээд сэтгүүлчийн ёс зүйн асуудлыг шийдэж байгаа мэтээр ингэж өнгөц оруулж ирж байгаа ерөөсөө буруу.

Тэгэхээр магадгүй энэ зүйлүүд байх юм бол одоо хэлэх гэж байгаа гол санаа маань ийм байгаа Хэвлэл мэдээллийн салбарт эзэд буюу хөрөнгө оруулагч нар байж байгаа. Дээрээс нь сэтгүүлч нар ажиллаж байгаа. 3 дахь буюу энэ хамгийн том оролцогч нь өөрсдөө олон нийт байхгүй юу. Олон нийт мэдэх эрхээ хангуулах, мэдэж авахын тулд эсвэл тодорхой итгэл үнэмшил сууж энэ мэдээлэл

олж авах эрхийг нь бас хангаж өгч байгаа энэ хэрэгсэл нь хэвлэл мэдээллийн байгууллага. Гэтэл олон нийтийгээ хаянгуутаа зөвхөн ийм өөрийн удирдлагын байгууллага байгуулахын төлөө, нөгөөдөх нь ямар чиг үүрэгтэй юм бүү мэд. Ерөнхий ингээд тавиад өгчихвөл болно энэ тэр гээд. Энэ лоббиг нь мэднэ л дээ сайд аа. Ингэж лоббид нь ороод ингээд явж болохгүй. Энэ гаднын санхүүжилттэй л ийм төсөл хэрэгжиж байдаг юм. Тэгэхээр хэдүүлээ энийг уг нь ингээд би бас тантай яг нийгүй л санал солилцож байсан. Уг нь ингээд 2 салгаж орж ирээд зөв л явчих ёстой байсан. Тэгээд энэ зүйлийг би бас таны байр суурийг сонсчихмоор байгаа юм.

Хоёрдугаарт энэ сэтгүүлчийн ёс зүйн асуудлуудыг Арбитраас шийдмээр байна. Өөрөөр хэлэх юм бол гүтгүүлчихсэн гээд байгаа хүн өөрийнхөө нэг арбитрчийг сонгоод, сэтгүүлч өөрөө арбитрчаа сонгоод, нөгөө 2 сонгогдсон арбитр маань гуравдагч арбитраа сонгоод явдаг энэ сэтгүүлийн, сэтгүүлчийн ёс зүйн асуудалтай, зөрчилтэй холбоотой маргааныг хэвлэл мэдээллийн арбитрууд шийддэг дэлхий нийтийн жишиг сүүлийн үед түгсэн байхгүй юу. Европын орнууд ингэж шийдэж байгаа. Солонгос улс ингэж шийдэж байгаа. Энэ жишиг рүү ингээд явчихъя гээд байхад л бас ингээд орж ирээгүй. Тэгээд энэ шийдэгдэхгүй болох л нөгөө сэтгүүлч нарыг чинь цагдаад өгдөг, шүүхэд дууддаг юм чинь тасрахгүй байхгүй юу. Бид хэд уг нь энэнээсээ л ангижиръя гэсэн шүү дээ.

Дээрээс нь хамгийн сүүлд сая Мөнхбаясгалан гишүүн хэлж л байна. Эх сурвалжаа нууцлах чухал боловч энэ дээр бас зэрэмдэглээд хаячхаж. Эх сурвалжийг нууцлах энэ асуудал зөвхөн Эрүүгийн хуультай, эрүүгийн процесстой холбогддог эд биш байхгүй юу. Захиргааны процесстой холбогдоно, иргэний процесстой холбогдоно, Арбитр, Зөрчил шалган шийдвэрлэх хуультай холбогдоно. Ингээд Төрийн болон албаны нууцын хуультай холбогддог эд. Ингээд ерөөсөө юмыг ингээд шийдээгүй. Зүгээр л ингээд ийм гоё ганган гарчиг зүйлүүд тавиад ингээд ороод ирчихсэнд жоохон харамсаад байгаа юм. Уг нь чухал юм яваад байдаг. Шийдлээ хэлээд байгаа байхгүй юу 2 салгаж оруулж ирэх байсан. Пүүжээ даргаа би асуултаа асуучихъя. Та битгий хөндлөнгөөс ороод бай.

Тэгэхээр ийм зүйлүүд байх юм. Тэгээд Алтангэрэл сайд саяын хэлж байгаа 3 асуудал дээр байр сууриа хэлээч. Уг нь ингээд дэмжихмээр байдаг. Ингээд юмыг ингээд хольж хутгахаар бас болж байна уу, үгүй юү гэдэг дээр бас таны.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Оюунсайханы Алтангэрэл сайд хариулт өгье.

О.Алтангэрэл: Сайнзориг гишүүн бас яг энэ хуулийн төслийг ярьж байхад өөрсдөө тулгарч байсан бэрхшээл юмыг ярьж байсан. Үндсэндээ энэ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд 4 удаа Их Хурлаар орж ирээд буцсан байдаг юм. Энэ болгоны шалтгааныг нь яагаад ингээд буцаад байдаг юм, яагаад болдоггүй юм гээд судлахаар манай хэвлэл мэдээллийн байгууллага сэтгүүлчид энэ хууль дээр ингээд өөр өөр байр суурь баримтлаад энэ үүднээс нь болоод л улс төрчид ингээд буцаагаад байсан юм байна лээ. Тэгээд бүх буцаасан шалтгаануудыг хараад тэгвэл яах ёстой юм гээд өнгөрсөн хугацаанд гол барьсан юм өнгөрсөн хугацаанд шийдвэрлээгүйн улмаас ,хуульчлаагүйн улмаас ямар эрх ашгууд их хохирсон юм бэ гэдэг талаас нь л харсан юм. Тэгэхээр яг Сайнзориг гишүүний хэлж байгаа шиг бид нар байгууллагын тусдаа явъя, хэвлэн нийтлэх эрх

чөлөөтэй холбоотой зүйл нь тусдаа явъя гэж бид нар бас ингэж бас оролдлого хийж байсан.

Тэгэнгүүт юу болсон бэ гэхлээр байгууллага байна гэхээр нөгөө байгууллага чинь юуг хэлэх юм, өөрийн зохицуулалтын байгууллага гэж юуг хэлэх юм, та нар Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийг хуульчлах гэж байгаа юм уу, өөр хүмүүс байгууллага байгуулбал яах юм, наадуул чинь ийм тийм гээд л ийм субьектив зүйлүүд асар ихтэй. Тэгээд ингээд зохицуулаад ингээд дунд нь ингээд хэлэлцүүлэг хийх энэ тэр гэхээр яг энэ зүйл дээр л маш их аллергитай юм байна лээ. Тэгэхээр байгууллагатай холбоотой зүйл нь ингэж байгаа бол бид нар энэ удаад өөрийн зохицуулалтын байгууллага байна гэдэг эрх зүйн үндсийг тогтоож өгөөд орхиё. Гагцхүү өнгөрсөн хугацаанд хэвлэл мэдээллийн салбартай холбоотой гарсан хүндрэл, бэрхшээлүүдийг л бид нар хамгийн ноцтой зүйлүүдийг ямар ч байсан энэ удаагийнхаа хуулийн төслөөр бид нар шийдье гэсэн орлогын үр дүн ийм болчихоод байгаа юм.

Арбитрыг би бүрэн дэмжиж байгаа юм. Манайхан арбитр гэхээр яг зүгээр хоорондын маргааныг тасалдаг Худалдаа аж үйлдвэрийн танхим дэргэд байдаг юм уу олон улсад байдаг байгууллагыг гэж ойлгоод байдаг. Энэ бол Эй Ди Ар буюу маргааныг алтернатив байдлаар шийдвэрлэх энэ бүтцийн нэг хэсэг мөн. Гаднын улсуудад таны хэлж байгаа туршлага байна. Газрын арбитр гэж хүртэл байна шүү дээ. Зөвхөн газрын маргааныг шийддэг газрын арбитр гээд сууж байдаг. Өөрсдөө төрөөс ямар хамааралгүй байгууллага байгаа. Яваандаа энэ зохицуулалтын байгууллага энэ чиг рүү явахаар юм билээ.

Тэгэхдээ өнөөдрийн нөхцөл байдал, түрүү түрүүчийн удаа тэгж буцсан байдал, энэ салбарынхны хоорондын үл ойлголцол энэ бүх зүйлийг хараад нэн тэргүүнд яг энэ алдаа гараад байгаа зүйлүүдийг л бид нар зохицуулчихъя гэж ингэж оруулж ирсэн юм.

Эх сурвалжаа нууцлах дээр хамгийн их өнөөдөр түгээмэл байгаа энэ судалгаан дээр гарч ирээд байгаа зүйл бол ерөөсөө ингээд цагдаа дээр ордог, байцаагддаг энэ үед бид нар заавал ч үгүй хэнээс, хаанаас мэдээ, материал авсан юм, энийгээ хэл гэж тулгадаг, шаарддаг, энэ хэцүү байна гэсэн зовлонг л манай сэтгүүлчид их ярьсан учраас нэн тэргүүнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд энийгээ оруулчихъя гэж ирээд л оруулж байгаа юм. Таны хэлдэг үнэн. Энэ ганцхан эрүүгийн процессын асуудал биш. Тэгэхдээ өнөөдрийн тулчхаад байгаа, өнөөдрийн хамгийн ихээр шаардлага гаргаж байгаа зовлон нь яг энэ эрүүгийн хэрэг дээр байцаагдаж байгаа энэ үе дээр бид нар эх сурвалжаа хэлэх асуудал хүндрээд байна гэсэн энэ зүйл дээр нь бид нар ингэж оруулж ирж байгаа юм. Тэгээд зохицуулах шаардлагатай дутуу зүйл байхыг үгүйсгэх.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн тодруулж асууя.

П.Сайнзориг: Арбитр энэ тэр дээр хэлэлцээд явъя гэж бодож байгаа юм байна. Тэгэхээр хамгийн гол нь энэ байхгүй юу Аагий дарга гомдол гаргаж байгаа иргэн нь хэвлэл мэдээллийн байгууллага нь миний эрх ашгийг хөндчихлөө гээд байхаар ямар процессоор явах нь тодорхойгүй, ямар шийдвэр гаргах нь тодорхойгүй, тэр шийдвэр нь байндинг буюу мөрдөгдөх юм уу, үгүй юу гэдэг нь тодорхойгүй ийм юман дээр иргэдийг та нар гомдол гаргаач гээд цагийг нь

алдуулж, бас ингэж мөнгө төгрөгөөр нь үрж болохгүй байхгүй юу. Энэ үнэхээр шүүхийн өмнөх шат юм бол энийг бас тодорхой болгох ёстой байдаг юм. Бид хэд ингээд иргэдийг мартаад зөвхөн энэ талаа хараад явчихаар бас энэ чинь өөрөө сэтгүүлчдийгээ хамгаалах биш улам сэтгүүл зүйн салбараа нэр хүндийг нь унагаана. Тийм учраас энийг гүйцэт хийвэл гүйцэт хийх ёстой.

Өөрөөр хэлэх юм бол шүүх рүү очихгүй, цагдаад дуудагдахгүй байхын тулд энэ асуудлаа дотроо шийддэг, энэ мэргэжлийн арбитраар нь шийдүүлдэг, мэргэжлийн институтээр нь шийдүүлдэг байх руу л орох ёстой. Энэ хүлээн зөвшөөрөгддөг байх ёстой байхгүй юу. Энэ чинь болохоор ямар ч хүлээн зөвшөөрөгдөх байдал харагдахгүй байхгүй байна шүү дээ. Тэгэхээр уг нь энэ хуулиа та бараг татаж аваад 2 салгаж орж ирээд орвол уг нь бас л зүгээр л байгаа юм. Тэгээд гишүүд маань шийднэ биз дээ.

Д.Амарбаясгалан: Санал хэллээ. Жадамбаагийн Баясгалан гишүүн алга байна. Цэндийн Сандаг-Очир гишүүн алга байна. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэболд: Баярлалаа. Ер нь бид нар ингээд яг энэ чуулганы хуралдааныг харж байхад, энэ асуудалд хандаж байгаа хандлагыг харж байхад маш олон өөр өөр төрлийн ойлголтуудыг нэг сагс руу хийх гэж хичээгээд байгаа юм шиг санагдаж байгаа.

Нэгдүгээрт бол энэ хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй холбоотой энэ асуудал яг одоогоор дэлхий дахинд ч гэсэн том сорилт болчихсон байгаа зүйл. Энэ том сорилт болчихсон гээд байгаа шалтгаан нь болох юм бол өнөөдөр жишээлбэл Герман улс, Их Британийн Умар Ирландын Нэгдсэн Вант Улс болон бид нарын ойлгодгоор өндөр хөгжилтэй орнуудад хүртэл энэ асуудал бас хүндэрчихсэн байгаа.

Тэгэхээр ер нь бол бид нар энэ абусмет дефимэйшн буюу энэ гүтгэх, доромжлохтой холбоотой асуудлыг шууд энэ хуультай холбох гэж тайлбарлах гээд байх хэрэггүй байх. Би зүгээр гишүүдийн зарим байр суурь дээрээс жоохон гайхаж байгаа. Яагаад гэхлээр энэ бол тусдаа хуулиар зохицуулагдаад явчихдаг асуудал байгаа.

Дээрээс нь болох юм бол тэр нийгмийн сүлжээ буюу тэр сошиал медиатай холбоотой асуудлыг шууд ийшийгээ холбох гэж байгаа бол яаж холбох вэ гэдгээ бас их тодорхой хэлмээр байна. Сая жишээлбэл сайд юу гэж хариулж байна гэхлээрээ нэг Их Хурлын гишүүний фэйсбүүк дээр явж байгаа лайв/live/ ч юм уу, контент нь редакц байхгүй учраас биш гэж хариулж байгаа. Гэтэл тэнд чинь туслах, зөвлөх гээд бүүр медиа баг хөлслөөд төлбөртэй ажиллаж байгаа, санаа зорилго нь ойлгомжтой, сонгогчдод мэдээллээ хүргэх гэсэн ингээд юм явж байгаа юм. Тэгэхээр бид нар энийг ингээд их тийм эмх цэгцтэй авч үзэх л хэрэгтэй юм шиг болчихоод байгаа юм. Зарим гишүүд болохлоороо энэ цензур нь хаана байх юм эд нар гэсэн асуудал яригдаад байгаа. Тэгэхээр энэ чинь Үндсэн хуулийн хүний жам ёсны эрхийн араас залгаж байгаа үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхийг бид нар аль болохоор ил тод, нээлттэй, шилэн тунгалаг л байдал руу оруулахгүй бол шууд бүхнийг ингээд механикаар зохицуулах гэхээр эргээд маш олон тодорхойлолтууд шаардаад байгаа. Хуулийн төслийг бол дэмжиж

байгаа нэг шалтгаан нь бол тэр эх сурвалжаа хамгаалах ч гэдэг юм уу, энэ сэтгүүлч хоригдол болоод байгаа, сэтгүүлч эрх нь зөрчигдөөд байгаа, улс төрчдийн хоорондын толхилцооны үзүүр дээр нь сэтгүүлч аваачаад төмөр хаалганы цаана суучихдаг зүйлийг л багасгах, бууруулах, энэ төрлийн асуудлуудыг байхгүй болгох гэсэн зорилготой юм байна гэж ойлгоод байгаа. Тэгээд гишүүдтэй ярьж байхад бол хэрвээ дэмжлээ гэж бодоход үзэл баримтлалыг нь дахиад ярьж болох уу, дахиад энийг базаж оруулж ирж болох уу эд нар гээд байгаа.

Тэгэхээр ер нь бол энэ дээр бид нар аягүй нухацтай хандах ёстой болчхоод байгаа. Тодорхой асуултууд байгаа. Яах вэ бид нар ингээд инфлюэнсер гэж ярьж байгаа, сошиал медиа гэж ярьж байгаа. Сая Боловсролын яамнаас оруулж ирсэн хууль дээр ч гэсэн энэ асуудлыг яриад зарим нэгэн гишүүнд чинь Фэйсбүүкийг тодорхой хугацаагаар хөдөө аж ахуй эд нар гэж яриад байгаа шүү дээ. Тэгэхлээр одоо ингээд нийгэмд шийдвэр гаргаж байгаа маш олон зүйлүүд, хиймэл оюун ухаан, биг дата буюу их тоон мэдээлэл тэгээд ийм өөрөө энэ уламжлалт медиа буюу хэвлэл мэдээлэл чинь өөрөө маш нөхцөл байдал өөрчлөгдчихсөн, шинэ тутам түвшинд хүмүүст мэдэх эрхийг нь янз бүрийн байдлаар хангаад байгаа учраас тэгээд энэ дээр бол маш их цэгцтэй хандах ёстой юм байна л гэж бодож байгаа юм. 2 асуулт байгаа.

Энэ хэвлэл мэдээллийн эрх чөлөө гэхлээр бас яг энэ ажлын хэсэг ахалж байгаа Лодойсамбуу гишүүнтэй түрүүн ярьж байсан энэ медиа буюу яг энэ хэвлэлийн байгууллага руугаа, институц рүүгээ чиглээд байна. Энийг тэр хэвлэн нийтлэх буюу яг үндсэн нөгөө Үндсэн хуулийн үзэл санаа болсон фрийдом оф спийч/freedom of speech/ гэдэг юм уу яг ийм өргөн хүрээтэй нэршээд тэгээд үзэл баримтлалыг нь дахиж маш сайн ярилцаад явах боломжтой юу? Нэг.

Хоёрдугаарт сая бас зарим сэтгүүлчид энэ үүдэнд уулзаад бас сэтгүүлчдийн холбооны ерөнхийлөгч харамсалтайгаар нас барсан байгаа. Тэгээд ядаж 49 хоногийг нь дуусгаад буцааж энийгээ татаж аваад дахиж бас энэ сэтгүүлчидтэй энэ асуудлыг ярилцаад базаад оруулж болох уу гээд.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Оюунсайханы Алтангэрэл сайд хариулт өгье.

О.Алтангэрэл: Эрдэнэболд гишүүний ярьж байгаа яг үндэстэй юм байгаа юм. Ер нь яг ингээд энэ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг яриад ирэхээр л их олон олон ойлголтуудыг хүмүүсийн, хүн болгоны үзэл бодол өөр, олон олон ойлголтуудыг энэ дотор байх ёстой гэж үздэг хандлага байдаг юм байна лээ. Тэгээд яг энэ хуулийн төсөлтэй ноцолдоод, хэлэлцүүлгийг нь хийгээд, уншиж судлаад ирэхээр энэ бас их өөр ойлголт харагдаж байгаа. Тухайлах юм бол иргэдийн мэдэх эрхтэй холбоотой асуудал байна. Төрийн байгууллага, албан тушаалтанд иргэдээс гомдол, мэдээлэл гаргах, журмын өргөдөл, гомдол гаргах журмын тухай хууль гэж хууль байгаа. Сэтгүүлчид өөрөө мэдээлэл нь олдохдоо хэцүү байна гэдэг асуудал байгаа.

Дээрээс нь Мэдээллийн ил тод байдлын тухай хууль гэж байгаа. Энэ дээр ямар мэдээлэл ил тод байх юм гэдэг байгаа. Ямар мэдээлэл албаны нууцад хамаарагдах юм гээд Төрийн болон албаны нууцын тухай хууль байгаа. Иргэдийн мэдэх эрхийг хангана гэдэг бол ганцхан энэ Хэвлэлийн эрх чөлөөний хуулиар биш

маш олон хуулийн нэгдэл дээр, үндэстэйгээр, нэлээн судалгаатайгаар хийх томоохон хэмжээний ажил юм билээ. Энэ хуулийн хүрээнд олон зүйл зохицуулж чадахгүй байгаа. Хуучин хууль маань 4 байсан, 4 заалттай байсан. Одоо энэ хууль 16 л байгаа. 18 байсныг 16 болгосон ийм л учиртай.

Тэгэхээр энэ хэвлэл мэдээлэл, хэвлэлийн байгууллагууд руу чиглэж байна гэдэг үнэн. Энэ хууль ерөөсөө хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа явуулж байгаа, энэ хэвлэлийн үйл ажиллагаа явуулж байгаа сэтгүүл зүйн байгууллага, сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулж байгаа хүмүүстэй холбогдох харилцааг гол төлөв зонхилон зохицуулж байгаа нь үнэн.

Иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй холбоотой асуудал дээр дахиад өөр төрлийн хууль юм уу, өөр төрлийн эрх зүйн зохицуулалтыг гаргаж бас болно. Өөрөөр хэлбэл, яг Эрдэнэболд гишүүн таны эхний тавьсан асуудал шиг олон олон асуудлуудыг л энэ хууль дор хийе гэсэн эрмэлзэл нь ингэж олон удаа батлагдахгүйд хүрдэг. Энэний цаана хамгаалагдах ёстой харилцаа хамгаалагддаггүй ийм зүйлд хүрч байгаа.

Би энэ Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн Ерөнхийлөгч асан Монголын нэрт сэтгүүлч Отгонбаатар асныг хүндэтгэн дурсаж байна. Манай энэ хэлэлцүүлэг дээр бүгд дээр нь ирж суусан, энэ хуулиа батлуулъя гэж ярьж байсан. Хамгийн сүүлд Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн шинэ жилээр манай яамнаас очиход хэдүүлээ хуулиа батлуулна гэж яриад, дараа нь хуулийн төслийг 1 сард өргөн барихад Төрийн ордонд энэ хуулийн төслийг бид нар дэмжиж байгаа, одоо энэ хуулийг батлах ёстой гэсэн байр суурь нь тодхон байгаа энэ гэгээн дурсгалыг нь хүндэтгэж байна. Харин ч тийм ч учраас бид энэ хүний дэмжиж байсан үйлсийг үргэлжлүүлж энэ хүний Монголын сэтгүүлд үлдээсэн мөр, зүтгэсэн зүтгэлийг нь алдаршуулж бид энэ хуулийнхаа төслийг харин ч цаашаагаа бид батлуулахаар эрмэлзэж явж байгаа гэдгээ хэлье.

Д.Амарбаясгалан: Далайн Батбаяр гишүүн алга байна. Тодруулах юм уу? Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн тодруулж асууя.

С.Эрдэнэболд: Сайд аа ийм юм байгаа юм жишээлбэл баруунд ч юм уу, АНУ-д бол жишээлбэл републикан буюу бүгд найрамдахчуудыг дэмждэг хэвлэл ч юм уу, эс үгүй бол ардчиллынхныг дэмждэг хэвлэл гээд ингээд тодорхой байдаг л даа. Хандив ч өгдөг, сонгуулиар ч дэмждэг. Том зах зээл буюу том хүн амтай орнуудын хувьд бол энэ бол их тийм том доргио үүсгэдэггүй байх. Тэгэнгүүт Монгол шиг ингээд цөөн хүн амтай орнуудад маш олон хэвлэл мэдээллийн байгууллага, дээрээс нь инфлюэнсер гээд нөлөөлөгч нар сонгуулийн үеэр маш их улс төрждөг.

Тэгээд яаж байна гэхлээрээ өнөөдөр ингээд би гишүүн болоод 7, 8, 9 сар болж байхад, ингээд харж байхад ордонд явж байгаа хэвлэл мэдээллийн байгууллагаас бараг 30 шахам хэвлэл мэдээллийн байгууллага гэрээ хийе гэж орж ирж байгаа. Гишүүдтэй ч гэсэн гэрээ хийнэ гээд орж ирдэг. Тэгээд энэ 4 сая 900 мянган төгрөг буюу 5 саяас доошоогоо зардлаар гэрээ хийе гээд л орж ирдэг. Бүх гишүүд дээр л орж ирдэг байх. Ингээд хараад байхад байхад бол ингээд гэрээ байгуулах байгуулах юм бол тухайн тэр ярилцлага янз бүрийн юм нь явуулдаг бололтой юм. Энэ юу гэж байна гэхлээрээ нөгөө улс төр ба энэ хэвлэл

мэдээллийн хамаарал их хүчтэй байгаад байгаа. Тэгэхээр энэ зохицуулалт дээр тодрох.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууя. Бүртгүүлсэн юм уу Ганбаатар гишүүн?

Г.Ганбаатар: Энэ Хэвлэлийн мэдээллийн эрх чөлөөний тухай хууль гээд эрх чөлөөтэй байхад ер нь хууль хэрэгтэй юм уу, үгүй юм уу нэрээсээ тээ? Яах вэ зохицуулах гээд Алтангэрэл сайд. Микрофон орж гараад байна шүү. Яах вэ тэгээд энэ төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно гээд. Уг нь энэ 98 оны хууль ч ингэж явсан юм билээ. Тэгээд энэ хууль ч өнөөдөр үндсэндээ юу нь ч хэрэгжсэнгүй л дээ. Алтангэрэл сайдын ярьж байгаа ч гарч л байна. Бараг бүх төрийн байгууллага, дээрээс нь төрийн өмчит болон орон нутгийн өмчийн компаниуд хажуудаа тийм мэдээллийн хэрэгсэлтэй рийлс хийдэг. Ер нь бараг л бааж шээхээсээ бусдадаа л хэвлэл, сэтгүүлч дагуулаад явж байна шүү дээ. Тэгээд энэ 98 оны хууль үндсэндээ хэрэгжсэнгүй.

Дээрээс нь өнгөрсөн хугацаанд энэ Засгийн газар ч гэсэн, ер нь манай энэ улс төрчид ерөөсөө битүүдээ л тийм рийлс хийдэг, контент хийдэг л их гоё шоудсан улсууд. Гарч байгаа үр дүн нь өнөөдрийн ард иргэдийн амьдрал ийм л байгаа байхгүй юу. Тэгэхлээр хууль хэрэгжүүлэх талаар энэ 98 оны хууль хэрэгжүүлэх талаар ерөөсөө хууль хяналтын байгууллагууд үнэхээрийн ажилласангүй. Үүнтэй санал нэг байгаа байх гэж бодож байна.

Хоёр дахь зүйл нь хэвлэл мэдээлэл дээр энэ хэвлэлийн салбарт ажиллаж байгаа улсуудын ёс зүй, хэм хэмжээ, мэдлэг боловсрол, ур чадвар үүнтэй холбоотой асуудал байдаг. Монголын хэвлэл мэдээллийн зөвлөлөөс 1 асуулт байна. Хэвлэл мэдээллийн энэ ёс зүйн зарчим, сэтгүүлчдийн мэргэжлийн хэм хэмжээг сахиулах үүрэг нь танай үүрэг. 10 жилийн өмнө би олны их танил л даа “Э” гээд сэтгүүлч байгаа юм. Нэрийг нь эхнийх нь үсгийг хэлэхгүй болохлоор манай Мөнхбаясгалан гишүүнийг гээд зарим хүмүүс бодоод байдаг юм шиг байна лээ. “Э” гээд сэтгүүлч нөхөрт их айхтар гүтгүүлж байсан юм. Тэгээд Хэвлэл мэдээллийн зөвлөл арга хэмжээ аваад тэр нөхөр сүүлдээ бүүр над руу Монгол Улсын Ерөнхий сайд байсан хүнээр гуйлгаж байгаад юм мултарч байсан байхгүй юу. Өнгөрсөн хугацаанд хэчнээн сэтгүүлч яг энэ ёс зүй, хэм хэмжээ, сахилгатай холбоотой хариуцлага үүрсэн бэ? Надад тоо хэлж өгнө үү?

Гурав дахь асуудал нь 21 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Засгийн газрын 400 дугаар тогтоолоор яагаад ч 12 сарын 31-ний өдөр Засгийн газар хуралдаад энэ МОНЦАМЭ агентлагийг Ерөнхийлөгчийн Тамгын газарт шилжүүлж байсныг би мэддэггүй юм. МОНЦАМЭ агентлаг хэвлэл мэдээллийн хэрэгсэл мөн үү? Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар төрийн байгууллага мөн үү? Үүн дээр хүн нь хариулт өгнө үү? Үүнийх нь дараа би тодруулга. Энэ хууль дээр бас ийм заалт байгаа байхгүй юу. Одоо оруулж ирж байгаа төсөл дээр чинь үүнтэй холбоотойгоор бас дараа нь асуух зүйл байна.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон хариулт өгье.

Г.Гүнжидмаа: Гишүүний асуултад хариулъя Гүнжидмаа.

Хэвлэл мэдээллийн зөвлөлд одоогийн байдлаар 600 орчим гомдол хүлээж авсан иргэдээс. Иргэд хэвлэл мэдээллийн агуулгад алдаа байна гэж үзвэл гомдлоо гаргадаг энэ механизм. Өнөөдрийн энэ 600 орчим гомдлоос бид нар яг хэрэг үүсгэж 400 орчмыг нь Ёс зүйн хороогоор хэлэлцсэн. 70 орчим хувь дээр нь ёс зүйн алдаа гарчээ гэж байсан дүгнэлт гарсан байгаа.

Тэгэхээр нэг талаар гүтгэлэг, гүтгэлгийг ёс зүйн хэм хэмжээний хүрээнд шийдвэрлэхэд бэрх юм. Энэ нотлох баримт цуглуулдаг. Хэвлэл мэдээллийн зөвлөлийн үндсэн үйл ажиллагаа биш, энэ бол шүүхийн үйл ажиллагаа явагддаг гүтгэлэг бол.

Мэргэжлийн алдаа гаргаснаас үүдээд нийтлэг мөрддөг ёс зүйн хэм хэмжээгээ зөрчиж үү, үгүй юү гэдгийг сэтгүүл зүйн бүтээлийг нь уншиж, судалж, дүгнэлт гаргадаг энэ мэргэжлийн үйл ажиллагаа байгаа. Тэгэхээр энэ хэн нэгэн биш, яг нөгөө тодорхой бүтээл дээр ажилладаг. Тэгэхээр энэ ойлголт маань бас буруу ,зөрүү явснаас болоод энэ тодорхой сэтгүүлчийн асуудлыг, хувь сэтгүүлчийн ёс зүйн асуудлыг бас оруулж ирдэг. Өөр бусад ёс зүйн асуудлуудтай холилдох гэж үздэг. Тэгэхээр хэвлэл мэдээллийн салбар бол мэргэжлийн сэтгүүлчдийн байгууллага нь хувь сэтгүүлчийн хувийн ёс зүйн асуудал дээр анхаардаг бол Хэвлэл мэдээллийн зөвлөл нь цагаан дээр хараар бичсэн сэтгүүл зүйн бүтээл нь ёс зүйн хэм хэмжээ, дүрмийнхээ хүрээнд байж уу, үгүй юү гэдэг дээр ёс зүйн дүгнэлт гаргадаг ийм байгаа. Тэгэхээр харьцангуй олон янзын сургалт нөлөөллийн ажил хийх шаардлага гардаг. Маш олон удаагийн редакцуудын уулзалтаар хэвлэл мэдээллийн ёс зүйн дүрмийг 10 жилийн өмнө салбараараа нэгдэж, нийлж боловсруулж баталсан энэ дүрмийг түгээн сурталчлах, таниулах ажил үргэлжилдэг.

Тэгэхээр энэ ёс зүйн зохицуулалтын өөрийн зохицуулалтын асуудалд хуулиар оролцдоггүй энэ мэргэжлийнхний талбар гэж үлдээдэг. Яг энэ үндэслэлээр энэ хууль дээр бичигдсэн байгаа. Энэ бол нийтлэг жишиг, олон улсын сайн жишиг. Монгол хэвлэл мэдээллийн зөвлөл нийтлэг хэм хэмжээ, нийтлэг сайн жишгийг тулгуурлаж бид нар энэ үйл ажиллагаагаа мэргэжлийн түвшинд явахын төлөө хичээж ажиллаж байгаа. Тэгэхээр энэ дээр ёс зүйн дүгнэлтийг гаргаад хэрхэн яаж энийгээ засаж залруулах вэ гэдэг нь бас хуулийн хариуцлага биш нөгөө зөөлөн зохицуулалтын хэм хэмжээгээрээ буюу алдаанаасаа алдаагаа засдаг байх, залруулдаг байх, алдаагаа олон дахин давтах нь мэргэжлийн хувьд нэр хүнд нь унах тэгээд энэ зүйлүүдээс сэргийлж олон нийтэд мэдээллийг, дүгнэлтийг нээлттэй гаргадаг. Тэгэхээр энэ байдлыг алдаагаа нэг гаргасан сэтгүүлч буцаад тэр алдаа.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Оюунсайханы Алтангэрэл сайд нэмж хариулья.

О.Алтангэрэл: Энэ Засгийн газар 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр 400 дугаар тогтоолоор Засгийн газрын харьяанаас Ерөнхийлөгчийн Тамгын газрын харьяанд МОНЦАМЭ агентлаг шилжүүлсэн байдаг юм. Тэгэхдээ энэ Монгол Улсын бодлого, шийдвэр албан ёсны мэдээллийг олон улсад нэг цонхоор гаргаж байх гэдэг, энэ сурталчилж байх гэдэг хүрээнд бид нар энэ Монгол Улсын тухай албан ёсны мэдээллийг олон улсад түгээх, сурталчлах зорилго бүхий хэвлэл мэдээллийн ашгийн төлөө бус байгууллагыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх үйл ажиллагаа явуулахыг бид нар зааж өгсөн юм.

Өнөөгийн байдлаар энэ МОНЦАМЭ агентлаг Монголын мэдээ сониныг Хятад хэлээр, Монгол Цүүшин сониныг Япон хэлээр, Монгол мессенжер сонин, Монголиа түдэй/Mongolia today/ сэтгүүл Англи хэлээр, Новости Монголия сонин, Хүмүүн бичиг сонин зэрэг энэ үйл ажиллагааг эрхэлдэг энэ аж ахуйн ийм байгууллага байгаа. Энэ байгууллагыг тусгаж орсон зориулалт нь Ганбаатар гишүүний хэлдэг үнэн л дээ бид нар энэ 1998 оны хуулийн зорилт ерөөсөө биелэхгүй энэ төрийн байгууллага дэргэддээ хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхгүй гэсэн хэр нь далд утгаараа ч явж байсан. Илээрээ явж байсан нь яг энэ МОНЦЕМЭ агентлаг. Хориглочихсон байдаг энэ үйл ажиллагаа явуулаад байдаг.

Гэтэл олон улсад бид чинь дэлхийн жишгээр, дэлхийн жишгээр шүү олон улсад нэг цонхны байдлаар өөрсдийн бодлого, шийдвэрээ гадаадад сурталчилж ашгийн төлөө бус ийм байгууллага байх шаардлагатай байдаг. Тэгээд хууль дээрээ хориглочихсон мөртөө яг нидэр дээр ийм байгууллага олон жил явсныг энийг ингээд хуульчлаад ганцхан МОНЦЕМЭ-д зориулж байгаа энэ ашгийн төлөө бус байгууллага байя, бусад байгууллагууд нь яг энэ хуулийнхаа зохицуулалтын дагуу явъя гэдэг ийм зорилгоор энэхүү удаагийн хуулийн төсөлдөө бид нар тусгаж оруулсан юм.

Д.Амарбаясгалан: Гомбын Ганбаатар гишүүн тодруулж асууя.

Г.Ганбаатар: Тэгвэл энэ хуулийнхаа 6.9 дээр бас арай жоохон өөр томъёолол хийх байх л даа. Дээрээс нь энэ нөгөө төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно гэдэг энэ ерөнхий заалт чинь журмын хуулийнхаа төслийн 6.9-тэй хэр уялдах вэ гэдэг ахиж найруулах юм уу яах юм? Тэгээд ийм юу гарч ирэх байх шүү. Өөр зүйлгүй.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууя.

Ө.Шижир: Сэтгүүлч гэдэг тийм тун хэцүү ёстой нөгөө хэлдгээр амаргүй мэргэжил юм шиг байгаа юм. Тийм учраас хэвлэн нийтлэх эрх чөлөөг сайтар хамгаалж, бас хангаж өгөх ийм зайлшгүй шаардлагатай. Энэ бол редакц юм, энэ бол сэтгүүлч юм, энэ веб сайт юм, энэ пэйж/page/ хуудас юм гэдгийг ямар нэгэн байдлаар төрийн байгууллага ялгаж, ямар нэгэн байдлаар тусгай зөвшөөрөл өгдөг байж боломгүй. Энийг мэргэжлийн холбоо, мэргэжлийн байгууллага нь олгодог байх хэрэгтэй. Нөгөө талаасаа манай маш олон гишүүдийн үгэнд гарч байна. Улсын төсөвт суусан төрийн байгууллага болон яам, тамгын газруудын өөрсдийгөө сурталчлан таниулах ажлыг тухайн бүх төрийн байгууллагын хэвлэлийн алба нэртэй хэлтэс бүтэц зохион байгуулалтад оруулдаг.

Тийм учраас Монголд өнөөдөр хамгийн их явж байгаа мэдээ, мэдээлэл дандаа улс төрийн мэдээлэл байгаа. Яагаад гэвэл энэ өөрөө төсөв мөнгөтэй холбоотой. Мөн бас энэ тухайн бүх төрийн байгууллага түүх бүх ТӨК-уд ба Их Хурлын дэргэдэх харьяа байгууллагууд өөртөө хэвлэлийн алба гээд 3-4 хүнтэй, рийл хийдэг 1 хүнтэй, 1 сэтгүүлчтэй, 1 видео контентертой, тэрийгээ түгээдэг хүнтэй гээд. Ингээд маш том ийм бүтцүүдтэй бий болсон. Тэгээд энэ нь өөрөө ийм төсөвт суусан хөрөнгийг ингээд хуваарилдаг зохион байгуулдаг ийм хэлбэр рүү орчхоод байгаа юм. Тэгэхээр энийг бас болих хэрэгтэй. Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын дарга гурвыг хүлээн зөвшөөрч болж байна.

Яагаад гэвэл гадаад улс оронд улс орноо төлөөлдөг, айлчлал хийдэг гэдэг зарчмаар энийг болж байна. Тэгэхээр ийм зүйлүүдийг бас болих хэрэгтэй. Тэгэхгүй энэ хэвлэлийн албаа дагаад маш үнэтэй зургийн аппарат, маш үнэтэй тоног төхөөрөмж байдаг юм. Мэргэжлийн редакцуудтайгаа ингээд манай төрийн байгууллагууд өөрсдөө өрсөлдөөд эхэлдэг. Өөрсдөө контент хийдэг болчихдог, өрсөлддөг. Өөрсдийнх нь хийсэн контент бэлдсэн мэдээгээ хэвлэн нийтлэх, хэвлэлийн сайтуудаар уг дугуй, “А”, “Б”-гүй ямар ч өөрчлөлтөөр гаргуулах гаргуулах гэж ингээд оролддог. Өөрөө ингээд энэ хэвлэл мэдээллийн байгууллага чинь өөрөө бид нарын яриад байгаа улс төрөөс аймаар ингээд хараат бус, хараат болчихоод байна л даа.

Тэгэхээр хараат болж байгаа асуудлыг нэг талаас нь санхүүгийн хувьд шийдэх асуудлууд үүснэ. Яаж үүсэх бэ гэхээр бүгдээрээ жишээ авъя. Ютүб /youtube/хуудсан дээр өөрийн бичлэгүүдээ оруулаад хандалтынх нь тоогоор, тэр дундуур явсан рекламных нь дундаа тухайн хүмүүс санхүүждэг. Яг үүнтэй адилхан энд Монголын аль нэг веб сайтын хийсэн видео контентыг 1 саяас дээш хүмүүс үзсэн тохиолдлууд манайд маш олон байгаа. Тэр дундуур бид нар байнга реклам үздэг. Тэгэхээр энэ веб сайтуудын манай энэ хэвлэл мэдээллийн байгууллагуудын редцуудын хийсэн контентуудын дундуур явж байгаа реклам орлогоос яг энэ ютүб/youtube/ шиг, фэйсбүүкээс, Х-ээс манай энэ хэвлэл мэдээллийн байгууллагууд орлого бас хуваалцдаг болох эрхтэй. Цахим хөгжлийн яам энэ талаар фэйсбүүктэй, Х-тэй, уулзалт хийх шаардлагатай тэгж байж бас тодорхой хэмжээнд санхүүгийн эх үүсвэр нэмэлт эх үүсвэрийг бид нар бүрдүүлнэ.

Ер нь энэ хуулийн төслийн, өөрөө энэ хуулийн төслийн гол зорилго нь өөрөө эх сурвалжаа нууцлах гэж ойлгосон. Тэгээд тэрний хүрээнд бид нар ярьж байна гэж ойлгож байгаа. Гэтэл энэ хуулийн жишээ нь 11.4-д юу гэхихсэн байгаа вэ гэхээр хэвлэл мэдээллийн байгууллага нь энэ хуулийн 6.5-д заасны дагуу хийгдэж байгаа нийтлэл, нэвтрүүлэг, захиалгат, эсвэл төлбөртэй болохыг тодорхой илэрхийлж тэмдэглэгээ хэрэглэнэ гээд. Энэ одоо угаасаа байнга хэрэглэгдэж байгаа шүү дээ. Төлбөртэй бол төлбөртэй, захиалгатай захиалгатай гээд тавигдчихдаг. Үүнийхээ араас төлбөр төлсөн этгээдийн нэрийг дурдана гэххэж байгаа юм. Тэгэхээр энэ нөгөө эх сурвалжаа нууцлах гэдэг асуудалтайгаа яг зөрчилдсөн заалт болчихоод байгаа юм.

Яагаад гэхээр энэ 6.5 дээр чинь төрийн байгууллагын асуудлыг л дурдчихаад байна шүү дээ тээ? Тэгэхээр ийм юм байгаа юм. Мэдээж энэ эх сурвалжаа нууцлахаас гадна мэдээж илт худал мэдээллийг гэдэг асуудлыг бас Эрүүгийн хуулиар шийтгээд байж болохгүй. Мөн бас энэ Эрүүгийн хуулийн 13.14-өөр бас сэтгүүлчдийг шийтгээд байж болохгүй. Тэгэхгүй бол юу болж байна вэ гэхээр өнөөдөр нэг хүн эх сурвалжаа нууцлаад нэг сэтгүүлч өөр өөрийнхөө редакц дээр веб сайт дээр ч юм уу мэдээ, мэдээлэл байрлууллаа гэхэд цагдаагийн байгууллагаас дууддаг, тэр сэтгүүлчийн зориг, хүслийг мохоодог, мэргэжлээрээ ажиллах хүсэл эрмэлзлийг байхгүй болго.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Шижир гишүүнд 1 минут нэмж өгье.

Ө.Шижир: Эрүүгийн хуулийн 13.14-өөр сэтгүүлчдийг дуудаад цагдаагийн байгууллагын үүдэнд тэр сэтгүүлчийг 2 жил хүртэл суулгасан ийм тохиолдлууд бас

байдаг. Өглөө болгон дууддаг асуудал асууж байгаа нэрээр. Тэгээд залхаан цээрлүүлдэг, урам зориг нь мохоодог, энэ мэргэжлээр ажиллах ямар ч сонирхолгүй болгодог ийм асуудлууд байна. Тэгэхээр энэ бүгдийг бас нэг бүрчлэн бид нар хуульчлах хэрэгтэй.

Ер нь илт үймээн сам үймээн самуунд уруу татсан, үндэсний аюулгүй байдалд ноцтой нөлөөлөхүйц хуурамч мэдээлэл тараасан энэ тэрийг Эрүүгийн хуулиар явах нь зөв. Гэхдээ ийм хуулиар ерөнхий байдлаар сэтгүүлчдийг залхаан цээрлүүлдэг ийм ажлыг бас байж болохгүй. Энэ Цахим хөгжлийн яам Засгийн газраас өргөсөн учраас би саяын асуух гэж байсан юм. Цахим хөгжлийн яам энэ фэйсбүүк, Х зэргүүдтэй уулзаад энэ манай видео контент үйлдвэрлэж байгаа энэ редакцуудын дундуур явж байгаа рекламаас борлуулалтын орлого хуваах боломжийг бүрдүүлж өгвөл бид нар бас нэмэлт санхүүгийн эх үүсвэртэй болно. Санхүүгийн эх үүсвэр нь олон талтай байж л улс төрөөс хараат бус бол.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Оюунсайханы Алтангэрэл сайд хариулт өгье.

О.Алтангэрэл: Төрийн байгууллагаас мөнгө төлж байгаа бол тэр эх сурвалж энэ тэр хамгаалагдахгүй ер нь товчхондоо. Төрөөс мөнгө гараад л тийшээгээ төлбөртэй байж байгаа бол тэр төлбөртэй гэдгээ бичье. Тэгээд хэн ямар байгууллагаас энэ мөнгийг төлөөд гаргаж байгаа вэ гэдгээ ил тод байлгая л гэсэн юм. Яагаад гэвэл төрийн байгууллагаас тэгж явах тохиолдолд сонгон шалгаруулалт зарлана ТӨК-удаас. Татвар төлөгчдийн мөнгө учраас.

Харин сэтгүүл зүйн өөрийнх нь бүтээл, эрэн сурвалжлах сэтгүүл зүй байдаг юм уу, асуудал хөндсөн сэтгүүл зүй ч байдаг юм уу, редакц өөрөө, сэтгүүлч өөрөө хийж байгаа бүтээл дээр эх сурвалж хамгаалагдана. Төрийн байгууллага мөнгө зарахдаа ч ил тод зар, тэр зарсан юмыг нь мөнгөөр үзүүлж байгаа гэдгээ ч ил тод олон нийтэд тайлагна гэдэг зарчмаар явж байгаа юм шүү. Тийм ялгаатай гэдгийг хэлье.

Эрүүгийн хуулийн 13.14 гэдэг зүйл, заалттай холбоотой илт худал мэдээлэл тараахтай холбоотой маш их хэмжээний хэлэлцүүлэг, гомдол яг энэ хуулийн төслийн хэлэлцүүлэг хийж байхад явсан. Яадаг вэ гэхлээр ирээд илт худал мэдээлэл тараах гэдэг ийм ерөнхий зүйлтэй, ирээд асуудаг сэтгүүлчийг дуудаад асууна. Та энэ дээр ингэж мэдээлсэн байна аа, үгүй. наадах чинь ийм жоохон эндүүрэл, ийм жоохон ташаарал гарсан гэдгийг ерөөсөө авч хэлэлцэхгүй. Хамгийн алдартай жишээ 15 удаа гадаад явсан гэж гүтгэсэн чинь 13-хан удаа явсан гэдэг энэ жишээ болчихоод байгаа юм.

Гэтэл энэ чинь сэтгүүл зүйд өөр эндүүрэл байж болдог, ташаарал байж болно. Андуурсан байж болно. Хэн нэгэн хүнийг юу гэдэг юм өөр хүнтэй явсан гэхэд тэр нь тэр тухайн бичигдэж байгаа хүн биш байж болно, андуурч болно. Гэтэл энийг нь тодорхойлоогүйн улмаас Эрүүгийн хуулийн энэ зүйл маань ерөнхий улмаас ямар байдлаар байдлаар бодит байдалтай нийцэхгүй л худал мэдээллийн ангилалд орчихоод байгаа юм. Тэгэхээр энэ хуулийн төслийн агуулга бол энэ Эрүүгийн хуулийн 13.14-тэй яаж уялдаад байгаа вэ гэвэл илт хууль худал мэдээлэл гэж ийм зүйлийг хэлнэ гээд бүүр нарийвчлаад оруулж өгчхөж байгаа юм. Ташаа мэдээлэл гэдэг нь болохоор ингээд бусдын сэтгэл санаа, бие махбод,

хуулийн этгээдийн үйл ажилд хохирол учруулах зорилгогүй. Тэгэхдээ түгээсэн бодит байдалтай нийцэхгүй гэдгийг эсвэл тэр сэтгүүлч мэдээгүй, эсвэл мэдэх боломжгүй алдаатай мэдээлэл, баримт сэлтийг ташаа мэдээлэл гээ. Энийг Эрүүгийн хуулиар ингэж байцаахгүй гэж байгаа юм.

Илт худал мэдээлэл гэдэг нь хүн, хуулийн этгээд, улс оронд санаатайгаар хохирол учруулах зорилгоор түгээсэн ор үндэслэлгүй худал мэдээ, мэдээлэл, баримт сэлтийг хэлье л гэж байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол энэ хуулийн төсөл батлагдах юм бол энэ зүйл, заалтын доор, энэ шүхэр доор энэ эндүүрсэн, ташаарсан сэтгүүлчид таны хэлж байгаа тэр цагдаагийн үүдийг сахидаг, олон хоног өнгөрүүлдэг, ийм байдалд ордог энэ байдлаас нь бид нар аварч хамгаалъя л гэж ийм илт худал мэдээлэл гэдгийг оруулсан юм.

Хэрвээ Эрүүгийн хуульд илт худал мэдээлэл орох гэдэг энэ гэмт хэрэг огт байхгүй гэж хууль тогтоогчид үзвэл тэр тэгээд байхгүй болох байх. Харин эндүүрэл, ташаарлын ингэж.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Өлзийхүүгийн Шижир гишүүн тодруулж асууя.

Ө.Шижир: Тийм. Тэгэхээр бүр эхний асуултдаа бас хариулт авчихъя. Тэр манай төсөвт суучихсан бүх зардлуудыг л төрийн байгууллагууд хэвлэлийн албаар дамжуулаад л хэвлэл мэдээлэлтэй харьцаад байна шүү дээ. Тэгэхээр улс төрийн мэдээлэл хамгийн их гарах нь аргагүй байхгүй юу. Яагаад гэвэл тэр чинь төрийн мөнгөөр явж байгаа, төрийн мөнгөний эзэд дандаа улс төрч байдаг дээр нь. Тэгэхээр энийг бид нар хязгаарлахын тулд санхүүгийн нэмэлт эх үүсвэртэй болох ёстой.

Тэгэхийн тулд манай Цахим хөгжлийн яамнаас фэйсбүүктэй, Х-тэй уулзаад манай контент бүтээгч нарын дундуур, веб сайтуудын хийж байгаа контентын дундуур явж байгаа рекламн орлогоос хуваалцах боломж хэр байгаа юм бэ? Энийг тусгах боломж хэр байгаа юм? Тэгэхгүй ингээд хэт улс төрөөс, санхүү нь өөрөө улс төрөөс хэт хамааралтай байгаа учраас мэдээ, мэдээллийн чинь ихэнх нь улс төрийн мэдээлэл яваад байгаа юм. Энэ санхүүгийн хамаарал байхгүй болж байж та бидний яриад байгаа энэ олон ёс зүйн дүрмүүд өөрөө үйлчилнэ, бидний яриад байгаа энэ бусдаас хамааралгүй байх асуудлууд өөрөө үйлчилнэ. Тэгэхээр энэ дээр яг хуулийн төслөөр яаж сууж байгаа юм бэ гэдгийг би дахиад лавлаж асууя.

Д.Амарбаясгалан: Сархадын Зулпхар гишүүн. Алтангэрэл сайд хариулах уу? Оюунсайханы Алтангэрэл сайд.

О.Алтангэрэл: Яг тэр фэйсбүүктэй холбоотой ч гэдэг юм уу, твиттер, сошиал платформуудтай холбоотойгоор зүйлүүд яаж шийдэгдэхийг нь яг үндсэндээ сайн мэдэхгүй байна. Энэ ийм үйлчлэлийн хүрээнд оролцохгүй байгаа. Тэгэхдээ Шижир гишүүний тавьж байгаа асуудал яг үндэслэлтэй асуудал. Монгол Улс 2023 онд хэвлэлийн эрх чөлөөний индексээр 180 орноос 88-д байсан бол 24 онд 109 болж ухарсан байгаа юм. Энэ дотор улс төрийн индикатор нь хамгийн их 118 гэж. Тэгэхээр энэ хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад ерөөсөө сэтгүүлчдээс хэвлэл мэдээллийн байгууллагаас гарсан олон асуудлуудын нэгдүгээрт саяын тэр 13.14 дараагийнх нь энэ төрийн оролцооны асуудал л удаа дараа л яриад байсан

учраас бид 1 ахиц гаргаад энэ зарцуулж байгаа мөнгө төгрөг нь ядаж сонгон шалгаруулалттай ил тод байя гэдэг энэ ахицыг л гаргаж байгаа юм. Цаашаагаа юу гэдэг юм бусад хуулиуд дээр энэ хуулиар зохицуулах бололцоогүй. Хэмнэлтийн хууль дээр юм уу, бусад Тендерийн хууль дээр юм уу оролцоод боловсронгуй явах зүйл байхыг үгүйсгэхгүй.

Д.Амарбаясгалан: Сархадын Зулпхар гишүүн алга байна. Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн алга байна. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуулт асууя.

Д.Пүрэвдаваа: Оройн мэнд хүргэе. Ийм байна сайдаас асуумааргүй, ажлын хэсгээс л асуумаар санагдаад байна. Эдийн засгийн хувьд энэ манай энэ сэтгүүл зүйн салбар эдийн засгийн хувьд эрх чөлөөтэй байж чадаж байна уу? Та бүхэнд тооцоо, судалгаа байдаг уу? Нийт хэчнээн хэмжээний мөнгө, санхүү эргэлддэг юм, тэдний хэчнээн хэмжээ нь энэ намууд болон улс төрчид санхүүжүүлдэг юм, яг реклам, сурталчилгаа бизнесийнхээ үйл ажиллагаагаар хэчнээн хэмжээний мөнгө төгрөг олдог юм бэ, татвар төлдөг юм бэ гэдэг тийм судалгаа байдаг уу? Тэр тал дээр ажилласан уу гэж асуумаар байна.

Хоёрдугаарт маш олон улсууд асуулт асууж байгаа болохоор давхардаад байна. Энэ түрүүний Сайнзориг гишүүн хэлчихсэн юм. Энэ Эрүүгийн хууль болон процессын хуулиар энэ сэтгүүлч нар хэлмэгдээд байна гэж байр сууриудыг олон хэлээд байгаа юм. Нийт хэчнээн хүн өнгөрсөн хугацаанд яг сэтгүүлчид энэ процессын болон Эрүүгийн хуулийн зүйл, заалтаар хэлмэгдсэн бэ, хэчнээн хүн ял шийтгэл эдэлсэн юм? Тэгээд та бүхний энэ оруулж ирж байгаа хуулийн үр дүнд тийм үү ямар өөрчлөлт гарах юм бэ? Одоо байгаа цэгээ үр дүнгээ хэд болгож багасгах гээд байгаа юм гэдэг яг нарийвчилсан тоон үзүүлэлтийг асуумаар санагдаад байгаа юм.

Миний хувь хүний зүгээсээ энэ Эрүүгийн хууль болон процессын хуульд энэ сэтгүүл зүйн салбарын бүүр иргэн, дээрээс нь сэтгүүлч, бүүр редакц бүхлээр нь Эрүүгийн хууль, процессын хуулиас бүгдээс нь авч хаямаар байгаа юм. Арбитр болон зөрчлийн хуулиар ч юм уу, Иргэний хуулиар ч юм уу шийдвэрлэдэг болохгүй бол хөрш орнуудаа харахаар хамгийн их хүний эрх зөрчигддөг улсууд хамгийн түрүүнд сэтгүүлчдээ барьж авч шоронд хийдэг. Одоо энэ Навальнигийн эсрэг өмөөрч дуугарсан, Путины эсрэг дуугарсан сэтгүүлчид яг энэ хоригдоод сууж байгаа шүү дээ. Дэлхий нийтээрээ л энийг ажиглаж байгаа. Тэгээд урд хөрш болон тэгээд Хойд Солонгос яриад ч хэрэггүй байх. Бид нар чинь сая баахан л ярилаа шүү дээ. Авторитар дэглэм рүү нэлээн дөхөөд оччихсон байна. Үүний нэгэн илрэл нь хэвлэл мэдээлэл ер нь ямар ч тохиолдолд Эрүүгийн зүйл, заалтаар яллагддаггүй байх л хэрэгтэй байгаа юм. Энэ дээр суурь шалтгаан нь юу байсан юм бэ гэдгийг хариулаад өгөөч. Яг энэ мэргэжлийн улсууд нь.

Дараагийнх нь зүйл энэ хэрвээ тооцоо, судалгаа байдаг бол энэ би энэ жижиг намын төлөөлөл байгаа юм энэ парламентад сууж байгаа юм. Энэ байсан, байсан. Тэгээд Ардчилсан нам болон Ардын намын өнгөрсөн хугацаанд сонгуулийн үеэр хэчнээн хэмжээний мөнгө санхүү зарцуулдаг юм бэ яг энэ салбарт? Тэр нь хэдэн хувийг нь эзэлдэг юм зөв үү? Тэгээд энэ аудитаараа яаж нотлогдож энэ хууль дээрээ яаж уялдсан байдаг юм зөв үү? Дээрээс нь энэ Ерөнхийлөгч хажуудаа институттай байх ёстой юм байна. Тэр нь яг зайлшгүй

Ерөнхийлөгчийн хажууд байх ёстой. Энэ нь яагаад нөгөө тендерийн зарчмаараа, зах зээлийн зарчмаараа хэрэгжиж болдоггүй юм бэ гэдэг суурь шалтгаануудыг хэлээд өгөөч. Тэгээд тодруулж асууя.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье Хэвлэл мэдээллийн зөвлөл Гүнжидмаа.

Г.Гүнжидмаа: Гишүүний асуултад хариулъя Гүнжидмаа. Хэвлэл мэдээллийн зах зээлийн байдлын талаар бас ерөнхий судалгаанууд хийгддэг. Хэвлэл мэдээллийн ерөнхий судалгаанууд. Гэхдээ таны хүсэж байгаа тоон мэдээлэл өнөөдөр энэ ил тод биш байна. Яг энэ тал руу нарийвчилсан судалгаа хийсэн статистик тоон мэдээлэл бас байхгүй байгаад байна. Энэ нь юуг илэрхийлж байна вэ гэхлээр энэ чиглэлийн судалгаануудыг бас илүү өргөжүүлэх, энэ талын мэдээллүүд илүү ил тод байх.

Тийм учраас тодорхой хэмжээнд нөгөө мэдээллийн ил тод байдлыг дэмжсэн тодорхой заалтууд ач холбогдолтой байгаа нь харагдаж байгаа. 10-аад жилийн өмнө ерөнхийдөө телевизүүд дээр хийхэд бас баримжаагаар 20 сая доллар ч юм уу телевиз дээр бол бас ингээд хэмжиж болох жишээтэй. Тэгтэл цахим сайтууд болоод хэвлэл мэдээлэл дээр энэ боломж нь бас одоогоор хангалтгүй байгаад байгаа учраас тоон мэдээллийг өгөх боломжгүй байна. Гэхдээ ерөнхий түүврээр хийсэн судалгаагаар Монгол Улсын хэвлэл мэдээллийн байгууллагуудын дийлэнх орлогыг зар сурталчилгаа бүрдүүлдэг байсан, бизнесийн байгууллагуудаас бүрдүүлдэг байсан бол сүүлийн 5 жил, 6 жилд төрийн байгууллагуудын бас өгч байгаа мэдээлэл сурталчилгааны орлого бол нэлээдгүй хувиар нэмэгдсэн байна гэдэг ийм тандалтын судалгааны дүнгүүд байдаг.

Тэгэхээр энэ тал дээр эдийн засгийн хувьд хэвлэл мэдээлэл сул байгаад бас анхаарал хандуулах хэрхэн яаж дэмжих вэ гэдэг бодлого бас чухал гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Хоёрт, Эрүүгийн хуулиар шийтгэгдсэн сэтгүүлчдийн тоог тодорхой хэмжээнд бас давтамжтайгаар зарим байгууллагууд хийдэг. Манай байгууллагын хувьд 4 жилийн өмнө сонгуулийн үеийг хамруулаад Эрүүгийн хуулиар маргаанд орсон 206 хэрэг байсан. Түүний яг судлаад үзэхэд 18 орчим нь сэтгүүлчидтэй холбогдсон, 80 гаруй хувь нь бол дан иргэн хоорондын маргаан байсан. Ингээд 10 орчим хувь дээр шийтгэгдсэн хувь нь цөөхөн байсан. Сүүлийн жилүүдэд энэ тоонууд нэмэгдэж байгаа. Энэний цаана юу яваад байна гэвэл Эрүүгийн хуулийг, Иргэний хуулийг ашиглаж цензур тогтоох айлгах, энэ нийтлэлээ татах, эсвэл хэвлэн нийтлүүлэхгүй байх талаар шүүхийн хуулийн энэ заалтуудыг ашигладаг. Энэ өөрийн цензур болоод байгаа учраас бид нар сэтгүүл зүйн үйл ажиллагаатай холбоотой алдаа мэдгийг ёс зүйн хүрээнд нь зөөлөн зохицуулалтын хэм хэмжээгээр шийддэг энэ нийтлэг жишгээ л бэхжүүлэхийн төлөө явж байгаа. Энэ нь буцаад төр сэтгүүл зүйн агуулгын хяналтад оролцохгүй. Нэг.

Хоёрдугаарт нь цензурээс хамгаалж байгаа зүйл байгаа юм. Ийм ач холбогдолтой учраас энэ хуулийн тодорхой бүлэг дээр энэ тогтолцоог нь зөвшөөрөөд.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Оюунсайханы Алтангэрэл сайд хариулт өгье.

О.Алтангэрэл: Бидэнд өнгөрсөн сонгуулийн статистик алга байна. Яг албан ёсоор 2020 оны сонгуулийн зардал 2020 оных шүү сонгуулийн хэвлэл мэдээлэл, радио телевиз энэ хэвлэл мэдээлэлд албан ёсоор зарцуулсан нийт зардал нь 1 тэрбум 633.2 сая төгрөг гэсэн ийм статистик бидэнд байгаа юм. Тэгээд энэ энэнээс хамаагүй ер нь их байгааг байх гэсэн ийм бодолтой байгаа. Яг албан ёсны дүн энэ.

Тэр Ерөнхийлөгчийн дэргэд институт гэж асуусан асуултад хариулахад Монголыг нэг цонх, гадаад бодлогыг нэг цонхны зарчмаар сурталчилдаг, Монголын талаар мэдээ мэдээлэл нэвтрүүлдэг арилжааны бус байгууллагыг зах зээлийн зарчмаар нь ажилла гээд орхиж нэгдүгээрт болохгүй байсан.

Хоёрдугаарт Засгийн газрын дэргэд байж байснаас албан ёсоор намаасаа түдгэлздэг Ерөнхийлөгчийн институтын дэргэд энэ байгууллага байх нь зүйтэй юм байна гэж үзэж төсөлд тусгасан.

Д.Амарбаясгалан: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн тодруулж асууя.

Д.Пүрэвдаваа: Ийм юм байгаа юм. Хууль тогтоомжийн хуулийн тухай 30.1.3-д үг хэллэгийг хоёрдмол утгагүй, товч тодорхой, ойлгоход хялбар бичиг, 1.4-д хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх гэсэн байгаа юм. Тэгээд энэ оруулж ирсэн төсөл дээр хэчнээн хэмжээний ийм хүч оруулсан нэр томьёо байгаа юм бэ? Тэгэнгүүт энэ дээр чинь аягүй жишээгээр би ингээд харж байгаа юм л даа илт худал мэдээлэл, худал мэдээлэл 2 их их ялгаатай юу, олон байгаа юу? Дээрээс нь энэ сэтгүүл зүйн салбарын ялангуяа эх сурвалжаа яагаад ч хэлэхгүй байж болдог тэр нөхцөлийг тавьж болдоггүй юм уу? Тэрний суурь шалтгаан нь юу юм? Тэр нотлох улсууд нь тэр шүүх, цагдаа дээрээ л нотолдог юм байгаа биз дээ. Сэтгүүлч хүн энийг нотлох, ил гаргах албагүй гэдгийг л хуульчилж болохгүй байгаа суурь шалтгааныг хэлж өг.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Хариулт өгье Алтангэрэл сайд.

О.Алтангэрэл: Аминдаа хуулийн төсөл дээр бичээд л оруулаад ирчихсэн байгаа нь энэ. Эх сурвалжаа нууцлах эрхтэй гээд. Өнөөдөр ерөөсөө эх сурвалжаа нууцлах эрх хамгаалагддаггүй. Ганцхан Үндэсний олон нийтийн радио, телевизийн сэтгүүлч эх сурвалжаа нууцлах эрхтэй гэдэг тэр хуульд нь байгаа. Бусад бүх зүйл дээр сэтгүүлчийг дуудаад эх сурвалжийг нь асууж байгаа. Энийг нь харин хамгаална, Эрүүгийн процессын хуулийн дагуу бас тэрийг нь баталгаажуулаад дагалдах хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулчихаад байж байгаа.

Илт худал мэдээлэл, худал гэдэг дээр илт гэдэг нь хүч оруулаад байгаа юм ерөөсөө биш. Монгол Улсын Эрүүгийн хуульд олон жил хэрэглэгдэж байгаа нэр томьёо. Харин илт гэдэг утга нь ямар байхыг тодруулах нь өнөөдөр илт худал байна уу, андуурал байна уу, ташаарал байна уу бодит байдлаас жоохон зөрүү гарахад л сэтгүүлчийг буруутгагдаад байгаа энэ үндэслэлийг нь арилгаж, илт худал мэдээлэл гэдэг ийм зүйлийг хэлэх юм гэж ялгаж оруулж ирсэн нь яг Пүрэвдаваа гишүүн таны хэлсэн сэтгүүлчийг хамгаалах зорилготой орсон зохицуулалт байгаа юм.

Д.Амарбаясгалан: Жудгийн Баярмаа гишүүн асуулт асууя.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье. Асуултууд нэлээн давхардаж байна. Гэхдээ хамгийн сүүлийн саяын яриан дээр л гээд л дүгнэлт хийхэд Глоб Интернэшнлийн судалгаагаар албаддаг шинж асар их байна гээд байгаа шүү дээ. Маш түгээмэл байна гээд байгаа юм сэтгүүлчид өөрсдөө судалгаагаар. Тэгэхээр яг энийг ингээд бүрэн хамгаалсан энэ заалт чинь тийм хангалттай тусаагүй байна гэдгийг сэтгүүлчид хэлээд байгаа юм. Тэгэхээр энэ яг ямар зүйл, заалт орсноор ингэж хангагдаж байгаа юм болоо гээд. Ер нь энэ 98 оны хууль чинь ер нь ёстой 4-хөн зүйлтэй бараг гайхамшигтай хууль шүү дээ. Ерөөсөө хамгийн амин сүнс нь гэвэл хэвлэлийн эрх чөлөөг боомилсон, дордуулсан хууль гаргахыг хориглосон байгаа.

Гэтэл энэ чинь эргээд тодорхой хэмжээнд боомилоод жоомоо алах гээд байшингаа шатаачих вий гэдэг юм болчхож байгаа юм биш байгаа гэж сэтгүүлчид өөрснөө маш их санаа зовж байна. Дээрээс нь энэ дүгнэлтүүд гарсан байна шүү дээ Нээлттэй нийгэм форум байна, энэ манай хуулийн Их Хурлаас бас дүгнэлт гарсан байна. Тэгэхээр Их Хурал бол стратеги баталчхаад байгаа хүний эрхийн цензурээр бүх хуулийг харна гээд. Тэгээд тэр цензурийнхээ дагуу бас нэлээн сайн ажилласан байна гэж би энэ дүгнэлтийг уншаад бодлоо. Тэгээд энэ дээр бол маш их нарийн зүйлүүд орсон байна, маш их зүйл давхардсан байна гэж байна.

Ер нь нэг ноцтой дүгнэлт бол нөгөө тэр хуулийн амин сүнс болох чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлахыг хориглохоор төсөлд тусгасныг дахиж хянаж үзэж тэр бусад хуулиудтай нийцүүлээч гэсэн байна. Тэгээд өөрөөр хэлбэл дагалдах хуулиуд нь дутуу орж ирсэн юм уу гэж харагдаж байна. Бас бус хуулиудаар бол энэ асуудлыг бол буруу зохицуулсан, нөгөө эрх чөлөөнд нь халдсан байдаг юм байна шүү дээ энэ жишээ дурдсан байна. Тэгэхээр эдний тэрийг яагаад бүгдийг нь бүхэлд нь авч үзэж энэ яг Үндсэн хуулийнхаа амин сүнсийг амьдруулах энэ зүйлийг дутуу хийсэн юм бэ гээд. Дахиад нөгөө байнгын ярьдаг Эрүүгийн хуулиас 13.14-ийг авах тал дээр сэтгүүлчид өөрснөө байнга хэлэхээс гадна манай Хүний эрхийн Үндэсний Комисс байнга зөвлөмж өгдөг удаа дараа, дээрээс нь НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл бас энэ дээр энийгээ Эрүүгийн хуулиас аваач гэдэг. Тэгээд энийг яагаад авч болдоггүй юм бэ гээд. Энэ дээр бас судалгаа байна л даа Эрүүгийн хэрэг үүсгэснээс 0.3 хувь нь л яг жинхэнэ эрүүгийн гэмт хэрэг болж явдаг юм байна.

Өөрөөр хэлбэл, цаана нь 99.7 хувь нь буруугүй гэж гардаг юм байна. Тэр нэгэнт ийм буруугүй гээд ингээд гарч байхад энийг заавал ч үгүй ингэж Эрүүгийн хуулиар шийтгэж ингэж баахан чирэгдэл учруулах ингэж сэтгүүлчдийг боомилох шаардлага байдаг юм уу? Энийг ерөөсөө гаргачихвал яадаг юм бэ? Тэгээд зөндөө л асуудал байна л даа. Энэ дагалдах хуулиуд Төрийн албаны, Төрийн болон албаны нууцын тухай хуульд нөгөө иргэдийг нууц хадгалах үүрэгтэй юм шиг ийм агуулга яваад байна тээ? Тэгээд нөгөө сэтгүүлч Өнөрцэцэг хадгалсан зүйл ангиар ингээд ял аваад явж байсан.

Тэгэхээр энэ төрийн албаныхан буюу гарын үсэг зурсан тэр хүмүүст л уг нь хамаарах ёстой байтал огт гарын үсэг зураагүй буюу хадгалах үүрэг хүлээгээгүй хүмүүст ийм зүйл, ангиар ял өгөөд байгааг яах ёстой юм бэ? Эцэст нь нэг чухал зүйл дурдъя гэж бодож байна. 2012 онд Хил хязгааргүй сэтгүүлчид гээд олон улсын байгууллагын гаргадаг индексээр Монголын хэвлэлийн эрх чөлөө 100

дугаар байранд байсан байна. Аанай л сүүл мушгиж явсан. Ардчилсан намын засаглалын үед 2015 онд 54 дүгээр байр руу орсон, бүүр 50 байраар урагшлаад 100 хувийн амжилт үзүүлсэн гэсэн үг шүү дээ. Харамсалтай нь 2015 онд 54-д байсан нөгөө индекс маань одоо энэ 24 онд 109 дүгээр байранд орчихсон. Дахиад 100 хувь буюу дахиад 50 байраар ухарчихсан. Тэгээд энэний шалтгаан нөхцөлийг судалсан уу? Энэ яагаад ингээд ухраад байдаг юм бэ Ардын намын үед? Ардчилсан намын үед яагаад урагшлаад бай.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Оюунсайханы Алтангэрэл сайд хариулъя.

О.Алтангэрэл: Харин ий М ойлголт төрчихсөн юм байна лээ. 1998 он үүргээ маш сайн гүйцэтгэсэн сайн хууль гэдгийг ойлгоно. Тэгэхдээ одоо ийм сайн хууль байж байхад гэж яриад байгаа. Эх сурвалжаа нууцлахыг, төрийн байгууллагын тэр үйл ажиллагааг нь илүү сайн зохицуулахыг, тэр хэвлэл мэдээлэлд хандахгүй байхыг. Тэгээд сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааг нь тодорхойлохыг нь энэ олон хэм хэмжээнүүдийг энэ хуулиар зохицуулаагүй. Өнөөдрийн байгаа бодит байдал яг л энэ хуулийн хэрэгжилтийн үр дүн бүгд. Тэгэхээр ямар нэг зүйлийг зохицуулалтыг хийж өгөхгүйгээр тэндээс үр дүн шаардах ч утгагүй. Юу ч зохицуулаагүй зүйлийг сайн юм гэж ярих ч бас ойлгомжгүй болчихоод байгаа байхгүй юу.

Албаддаг шинжүүд гэж ярьж байна. Түрүүн тэр нөгөө Их Хурлын дүгнэлтийг манай Баярмаа гишүүн та буруу ойлгосон юм шиг байна. Энэ чинь бүүр хүрээ хязгаарыг нь тогтоож өгөөсэй гэсэн утгатай үг, өгүүлбэр байсан юм шүү наад өгүүлбэр чинь. Одоо яг унших юм бол хэвлэн нийтлэх эрх нь мөн чанараараа 2 талтай буюу нэг талаас ямар нөлөөлөл дарамт шахалтгүйгээр үзэл бодлоо чөлөөтэй хэвлэн нийтэлдэг байх. Нөгөө талаас ийнхүү хэвлэн нийтлэх эрхээ хэрэгжүүлэх явцдаа бусдын нэр төр, нийгмийн ёс суртахууныг гутаахгүй, үндэсний аюулгүй байдал сөрөг үр дагавар учруулахгүй байх гэсэн хүрээ хязгаарын дотор хэрэгжих зарчимтай гэсэн өгүүлбэр байгаа.

Өөрөөр хэлбэл, бүүр наадах чинь хүрээ хязгаар тогтоо гэсэн агуулгатай бид бол наадхыг чинь хүлээн зөвшөөрөхгүй, бид эрх чөлөө тавих гэж байгаа гэсэн утгаар тэр дүгнэлтэд хандсан гэдгээ хэлье.

Энэ 0.3 хувь нь бурууддаг юм байна. Бусад нь ингээд хэрэгсэхгүй болдог юм байна гэсэн зүйл ярьж байна. Яг үнэн. Тэгэхээр бид яагаад энэ хуульдаа тэр илт худал мэдээлэл, худал мэдээллийг ялгаад байгаа вэ гэхлээр ерөөсөө авчирч ирээд л илт худал мэдээлэл байна гэж хэлээд л ингээд л баахан асуучихдаг, тэгээд мөрдөн байцаалтын үйл ажиллагаа явуулдаг, прокурор хянадаг, шүүх рүүгээ очдог энэ процесс дунд чинь шүүхээр орж бурууталгүйгээр маш олон хүмүүс яг энэ зүйл ангийн дагуу шалгагдаад байгаа юм. Тэгэхээр бид нар хүрээ хязгаарыг нь жижигсгэж өгч байгаа.

Харин яг Эрүүгийн хуулийн 13.14-тэй зүйлийг яг Эрүүгийн хуулийн тэр зүйл заалтыг ярьж байхдаа бид нар хэлэлцэхгүй бол яг энэ хуулийг дагалдуулаад дахиад бас Эрүүгийн хууль гэж ярьж болохгүй болчихоод байгаа юм. Саяхан жишээлбэл бид нар Зөвшөөрлийн хууль дээр яаралтай цахим асуудлыг шийдвэрлэе гээд Эрүүгийн хуульд нь өөрчлөлт оруулъя гэсэн ингээд өөр хуулийг

дагалдуулж Эрүүгийн хууль оруулж ирлээ гээд маш их шүүмжлэлд өртсөн. Тэгэхээр энэ өөр хуулийн хүрээнд яригдах асуудал.

Төрийн болон албаны нууц задруулах дээр бид нар яг одоо Их Хурал дээр Төрийн болон албаны нууцын тухай хууль хэлэлцэж байгаа энэ зарчмыг бас бид нар нэмж оруулах нь зүйтэй. Ер нь нууц хадгалах гэдэг хариуцсан албан тушаалтны үүрэг болохоос биш тэрийг мэдээлсэн хүний сэтгүүлчийн буруу болж бас үүрэг нь болох ёсгүй гэдэг энэ зарчим дээр байгаа.

Индекс дээр асуудлыг тавьж байна. Индекс бол яг үнэхээр ухарч байгаа нь үнэн. Тэгэхээр бид Төрийн болон албаны нууцын тухай өөрчлөөд, дахиад хүний эрхтэй холбоотой энэ хуулийн өөрчлөлтүүдийг хийгээд ерөөсөө хэвлэлийн эрх чөлөө маань бусад эрх, эрх чөлөөнүүдтэй хамтран яригдаж байгаа учраас тэгээд энэ Хэвлэлийн эрх чөлөөний хуулиа бас сайтар томъёолоод баталж чадах юм бол бас яг энэ индексээ сайжрах, хүний эрх чөлөө дээрдэх бас нэг алхам болох байх гэж үзсэний үндсэн дээр Засгийн газар энэ хаврын чуулганд яг энэ хүний эрх чөлөөтэй холбоотой энэ хуулийн.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Баярмаа гишүүн тодруулж асууя.

Ж.Баярмаа: Яг ингээд шалтгаан нөхцөлийг маш сайн тодорхойлж гаргах ёстой л доо. Яг ийм ийм ийм зүйл болсон учир ингээд ухраад байна гээд. Тэр чинь нарийн шалгуур ингээд байж байгаа байлтай билээ. Тэгээд эцсийн дүнд нөгөө бид нарын хийж сурч байгаа гэдгийг чинь ерөөсөө энэ олон улсын байгууллагууд л тогтоогоод байгаа шүү дээ. Тэнд чинь багш байгаад байна шүү дээ. Багш нь хүүхдүүдээ нөгөө дүн тавьдаг шиг ингээд улс орнуудад дүн тавихаар манайх ингээд ерөөсөө ингээд 4 жилийн интервалтайгаар бүүр шувтан “F” авч байгаа байхгүй юу. “F” бүүр. 100 хувь доройтсон гэсэн үг шүү дээ хэвлэлийн эрх чөлөө.

Тэгэхээр энэ хууль гарснаар хэвлэлийн эрх чөлөө дээрдээд нөгөө энэ индекс яг сайжрах эсэхийг би сайн ойлгохгүй байгаад байна. Тэгээд энд ингээд байна шүү дээ хууль хоорондын уялдааг хангаагүй байна гэсэн агуулга түрүүн та бид 2 энэ хууль зүйн дүгнэлт дээр зөрөөд байна л даа. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, олон улсын гэрээний хүрээнд дахин нягталж, тэгээд хууль хоорондын уялдааг хангах нь зүйтэй байна гээд. Ингэж .../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Айн? Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: Тийм байгаад байгаа юм. Тэгээд энд бас 1 асуулт байна. Энэ хуулийн 6.5 дээр төрийн байгууллага төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь өөрийн үйл ажиллагааг тусгайлан сурталчлах бол хэвлэл мэдээллийн байгууллагыг хуульд заасны дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулна гэсэн. Энэ заалтыг би жоохон гайхаад байна л даа. Энэ чинь яаж шалгаруулах юм, юу гэсэн ч үг юм. Тэгээд ерөөсөө нөгөө сам себя ... гээд Оросоор. Хүн болгон сэтгүүлч шахам болчихоод байгаа нэг талаасаа.

Гэхдээ энэ чинь жижиг сэтгүүлч, том сэтгүүлч гэдэг шиг жижиг сэтгүүл зүй, том сэтгүүл зүйч гэдэг шиг бараг өчнөөн олон сэтгүүлчид байна шүү дээ. Хөөрхий нэг студи байгуулаад л түүгээрээ ингээд л сэтгүүл зүйн ажлыг хийгээд байгаа хүмүүс зөндөө байгаа. Тэгээд тэр бүхэнд энэ сэтгүүл зүйн ажлыг эрхлэх төрийн

байгууллагын үйл ажиллагааг сурталчлах боломж нь хаагдчих юм биш үү? Энэ тендерээр нөгөө том акулуд нь ороод нөгөө сэтгүүл зүйг хийхийг ядаж байгаа тэр сэтгүүлчид орох бололцоогүй болоод энэ үйл ажиллагаагаа явуулах эрх нь хаагдах юм биш үү гэдэг ийм.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Оюунсайханы Алтангэрэл сайд хариулъя.

О.Алтангэрэл: Үгүй. нээлттэй болгох гээд л энэ сонгон шалгаруулалт гэдэг юмыг оруулж ирж байгаа юм. Одоо ерөөсөө энэ жижиг ч гэлтгүй, том ч гэлтгүй тухайн ТӨК болон төрийн байгууллагуудын улс төрчтэй хэн нь ойрхон байна, хэнд итгэж байна тэр хүмүүс л ингээд яваад байгаа харилцаа. Өөрөөр хэлбэл, тэр жижиг, том аль алинд нь хамааралгүй яваад байгаа харилцааг нэгдүгээрт ил тод байлга гэж байгаа юм. Энэ чинь дагнасан редакцууд байгаа. Эрүүл мэндийн чиглэлээр сайн бичдэг, хуулийн чиглэлээр сайн бичдэг ч гэдэг юм уу энэ шалгуур тогтоохыг нь бид нар тэр дараагийнх нь зүйлд нь ингээд оруулаад өгчихсөн.

Тэгээд индекстэй холбоотой асуудал яаж сайжрах юм бэ гэж асууж байгаа юм. Бид нар жишээлбэл энэ хуулийн хэлэлцүүлгийн хүрээнд 2 тэр Хил хязгааргүй сэтгүүлчид, бас 1 ТББ, 2 олон улсын байгууллагатай хэлцэл хийсэн. Дахиад энэ хүний эрх хуулийн чиглэлийн олон улсын байгууллагын шинжээч ирээд дүгнэлт гаргасан. Энэ болгоны маань дүгнэлт, бид нарын хийж байгаа оролдлого энэ бүх зүйлүүд репорт/report/ болоод гарах байх.

Дээрээс нь сэтгүүлчид эрүүгийн хэрэгт холбогдож байгаа статистик буураад энэ олон зүйлүүд нь хууль эерэг үйл нөлөөллөөр ирэхээр энэ.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 7 дугаар микрофон Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбооны тэргүүн Шаравдорж гуай нэмэлт хариулт өгнө.

С.Шаравдорж: Баярмаа гишүүний асуултад бас нэмж хариулъя гэж бодож байна. Ер нь хэвлэлийн эрх чөлөөний индекс яагаад 54-д байснаа 100 гараад ингээд их хол хэлбэлзээд байгаа юм бэ гэдэг. Тэгэхээр 2015 онд Монгол Улс энэ хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллага гэдэг энэ байгууллагыг байгуулсан энэ явдал бол хэвлэлийн эрх чөлөөний индекс ийм огцом урагшлахад нөлөө үзүүлсэн гэж бид үздэг.

Ер нь өөрийн зохицуулалтын байгууллагыг аль ч улс орон тийм амархан байгуулчихдаггүй. Салбарынхан үзэл бодол өөрсдөө нэгдэж энэ байгууллагыг байгуулах нь хамгийн хүнд асуудал байдаг. Харин Монгол Улсад энэ маш амжилттай байгуулж чадсаныг нь тэр индексийг одоо гаргахдаа харгалзан үзсэн байдаг.

Сүүлийн жилүүдэд харин хэвлэл мэдээллийн энэ үйл ажиллагаа нь төрийн оролцоо, ялангуяа өнөөдрийн бид нарын яриад байгаа.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

О.Алтангэрэл: Сүүлийн жилүүдэд энэ индекс эргээд их унаж байгаагийн нэг гол шалтгаан бол төрөөс их хамааралтай, хэвлэл мэдээллийн салбарын хөгжил хэт хамааралтай болж байгаа. Ялангуяа төрийн бүх шатын хэвлэл мэдээллийн

байгууллагуудад энэ үйл ажиллагаа хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх байдал их хавтгайрч газар авч байгаа. Одоо хөдөө, орон нутагт аймгийн төвөөс гадна сум руу бас зарим аймагт ЗДТГ-ын дэргэд хэвлэл мэдээллийн орон нутгийн өмчит аж ахуйн нэгж хүртэл байгуулагдаад, тендерт оролцоод хэвлэл мэдээллийн бүхэл бүтэн том баг ажиллуулаад, тэр аймагт хараат бус жижиг хэвлэл мэдээлэл оршин тогтнох ямар ч боломжгүй болж байгаа ийм байдлыг бас энэ индекс харуулж байна гэж үзэж байгаа.

Д.Амарбаясгалан: Жаргалсайханы Золжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Золжаргал: Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль буюу эрх чөлөөний тухай хууль байгаа. Тэгэхээр эрх чөлөөг яаж нэмэгдүүлээд хангачхав гэдэг дээр аягүй их асуудал байна. Сэтгүүлч мэргэжлийн хэвлэл мэдээллийн байгууллага түүнийг тодорхойлоод түүний үйл ажиллагааг хамгаалсан талын заалтууд орсон болохоор эрх чөлөөг сайжруулчихлаа гэж харж байгаа юм шиг байгаа юм. Гэтэл нөгөө хэвлэн нийтлэх үгээ хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх хүрээлэл өөрөө шал өөр болчихсон болохоор тэр хүрээнд эрх чөлөөг хязгаарласан заалтууд харагдаад байна. Ингэхээр энэ үзэл баримтлалын ялгаа харагдаад байгаа юм.

Жишээлбэл, олон нийтийн эрх, ашиг сонирхлын төлөө мэдээллийг хэвлэн нийтлэхтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулах энэ агуулга үзэл баримтлалд нь орсон байгаа. Өөрөөр хэлбэл юуг олон нийтийн эрх ашиг сонирхол гэдэг юм бэ. Үүгээрээ дамжуулаад цензур хязгаарлалт тавих олон нийтийн эрх ашгийн эсрэг юм та ярьж байна гэдэг хязгаарласан ам хамжих заалт болчих юм биш биз дээ? Бас нэг зүйл нь болохоор ёс зүйг хуульчилсан. Ёс зүйг энэ хэдэн мянган жилийн түүхтэй уламжлал, шашин, гүн ухаантнууд тодорхойлдог болохоос биш хэдэн хүмүүс сууж байгаад хууль дээр ёс зүйг тодорхойлохгүй гэж бодож байгаа юм. Хуулийн үйлчлэх хүрээ нь яг хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагааг ингээд хамаарсан, зохицуулсан, нөгөө илэрхийлж байгаа, үг хэлж байгаа янз бүрийн субъектүүдийг хамрааж чадаагүй байна. Хэвлэл мэдээллийн байгууллага ийм байна. Сэтгүүлчийн, сэтгүүл зүйн үйл ажиллагаа гэж энийг хэлнэ, хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэж энэ энэ энийг хэлнэ ээ. Тэгэхээр зэрэг нөгөө энэ хэрэгсэл дотроос шал өөр юм хэрэглэдэг ийм байгууллага ерөөсөө байхгүй. Тэгэхдээ нийгэмд үйл ажиллагаа идэвхтэй явуулдаг хэвлэн нийтлэл нийтлэгч энэ зохицуулалтын гадна орчхож байгаа юм шиг харагдаад байгаа байхгүй юу. Олон улсын тэр түгээмэл жишиг хүний эрх, янз бүрийн фактуудаар адилхан хамгаалагдах үүрэг эдлэх ёстой ямар ч хэвлэн нийтлэл ч бай.

Тийм болохоор чөлөөлөх гэж байгаа бол хязгаарлах биш чөлөөлөх үйл ажиллагаа явуулмаар байна. Тэгээд чөлөөлөх нь цаанаа бусад хуулиудтайгаа багц байж таарна. Түрүүн дурдагдсан Төрийн ба албаны нууцын тухай. Төрийн нууц гэж байдаг. Албаны нууц гэхээр зэрэг янз бүрийн нөгөө арилжааныхаа юмыг нуудаг төрийн өмчийн компани янз бүрийн байгууллагууд ингээд нууц гэдэг ангилалд оруулж байгаад тэрийгээ задалсан хүмүүсийг хамаатуулж хариуцлага хүлээлгэх гээд байдаг. Тэгээд төрийн байгууллагад нууц байгаа бол тэр нь төрийн нууц л байна шүү дээ. Албаны нууц гэж ер нь юу байдаг юм? Тэр дээр бас өөрчлөлт оруулах хэрэг гарах байх. Тэгэхээр иймэрхүү багц хуулиудтай нь өөрчилж таарна гэж бодож байна.

Яагаад гэхээр 2011 онд энэ хууль яригдаж байгаад 13 он хүртэл яригдаад тэгээд ерөөсөө зөвхөн сэтгүүлчид биш иргэний үг хэллэгтэй холбоотой учраас гээд ингээд хойшоо тавигдчихсан. Яг энэ байдал одоо давтагдаж харагдаад байна. Улсын Их Хурлын даргын захирамжаар Улсын Их Хурал дээр ажлын хэсэг гарчихсан байгаа хэвлэл мэдээллийн эрх зүйн орчныг сайжруулах, судлах, хуулийн төсөл боловсруулах магадгүй. Тэгэхээр энэ ажилтайгаа энийгээ уяад тэгээд хэлэлцүүлэхгүйгээр татаж аваад дараа нь үзэл баримтлалын хувьд нийтлэг болгож оруулж ирж болохгүй юм уу гэдэг асуулт. Тэгээд тодруулъя. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Оюунсайханы Алтангэрэл сайд хариулт өгье.

О.Алтангэрэл: Бид нар энэ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль гээд эрх чөлөөг яаж сайжруулж байна вэ гэж. Бид нар энэ хуулиар эрх чөлөөг сайжруулах ч гэдэг юм уу, эрх чөлөөг олгох зорилго тавиагүй. Угаасаа тэр эрх чөлөө байгаа. Монгол Улсын Үндсэн хуулиар энийг сайжруулах ч юм уу, ийм ойлголт байхгүй. Ерөөсөө Үндсэн хуулиар шууд утгаар нь заагаад өгчихсөн. Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй. Гагцхүү бид энэ дундаас бас олон төрлийн субъектүүдээр хэлж байна. Тийм ер нь бүх төрлийн субъектүүд оруулаагүй. Энэ хуулийн үйлчлэлийн хүрээнд сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаа явуулж байгаа хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн үйл ажиллагааг хэрхэн, яаж энэ эрхээ хэрэгжүүлэхэд нь бид нар харин энэ зохицуулалтыг нь хийж өгөх юм бэ гэдэг энэ үндсэн дээр л бичигдсэн хуулийн төсөл. Бүгдийг нь хамруулаагүй. Энэ дээр яг редакциятай сэтгүүл зүйн мэргэжлээр өөрсдөө бүтээл туурвиж байгаа тэр хэсгийг хэвлэл мэдээллийн хэрэгслийг л энэ хуулиар зориуд ингэж эрх зүйн байдал, статусыг нь хамгаалж тэр эрх чөлөөг нь хамгаалахын тулд л оруулж ирж байгаа хуулийн төсөл гэдгээ хэлье.

Энэ олон нийтийн эрх ашиг гээд энэ ам хамхих зүйл болох юм шиг байна. Огт тийм агуулга байхгүй. Цензурдэх, ам хаах агуулга энэ хуулийн төсөлд ерөөсөө байхгүй. Түрүүн бас манай ажлын хэсгээс дурдаж энэ шүүмжлэлд өртөж байгаа тэр зарчим гэсэн хэсэг байгаа. Ер нь ямар зарчмын үндсэн дээр явах юм гээд. Энэнтэйгээ холбоотой Зөрчлийн, Эрүүгийн, бусад хуулиудад ямар ч хариуцлагын механизм байхгүй. Тунхгийн шинжтэй 5 зарчим тавьсан. Эдгээр хэлэлцүүлгийн явцад хасагдаад ийм зарчим байх ёсгүй гэж ингэж үзэж, ингэж хассан ч энэ уг хуулийнхаа зорилго энэ зүйлд ерөөсөө харшлахгүй ийм зүйлүүд байгаа.

Яагаад бүх субъектийг хамруулаагүй вэ гэвэл бүх субъектийг хамгаална гэдэг нэрийн доор, энэ эрх чөлөөг хамгаална гэдэг нэрийн доор яг хариуцлагатайгаар явж байгаа энэ сэтгүүл зүй сэтгүүлчид чинь хамгаалалтгүй байна. Энэ үйл ажиллагаанд нь зөндөө олон дутагдал гараад байна. Олон жил ингэж ярьж, олон жил энэ хуулийг өргөж буцааж энэний чинь хооронд бид нарын тэр хэвлэлийн эрх чөлөөний индекс унаад байгаа байдал сэтгүүлчдэд ямар байдлаар эрүү шүүлт тулгадаг, мөрдөж байцаадаг энэ зүйлүүд чинь байна. Энд ерөөсөө ямар хамгаалалт үүсэхгүй байна гэсэн үүднээс хийсэн юм. Ажлын хэсэгт, Их Хурал дээр байгуулагдсан ажлын хэсэгтэй холбоотой зүйл дээр санал нэг байгаа. Бид энэ асуудлаа хэлэлцэх эсэхийг нь шийдвэрлээд Их Хурал дээр байгаа ажлын хэсэг дээр зарчмын зөрүүтэй зүйлүүдээ нэгтгээд цаашаагаа хэлэлцээд яваад үзье.

Үнэхээр Их Хурал дээр байгуулагдсан ажлын хэсэг гишүүдтэй Засгийн газраас өргөн барьсан төсөл ингэж нэгдэж нийлэхгүй юм байна. Энэ хоорондоо ямар маягаар уялдахгүй юм байна, энийг дэмжих бололцоогүй гэж үзвэл хууль тогтоогчийн зүгээс ийм шийдвэрт хүрэх юм бол тэгвэл заавал ч үгүй ингэж Их Хурал дээр байгаа ажлын хэсгийн зарчим, үйл ажиллагаатай нэгдэхгүй бол бид нар татаж авъя.

Гэхдээ үүнээс өмнө бид нар энэ хуулиар зохицуулагдаж байгаа, өнөөдөр сэтгүүл зүйн үйл ажиллагааг дээрдүүлж байгаа энэ зүйлүүдээ бид нар хэлэлцээд явъя гэсэн ийм л байр.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Золжаргал гишүүн тодруулж асууя.

Ж.Золжаргал: Харин яг л энийг бодоод байна л даа. Одоо байгаа хүрээнд нь мэргэжлийн сэтгүүл зүйг ингээд хамгаалах, сайжруулах. Гэтэл энд чинь өөр хүрээ бодогдоод, энэ идэвхтэй яг энэ дээр ажиллаж байгаа гишүүд нь өөр байр суурьтай байгаад байгаа үзэл баримтлал сууриараа. Тэгэхээр хэлэлцүүлбэл энэ чинь дэмжигдэх юм уу, үгүй юү? Эргэлзээтэй байхгүй юу. Тэр зүгээр санал болгож байгаа шүү.

Нөгөөх нь болохоор нэгэнт чөлөөлье гэж байгаа бол улс төрийн төрийн нөлөөнөөс чөлөөлмөөр байна. Олон Үндэсний олон нийтийн телевизийн тухай хууль, төрийн томилгоотой Үндэсний зөвлөл, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, төрөөс санхүүждэг телевизүүд, тэгээд Засгийн газрын суртал ухуулгын нэвтрүүлгийг 10 хэдэн сувгаар нэг зэрэг цацдаг эд нарыг нь журамлаж, хязгаарлаж яг тэр үндэсний контент, соёл урлаг юу байдаг юм өв уламжлалаа тавихгүй хажуугаар нь ийм тархи угаалт явуулдаг юмнуудыг бид нар бас энэ хүрээнд авч үзэх хэрэгтэй байна.

Д.Амарбаясгалан: Санал хэллээ. Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн асуулт асууя. Их Хурал дээрх ажлын хэсгийн дарга.

Ч.Лодойсамбуу: Баярлалаа. Тийм энэ дээр яг залруулга хэлэхгүй бол одоо Их Хурлын даргын захирамжаар байгуулсан миний ахалж байгаа ажлын хэсэг хэвлэлийн эрх чөлөөг хангах талаар санал, дүгнэлт боловсруулаад шаардлагатай бол хуулийн төсөл өргөн барих ажлын хэсэг байгаа. Энэ орж ирж байгаа Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл бол Засгийн газраас өргөн барьсан төсөл. Одоо хэлэлцэх эсэхийг нь хэлэлцэж байгаа. Тэгэхгүй нөгөө бас хольж ойлгоод байх шиг байна.

Ингээд анхнаасаа энэ Засгийн газраас өргөн барьсан хуулийн төслийг анхны төслөөс нь авхуулаад дэмжихгүй гэдгээ илэрхийлж явж байсан. Алтангэрэл сайдтай удаа дараагийн уулзалт хийсэн. Алтангэрэл сайд бол хүсэлт тавьсан. Энэ хуулиа бид нар шинэчилсэн найруулга учраас хэлэлцүүлгийн шатад хэлэлцүүлээд тэгээд танай ажлын хэсгээс гарч ирж байгаа санал ингээд нийлүүлээд болох юмыг нь болгоод, болохгүйг нь хасаад ингээд явъя гэдэг ийм санал хэлсэн.

Алтангэрэл сайд бол 60:40-ийн харьцаа гэж хэлж байгаа. Одоо өргөн барьсан төслийнхөө 60 хувийг үндсэндээ хамгаалах байр суурьтай байгаа гэж. Миний зүгээс юуг хэлж байгаа вэ гэхээр хэвлэлийн эрх чөлөө манай сэтгүүлч нар

өнөөдөр нэмж эрх чөлөө ерөөсөө хүсээгүй. 98 онд хуулиар олгогдсон, Үндсэн хуулиар олгосон эрхээ эдэлье л гэж байгаа юм. Энийг нь хангаад өгөөч гэж байгаа юм. Манай ажлын хэсэг бас буруу тайлбарлаж байна шүү та тэр Орон нутгийн хэвлэлийн мэдээллийн. Индекс яагаад буурч байгаа вэ? Энэ КОВИД-оос хойш мэдээллүүд олдохоо больчихсон байхгүй юу даа. Бүх мэдээлэл төрийн мэдээлэл олдохоо больчихсон. Цагдаад дуудагддаг тоо нэмэгдчихсэн. Таны хэлж байгаа логигоор жишээлбэл тэр зөвлөл дээр ирж байгаа гомдлын тоо тэр зөвлөл байгуулагдсанаар индекс яг логигоор нь бодох юм бол унах ёстой шүү дээ. Тэр чинь яагаад гэвэл хэвлэлд бас нэг талаасаа цензур тогтоож байгаа асуудал мөн үү? Мөн шүү дээ. Эрх чөлөө гэдэг чинь эрх чөлөөг л хэлнэ. Нээлттэй байхыг л хэлнэ. Эрх чөлөөг хуульчлаад байх тусмаа л эрх чөлөө хумигдана. Энийг бүгд мэдэж байгаа. Энийг бүх хуульчид хэн ч надаар хэлүүлэлгүй мэдэж байгаа. Тэгэхээр би энэ Алтангэрэл сайдаасаа дахиад хүсэж байгаа юм. Одоо ингээд яг энэ процессын хувьд юу болох вэ гэхээр энэ 16 заалттай, зүйлтэй энэ хууль ингээд хэлэлцэх эсэх нь шийдэгдээд ингээд явлаа, хэлэлцье гэж бодоход, бид нар хүсэж байгаа өөрчлөлтүүдээ хийе гэж бодоход тэр тооны дагуу тэр төдий чинээ зарчмын зөрүүтэй санал гарна. Зарчмын зөрүүтэй санал болгон дээр санал хураана. Ингээд Их Хурлын гишүүдийн байр суурийг ерөнхийдөө сонслоо. Хариуцлага л ярьж байна. Яаж сэтгүүлчдийн дураараа байгаа байдлыг цензурдэх вэ л гэж байна шүү дээ. Тэгэхээр энэ бол хэлэлцэгдээд явж байгаа шатдаа бол бүүр хүсээгүй үр дүн рүүгээ явах юм биш үү. Тэгээд энэ Ардчилсан нам хэвлэн нийтлэх эрх чөлөө, хүний эрх, эрх чөлөөг дээдэлдэг үзэл баримтлалаа тугаа болгосон энэ нам 42 суудал авсан дээрээ их яараад байх хэрэг байна уу даа. Ултай, суурьтай авч үзвэл яасан юм бэ, тэгээд буцаагаад татчихвал яасан юм бэ гэдэг ийм санал тавьж байгаа. Асуулт алга.

Д.Амарбаясгалан: Санал хэллээ. Нам гэлтгүй ер нь энэ парламентад сууж байгаа гишүүд хэвлэл мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулах, хэвлэн нийтэлсэнтэй холбоотой үүрэг, хариуцлага хүлээдэг холбоотой асуудлыг тодорхой болгох гэдэг дээр л төвлөрч ажиллая гэж байгаа шүү дээ. Тийм учраас би бас Их Хурлын даргын хувьд санаачилга гаргаад Улсын Их Хурлын гишүүдээр бүрдүүлээд ажлын хэсэг байгуулаад ажиллуулж байгаа юм. Тэгээд бидний зорилго тэр л байх ёстой. Энэ ардчилал, эрх, эрх чөлөөг дэмжих, хүний эрхийг дээдэлсэн нийгмийг улам бүүр баталгаажуулах зорилгоо хангахын тулд хэвлэл мэдээллийн байгууллага, хэвлэл мэдээлэлд ажиллаж байгаа сэтгүүлч эрх чөлөөтэй, мэдээж хэрэг өндөр хариуцлагатай ажилладаг байх тэр нөхцөл боломжийг л бүрдүүлж өгье гэж ингэж зорьж ажлын хэсэг байгуулагдсан.

Ингээд Засгийн газраас Алтангэрэл сайд мэдээж хэрэг бас л хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах, баталгаажуулах зорилго агуулж ажлын хэсэг байгуулж, удаа дараагийн хэлэлцүүлэг зохион байгуулж бас энэ төсөл өргөн баригдаад явж байгаа. Тэгээд шинэчилсэн найруулгын төсөл байгаа юм төсөл нь бол. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиа 40.1-ээр бол энэ төслийг хэлэлцэх эсэхийг дэмжсэн тохиолдолд Байнгын хороо анхдагч болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэхдээ шинэ бүлэг, зүйл, хэсэг, заалт нэмэх, эсхүл өргөн мэдүүлсэн хуулийн төслөөс холбогдох бүлэг, зүйл, хэсэг, заалтыг хасах, бүтэц, найруулга, үг хэллэгийг өөрчлөх, засварлах тухай санал, дүгнэлт гаргана гэж байгаа юм. Тэгээд нэг ёсондоо Лодойсамбуу гишүүн энэ нэгэнт Улсын Их Хурал энэ хуулийн төслийг хэлэлцье гэдгийг дэмжигдээд явах юм бол энэ Алтангэрэл сайдын асуудал биш Засгийн газраас өргөн барьсан төслийг

Улсын Их Хурал хүлээж аваад, өөрөө ажлын хэсэг байгуулаад өөрчилж, шинэчилж, засаж сайжруулах, зарим шаардлагагүй зүйл, заалтыг хасах тэр боломж бол Дэгийн тухай хуулиараа нээлттэй байгаа юм.

Тэгэхээр энэ дээр яах вэ Улсын Их Хурлын гишүүд бас энэ хэвлэл мэдээллийн байгууллагынхантай ярилцах ёстой л доо. Энэ асуудлыг хэлэлцэхгүйгээр буцаасан тохиолдолд магадгүй дахиж өргөн баригдах хугацаа хэзээ гэдгийг хэлэхэд их хэцүү шүү дээ. Ахиад жил жил алдаад явах уу, энэ парламентын бүрэн эрхийн хугацаанд дахиж хэлэлцэгдэх үү, үгүй юү гэдэг асуудлууд үүсэх талтай. Тэгэхээр аль аль талаа бодолцоод хэлэлцэх эсэхээ дэмжихээд, ажлын хэсэг байгуулаад хэвлэл мэдээллийн байгууллагуудын оролцоог бүрэн хангаад хамтарч ажиллах сонголт байх юм уу, үгүй юу гэдэг л зүйл дээр гишүүд саналаа өгнө л гэсэн үг. Тэгэхээр энэ дээр бид бол нээлттэй ярилцах ёстой. Энд ямар нэгэн байдлаар нам, улс төрчийн асуудал ярьж улс төрчид талцаж хуваагдаад хэрэггүй. Монгол Улс ардчилсан улс, хэвлэлийнхээ эрх, эрх чөлөөг улам бүүр баталгаажуулахын төлөө энэ парламентад сууж байгаа 126 гишүүн бүгдээрээ хамтарч ажиллах үүрэгтэй л гэж ингэж ойлгох нь зөв юм гэж бодож байна.

Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Д.Энхтүвшин: 2 асуулт байгаа. Нэлээн давхардсан учраас 2 асуулт асууя. Хуулийн зорилт дээр энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулах, хэвлэл мэдээллийн бие даасан хараат бус байдлыг хангах, олон ургалч чөлөөт хэвлэл мэдээллийг хөгжүүлэхэд оршино гээд. Тэгээд энэ Үндсэн хуулийн заалт нь өөрөө иргэнтэй холбоотой заалт байгаа. Монгол Улс Үндсэн хуулийн 16.16 дээр болохоор иргэний ийм баталгаатай эрх эдэлнэ гэдэг дээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх гэсэн утгатай байгаа. Тэгэхээр яг энэ хуулийн агуулгыг нь харахаар яг иргэний энэ үзэл бодлоо илэрхийлэх, чөлөөтэй илэрхийлэхтэй холбоотой заалт байхгүй байгаа.

Нөгөө талаас агуулгыг нь аваад үзэхээр хэвлэн нийтлэх үйл ажиллагаатай холбоотой байгаа. Тэгэхээр яах вэ нэр нь өөрөө Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль буюу 98 оны энэ хуультайгаа адилхан ингээд нэр өгчихөөр хүмүүсийн буруу ойлголт төрүүлээд, нэлээн өргөн хүрээтэй юм шиг ингэж харагдаад байгаа. Тэгэхээр Алтангэрэл сайдаас асуух гээд байгаа нь болохоор энийг зүгээр Хэвлэн нийтлэх үйл ажиллагааны тухай хууль гэхивэл илүү тодорхой болох юм биш үү? Тэгэхгүй бол ийм эрх чөлөөний тухай гээд ирэхээр тэгээд Үндсэн хуулийн заалтыг оруулаад ирэхээр иргэдийн үзэл бодлоо илэрхийлэхдээ холигдож ойлгогдоод байна. Тэгээд энэ талаар таны бодол ямар байгааг асуумаар байна.

Хоёрдугаарт нь энэ хуулийн төслийн 2 дугаар бүлэг дээр хэвлэл мэдээллийн хараат бус, бие даасан байдлын баталгаа гэсэн 2 дугаар бүлэг байгаа. Энэний 6 дугаар зүйлийн гарчиг нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөг төрөөс хангах баталгаа гэж. Өнөөдөр төрөөс хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгийн их боож байгаа нь миний бодлоор бол төр болоод байгаа юм. Яагаад вэ гэхээр энэ судалгаан дээр ч гэсэн гарч ирсэн байгаа энэ хавсаргасан судалгаан дээр. Хэвлэл мэдээллийн байгууллагууд эдийн засгийн хараат байдлын улмаас бие даасан үйл

ажиллагаа явуулж чадахгүйд хүрч байна. Өөрөөр хэлбэл, мөнгө өгч байгаа эздийнхээ төлөө үйлчилдэг ийм болоод байна гээд.

Тэгэхээр энэ хэвлэл мэдээллийн салбарт маань өнөөдрийн жишээлбэл бид нар мэдээ, сонин харахад ч гэсэн улс төрийн агуулга, түрүүн Шижир гишүүн бас хэлж байсан хийрхэл энэ их олон юмыг чинь гол бас үндэслэл нь энэ төрөөс улс төртэй холбоотой, улс төрчидтэй холбоотой төрийн байгууллагуудын энэ улс төрчдийн төсвийн мөнгийг ашиглаж энэ, зарцуулж байгаа энэ зардалтай нэлээн холбоотой байгаа. Тэгээд энэ дээр би түрүүн Байнгын хороон дээр уул нь асуулт асуусан. Хариулт авч чадаагүй. Тэгэхээр хоёрдугаарх зүйл нь болохоор Алтангэрэл сайдыг энэ хэлэлцүүлэг ингээд үргэлжилж явахаар бол Сангийн яамтай ярьж байгаад юм уу, төрийн байгууллагууд төрийн болон орон нутгийн өмчит компаниуд дээр яг энэ хэвлэл мэдээлэл хариуцсан хэчнээн орон тоо байгаа юм, ямар зардалтай байдаг юм? Дээр нь гуравдагч этгээдүүд энэ хэвлэл мэдээллийн салбарууд боловсруулах болон дамжуулахдаа ямар хэмжээний зардал гаргадаг гэдэг энэ дүнгээ мэдмээр байна. Дээр нь бас түрүүн.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье.

Д.Энхтүвшин: Энэ хэвлэл мэдээллийн салбарын бас байгууллага байна гэж ойлгосон. Гэхдээ салбарынхаа нийт зах зээлийн хэмжээг мэдэхгүй байна гэдэг бас жоохон хангалтгүй санагдаж байна. Тэгэхээр энэ тоогоо хэрвээ энэ хэлэлцүүлэгдэж явахаар бол энэ тоог бас илүү ямар нэгэн байдлаар тоо бас хэлж өгөөч. Тэгэхгүй бас яг энэ ямар түвшинд байгаад жишээлбэл хэвлэлийн эрх чөлөөг төрөөс хангах баталгаа гэдэг энэ төр аль болохоор л энэ хэвлэл мэдээлэл дээр зардаг зарцуулдаг мөнгөө багасгах нь илүү бас бодитой мэдээлэл түгээх ийм бололцоо, хэтэрхий улс төржиж хийрхэх энэ асуудлаас бас холдох боломжтой юм уу гэж бодож байгаа. Тэгэхээр энэ талаарх мэдээллүүдээ дараа энэ хэлэлцүүлгийн явцад Сангийн яамнаас болон энэ салбарын хүмүүс нь мэдээлэл олж өгөөч гэсэн ийм 2 асуулт байна.

Д.Амарбаясгалан: Оюунсайханы Алтангэрэл сайдад хариулт өгье.

О.Алтангэрэл: Энхтүвшин гишүүний хэлсэн санал асуултуудтай ер нь байр суурь нэг байна. Манай энэ хуулийн төслийн 2 дугаар бүлэгт энэ хэвлэл мэдээллийн эрх чөлөөг төрөөс хангах баталгаа гээд орчихсон. Зарим нь, зарим хүмүүс жоохон гуйвуулаад төрөөс яаж хангадаг юм энэ тэр гэж. Ерөөсөө төрөөс жишээлбэл нийгмийн харилцааг хамгаалж иргэдийнхээ амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалж Эрүүгийн хуулиар жишээлбэл хамгаалдаг. Дээрээс нь оролцохгүй байж хамгаална. Төр энэ салбарт ерөөсөө цензур тавихгүй байх, энэ агуулгын хяналт тогтоох гээд нөгөө хуучин хуулиар зохицуулж байсан заалт маань яг энэ дотор орж байгаа. Төр өөрөө ямар байдлаар цензурыг агуулгын хяналт тавихгүй байж байж оролцоно.

Дээрээс нь төрийн байгууллага, албан тушаалтан, хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаандаа бие даасан хараат бусаар эрхлэхэд саад учруулах, үйл ажиллагааг нь хуульд зааснаас бусад үндэслэлээр албадан зогсоох, татан буулгах, энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр мэдээллийн эх сурвалжаа

илчлэх, шаардахыг хориглоно гээд ингээд ийм байдлаар яаж энэ баталгааг хангах вэ гэдгээ л томъёолж оруулсан юм.

Хуулийн нэрийн хувьд таны хэлсэн томъёоллын дагуу байж бүрэн болно. Бид нөгөө хуучин явж байсан энэ төслийнхөө нэрээр ингээд нэрлээд явж байгаа. Бас дахиад энэ хуулийн нэртэй холбоотой манай Лодойсамбуу гишүүн энэ тэрнээс өөрөөр нэрлээд өөр хууль байх ёстой гэсэн ийм нэр томъёоны асуудлууд ч ярьж байсан. Тэгээд хэлэлцэх эсэхээ шийдээд явбал хуулийнхаа нэр дээр ч гэсэн бид нар цаашаагаа ярилцах бололцоотой.

Төрийн байгууллага дээрх орон тоо бас энэ багцааг бид нар энэ хуулийн төслийг судалж байхдаа гаргах гэж үзсэн юм. Энэ хүнд юм байна лээ. Яагаад хүнд юм бэ гэвэл яг хэвлэл мэдээллийн байгууллагад өөрсдийн үйл ажиллагааг сурталчилна гэж явахаасаа илүүгээр төрийн өмчтэй аж ахуйн нэгж томоохон компаниуд нийгмийн хариуцлагын хүрээнд гэж ямарваа аяны доор энэ тэр мөнгө шилжүүлдэг тоонууд их байдаг юм байна. Нарийн задаргаа нь ерөөсөө гарч өгдөггүй, олдож өгдөггүй.

Тухайлах юм бол ийм аян явуулна гэж ийм том малгай тавьж байгаад тэрнийхээ хүрээнд гэрээ байгуулчихдаг. Тэрнээсээ яг чухам хэдэн төгрөг нь зарцуулагдав, яав ийв гэдэг нь бас тодорхой мэдэгддэггүй. Тэгээд л бид нар ямар сайндаа энэ зарцуулж байгаа мөнгөө ил сонгон шалгаруулалт явуул гэж аминдаа л ил тод байлгаад тэгээд тэр журмыг нь баталъя гэдэг, Засгийн газар баталъя гэдэг байдлаар л оруулчихаад байгаа юм.

Энэ хуулийн төслийг хэлэлцээд явбал таны хэлж байгаа тэр тоо баримтыг тодруулахаас арга байхгүй ер нь. Ямар хэмжээний хөрөнгө эргэлдэж байгаа юм, энэнээс ямар хэмжээнд төрөөс гарч байгаа юм, энэ нь өөрөө хэвлэл мэдээллийн байгууллагын хараат бус бие даасан үйл ажиллагаанд яаж нөлөөлж байгаа юм гэдэг дээр бид нар харахаас арга байхгүй.

Өнөөдөр яг энэ Төрийн болон албан нууцын тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай хууль гээд олон хуулиар энэ үйл ажиллагаа нь хязгаартай байгаад байгаа учраас бид нар энэ дээр тодорхой хариулт өгч чадахгүй байгаад байгаа юм. Тэгээд одоо энэ бидэнд жишээ нь түрүүн энэ сонгуулийн судалгаа бид нар ингээд л хэлэхэд өнгөрсөн дата буюу бид нар 2024 оныхоо энэ дата юмнууд нь бүрэн олдохгүй 20 оны сонгуулийн дата-г хараад л бид нар тоо баримт хэлж байх жишээний. Тэгэхээр яг энэ эдийн засаг, зах зээлтэй холбоотой таны хэлж байгаа тоо баримтуудыг судлах шаардлага байгаа гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

Д.Амарбаясгалан: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Д.Энхтүвшин: 6.5 дээр ийм сая төрийн байгууллага төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээд нь өөрийн үйл ажиллагаагаа тусгайлан сурталчлуулах гэхихсэн энийг зүгээр бусад орнуудад болохоор яг төрийн үйлчилгээгээ сурталчлах л юмыг зөвшөөрөөд жишээ нь үйл ажиллагаа зохицуулна, сурталчилна гэхгүй төрийн үйлчилгээгээ сурталчлахыг зөвшөөрдөг, бусад юмыг хориглодог, улс төрийн үйл ажиллагаануудыг тийм шинжтэй үйл ажиллагаануудыг хориглодог тийм заалтууд байдаг. Иймэрхүү зохицуулалтын талаар та юу гэж бодож байгаа вэ?

Д.Амарбаясгалан: Алтангэрэл сайд.

О.Алтангэрэл: Тийм энэ нөгөө үйл ажиллагаа гэхээр бас таны хэлж байгаа саналыг хүлээж авч байна. Үйл ажиллагаа гэхлээр дарга нь ямар мундаг удирдагч болох тухай, захирал нь хэчнээн сайхан санаа санаачилга гаргасан тухай бас тийм сурталчилгаа болж хувирах гээд байх агуулга байх л юм байна л даа. Бид аль болохоор мэдээллийн агуулга руу л орохгүй гэж ингэж үйл ажиллагаа гэдэг үгийг тавьчихсан. Тэгэхдээ агуулга дотроо бүүр илүү нарийсгаад төрийн үйлчилгээ гэдэг агуулгаар бас оруулж энийг илүү сайжруулж бас болох юм байна. Хүлээн зөвшөөрч байна.

Д.Амарбаясгалан: Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууя.

Б.Жаргалан: Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль гэдэг 4-хөн заалттай хууль анх 1998 онд батлагдсан байдаг. Ер нь эргээд харахдаа 1996-2000 оны хооронд ажиллаж байсан Улсын Их Хурал Ардчилсан Үндсэн хуулийн үзэл санаатай органик хуулиудыг нийцүүлэх чиглэлээр, ер нь энэ шинэ нийгмийн үзэл санааг төлөвшүүлэх чиглэлээр маш их томоохон ажлуудыг бас хийж чадсан юм байна, бас энэ ардчилсан тогтолцоог бэхжүүлэхэд том үйл хэрэг бүтээж чадсан юм байна гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Ер нь аливаа зүйл чинь товч, тодорхой байх тусмаа илүү хүчтэй, үр дүнтэй байдаг гэдгийн үлгэрээр өнгөрсөн хугацаанд бараг 30 шахам жил энэ хуульд Улсын Их Хурал хүрч зүрхлээгүй. Яагаад гэвэл хэвлэл мэдээллийн эрх чөлөө бол Монголын ардчиллын амин сүнс. Үеийн үед ардчилалд хайртай хүмүүс үүнийг ойлгож байсан. Хоёрын хооронд өөрчлөлт хийж, эрсдэлийг нэмэгдүүлж байснаас энэ чигээр нь үлдээсэн нь дээр санагдаж байсан юм болов уу. Тэгэхээр бид бас маш 7 хэмжиж 1 огтлох зарчмаар энэ асуудалд хандахгүй бол болохгүй гэдгийг бас сануулъя.

Харамсалтай нь сүүлийн жилүүдэд Монголын ардчилал хямарч байна, хэвлэл мэдээллийн эрх чөлөө хумигдаж байна. Нэг талаас мэдээллийн урсгал нэмэгдсэн юм шиг хэр нь нөгөө талаас мэдээллийн урсгал нь төрөөс, төсвөөс хамааралтай болсон. Дээрээс нь уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслээс гадна олон нийтийн харилцааны платформууд хөгжиж хүн бүр шахуу контент үйлдвэрлэгч болсон. Улмаар хуурамч мэдээ мэдээлэл ч гэсэн нэмэгдсэн. Сэтгүүлчдэд хэрэг нээх, сэтгүүлчдийг саатуулах, шоронд хийх тохиолдол ч бас олширсон байна. Хамгийн сүүлд Ноорогийн залуусыг залхаан цээрлүүлсэн явдал гарсан байгаа. Тэгэхээр ингэхэд Ноорогтой холбоотой асуудал юу болсон бэ гэдэг эхний асуулт. Энэ хэрэг явдлаас бид ямар сургамж авсан бэ? Цаашид бид сэтгүүлчдээ яаж бодитоор хамгаалах юм бэ?

Хоёрдугаарт Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг Алтангэрэл сайд сая бас хэд хэдэн удаа дурдлаа. Уг хуулиар олон нийтийн мэдэх эрхийг баталгаажуулж өгсөн боловч Төрийн болон албаны нууцын тухай хуулиар маш их мэдээллийг бас нууцалсан байгаад байгаа. Тэгэхээр энэ зүйл дээр ямар бодолтой байгаад байгаа юм бэ? Хэдэн төрлийн мэдээллийг нууцалж байгаа вэ? Төрийн болон албаны нууцыг цөөлөх талаар ер нь салбарын яам ямар арга хэмжээ авч байна, энэ дээр Засгийн газрын бодлого яаж явж байна гээд гэдэг

асуулт байна. Нүүрсний оффтэйкийн гэрээнүүдээ хүртэл бид нар нууцалчихсан явсан шүү дээ нэг хэсэг.

Гуравдугаар асуулт. Засгийн газар, Төрийн байгууллагууд Монгол Улсын хамгийн том зар сурталчилгаа худалдан авагч болчихсон талаар бас гишүүд дурдаж байна. Угаасаа ийм судалгаанууд бас хэдэн жилийн өмнө гарчихсан байсан бас харж л байсан санагдаж байна. Хамгийн том зар сурталчилгаа худалдан авагч гэдэг дээр 1 номерт Засгийн газар гэхсэн. Өдөр тутамдаа өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн зарж борлуулдаг компаниудтай өрсөлдөөд 1 номерын зар сурталчилгаа нийлүүлээд байгаа шүү дээ. Тэгэхээр Засгийн газарт яг энэ чиглэлийн нарийн мэдээлэл байхгүй юм байна гэж сая сайдын хариултаа бас ойлголоо.

Уг нь нэгэнт Засгийн газраас судалгаануудаа хийгээд энэ хуулийн төсөл өргөн барьж байгаа бол Сангийн яамнаасаа бас мэдээллүүдээ аваад, энэ бүх бас тоон мэдээллүүдээ нэгтгэвэл бас сайн байгаад байна. Сангийн яаман дээр бас холбогдох мэдээллүүд байж л байх ёстой. Тэгээд үүнтэй холбоотойгоор энэ хуулийн төслийн 6.7-д төсвийн зарцуулалттай холбоотой их сонин заалт ороод ирчихсэн байх юм. Үүнийгээ бас тайлбарлаж өгнө үү гэж хүсье. Хэвлэл мэдээллийн үйлчилгээ авахад холбогдох төсөв.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Оюунсайханы Алтангэрэл сайд хариулт өгье.

О.Алтангэрэл: 1998 оны хууль маш сайн үүрэг гүйцэтгэсэн. 96-2000 оны парламентын баталсан маш сайн хуулиудын нэг гэдгийг эргэлзээгүй хүлээн зөвшөөрнө. Энэ бол маш дэвшилттэй хууль байсан. Тэгэхдээ тодорхой үр дүнтэй гэдэг сая Жаргалан гишүүний хэлж байгаа зарчим эрх зүйн харилцааг зохицуулах гэж байгаа нэн ялангуяа хамгаалах гэж байгаа бол ийм зарчим огт үйлчлэхгүй. Энэ буруу ойлголт. Бид нар хэрвээ нийгмийн харилцааг хамгаалах гэж байгаа бол, нэн ялангуяа үзэл бодлоо илэрхийлэх хэвлэл мэдээллийн байгууллагын өөрсдийн явуулах үйл ажиллагааг бид нар хүний эрхийг хангах чиглэлээр өөрчлөх гэж байгаа бол харин ч бид нар аль хэсгийг нь яаж хамгаалах вэ гэдгээ зохицуулж байж явна. Тэгээд үнэхээр 98 оны хууль маань энэ олон жилийн дараа үүргээ гүйцэтгэж чадахгүй байгаа нь сая манай Жаргалан гишүүн өөрийнх нь ярианд гарч байгаа энэ Монголын ардчилал хямарч байна, хуурамч мэдээлэл гаарч байна гэдэг ч юм уу энэ бүх үр дүнгүүдээр өнөөдөр үүсэж байгаа тэр сэтгүүлч нар байцаагдаж байгаа энэ үйл ажиллагаанд ч гэсэн харагдаж байгаа байх. Тэгэхээр бид нар энэ орон зайг тэр хэвлэлийн эрх чөлөөнд халдаад байгаа тэр хэсэг, хэвлэлийн эрх зөрчигдөөд байгаа тэр орон зайг хамгаалахын үүднээс л энэ төслийг боловсруулсан.

Тэр Норог сайттай холбоотой асуудал юу болсон бэ гэж. Энэ асуудал хэрэг мөрдөн байцаалтынх нь үйл ажиллагаа шалгагдаад ингээд үргэлжлээд явж байгаа. Нэгэнтээ энэ сайтын энэ залуучуудтай холбоотой үзлэг нэгжлэг хийсэн ажиллагааг ярьж байгаа дахиад дурдах ёстой. Өнөөдөр төрийн нууц задруулсан гээд сэтгүүлч шоронд хоригдоод гарсан шүү дээ. Энэ бүүр ноцтой жишээ байхгүй юу. Тэгэхээр тэр төрийн нууц гэдэг нь юу байсан бэ ингээд судлаад үзэхээр нууцад хамаарахгүй л зүйл гэж ингэж мэдээлэгдэж байсан шүү дээ. Өнөөдөр Төрийн болон албаны нууцын тухай хуулиар бид нар хуулийн өөрчлөлтийг Их Хуралд өргөн барьчихсан. Хүний эрхтэй холбоотой 13 хуулийн төсөл өргөн барьснаас бид

нар 12 нь хэлэлцэхээр дэмжигдчихсэн одоо яг ингээд хэлэлцүүлгийнхээ шатад явж байгаа.

Энэ дотор албаны нууцад хамаарч байгаа 1073 нууц байна гэдэг бид нарын хийсэн судалгаан дээр гарсан. Ийм байж болохгүй. Худалдан авалт хийхээрээ албаны нууц гээд тамга дарчихдаг. Тэр нь албаны нууцад хамаарах эсэх дээр ямар ч хүн дүгнэлт гаргаж болдоггүй энэ байдлыг арилгая. Албаны нууц гэдэг тодорхой шалгууртай байя, шалгуурыг нь жил болгон үнэлдэг байя, тэр тайлангаа гаргаж өгдөг байя гэсэн энэ өөрчлөлтийг оруулаад явж байгаа. Хэрэв энэ батлагдах юм бол тэр Нийтийн мэдээллийн хуулиар нээлттэй болгох ёстой мэдээллүүд дээр бид нар нээлттэй болгоход ахиц дэвшил үзүүлнэ.

Тэр 6.7 яагаад энэ холбогдох төсөв хуваарилах зарцуулах журмыг Засгийн газар баталж мөрдүүлнэ гэж заасан бэ гэхлээр одоо ямар ч журамгүй байгаа юм. Төрөөс зарцуулагдаж байгаа мөнгө ямар ч журам байхгүй. Тэнд хэн нэгэн дарга, хэн нэгэн сайд, хэн нэгэн албан тушаалтан, хэн нэгэн захирлын үзэмж доор заримдаа өөр мэдээлэл, өөр халхавч дор энэ мөнгө төгрөг яваад байгаа юм. Яг үзэхээр, албан ёсоор үзэхээр хэвлэлийн алба гэж байхгүй боловч өөр орон тоон дээр хүн цалинжуулдаг, тэр рийл хийдэг, нэвтрүүлэг хийдэг хүмүүсээ өөрөөр халхавч доор ажиллуулдаг, гэрээний үндсэн дээр ажиллуулдаг ийм олон зүйлийг нуучхаад байгаа учраас энийг ил тод болгоё л гэдэг зорилго.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Жаргалан гишүүн тодруулж асууя.

Б.Жаргалан: Тэгэхээр сүүлийн жилүүдэд алдаа завхралууд гараад байгаа учраас хуульд өөрчлөлт оруулах шаардлага гарсан байхыг үгүйсгэхгүй. Гэлээ гэхдээ бас яг энэ орчин цагт өнгөрсөн 30 жилийн хугацаанд гарсан бас энэ нийгэм улс төр, эдийн засгийн өөрчлөлтүүдийг тусгасан яг тухайн салбарын шинэ тутам тулгамдаж байгаа сорилтуудыг хангалттай бас судалж тусгасан ийм бас хууль болсон гэдэгт бас эргэлзээд байгаа учраас л яриад байгаа юм л даа. Нэн ялангуяа шинэ зохицуулалтууд бас шаардлагатай талаар дэлхий дахинд л яригдаж байна. Тэр зүйлүүд харагдахгүй байна. Бид нар нөгөө л уламжлалт нөгөө тулга тойрсон яриануудаа л энд оруулчихсан л байгаад байна л даа. Тэгэхээр магадгүй гишүүдийн хэлээд байгаа шүүмжлэлүүдийг бас сайд бодолцоод энэ хууль дээрээ ахиж жаахан нэмж ажиллах ёстой юм биш үү л гэдэг санаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үг хэлэх гишүүд нэрсээ ирүүлсэн байна. Танхимд байхгүй байна гишүүд. Үг хэлсэнд тооцлоо. Уучлаарай би Г.Ганбаатар гишүүнтэй андуурчхаж. Амгаланбаатарын Ганбаатар гишүүн үг хэлнэ. 1 дүгээр индэр. Ганбаатар гишүүн индэр дээрээс 1 дүгээр индэр. Алтангэрэл сайдын өөдөөс харж байгаад.

А.Ганбаатар: Баярлалаа. Асуулт асуухгүй үг хэлье гэсэн чинь золтой мултарчихсангүй. Юуны өмнө хэвлэлийн эрх чөлөөний тухай индексийн хэдэн статистик надад байна. Судалгааны байгууллагуудаас бидэнд өгсөн. 2023 оны байдлаар 88 дугаар байрт хэвлэлийн эрх чөлөө индекст байгаа юм. Энэ юу вэ гэхээр асуудалтай гэдэг категорит орж байна. 2024 онд 109 дүгээр байранд буюу хүнд нөхцөл байдалтай байна гээд. Бас нэг зүйл нь 1998 оны манай хэвлэлийн эрх

чөлөөний сайн болсон хууль гэж бид нар ярьж байна. Гэхдээ хуулийн хэрэгжилт нь өнөөдөр 0-тэй тэнцүү байна гэсэн ийм 3 тоо надад байна л даа. Тэгэхээр өнөөдөр энэ Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгтэй юү гэвэл хэрэгтэй байна.

Гэхдээ эрхэм гишүүд, төрийн өндөр албан тушаал хашиж байгаа улс төрчид бид нар Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг ярихдаа нэг өнцгөөс хармаар байна. Нэг өнцгөөс. Тэр нь юу вэ гэхээр төрийн өндөр албан тушаалтан, улс төрчид олон нийтийн хардлагын субъект гэдгээ ойлгох ёстой. Бид нар олон нийтийн хардлагын субъект шүү гэдгээ ойлгочих юм бол энэ хуулийн үзэл санаа, энэ хуулийн логик нь гараад ирнэ. Өөрөөр хэлбэл, олон нийт, улс төр, өндөр албан тушаал хашиж байгаа хүмүүсийг хардах эрхтэй, янз бүрийн мэдээлэл тавих эрхтэй сэтгүүлч нар. Зөвхөн улс төрчид, өндөр албан тушаалтнууд өөрсдийнхөө буруугүй гэдгээ л нотлох энэ өнцгөөс хандах ёстой. Бид нар болохоор өрөөсгөл хандаад байгаа юм нь энэ сэтгүүлч энэ хүн намайг гүтгэлээ, энийг би яаж шүүх вэ, энийг ямар цагдаад өгөх вэ, энэ ямар хуулиар, магадгүй Эрүүгийн хуулиар яаж шийдэгдэх вэ гэдэг талаас нь хараад байна. Тэгвэл энэ Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль болохгүй. Тэгэхээр энэ өнцгөөс харж энэ хуулийг хийх ёстой байсан юм болов уу гэж харж байна.

Хоёрт нь Алтангэрэл сайдад түрүүн Сайнзориг гишүүн хэлж байсан энэ хууль 2 салах ёстой байсан юм болов уу гэж. Нэг нь Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль, нөгөөдөх нь.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Минут дууслаа. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн үг хэлье 1 дүгээр индэр. Нэмэлт минут гэдэг дэг байхгүй үгэн дээр уучлаарай. Микрофоныг нь өгье.

С.Эрдэнэболд: Хууль санаачлагчид дараах зүйлсийг Алтангэрэл сайд аа нэгдүгээрт нь болохлоор энэ төрөөс мэдээж прокурор ч юм уу, шүүгч гэдэг юм уу, нотариатч гэдэг юм уу яг энэ хууль хэрэгжүүлж байгаа байгууллагууд дээр бид нар ёс зүйн кодыг тавьж өгөх нь бол төрт ёсны зарчим, хуулийн зарчим гэж үзэж байгаа. Тэгэхээр яг энэ олон нийтийн хяналт тавьдаг иргэдийн мэдэх эрхийг нь бас дунд нь гүүр болж байгаа, бас дээрээс нь 4 дэх засаглал гэж хэлэгддэг ийм нийгмийн хүлээлттэй байдаг зүйл дээр Хэвлэлийн эрх чөлөөний хэвлэл мэдээллийн энэ хуулийг хийхдээ яг энэ ёс зүйн зарчмуудыг энэ дээр давхар шаардах нь зөв үү гэдэг асуудал байгаа.

Тийм учраас бол энэ гишүүдийн яриад байгаа хэвлэлийн эрх чөлөө болон хэвлэн нийтлэх эрх чөлөө хоёрыг хооронд нь хольж хутгахгүйгээр тус тусад нь авч үзэх нь зүйд нийцнэ гэж үзэж байгаа. Тэгэхгүй болохлоор ерөнхийдөө бид нар асар том өргөн хүрээтэй зүйлийг сүүлдээ нөгөө нийгмийн сүлжээ, сошиал медиа, ёс суртахуун бүгдийг нь холиод нэг сав руу хийгээд шийдэх гэж хичээгээд байгаа. Тэгэхээр энийгээ бол ингээд ойлголтын хувьд бол тус тусад нь ялгамжтайгаар авч үзэх хэрэгтэй. Мөн Улсын Их Хурлын Тамгын газраас дүгнэлтийг уншиж байхад, гаргасан дүгнэлтийг уншиж байхад хууль зүйн нэр томъёо буюу дефинишн/definition/ буюу яг тэр нэр томъёог юу гэж ойлгох вэ гэдэг дээрээ дахиад ул суурьтай бас гаргалгаануудыг хэлэлцэх явцад хийх ёстой юм байна гэж үзэж байгаа юм. Тэгэхгүй болохоор нэг ойлголт дээр өөр өөр байдлаар хүмүүс ойлголттой байгаад байна.

Дараад нь яг ажил хэрэгч санал нь болохлоор энэ 5 дугаар зүйл байгаа. 5 дугаар зүйл дээр бол жишээлбэл сэтгүүл зүйн үйл ажиллагаанд баримтлах зарчим гэж байгаа юм. Энэ дээр жишээлбэл хараат бус, бие даасан байдлаар тэнцвэртэй мэдээлэх гэж байгаа юм. Тэнцвэртэй мэдээлэх гэдгийг жишээлбэл хэн яаж тогтоох вэ?

5.1.2 дээр хүнлэг, шударга ёсыг баримтлах гэж байгаа юм. Тэр хүнлэг байдал, шударга ёс гэдгийг хэн тэгж тогтоох вэ? Яаж?

Дээрээс нь үндэсний аюулгүй байдалд, хүний эрх, нийтийн ашиг сонирхлыг дээдлэх гэж байгаа. Тэр нийтийн ашиг сонирхлыг дээдлэх гэдгийг бас хэн яаж тогтоох вэ?

Дээрээс нь 5.1.5 дээр хуулиар хамгаалагдсан нууцад хүндэтгэлтэй хандах гэж байгаа юм. Хүндэтгэлтэй хандах гэж жишээлбэл юуг хэлж байгаа юм? Хүндэтгэлтэй хандахгүй байна гэвэл юуг хэлэх юм? Хүндэтгэлтэй хандана гэвэл юуг хэлэх юм? Энийг ямар хэмжүүрээр, яаж тогтоох юм бэ гэдэг ойлголт байгаа.

Яагаад энийг хэлж байгаа вэ гэхлээр энэ нь эргээд эрх мэдэлтэн, албан тушаалтнуудын субъектив хандлагаар эргээд хүн хилсдүүлэх ч юм уу, хэлмэгдүүлэх шалтаг, шалтгаан болчих вий дээ. Шалтгаан биш юм гэж бодоход шалтаг болчих вий дээ гэсэн болгоомжлол байгаа байхгүй юу. Тэгэхээр ерөнхийдөө бол энэ 5 дугаар зүйлийг хэрвээ хууль цаашаа явлаа гэхэд бол бүхэлд нь энэ үзэл санааг эндээс хасах саналтай байгаа юм. Ерөнхий хуулийн үзэл санааг дэмжиж байгаа ч гэсэн 5 дугаар зүйл дээр байгаа ингээд хэт нарийвчилсан, хэт төр рүү энэ хэвлэн нийтлэх эрхийг татаж байгаа энэ зохицуулалт нь өөрөө Үндсэн хуулийн агуулгад нийцэх үү гэдэг саналыг хэлэх гэж байгаа юм.

Ер нь одоо хэлэлцүүлгийн явцад ажиглагдаж байгаа нэг зүйл болохлоороо дахиад хэлэхэд хэвлэлийн эрх чөлөө, хэвлэн нийтлэх эрх чөлөө нэг талдаа бид нар яг медиа буюу хэвлэл мэдээллийн байгууллагуудын асуудлыг яриад байгаа юм шиг боловчиг нөгөө талдаа зарим гишүүдийн байр суурь нь болохоор хэвлэн нийтлэх эрх чөлөө, үг хэлэх эрх чөлөөтэй холбогдоод нөгөө фрийдом оф спийч/freedom of speech/ рүүгээ ороод явчхаж байгаа юм. Тэгэхээр энэ дээр бол бас энэ хэлэлцүүлгийн явцад ойлголтыг нэг мөр болгож хууль зүйн нэр томъёонуудыг нэг мөр болгох ёстой. Тэр тодорхойлолт дээр байгаа тэр илтэд худал мэдээлэх гэж илтэд гэдэг нь жишээлбэл яг юуг хэлж байгаа юм? Эргээд энэ чинь цаашаагаа өнөөдөр жишээлбэл хүн амьтан хоригдоод, сэтгүүлчид ажил үүргээ гүйцэтгэж явсны төлөө хэлмэгдээд шорон оронд ороод ороод байгаа учраас энэ асуудлуудыг бид нар маш нухацтай авч үзэх нь өөрөө хүний эрхийн шалгуур зарчим байна гэж үзэж байгаа юм.

Тийм учраас бас Хүний эрхийн дэд хорооны даргын хувьд энэ асуудал дээр нухацтай хандаач, хоёрдугаарт 5 дугаар зүйлийг ер нь бүхэлд нь хэлэлцэгдсэн тохиолдолд хасах саналтай. Мэргэжлийн байгууллагуудаас дахиад энэ дээр хэлэлцүүлэг явуулаач гэж хүсэж байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ганбаатар гишүүний минутыг сая шүүлгэж үзлээ. Бас жоохон дутуу яачих шиг болохоор нь. Тэгээд 40 секунд дутуу байхад систем унтарсан байна. Нэмж үг хэлэх үү? Энэ 1 дүгээр индэр дээрээс 1 минут үг хэлье.

А.Ганбаатар: Тэгэхээр энэ хуулийг 2 хэсэгт оруулаач гэж. Нэг нь эрх чөлөөний тухай, нөгөөдөх нь хэвлэл мэдээллийн байгууллагын зохицуулалтыг хангасан байхаар.

Тухайлбал энэ Эрүүгийн хуулийн 13.14-ийг ерөөсөө авч хаях хэрэгтэй. Сэтгүүлч нар ямар нэгэн зүйл хэлснийхээ төлөө, хэвлэн нийтлэлийнхээ эрүүгээр ерөөсөө шийтгэгдэггүй байх. Энэ олон улсын жишиг шүү.

Дараа нь тэр Эрдэнэболд гишүүн сая яриад байна. Энэ 5 дугаар зүйл ёс зүйг хуульчилна гэж ерөөсөө байхгүй. Тэгэхээр ёс зүй хэвлэл мэдээллийн өөрөө өөрийгөө зохицуулах байдлаар шийдэгдэнэ. Тэгэхээр энэ жишээлбэл энэ 5 дугаар зүйл авагдах ёстой.

Тэр дагалдаж орж ирсэн 6 хууль дотор шийдэгдэж байгаа асуудлууд тун цөөхөн байна. Энэ дотор ахиад төрийн болон албаны нууц ерөөсөө учир нь олдохгүй байж байгаа.

Дараачийн нэг юм нь тэр сошиал контентуудыг ерөөсөө оруулаагүй байж байгаа.

Тэр Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн тухай хуульд байж байгаа 18 телевиз бусдаасаа давуу эрх эдэлж байгаа гэх мэтийн зүйлүүдийг үүгээр бас зохицуулах ёстой юм. Тэгэхээр эд нар нь.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд үг хэлж дууслаа.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дуусаад өнөөдрийн чуулган хааж байна.

Санал хураалтууд маргааш үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдаанаар явагдана. Эхний асуудал.

17.36 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР

